

**Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гурван талт зөвлөл
ОТМШБ, ХШБ-ийн судалгааны эцсийн тайлангийн Тайлбар бичиг**

Монгол Улс
Өмнөговь аймаг
Ханбогд сум

2017 оны 01-р сарын 12

Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн¹ захиалгаар хөндлөнгийн судлаачдийн багийн хэрэгжүүлсэн Ханбогд сумын малчин өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа болон Ундай голын гольдрол өөрчлөлтийн улмаас үүссэн хам нөлөөллийн 2-р шатны судалгааны тайланг олон нийтэд хүргэж байна.

Энэхүү судалгааг Дэлхийн Банкны Группын (ДБГ-ын) Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний Газарт (ЭЗХЗОГ) Ханбогд сумын малчдын гаргасан гомдлыг шийдвэрлэхэд туслах зорилгоор хэрэгжүүлсэн юм. Судалгаа нь Ханбогд сумын болон малчдын ахуй амьжиргаа, нийгэм соёлын байдалд гарсан сүүлийн 10 гаруй жилийн өөрчлөлтийг бодитойгоор хараат бус, олон талын эх үүсвэрээс авсан мэдээлэлд үндэслэн зураглаж гаргах, улмаар эдгээр өөрчлөлтөөс аль нь Оюу толгой компанийн үйл ажиллагаанаас нөлөөлсөн болохыг тодорхойлох, уурхайн нөлөөллийн нөхөн олговрын хөтөлбөр зохистой байсан эсэх мөн Ундай, Халив Дугатын голын гольдрол өөрчлөлтийн улмаас бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болох хуримтлагдах нөлөөлөл, ОТ-н хаягдлын далангийн нөлөөллийг үнэлэх зорилготой байсан. Судалгааг Олон талт маргэжлийн шинжээчдийн баг (ОТМШБ) болон Хөндлөнгийн шинжээчдийн баг (ХШБ) 2016 онд хийж 2017 оны 1-р сард Ханбогд сумын Гурван Талт Зөвлөлд хүлээлгэн өгсөн болно.

ОТМШБ болон ХШБ-ийн судалгааны тайланд дурдсан дүгнэлтүүд нь Гурван талт зөвлөлийн байр суурь биш бөгөөд судалгааны багуудын өөрсдийн хараат бус, хөндлөнгийн үнэлгээ дүгнэлт юм. Судалгааны тайлангийн зарим дүгнэлтүүдийг Зөвлөлд нэгдсэн талууд бүрэн хүлээн зөвшөөрөөгүй гэдгийг тайланг үзэж сонирхох аливаа байгууллага хувь хүмүүст энэхүү тайлбар бичгээр мэдэгдэж байна. Гэхдээ малчдын гомдлын асуудлыг шийдэхийн тулд Талууд энэ судалгааны зөвлөмжүүдийг хэлэлцэж хэрэгжүүлэхээр тохирсон болно.

Энэхүү тайланг зохисгүй ашигласан тал холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

Тайлантай холбоотой аливаа асуудлаар дараах хаягаар хандана уу.

Өмнөговь аймаг, Ханбогд сум
Гурван талт зөвлөл

¹ Ханбогд сумын Засаг захиргаа, Малчдын төлөөлөгчид болон Оюу толгой компанийн хамтарсан Гурван талт зөвлөл (ГТЗ) нь талуудын маргааныг шийдвэрлэх зорилгоор Харилцан ойлголцлын санамж бичигт зурсны дагуу 2015 оны 6 сарын 8-нд албан ёсоор байгуулагдсан болно. ГТЗ-ийн үйл ажиллагааг Эрх зүйн нийцэл хяналт, зөвлөгөө, омбудсмэний газраас (ЭЗХЗОГ) чиглүүлж байна. ЭЗХЗОГ бол Дэлхийн банкны группын Олон улсын санхүүгийн корпораци болон Олон Талт Хөрөнгө Оруулалтын Даатгалын Байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хараат бус байгууллага болно.

2017 ОНЫ 1 ДУГААР САР



ОЛОН ТАЛТ МЭРГЭЖЛИЙН ШИНЖЭЭЧДИЙН БАГ
БОЛОН
ХӨНДЛӨНГИЙН ШИНЖЭЭЧДИЙН БАГ
БАРИМТ ХАМТРАН ОЛЖ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ

ШИНЖЭЭЧДИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Жэй Эс Эл Консалтинг Лтд.
ОКСФОРД, НВУ
www.shankleman.com

ЕРӨНХИЙ ХУРААНГУЙ.....	1
1 УДИРТГАЛ.....	2
1.1 Үндэслэл	2
1.2 БАРИМТ ХАМТРАН ОЛЖ ТОГТООХ (БХОТ)	2
1.3 ЭНЭХҮҮ ТАЙЛАН	3
2 БЭЛЧЭЭР, МАЛЫН УСНЫ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН ҮНЭЛГЭЭ.....	4
2.1 Үнэлгээний ХАМРАХ ХҮРЭЭ	4
2.2 АРГАЧЛАЛ	4
2.3 ДҮГНЭЛТҮҮД	4
2.3.1 МОНИТОРИНГ	6
2.3.2 Тоос.....	6
2.3.3 ЕРӨНХИЙ	6
2.4 Зөвлөмжүүд.....	7
3 ӨНГӨРСӨН АРВАН ЖИЛД МАЛЧДЫН ХӨРӨНГӨ, АМЬЖИРГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	9
3.1 ХАМРАХ ХҮРЭЭ	9
3.2 АРГАЧЛАЛ	9
3.3 ДҮГНЭЛТҮҮД	10
3.4 Зөвлөмжүүд.....	10
4 НӨХӨН ОЛГОВРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАСАН НЬ.....	11
4.1 Хяналтын ХАМРАХ ХҮРЭЭ	11
Нөхөн олговрын хөтөлбөрийг хянаж үзэхдээ ОТ-н нөлөөлөлд өртсөн малчдад олгосон нөхөн олговрыг судаллаа. Ингэхдээ ажлын даалгаварт тодорхойлсон дараах асуудлуудыг авч үзсэн болно. Үүнд:	11
4.2 АРГАЧЛАЛ	12
4.3 ДҮГНЭЛТҮҮД	12
4.4 Зөвлөмжүүд.....	13
5 2-Р ШАТНЫ ТАЙЛАН: УНДАЙ ГОЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГОМДОЛ.....	14
5.1 Үнэлгээний ХАМРАХ ХҮРЭЭ	14
5.2 АРГАЧЛАЛ	14
5.3 ДҮГНЭЛТҮҮД	15
5.3.1 Гидрологи	15
5.3.2 Нийгмийн үнэлгээ.....	15
5.4 Зөвлөмжүүд.....	16
5.4.1 Гидрологи	16
5.4.2 Нийгмийн үнэлгээ	16
6 ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТҮҮД	17
6.1 ОТМШБ/ХШБ-ийн судалгаанууд	17
6.2 Нэмэлт ажиглалтууд.....	19

7 ЗӨВЛӨМЖҮҮДИЙН ЭМХТГЭЛ	20
УСТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖҮҮД.....	22
НӨХӨН ОЛГОВОРТОЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖҮҮД	25
ТОВЧИЛСОН ҮГҮҮД	28
ЗУРГУУД	29
МАЛЫН ҮЗЛЭГ	29
УС ХЭМЖИЛТ	30
НИСДЭГ ТӨХӨӨРӨМЖ	30
ГАДАРГЫН УС, БАЯН БАГ	31
ТООСНЫ ЗАНГА ТОГТООЖ БАЙГАА НЬ	31
ЦООЖТОЙ ХУДАГ	32
СУМЫН ЗАСАГ ЗАХИРГАА	32
КАТАРЫН ЗЭРЛЭГ АМЬТАД ХАМГААЛАХ ГАЗАР.....	33
ХИЛ ДЭЭР ДУГААРЛАЖ БУЙ НҮҮРСНИЙ ТЭРЭГНҮҮД.....	33

Ерөнхий Хураангуй

Хөндлөнгийн шинжээчид болон малчид, Оюу Толгой уурхай, Монгол улсын Ханбогд сумын засаг захиргааг төлөөлсөн Гурван Талт Зөвлөл (ГТЗ) хамтран гүйцэтгэсэн Баримт Хамтран Олж Тогтоох Үйл явцын хэд хэдэн судалгаагаар олж илрүүлсэн зүйлсийг Энэхүү Хураангуй Тайлангаар танилцуулж байна.

Судалгаануудын зорилго нь ОУСК-ийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хүмүүс гомдол гаргадаг бие даасан гомдлын механизм – Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмений Газарт малчдаас гаргасан гомдлуудыг шийдвэрлэхэд туслахад оршино.

Судалгаануудад бэлчээр ба малын ус; ОТ-оос малчдад өгсөн нөхөн олговор зохистой эсэх; Ундай, Халив Дугатын голуудад учруулсан нөлөөлөл, малчдад тусах үр дагавар, хаягдал хадгалах байгууламжийн бүрэн бүтэн байдал, аливаа шүүрэлтээс Халив Дугатын голд үзүүлэх нөлөөлөл зэрэгтэй холбоотой асуудлуудыг авч үзлээ. Хөндлөнгийн шинжээчид судалгаа тус бүрийг ГТЗ-тэй тохирсон аргачлал, ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Эдгээр судалгаагаар ерөнхийдөө ОТ-с малчдад учруулсан зарим нөлөөллүүдийг өмнө нь бүрэн ойлгоогүй, бүрэн нөхөн төлөөгүйг олж тогтоов. Түүнчлэн анхдагч суурь мониторингийн цоорхой болон Ханбогд сумын мал маллагаанд гарсан ОТ-д хамааралгүй хэд хэдэн өөрчлөлтийн улмаас малчдын тулгамдсан зарим асуудлууд тухайлбал ОТ-с малын үндны усанд үзүүлж буй нөлөөлөлтэй холбоотой асуудлыг бүрмөсөн шийдэх боломжгүйг бид бас тогтоолоо. Мониторинг, харилцааг сайжруулах хэрэгтэй, үүнийг хэрэгжүүлбэл ОТ ба малчдын хоорондын итгэлцэл яваандаа сайжрах болно гэж бид үзэж байна. Үүн дээр нэмж хэлэхэд уул уурхай, мал аж ахуй амжилттай зэрэгцэн орших явдлыг хангах үүргийг сүм хүлээсэн, мөн малын тоо толгой өссөн гэх мэтээс бэлчээрийн ачаалал нэмэгдэж байгаа тул сумын хэмжээнд бэлчээр, усыг зохицуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зайлшгүй чухал. ОТ өөрийнх нь үйл ажиллагааны улмаас малчдын усны нөөцөд хохирол учраагүй гэдгийг харуулж чадахгүй байгаагаа хүлээн зөвшөөрч, ашигладаггүй бэлчээрийн газарт нэмэлт худаг барих санхүүжилтийг гаргахыг зөвлөж байна.

Судалгааны үр дүнд дээр дурьдсанаас гадна бэлчээр, ус, нөхөн олговор, ОТ ба малчдын хоорондын харилцаа, мониторинг, хаягдал хадгалах байгууламжтай холбоотой зөвлөмжүүд гаргалаа. Эдгээрийг хураангуй тайланд оруулсан ба бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн тайланд илүү дэлгэрэнгүй тусгасан; мөн энэхүү хураангуй тайлангийн ард зөвлөмжүүдийн нэгдсэн жагсаалт хийж харуулсан болно.

Энэ тайлангаар талуудаас бүрэн хамааралгүй хөндлөнгийн шинжээчдийн олж илрүүлсэн зүйлсийг танилцуулж байгаа болно.

Жилл Шанклеман

Трой Штернберг

Оксфорд, 2017 оны 1 дугаар сар

1 Удиртгал

1.1 Үндэслэл

Оюу Толгой (ОТ) төсөл нь Монгол улсын Өмнийн Говийн бүст байдаг зэс, алтны уурхайн үйл ажиллагаа явуулах 12 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай төсөл. Оюу Толгой ХХК-ийн гол өмчлөгч (66 хувь) нь Торонтогийн хөрөнгийн биржэд бүртгэлтэй Туркойз Хилл Ресурс хэмээх Канадын хувьцаат компани. Монгол улсын төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК үлдсэн 34 хувийг эзэмшдэг. Туркойз Хилл Ресурсийн гол хувьцаа эзэмшигч нь олон улсын уул уурхайн том компани Рио Тинто ХК. Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) хөрөнгө оруулалт хийх тухайгаа өмнө нь олон нийтэд мэдээлж байсан ба 2013 онд төслийн санхүүжилтийн багцын нэг хэсэг хөрөнгө оруулалтыг баталсан байна.

2012 оны 10 дугаар сард өөрсдийгөө Монгол улсын Өмнийн Говьд буй ОТ төслийн нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй нутгийн малчид үндэсний ТББ ОТ Хяналт ба орон нутгийн Говийн Газар Шороо ТББ-ын туслалцаатай ОУСК-ийн төслүүдийн нөлөөлөлд өртсөн хүмүүс гомдол гаргадаг бие даасан гомдлын механизм – Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газарт гомдол гаргажээ. Гомдол гаргагчид төсөл газар, ус ашиглаж байгаа нь тэдний нүүдлийн аж төрөх ёсыг алдагдуулан, тэдний уугуул соёл, амьжиргаанд аюул учруулж байна хэмээжээ. Гомдол гаргагчид тэдэнд зохих ёсоор нөхөн олговор олгоогүй буюу эсвэл нүүлгэн шилжүүлээгүй гээд төслийн зохист байдлын магадлан шинжилгээ хэрхэн хийгдсэн, ялангуяа хуурайшилтай бүс нутагт усыг тогтвортой ашиглахтай холбоотой асуудлаар нэхэмжлэл гаргасан.

2013 оны 2 дугаар сард төслийн ойролцоо амьдарч, амьжиргаагаа залгуулдаг нутгийн малчид, иргэд хоёр дахь гомдлыг гаргажээ. Гомдол гаргагчдын тавьсан гол асуудал нь төслөөс Ундай голыг өөрчлөхтэй холбоотой. Гомдол гаргагчид голын гольдролыг өөрчилснөөр тэдний уламжлалт нүүдлийн аж төрөх хэв маяг, амьжиргаанд аюул учруулна гэж үзсэн. Тэд голын гольдролын өөрчлөлт хэд хэдэн усны сүлжээг хуурайшуулж, бэлчээрийн гарцыг муутган, хайлаас модны төглүүд усаар хангагдахгүй болох ба мөн ариун дагшин гэж тэд шүтдэг голд нь соёлын нөлөөлөл учирна хэмээн онцгой санаа зовж буйгаа илэрхийлсэн байна.

Малчид ЭЗХНЗОГ-т гаргасан хоёр гомдлыг хамтад нь шийдвэрлэх маргаан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдийг нь төлөөлөх багийг сонгосон. Гомдол гаргагчид болон ОТ гомдолд тавьсан асуудлуудыг хамтдаа шийдвэрлэхийн тулд ЭЗХНЗОГ-ын маргаан шийдвэрлэх багтай хамтран ажиллахыг зөвшөөрч, улмаар 2015 оны 6 дугаар сард малчид, ОТ, орон нутгийн засаг захиргааны (сум) төлөөллөөс бүрдсэн Гурван Талт Зөвлөлийг (ГТЗ) байгуулжээ. Мэдээллийн хүртээмж, малчдыг уурхайн талбайд оруулж үзүүлэх/хяналт хийх, ОТ төслийн талбай дотор мал бэлчээрлүүлэх, төслийн зарим нөлөөллүүдийг авч хэлэлцэхэд баримт хамтран олж тогтоох (БХОТ) үйл явцыг ашиглах гэх мэт асуудлаар завсрын олон шийдвэр тохиролцоонд хүрсэн байна.

1.2 Баримт Хамтран Олж Тогтоох (БХОТ)

БХОТ арга нь ГТЗ Ажлын Даалгавар (АД) бэлтгэх, судалгаа хийх шинжээчдийг сонгох; ГТЗ болон томилогдсон шинжээчдийн байнгын харилцаа холбоо, жишээ нь: ажлын төлөвлөгөө батлах, холбогдох баримт бичгүүдийг тодорхойлон, хуваалцах, зорилтот бүлгийн уулзалт зохион байгуулж, судалгаанд хамруулах малчид болон бусад ярилцага өгөх хүмүүсийг тогтоох; урьдчилсан тайланг дэлгэрэнгүй хэлэлцэх зэрэг ажлуудыг хамарсан. Дүгнэлт, зөвлөмжүүдийг шинжээчид гаргасан бөгөөд зөвлөмжүүдийг хүлээн авах эсэх, хэрхэн хэрэгжүүлэхийг ГТЗ шийднэ.

Энэ баримт бичгээр баримт хамтран олж тогтоох үйл явцаар тогтоосон дараахь зүйлсийг тайлагнаж байна. Үүнд:

- ХШБ-ийн 2-р шатны судалгаа - Халив Дугатын голд учирсан нөлөөлөл болон Ундай голын сав газар дахь хуримтлагдах нөлөөлөлтэй холбоотой. Энэ ажил 2016 оны 2 сард эхэлсэн. Ундай голд төслөөс учруулсан нөлөөллийг үнэлэх¹ Хөндлөнгийн Шинжээчдийн Багийг (ХШБ) ² талууд хамтран сонгосон. (ХШБ-ийн 1-р шатны судалгаа 2015 оны эхээр дууссан, үр дүнгийн талаар ЭЗХНЗОГ-ын цахим хуудаснаас үзэж болно.)³
- Сүүлийн арван жилийн туршид амьжиргаа, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдийн зураглалыг хөндлөнгөөс гарган, ургамалжилт, усны өөрчлөлтөнд дүн шинжилгээ хийх, нөхөн олговор зохистой эсэхэд үнэлэлт өгөх зорилготой сумын нийт малчин өрхүүдийн нийгэм-эдийн засаг, байгаль орчны судалгаа⁴ хийхээр томилогдсон Олон Талт Мэргэжлийн Багийн (ОТМШБ)⁵ ажлын үр дүн.

ГТЗ-өөс БХОТ үйл явцад оролцон, дэмжин тусалж байсанд ОТМШБ, ХШБ-ийн гишүүд ихэд талархалтай байгаа бөгөөд биднийг дэмжин, урам зориг өгч, хамтран ажилласан явдалд баярлаж буйгаа илэрхийлье. Монгол, Англи хэлээр яригч талуудын цахим харилцааг орчуулан, баримт бичгээр саадгүй хангаж байсан ГТЗ-ийн нарийн бичигт онцгойлон талархаж байна. Мөн үйл явцыг чиглүүлэхэд туслалцаа үзүүлсэн ЭЗХНЗОГ-т талархлаа илэрхийлье.

1.3 Энэхүү тайлан

Энэ тайланг ГТЗ-д гарган өгч байна. Үүнд БХОТ ажлын үр дүнгийн хураангуйг дараах байдлаар танилцуулсан болно. Үүнд:

- Бэлчээр, усны чанар, хүртээмжийн үнэлгээ
- Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн лүн шинжилгээ
- Нөхөн олговрын хөтөлбөрийг хянасан байдал
- 2-р шатны тайлан: Ундай Голын Өөрчлөлтийн тухай Гомдол.

Урьдчилсан тайлан нэг бүрийг 2016 оны 10 сард ГТЗ-өөр хэлэлцэж, тал тус бүрээс тус болохуйц, дэлгэрэнгүй санал хүлээн авсан. Тайлан нэг бүрийг саналуудтай уялдуулан хянан засварлаж, энэ Хураангуй Тайланд хавсаргалаа. Гэхдээ тайлангууд талуудаас бүрэн хамааралгүй хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлтүүдийг тусгаж байгаа болно.

ОТМШБ болон МШБ-ийн ажлын даалгавар, арга, үр дүн өөр өөр. ОТМШБ үүрхэйн талбайтай ойр ба хол байх газруудыг оролцуулан сумыг бүхэлд нь үнэлсэн; ХШБ Ундай голын ОТ өөрчлөлт хийсэн хэсгийн багахан газарт төвлөрөв. ОТМШБ нийт сумын хэмжээнд нийгэм-эдийн засгийн

¹ Энэ ажлын Ажлын Даалгаврыг http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/FINALENG_ToRfor_UndaiRiverDiversionComplaint_CA_OIEP.pdf сайтаас үзэж болно.

² Багийн гишүүд: Стив Баклей, Др. Сабине Шмидт.

³ http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/ExecutiveSummary_edit_Jan_30_2015-Eng.pdf

⁴ Энэ ажлын Ажлын Даалгаврыг http://www.cao-ombudsman.org/cases/document-links/documents/MDTEOI_ENGandMON.pdf сайтаас үзнэ үү.

⁵ Багийн гишүүд: Др. Ариелл Ахерн, Др. Б. Батбуян, Др. Жилл Шинклеман, Др. Трой Штернберг

түүвэр судалгаа явуулан, ургамалжилт, ус, тоосны шинжилгээ хийлээ. ХШБ Ундай голын бүст газар ашиглахад гарсан өөрчлөлтийн талаар малчдаас дэлгэрэнгүй ярилцлага авахад анхаарал хандуулсан. Хоёр багийн олж тогтоосон зүйлсийг ерөнхийд нь энэхүү Хураангуй Тайланд тусгасан ба нарийн дэлгэрэнгүйг дээр заасан дөрвөн тайлангаас үзэх хэрэгтэй. Энэхүү Хураангуй Тайлангаар БХОТ явцад авч үзсэн асуудлуудаарх ерөнхий ажиглалтууд, мөн БХОТ явцад гаргасан зөвлөмжүүдийн нэгдсэн жагсаалтыг танилцуулж байна.

2 Бэлчээр, малын усны чанар, хүртээмжийн үнэлгээ

2.1 Үнэлгээний хамрах хүрээ

ОТМШБ-ийн ажлын энэ бүрэлдэхүүн хэсэгт бэлчээр, малын усны чанар, хүртээмжийг үнэллээ:

- 2003 оноос хойш Ханбогд сумын бэлчээр, малчдын усанд гарсан өөрчлөлтүүд
- Эдгээрийн аль хэсэг нь ОТ-н улмаас учирсан, ирээдүйд ОТ-с учруулах нөлөөллүүдийг даах бэлчээр болон малын усны хүчин чадал
- Экосистемийг хадгалж/сэргээх, уламжлалт мал маллагааг үргэлжлүүлэн авч явахын тулд юу шаардлагатай болох.

2.2 Аргачлал

Байгаль орчны нөхцөл байдлыг үнэлэхийн тулд өргөн цар хүрээтэй хээрийн судалгаа явуулж, ОТ-н баримт бичгүүдийг үнэлэн, олон тооны хоёрдогч эх үүсвэрийг хянаж үзсэн болно.

Хийгдсэн ажлууд:

- Шинээр тоо баримт цуглуулах хээрийн судалгааны үеэр усны эх үүсвэрийн үнэлгээ, ургамалжилтийн хөндлөн огтлолын үнэлгээ, тоосны мониторинг, байгаль орчны ажиглалт (3,500 км газрыг хамарсан), мөн Манлай сумын мал маллагааны нөхцөл байдалтай харьцуулалт хийлээ.
- Хоёрдогч эх үүсвэрт уур амьсгалын мэдээ, ургамлын бүрхэвчийн түүхийг харуулсан хиймэл дагуулын алсын зайн тандалт, уур амьсгалын нэмэлт тоо баримт болон тоосны ажиглалт, ОТ-н болон зээлдүүлэгчээс заавал хийхийг шаарддаг тайлангууд, байгаль орчинтой холбоотой бусад холбогдох судалгаа, ажлууд, засгийн газрын мэдээлэл, ярилцлагууд орно.
- Байгаль орчин, малынн талаарх малчдын төсөөллийн судалгаа.

2.3 Дүгнэлтүүд

Ханбогд сумын мал маллагааны нөхцөл байдалд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлс байна: уур амьсгал ба байгалийн хүчин; малчдын ажиллагаа; засаг захиргаа, хувийн хэвшлийнхний шийдвэр ба авч буй арга хэмжээ, түүнчлэн ОТ-н үйл ажиллагаа. Эдгээр нь тус бүрдээ Ханбогд сумын малчдын бэлчээр, усны нөөцийн боломжид нөлөөлсөн эсвэл өнөө ч нөлөөлж байна гэж бид үзэж байна.

- Үндсэн хүчин зүйл нь Ханбогд сум жилдээ 95 мм хур тунадас унадаг, гэхдээ энэ нь жилээс жилд ихээхэн өөрчлөлттэй, хуурайшилтай цөлийн орчинд оршдог явдал. Малчид хүртэх боломжтой бэлчээр, усны нөөцийг гол төлөв уур амьсгал тодорхойлно. Ургамалжилт өөр өөр байдлын гол эх үүсвэр нь хур тунадас.
- Ургамалжилтийн алсын зайн тандалтын мэдээг хур тунадасны тоо баримттай харьцуулан үзэхэд хур тунадас болон түүнтэй холбоотой ургамалжилт, усны түвшин жилээс жилд ихээхэн өөрчлөлттэй байжээ.
- Бороо хурын хэмжээ болон малчдын ажиллагаанаас хамаараад зарим жилүүдэд зарим газарт бэлчээр, ус тун их ачаалалтай байдаг, гэхдээ малын тоо нийтдээ өсч байгаа нь тус суманд мал маллаж болоод байгааг илтгэнэ.
- Мал тоонд дүн шинжилгээ хийж үзэхэд зудын дараа өр нэмэгдэх гэх мэтээр мал маллагааны орчин, малчдын амьжиргаанд зуд ихээхэн нөлөөлдөг нь харагдаж байна.

- Малчдын ажиллагаа бас бэлчээр, усны нөөцөд нөлөөлж байна. Тухайлбал, 2003 оноос хойш малын тоо ихээхэн өссөнөөр тэр хэмжээний их ус, өвс ургамал шаардагдаж байгаа. Нэмж хэлэхэд хэд хэдэн хүчин зүйлийн улмаас нүүдэл багасч, сумын зарим бүсэд мал төвлөрчээ.
 - өрх тасарсан, сумын төвд ойрхон байх гм суурьшил
 - уст цэгийн орчимд мал бөөгнөрснөөр зарим бэлчээрийг талхалсан
 - худгийн засвар үйлчилгээ муу
 - зарим малчид усны эх үүсвэрийг цоожлох гэх мэтээр нөөцийг эзэгнэдэг
 - өвөлжөө эзэмшиж байгаагаа бэлчээрийг нь ашиглах эрхтэй гэж ойлгон тэр эрхээ хамгаалахад хэрэглэх
 - 200 км² бэлчээрийн газар эвдэгдсэн буюу ОТ-н дэд бүтэц, УЛТ, замуудад алдсан.

Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс өөрчлөгдөхийн хэрээр (машин тэрэг, зардал өсөх, боловсрол, үйлчилгээ авахын тулд сүм руу нүүх) Ханбогд сумын мал аж ахуй Говийн ба Монголын бусад сумдаас ялгаатай болж байна.

2003 оноос хойш Ханбогд сумын нөхцөл байдлыг малчид хэрхэн ашиглаж, ойлгож байгаад ихээхэн хувьсал гарсан гэж бид тогтоолоо. Ялангуяа ОТ-н уурхай байгаатай холбоотойгоор эвдэрч бутарч байгаа, тодорхой бус сэтгэгдэл газар авч; өөрийн болон бусдын ус, газар эзэмших эрхийн талаарх хүмүүсийн ойлголт өөрчлөгдөн, мал маллагаанд машин тэрэг ихээр ашиглан (үүний хамт бензин шатахууны зардал, бэлчээрийн нөлөөлөл), суурин орон байр барих болжээ. Нөөцөө хуваах маягаар газрыг хамтран ашигладаг уламжлалт барилаас өөрийн ашгийн төлөө бэлчээр, усыг дээд зэргээр ашиглах явдал руу шилжиж байна. Малын тоо өссөн, нүүдэл цөөрч/өөрчлөгдсөн, өрхийн болон хөдөлмөрийн зохион байгуулалт өөрчлөгдсөн зэргээс бэлчээрийн нөөцийн ачаалал нэмэгдэж, илүү их ус хэрэгцээтэй болсон байна. Нүүдлийн мал аж ахуйн арга барилд гарсан өөрчлөлт байгаль орчинд нөлөөлж буйг малчид хүлээн зөвшөөрч, тэдний гаргах шийдвэр нүүдлийн мал аж ахуй урт удаан хугацаанд оршин тогтноход нөлөөлнө гэдгийг ухамсарлан ойлгох хэрэгтэй.

Улсын, орон нутгийн засаг захиргаа болон бусад компаниуд төмөр зам барих, Таван Толгойн зам, Катарын зэрлэг амьтны хамгаалалтын газар гэх мэт мал аж ахуйд нөлөөлөх хөрөнгө оруулалт хийсэн. Үүн дээр нэмж хэлэхэд сумын засаг захиргааны байгууллагууд нүүдлийн мал аж ахуй, байгаль орчинд нөлөөлж буй хүчнүүдтэй учраа олоход хүчин мөхөсдөж байгаа бололтой. Сумын эрх мэдлээс давсан хүчин зүйлс хязгаарлагдмал төлөвлөлт, удирдлагатай хавсарснаар нүүдэллэх боломж олгохын тулд бэлчээрийг үр дүнтэй зохион байгуулах, худгийн засвар үйлчилгээ хийх, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг хүртээлтэй болгохын оронд сум үйл явдал өнгөрч, дарамт шахалт ирсэн хойно хариу үйлдэл хийдэг болжээ. 2015 онд батлагдсан сумын Мал Аж Ахуйн Салбарын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрт холбогдох асуудлууд тусгагдсан, түүний хэрэгжилтийг сайн дэмжих хэрэгтэй. Засаг захиргааны дутагдал нь орон нутгийн удирдлагын үүрэг болон үндэсний төр засгаас суманд тавих анхаарал бага байгаа зэргээр илэрч байна. Мал аж ахуйн зохион байгуулалт, сумын хөгжил зэрэг нь ОТ-н гэрээгээр хүлээсэн үүргээс ангид хэдий ч малчид, сум хэн хэн нь үнэндээ ОТ-н амыг харж, мөнгө горилох болжээ.

Өмнө нь ОТ-н хориотой бүс, дэд бүтцээс (УЛТ, нисэх буудал, замууд, усны шугам хоолой) малчдыг өөр тийш нүүлгэн төвөг учруулсан (ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 2 ба 3-т хэлэлцсэн). Одоогоор ОТ-с бэлчээр, ургамалд учруулж буй мэдэгдсэн шүүд нөлөөлөл хязгаарлагдмал.

Уурхайн газартай харьцах байдал сайн зохион байгуулагдсан, замаас гарч явахгүй байх зэрэг тодорхой стандарттай дүрэм журам баримталдаг. Байгаль орчинд учруулах нөлөөлөл нь ОТ-н зам дээрх хөдөлгөөнөөс малд учрах эрсдэл, Ханбогдын замд (хучилттай болгох ажил хийгдэж байгаа) ойр байгаа газрын тоос зэргийг хамарч байна.

Гэвч ОТ-н өмнөөс гаргасан 476 цооногийн улмаас гүехэн болон гүний усны ай сав хоорондоо холбогдсон байж болзошгүй нэлээд ноцтой асуудал байна. Мониторингийн суурь мэдээлэл дутмаг байгаа нь малчдын худгийн усны түвшинг (өрөмдлөг эхлэхээс өмнөх) өнөөгийнхтэй харьцуулж болохуйц урт хугацаанд хийсэн мониторингийн найдвартай мэдээлэл алга гэсэн үг. RPS Акуатеррагийн 2013 оны тайланд Гүний Хоолой орчмын хэдэн худгууд нөлөөлөлд өртөж болзошгүй гэсэн байдаг. Цооногийн барилгын анхны аргачлал, бүртгэл мэдээ тааруу байсны улмаас нэвчилтийг эргэлзээгүй үгүйсгэх боломжгүй. Олон малчин тэдний усны нөөцөд хохирол учирсанд сэтгэл нь зовж байна. Ус алдаж буй 9 цооногийг тодорхойлж, одоо ОТ асуудлыг шийдэхээр ажиллаж байгаа ба энэ нь сумын хаа нэгтээ ингэж хоорондоо холбогдсон байх өчүүхэн ч гэсэн магадлалтайг харуулж байгаа юм. Усан хангамжийн тодорхойгүй байдал нь усны мониторингийг байнга хийх хэрэгтэйг тодотгож байна.

2.3.1 Мониторинг

ОТ орон нутгийн бодит байдал болон нийгмийн орчны талаар хэсэгчилсэн мэдлэгтэй, гүний ус, бэлчээрийн менежмент гэх зэрэг олон ажлыг өөрсдийн зүгээс хязгаарлагдмал хяналт эсвэл оролцоотойгоор суманд байдаггүй этгээдүүдтэй гэрээлж хийлгэжээ. Үүний улмаас ОТ-д байгаль орчны асуудлаар нэгдсэн арга барил дутмаг, байгаль орчны мониторингийг бэлчээрийн менежментийн үйл ажиллагаатай бүрэн уялдуулахгүй байна. Ажилтнууд нь өөрийн хариуцсан зүйлийг мэддэг ч нэгдмэл арга ажиллагаа байхгүй. Үр дагавар нь бөөн мэдээлэл, ядмаг тайлбар эсвэл нотолгоо, үр ашиг муутай харилцаа, орон нутгийн иргэдийн итгэл доогуур. Суманд бэлчээрийн мониторингийг зохих ёсоор хийх цаг зав, хүн хүч байхгүй ч зарим ажлыг сум руу шилжүүлсэн. Мөн нүүдлийн мал аж ахуйг сайжруулахын тулд малчдын нөхөрлөл байгуулах талаар гаргасан хүчин чармайлтын үр дүнг харуулсан баримт алга.

2.3.2 Тоос

Одоогийн байдлаар ОТ (замууд), орон нутгийн иргэдийн (шороон замууд) бий болгосон тээврийн хонгилуудаас өөрөөр тоосноос байгаль орчинд учруулж буй томхон нөлөөлөл алга байна. Сумын тоосжилтийн дээд хэмжээ 2010 онд дээд цэгтээ хүрч байсан, одоо ерөнхийдөө гайгүй; тодорхой цэгүүдэд, гол төлөв Ханбогдын зам дээр, зам дагуу тоос босч байгаа ч тархалт нь хязгаарлагдмал, замын хучилт хийгдэж дуусахаар тоос босохгүй болно. Хөдөлгөөнд ОТ-н болон ОТ-н бус машин тэрэг оролцдог, тэгэхээр ОТ орон нутаг дахь замын тоосыг бүгдийг биш нэг хэсгийг нь гаргаж байна. Бас суманд хаа сайгүй байх малчдын машин тэрэг явдаг шороон замуудаас тоос босдог.

2.3.3 Ерөнхий

Ерөнхийдөө, асуудал байгаа хэдий ч – тухайлбал усны ай савын хоорондын холбоо - мониторинг зэрэг - Ханбогд сумын малчдын бэлчээр, усанд учирч буй үндсэн нөлөөллүүд нь ОТ-оос өөр эх үүсвэрээс үүдэлтэй гэж бид дүгнэж байна. Малчдын ашиглаж буй усны зарим эх үүсвэрийг ОТ засч, дахин барьж өгснийг сайшаан хүлээн зөвшөөрөх явдал бага байв. Бэлчээрийн мал аж ахуйн үр дүнтэй засаглал дутмагаас засгийн газрын үүргийг ОТ-гоор гүйцэтгүүлэхээр хардаг болсон байгаа нь Манлай сумаас тод ялгарч байна.

2.4 Зөвлөмжүүд

Бэлчээр ба усны дүн шинжилгээнд үндэслэн доорх дүгнэлт, зөвлөмжүүдийг бид гаргаж байна.

Бэлчээрийн тухайд:

- Малчид ба сумын захиргаанаас гаргасан шийдвэр нь бэлчээр ашиглалт, хуваарилалт, нягтралд ихээхэн нөлөөлж байна. Зарим газрын бэлчээрийн ашиглалт хэт өндөр байгаа байдлыг өөрчлөгдтөл засаг захиргааны зүгээс малчид уламжлалт байдлаар нүүдэллэх, ус, бэлчээрийг чөлөөтэй хүртэх, худаг, бэлчээрт малчид хориг тавьдагыг багасгахыг хөхүүлэн дэмжих талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай. Уламжлалт мал аж ахуйг үр ашигтай эрхлэх түршлагыг сурталчилах, малын бэлчээрт зориулан шинэ газар нутаг гаргаж өгөх зэргээр сум идэвхтэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэй. Ашиглаагүй бэлчээрийн газар их байна, тухайлбал хойд, зүүн, урд зүгийн нутаг дэвсгэрт устай бол бүтээмжтэй байх газрууд байна; үүнд Онцгой хамгаалалтын бүсүүд ороогүй болно. Малчны эзэмшлийн эрхийн тодорхойлолт (өвөлжөө, хаваржааны бууц, худгууд гм.) болон бусад малчид газар, худгийг ашиглахын тухайд эдгээр эрх нь ямар утгатайг тодорхой болгох шаардлагатай.
- Ханбогдын замыг хучилттай болгосноор (одоо ажил нь явагдаж байгаа) замын хонгил дагуух тоосны асуудал шийдэгдэнэ, төлөвлөснөөрөө 2017-18 онуудад барьж дуусгах хэрэгтэй.
- ОТ-н зам дээрх хөдөлгөөний хурдыг багасгахын тулд малын гарамуудын хоёр талд нь хурд сааруулагч хийж өгөх шаардлагатай. Ялангуяа барилгын ажил нэмэгдэн, үйлдвэрлэл ихсэх үед тун чухал; энэ нь бэлчээр хуваагдлын үр дагаврыг бууруулна.
- ХШБ-ийн тайланд дурьдсан УЛТ-н зүүн хойд талд газар хуваагдсан асуудлыг нийтийн нөхөн олговроор шийдэж болох юм.

Усны тухайд:

- Гүехэн болон гүний усны ай савууд хоорондоо бага ч гэсэн холбоотой байж магадгүй нь малчдын устай холбоотой тулгамдсан асуудал бөгөөд ОТ үүнийг бууруулах шаардлагатай. Одоо байгаа тохиолдлууд энэ асуудал нийт сумын асуудал болохыг тодотгож байна. Нийтийн нөхөн олговрын (дор дурьдсан) хүрээнд сумын хэд хэдэн газарт ялангуяа бэлчээртэй ч худаггүй газарт гүехэн гар худгууд барихыг бид ОТ-д зөвлөж байна. Худгууд гүехэн (гүний биш), бөх, эдэлгээтэй, нийтэд хүртээмжтэй, түгжээгүй байх хэрэгтэй бөгөөд ОТ-оос малчдад саяхан барьж өгсөн бетонон гүехэн худгуудыг санал болгоё. Үүний зорилго нь:
 - 4 багийн нутагт шинээр нэмж бэлчээр нээн өгч, малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг хөхүүлэн, тэдэнд уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломж олгох.
 - ашиглагдаж байгаа бэлчээрийн бүст хэрэглэж болох усны цоорхойг нөхөх.
- ОТ-н усны нөөцөд учруулсан нөлөөллийг бууруулах, ОТ-н улмаас газар хуваагдсан, сумын дэд бүтцийн хязгаарлагдмал зохион байгуулалт, малчдын газар ашиглалтын оновчгүй төлөвлөлт зэргийг багасгахын тулд сум ба ОТ энэ хөтөлбөрт хамтран ажиллах шаардлагатай. Сумын зүгээс малчдын бэлчээрт хүрэх боломжийг өргөжүүлэн, бататгаж өгөх хэрэгтэй.
- Шинжээчид бидний бодлоор энгийн, бат бөх загвартай, нэгж өртөг багатай гар худгууд нь өндөр өртөгтэй, нарийн загвартай худгаас илүү үнэ цэнэтэй бөгөөд ус, бэлчээрийн хүртээмжийг улам нэмэгдүүлэх боломж олгоно. ОТ-гоос 2007, 2010 онд хийлгэсэн тайланд 320 орчим гар худаг байна гэсэн; тэр үеэс хойш малын тоо ихээхэн өссөн. Холын бэлчээр рүү нүүх явдлыг хөхүүлэхийн тулд гидрологийн судалгаанд тулгуурлан

75-с дээш тооны худаг барихыг бид санал болгож байна. Бог малын нүүдлийг хангахын тулд хэд хэдэн худаг гаргах; тэмээний бэлчээрт худгууд холхон зайтай байж болох юм.

- Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршлыг гүний усны судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай. Нийт малчдад аль болох их бэлчээрийн боломж олгохын тулд байршлийг сумтай хамтран тогтоох. Нийтийн нөхөн олговрын өмнөх цоорхойг худгууд нөхөх болно.
- Малчид нүүдлээ хийн, өөр шинэ бэлчээр ашиглах явдлыг сайжруулахын тулд худгуудыг 4 багийн нутагт тараан гаргах хэрэгтэй.
- Аллювын уст давхаргын мониторинг, загварчлалыг газар зүйн хувьд тараан байрлуулсан цэгүүд дээр хийх, мөн ОТ-н одоо ба ирээдүйн нөлөөллийг тоон үзүүлэлтээр харуулах, аллювын нөөцөд чиглэсэн гидрологийн судалгаа явуулахыг зөвлөө. Ингэснээр малчид хараат байдаг гүехэн гүний усны динамикийн талаар илүү сайн ойлголттой болж, загварчлалыг сайжруулан, ирээдүйд усны нөөцийн өөрчлөлтийг хэмжиж чаддаг болно.
- Малчдыг усаар хангаж байгаа нь түр зуурын арга хэмжээ бөгөөд тэднийг бусдаас хамааралтай, санаа түгшсэн (больчих болов уу, хэзээ зогсоох бол хэмээн малчдын сэтгэл зовдог) байдалд оруулсан, урт хугацаанд тогтвортой байж чадахгүй тул аажмаар болих нь хэрэгтэй. Тодорхой хугацаа тохироод, одоо ус зөөж өгч байгаа газруудын усны нөөцөд үнэлгээ хийлгэх; хэрэв ажиллагаатай худаг тэнд нь байгаа бол хөтөлбөрийг зогсоох; худаггүй бол санал болгож буй худаг барих хөтөлбөрийн хүрээнд нэгийг барьж өгөх нь зөв.
- Суманд одоо байгаа малчдын худгууд болон дээр санал болгосон худгуудад засвар үйлчилгээ хийх сайн систем хэрэгтэй. Нөхөн олговрын цоорхойг нөхөх нийтийн нөхөн олговрын хөтөлбөрийн нэг хэсэг энэ байж болно гэж бид үзэж байна.
- Усны суурь мэдээлэл дутмаг байгаа нь хугацааны туршид усны нөөцөд гарсан өөрчлөлтийг тодорхойлох боломжгүй болгож байна.
- Усны тайлан, мэдээг нутгийн иргэдэд ил тод мэдээлэхгүй байх ямар нэгэн шалтгаан бид олж харсангүй.

Мониторинг болон ОТ, малчид, сумын засаг захиргаа хоорондын харилцааны тухайд:

- Малчид болон бусад хүмүүст үнэмшилтэй, найдвартай, урт хугацааны мэдээ мэдээлэл гаргахын тулд малчдын худаг, тоос, бэлчээр/ургамлын байгаль орчны мониторингийн хөтөлбөрүүдийг дахин боловсруулж, шинээр зохион байгуулах шаардлагатай. Оролцоо хангахын тулд хөтөлбөрүүд мал маллагааны хэв маягт тохирсон, малчид хянан баталгаажуулах боломжтой байвал зохино. Хөтөлбөрт малчдын худгийн ус (тоо ба чанар), тоос, ургамал/бэлчээрийн чанарын асуудлыг хамарч, хатуу шинжлэх ухаанч байдал, итгэл үнэмшлийг хангасан, хүртээлтэй байлгахын тулд баримт хамтран олж тогтоох аргачлалыг ашиглан хэрэгжүүлэх; мониторингийг гадагш нь гэрээлж хийлгэж байгааг больж, орон нутгийн мониторингоор солих шаардлагатай.
- ОТ мониторингийн тайлан мэдээ, түүний үндсэн дээр авсан эсвэл санал болгосон аливаа арга хэмжээг байнга тайлагнан, малчид, орон нутгийн иргэдэд тогтмол танилцуулж байх; одоогийн харилцаа холбоо хангалтгүй байна. Мэдээлэл шууд, ойлгомжтой, малчидтай холбоотой; сумд өгөх тайлангууд мэргэжилтнүүдэд ойлгогдохоор байх хэрэгтэй. Австралийн Пилбард хэрэглэсэн ⁶ тоосны бодит цагийн мониторинг гэх мэт Рио Тинтогийн ашигладаг аргуудыг Ханбогдод хэрэглэх нь зөв. ОТ

⁶ riotinto.com/documents/FAQ_air_quality_monitoring.pdf

илэрсэн зүйлийн талаар бүх багийн төв, сумын төв дээр танилцуулж байх шаардлагатай. Мониторингийг амжилттай хэрэгжүүлэхэд малчдын зүгээс чин сэтгэлээсээ оролцох явдал тун чухал бөгөөд үйл явцад гүйцэтгэх малчдын үүрэг хариуцлага мөн.

- Ургамлын мониторингийг явуулахад хашаалсан талбайг санал болгож байна. Үүнийг малчид, сумын албан тушаалтнуудтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй.

Газар ашиглалтын тухайд:

- Шинэ дэд бүтэц, магадгүй бусад уурхайнууд болон эрдэс баялаг олборлохтой холбоотойгоор Ханбогд суманд одоо болон ирээдүйд газрын эрэлт хэрэгцээ их гарахаар байна. Өнөөгийн байдлаар эдгээр бүтээн байгуулалтуудаас учирч буй асуудлуудыг шийдвэрлэх хүчин чадал, эрх мэдэл сумын засаг захиргаанд дутмаг. Газар ашиглалт, хөдөөгийн амьжиргааг хамгаалах цогц стратеги яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр өөрчлөлтийн хүрээнд малчдын амьжиргааг тогтвортой байлгахын тулд ОТ ба түүнд зээл олгогчид (ялангуяа Дэлхийн Банкны группийн нэг бүрэлдэхүүн ОУСК) өөрсдийн харилцаа холбоо, мөн үндэсний ба орон нутгийн засаг захиргаа, гадны (олон улсын) агентлагуудтай ажиллаж байсан туршлагаа сумын түвшний стратеги, төлөвлөгөө боловсруулахад дайчлахыг хүсч байна.

Нийтийн нөхөн олговор:

- Уст давхаргын хоорондын холбоо, газар хуваагдал зэргийг хамруулан ОТ-н нөлөөллүүдийг орон нутгийн нөхөн олговроор дамжуулан засч залруулахыг санал болгож байна. Ялангуяа, байршил тогтоох гидрологийн судалгаа хийгдсэний дараа хэд хэдэн гүехэн гүний худаг барих хөтөлбөрийг ОТ сумтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй. Худгуудыг сумын хойно, зүүн, өмнө талд буй ашиглалт багатай газруудад байршуулах, ингэснээр боломжит шинэ бэлчээр, мал хариулах газар гаргаж, уламжлалт мал аж ахуйг дэмжин, ус, бэлчээрийн асуудлыг шийднэ. Энэ нь суманд уламжлалт мал аж ахуй эрхлэх боломжийг хангах, нутгийн иргэдэд өгөөжтэй нийтийн нөхөн олговроор ОТ-н ерөнхий нөлөөллүүдийг шийдвэрлэх явдал юм.

3 Өнгөрсөн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн дүн шинжилгээ

3.1 Хамрах хүрээ

ОТМШБ-ийн ажлын энэ бүрэлдэхүүн хэсэг нь дараах асуудлуудыг хамран явуулсан нийгэм-эдийн засгийн судалгаа байв:

- 2003 оноос өнөөг хүртэл малчин өрхүүдийн амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд, уламжлалт амьжиргаа, соёл хэр алдагдсан.
- Малчин өрхүүд дараагийн үедээ уламжлалт амьжиргаагаа тогтвортой өвлүүлэх чадамж.
- Ямар нөлөөллүүд ОТ-с шалтгаалсан болох.

3.2 Аргачлал

Судалгаагаар баримт бүчгүүдийг хянан үзэж, 2016 оны 5 сараас 7 саруудад хийсэн хагас бүтэцтэй ярилцлага ба оролцогчийн ажиглалтыг хослуулсан нийгэм-эдийн засгийн судалгааг сумаас түүвэрлэсэн 106 малчин өрхийг хамран явуулж; багийн төвүүдэд зорилтот бүлгийн уулзалт; сумын төвийн оршин суугчид, ОТ, сумын засаг захиргааны төлөөлөлтэй хэлэлцүүлэг уулзалтууд хийсэн болно. Манлай суманд хийсэн ярилцлагууд ОТ-с шууд нөлөөлөл учраагүй жишиж болохуйц бүстэй харьцуулах боломж олгосон.

3.3 Дүгнэлтүүд

Судалгаагаар 2003 оноос хойш Ханбогд сумын малчдын амьжиргаанд гарсан өөрчлөлтүүдийн гол хүчин зүйлсийг тогтоолоо. Үүнд:

- бүс нутагт том хэмжээний уурхайнууд нээгдсэн, цаашид уул уурхайн олборлолт хийх лиценз олголт;
- мал маллагааны арга барил, түршлагад гарсан материаллаг өөрчлөлтүүд
- өрхийн болон хөдөлмөрийн шинэ хэлбэрүүд зэрэг нийгмийн өөрчлөлтүүд
- малын тооны өсөлт, ус ба бэлчээрийн ачаалал
- малчин өрхийн зохион байгуулалтанд нөлөөлсөн засгийн газрын бодлогын өөрчлөлт.

Уламжлалт амьжиргаа, соёл алдагдсан тухайд бидний олж тогтоосон зүйлс нь нийгэм- эдийн засгийн сонголт болон хүүхдүүд бага наснаасаа мал маллагааны аргад суралцах боломжийг багасгахад хүргэсэн хүүхдийн сургуульд ойртох гэх мэтэд үндэслэсэн малчин өрхийн бүтэц зохион байгуулалтын шинэ хэв маягтай холбоотой алдагдлыг харуулсан бусад судалгааныхтай таарч байна. Үүний зэрэгцээ дэд бүтцийн бүтээн байгуулалт болон газар эзэмших, ашиглах шинэ хэв маягийн улмаас бэлчээр, усны ачаалал ихсэн уламжлалт зан заншил алдагдсан гэж бид тогтоолоо. Мал аж ахуйн гаралтай өрхийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүн багасч, цалинтай хөдөлмөр эрхлэх, орлого бий болгох үйл ажиллагаанд илүү анхаарах болсон нь бидэнд мөн ажиглагдав.

Малчид уламжлалт амьжиргаагаар тогтвортой авч явахын тухайд эдийн засаг, байгаль орчны баталгаагүй байдлын улмаас дараа үеийнхэн нь малчдын амьжиргааг үргэлжлүүлэхийг бүх малчид тэр болгон хүсэхгүй байгааг судалгаа харуулж байна. Хүсч буй хэсгийн хувьд үүнийг боломжтой болгохын тулд Ханбогдод тодорхой бэрхшээлүүд байгааг шийдвэрлэх шаардлагатай. Гол асуудал нь ганц уул уурхай ч бус мөн уурхайтай холбоотой болон бусад дэд бүтэц, түүнчлэн малчдын бэлчээр, худаг эзэмших, нүүдэллэх уламжлалт эрхийг хамгаалах засаглалын тодорхой бүтэц дутмаг байгаа явдал юм.

ОТ ийм дарамт бий болоход хувь нэмрээ оруулсан гэлээ ч цорын ганц эх үүсвэр биш гэж бид тогтоолоо. ОТ-н нөлөөлөл дараахийг хамарна, үүнд: байнгын болон түр ажлын байраар дамжуулан малчдын уламжлалт амьжиргаанд өөр хувилбар бий болгосон, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговрын хөтөлбөр хэрэгжүүлснээр өрхүүдийн хооронд болон тэдгээрийн дотоодод тэтгэмж, өвөлжөө бүүцны байршилтай холбоотой зөрчил, хурцадмал байдлыг санамсаргүй үүсгэсэн. Ундай гол, Бор Овоон задгайн шууд нөлөөлөл, түүнчлэн олон тооны цооног, худаг үхсэн нь малчдын ус ашиглах хэв маягийг өөрчилжээ. Шинэ өвөлжөө бүүцны байршил сонгох уламжлалт заншлыг дагалгүйгээр нүүлгэн шилжүүлсэн малчдын өвөлжөө бүүцыг Гавилуудад барьсан нь газрын эрх, амьжиргааны хэтийн төлөв баталгаагүй гэсэн бодол төрүүлэхэд хүргэжээ. ОТ ийм дарамт бий болоход хувь нэмрээ оруулсан хэдий ч цорын ганц эх үүсвэр бол биш гэж бид тогтоолоо. Орон нутгийн засаг захиргааны бүтцийн нэг хэсгийн хувьд орон нутгийн асуудлыг сүм шийдвэрлэх үүрэгтэй. Гэхдээ ОТ бол үндэсний болоод орон нутгийн засгийн газартай зөвшилцсөн, тэдэнд тайлагнадаг төсөл билээ. Усны хүрэлцээтэй холбоотой гол асуудлуудыг шийдвэрлэхэд үндэсний засгийн газрын оролцоо дутмагаас орон нутгийн малчдын дунд ОТ бүх асуудлыг шийдэж чадна, шийдэх ёстой хэмээх хүлээлтийг бий болгожээ.

3.4 Зөвлөмжүүд

ОТ засч залруулбал зохих тодорхой асуудлууд байна. Үүнд малчидтай идэвхитэй харилцах, 2004 ба 2011 онд малчид орхигдсон нөхөн олговор (Бүрэлдэхүүн 3 тайланг үзнэ үү), малчдыг

тогтвортой амьжиргаанд шилжүүлэх талаар засгийн газар болон орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах, сумын засаг захиргаатай мэдээллээ идэвхтэй хуваалцах, сумын засаг захиргааны чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх зэрэг багтана.

Малчидтай харилцахтай холбоотой тусгай зөвлөмж:

Орон нутгийн харилцааны багийг өргөжүүлэх. Багийг ОТ ба малчдын (мөн орон нутгийн бусад иргэдийн) хооронд хоёр талын үр дүнтэй харилцаа бий болгох үүрэг бүхий, бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдүүлэх. Үүнд мөн албан ёсны уулзалтуудад оролцох, жишээ нь багийн хуралд суух, орон нутгийн захиргаа болон сонгогдсон албан тушаалтнуудтай ойр холбоотой байх; 'эмзэг' гэж тогтоогдсон хүмүүсийг оролцуулан хэрэгжиж буй нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан хүмүүстэй байнгын холбоотой байх, цаг зав гарган сумын хэмжээгээр явж, хүмүүстэй албан бус харилцаа тогтоох зэрэг орно.

ОТ-н үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээллийг (ялангуяа барилгын ажлын үеэр, УЛТ-н гадна ажиллаж буй гэрээт байгууллагуудын үйл ажиллагаа, хэн хаана юуг хэдий хугацаагаар хийж буй, хүмүүсийг ажилд яаж авч байгаа гэх мэт) малчид, орон нутгийн бусад иргэдэд хүргэх, мэдсэн сонссон асуудлуудаа эргэж удирдлагадаа танилцуулж байхын тулд орон нутгийн харилцааны ажилтнууд ОТ компани дотроо маш сайн харилцаа холбоотой байх хэрэгтэй.

ОТ өнгөрсөн оныхоо гүйцэтгэл, ирэх оны төлөвлөгөө, орон нутгийн эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл - ажил олголт, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутгийн худалдан авалт; байгаль орчны нөлөөлөл - байгаль орчны нөлөөллийн мониторинг ба менежментийн хөтөлбөрүүд холбогдох тоо баримт; нийгмийн гүйцэтгэл - нөхөн олговрын хөтөлбөр, эмзэг хүмүүст тусалсан байдал, сургалт, бизнес эрхлэлт, Хамтын ажиллагааны гэрээний төслүүд, хандив зэргийг хамарсан тайлан мэдээллийг жил бүр гаргаж байхыг бид бас санал болгож байна. Үүнийг Монгол хэл дээр, малчдад хүртээлтэй хэлбэрээр гаргах нь зүйтэй.

4 Нөхөн Олговрын Хөтөлбөрийг Хянасан нь

4.1 Хяналтын хамрах хүрээ

Нөхөн олговрын хөтөлбөрийг хянаж үзэхдээ ОТ-н нөлөөлөлд өртсөн малчдад олгосон нөхөн олговрыг судаллаа. Ингэхдээ ажлын даалгаварт тодорхойлсон дараах асуудлуудыг авч үзсэн болно. Үүнд:

1. 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцад ашигласан нөлөөллийг үнэлэх аргачлал нь зохистой, хангалттай байсан эсэх;
2. ОТ өөрийн хэрэгцээний дэд бүтэц, байгалийн баялаг ашигласан зэргийг оролцуулан ОТ-н улмаас учирсан сөрөг нөлөөллүүдийг хангалттай нөхөн төлсөн эсэх;
3. Олгосон нөхөн олговор нь тогтвортой амьжиргаанд шилжихэд хангалттай байсан эсэх;
4. Нөхөн олговор авбал зохих бүх малчдад нөхөн олговор олгосон эсэх;
5. Нөхөн олговрын үйл ажиллагаа нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн 5-р стандартад нийцсэн эсэх.

Шинжээчдийн баг ажлаа эхэлсний дараа ГТЗ дэх малчдын бүлэг хүсэлт гаргасны дагуу нөхөн олговрыг хянахдаа дараах зүйлсийн талаар зарим нэг дүн шинжилгээг хамруулсан болно. Үүнд:

- Нүүлгэн шилжүүлэлтийн улмаас өндөр настай малчдад учирсан сэтгэл санааны хохирол

- Нөхөн олговрын гэрээний хоёр тусгай заалтын утга учир
- Эмзэг хүмүүст учруулсан нөлөөллийн үнэлгээ
- Биет бус соёлын өвд учруулсан хохирлын нөхөн олговор.

4.2 Аргачлал

Нөхөн олговрын хөтөлбөрийг хянаж үзэх аргачлалыг ГТЗ-тэй хэлэлцэн тохирсон болно. Үүнд:

- ОТ-н холбогдох бичиг баримтуудтай танилцах, ялангуяа нөлөөллийн үнэлгээнүүд, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон түүнтэй холбоотой баримт бичгүүд, нөхөн олговрын гэрээнүүд;
- ОТ, ГТЗ, малчид, сумын албан тушаалтнуудтай уулзах;
- Малчдын бэлчээр, усны чанар, хүртээмжийн үнэлгээгээр тогтоосон зүйлсийг нэгтгэх_ өнгөрсөн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтөнд дүн шинжилгээ хийх;
- Нөлөөллийн үнэлгээнүүд зохих ёсоор хийгдсэн эсэх, урьдчилсан тохирсон шалгуурын үндсэн дээр ОУСК-ийн ГС5-тай нийцэж буй байдал.

4.3 Дүгнэлтүүд

Нөхөн олговрын хөтөлбөрийг хянаж үзээд, ГТЗ-өөс тодорхойлсон асуудлуудаар дараах дүгнэлтэнд хүрлээ (Олж тогтоосон зүйлсийг бүрнээр нь Нөхөн Олговрын Хөтөлбөрийг Хянасан Тайлангаас үзнэ үү.)

- 2004 оны нөхөн олговрын хөтөлбөрт зориулан хийгдсэн нөлөөллийн үнэлгээ нь малчдад учруулах нөлөөллийг бууруулах үндэслэл болохоор хангалттай байж чадаагүй. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө байгаагүй.
- 2011 оны нөхөн олговрын үндэслэл болсон судалгаанууд, нөлөөллийн үнэлгээнүүд, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө дийлэнх нь зохистой, хангалттай байсан байна. Нөлөөллийн бүсийг тогтоох тал дээр дутагдалтай байснаас нөлөөлөлд өртсөн зарим малчдыг тодорхойлоогүй, мөн нөхөн олговрын багцын элементүүд тогтвортой байж чадаагүй гэх мэт сул талууд байна.
- 2012 оноос хойш төсөлд гарсан өөрчлөлтүүд, бүтээн байгуулалтуудыг одоо байгаа нөлөөллийн үнэлгээнд хамруулаагүй.
- ОТ-гоос бэлчээрт учруулсан нөлөөллийн тухайд ОТ-н улмаас бэлчээрт учирсан сөрөг нөлөөллийн дийлэнхийг ОТ зохих ёсоор нөхөн төлсөн.
- Усны тухайд ОТ (ялангуяа үйл ажиллагааг өмнө нь явуулж байсан АММИ) аллювын ай савууд болон малчдын ашиглаж байсан худгуудын суурь мэдээлэл гаргаагүй буюу загварчлалыг хийгээгүйгээс малчид өөрсдийнх нь хэрэглэх ус ОТ-н улмаас багассан хэмээн буруутгаж байгааг няцаах боломжгүй. Түүнчлэн ОТ ажлаа эхэлснээс хойш бусад хүчин зүйлүүд өөрчлөгдсөн, малчдын малын тоо толгой мэдэгдэхүйц өссөн нөхцөлд найдвартай суурь мэдээлэлгүйгээр нөлөөллийг нь батлах боломжгүй.
- Нөлөөллийг тодорхойлох аргачлал дулимаг байсан гэдэг нь 2004 ба 2011 онд нөхөн олговор олгогдсон байвал зохих зарим малчид байна гэсэн үг. Үүнд өвөлжөөний лицензтэй малчдад нөхөн олговор авах эрх олгосон шиг хаваржаатай эсвэл бэлчээр, ус ашиглаж байсныг нь нотолж болохуйц (гэхдээ лицензгүй) малчид; нөхөн олговрын эрх олгох тиг шугамны гадна гэхдээ нөхөн олговор авсан малчидтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсан малчид, түүнчлэн ОТ-н нүүлгэн шилжүүлэлтийн улмаас өөрсдийнх нь

ашиглаж байсан нутагт нүүлгэн шилжүүлэгдсэн хүмүүсийн улмаас амьжиргаа нь хохирсныг баталж чадах аливаа малчид орно.

- Ханбогд сумын малчид хагас-нүүдэлчид (жилийн түршид нэг газраас нөгөө рүү нүүх янз тоо нь янз бүр). ОТ-н авсан газар хэдийгээр томоохон ч Ханбогд сумын бэлчээрийн газрын бага хувийг эзэлдэг. Тиймээс зарчмын хувьд ОТ байсан ч малчид малаа үргэлжлүүлэн малласаар байх боломжтой. 2004 ба 2011 онд малчдад олгосон нөхөн олговор нь малаа үргэлжлүүлэн маллах явдлыг дэмжих элементүүд болон малчдын үр хүүхдэд ажлын байр, боловсролын дэмжлэг үзүүлэх нөхөн олговор зэргийг багтаажээ. Энэ бол зөв арга гэж бид үзэж байна.
- Гэвч бодит байдал дээр нөхөн олговор нүүлгэн шилжүүлсэн бүх малчдыг тогтвортой амьжиргаанд шилжүүлэхэд тус болж чадаагүй (2011 оны нөхөн олговрын аудит хийгдээгүй байгаа хэдий ч). Орлуулан өгсөн өвөлжөө, хашаа хороо; нөхөн олговрын нэг хэсэг болох ажлын байр, мал аж ахуйтай хамаатай эс хамаатай жижиг бизнес эрхлэх гэх мэт нь асуудалтай байна. 2004 онд нөхөн олговроор байнгын ажлын байртай болсон өрхүүдийн талаас илүүд нь одоо ажилтай хүн байхгүй; эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтэнд өртсөн олон өрхүүдийн нэлээд нь 5-хан жил хийлгэхээр санал болгосон, одоо дуусах хугацаа нь дөхөж буй хагас цагийн ажлын цалингаас хамааралтай болжээ.
- 2004 оны нөхөн олговрын үйл явц ОУСК-ийн 2012 оны Гүйцэтгэлийн Стандарт 5-тай олон зүйлээр нийцээгүй.
- 2011 оны нөхөн олговрын үйл явц нэлээд сайжирсан хэдий ч тодорхой, хяналт тавьж болохуйц Амьжиргаа Сэргээх Төлөвлөгөө байхгүй тул нийцэхээргүй; нууцлалын тухай зохисгүй заалт оруулсан. Түүнчлэн 2015 онд нэмэлт хийсэн гомдлын механизм нь хөндлөнгийн механизмд гомдол гаргах заалтгүй.

Ажил эхэлсний дараа малчдаас тавьсан асуудлуудын тухайд бид дараах дүгнэлтэнд хүрлээ:

- ОТ болон бусад төслүүдийн улмаас амьдралд нь өөрчлөлт орсонд сумын нийт малчид уурлан, цухалдаж буйгаа илэрхийлж, эдгээр өөрчлөлтөнд нөлөөлөх хүчгүй гэгцгээж байв. Зарим малчид, ялангуяа настай хүмүүс яаж цөхөрч арга ядаж буйг бид харсан. 2004 нүүлгэн шилжүүлэлт малчид, ОТ-н хооронд үл итгэлцэл бий болгосон нь өнөө ч хэвээрээ байна.
- 2011 оноос хойш ОТ эмзэг бүлгийн хүмүүсийн ялгаатай нөлөөллийн асуудлыг авч үзэж эхэлсэн бөгөөд эмзэг байдлын талаар авсан арга хэмжээнүүд нь тохиромжтой байна. Гэвч хэрэгжилт, үр дүнгийн талаар мэдээлэл дутмаг.
- 2011 оноос ОТ биет болон биет бус соёлын өвийн нөлөөллүүд, тэдгээрийг зохих ёсоор болгоомжтой, хамтран ажиллах замаар зохицуулах хэрэгтэйг тодорхойлсон нь зохистой байна. Харин хэрэгжилтийн талаар мэдээлэл бидэнд бага байсан ба Бор Овоогийн шүтлэгт газарт учирсан нөлөөллийн тухайд хүмүүс санаа зовж буйгаа нийгэм-эдийн засгийн судалгаанд илэрхийлсэн байв. Соёлын өвийн талаарх өргөдөл гомдлыг гомдлын механизмаар авч үзэх ёстой. Тэдгээр нь нөхөн олговрын асуудал биш.

4.4 Зөвлөмжүүд

Нөлөөллийн үнэлгээнд ОТ-н төлөвлөж буй бүх бүтээн байгуулалтыг хамрахын тулд:

- ОТ далд уурхайн төсөлтэй холбоотой нэмэлт нөлөөллийг (ба нөлөөллийг бууруулах арга хэмжээ); тодорхойлж зөвлөлдөхийн тулд ажлаа эхлэхээс өмнө нэг эсвэл хэд хэдэн нэмэлт БОННУ-ний үр дүн; эрчим хүчний гэрээ; ажиллах хүчний орон байрны төлөвлөгөөнд орсон өөрчлөлт; төмөр замын барилгын ажил; Ханбогд сум ОТ

хоорондын замын хучилт; 2012 оны БОННУ гарснаас хойш төсөлд гарсан томхон өөрчлөлтүүд болон бусад дэд бүтэц, уул уурхай/газрын тосны төслийн улмаас үүсэх хуримтлагдах нөлөөллийн дүн шинжилгээний талаарх сүүлийн үеийн мэдээллийг ОУСК-ийн стандартын дагуу олон нийтэд ил тод мэдээлэх хэрэгтэй.

2004 ба 2011 оны нөхөн олговрын цоорхойг нөхөхийн тулд:

- ГТЗ 2004 ба 2011 оны нөхөн олговорт хөөн хэлэлцүүлж оруулах нэхэмжлэлийн талаар санал гаргах Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо (НОНХ) байгуулах хэрэгтэй.
- 'Зөвлөмжүүд: Нөхөн Олговор' хэсгийн жагсаалтанд заасан малчид Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороонд нөхөн олговор хүсч нэхэмжлэл гаргах эрхтэй.

Малчид тогтвортой амьжиргаанд шилжихэд нь нөхөн олговор тус нэмэртэй байхыг баталгаажуулахын тулд:

- 2004 онд нөхөн олговор авсан бөгөөд гэр бүлийн гишүүн нь одоо ОТ-д ажилладаггүй өрхийн нэг гишүүнийг ажилд авах боломжоор хангах. Үүнийг хийсний дараа 2004 оны нөхөн олговрын гэрээнүүдэд тодотгол хийн, ийм өрхүүдийн нэг гишүүнийг уурхай ажиллах хугацааны туршид байнгын ажлын байраар хангах үүргийг ОТ хүлээхгүй тухай заалт оруулах.
- 2004 онд барьж өгсөн өвөлжөөний хашаа хороонд үнэлгээ хийж, хичнээн тооны малд гэж барьсан байна тэрэндээ хүрэхгүй байгааг нь засч өгөх.
- 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрт аудит хийлгэж, амьжиргаагаа сэргээж чадаагүй аливаа өрхөд зориулсан хөтөлбөрийг тусад нь боловсруулах.
- Аудитын дүн гартал одоо нөхөн олговор авч байгаа хүмүүст 2011 оны нөхөн олговрын гэрээгээр олгосон түр ажлын байрыг үргэлжлүүлэх. БХОТ үйл явцад 2011 оны хөтөлбөрт нэмэгдэн орох малчдад энэхүү хөтөлбөрийн дагуу олгох ажлын байр нь түр зуурын бөгөөд ОТ-н нөлөөллийг харгалзан дахин зохион байгуулалт хийх хугацаанд нь малчдад туслахад чиглэсэн болохыг ойлгуулах ёстойг тэмдэглэе.

5 2-р Шатны Тайлан: Ундай Голын Өөрчлөлтэй Холбоотой Гомдол

5.1 Үнэлгээний хамрах хүрээ

- Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл хожим өөрчлөх эсэх, Ундай, Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсний улмаас энэ бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болзошгүй хуримтлагдах нөлөөлөл;
- Хаягдал хадгалах байгууламж одоо шүүрч байгаа эсэх, ирээдүйд ингэж шүүрэх эрсдэл байгаа эсэх, энэ шүүрэл нь Халив-Дугатын гол болон малчдын, малын усны бусад аливаа эх үүсвэрт ямар нөлөөлөл(үүд) учруулах; мөн
- Халив-Дугатын голд учруулах нөлөөллөөс зайлсхийхийн тулд Төслийн хаягдал хадгалах байгууламжийг өөрчлөх боломжтой эсэх эсвэл холбогдох мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг нь хэр үндэслэлтэй болох.

5.2 Аргачлал

Гидрологи

- Бэлэн байгаа тайлангууд, мониторингийн мэдээ баримтыг хянан үзэж, ХШБ-ийн ажлын даалгаварт заасан асуудлуудад хариулахад тухайлан анхаарлаа.

Нийгмийн үнэлгээ

- зорилтот газар нутагт хамтарсан хээрийн судалгаа хийсэн. Зорилтот бүлгүүдтэй хийсэн хэлэлцүүлэг, гол мэдээлэл өгөгч малчидтай хийсэн ярилцлага, орон нутгийн захиргаа, ОТ-н ажилтнууд болон засгийн газрын байгууллагуудын мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтууд.
- Судалгаагаар хамрах бүсийн бэлчээрт мал бэлчих байдалд (тоо) гарсан өөрчлөлтийг үнэлэхийн тулд гол мэдээлэгчид, судалгааны бүс нутаг дахь өрх, мал, төрөл, тоог харуулсан орон нутгийн засаг захиргааны архивын баримт мэдээнд үндэслэсэн судалгаа.
- Бичиг баримтуудыг хянан үзсэн, ингэхдээ БОННУ, БОННДУ-ний Ундай голын ай савын хуримтлагдах нөлөөллийн тухай хэсгүүд, ОУСК-ийн Тэргүүн Туршлагын Гарын Авлагад заасан хуримтлагдах нөлөөллийг үнэлэх аргачлалыг хэрхэн ашигласан зэрэгт голчлон анхаарав.

5.3 Дүгнэлтүүд

5.3.1 Гидрологи

- Халив-Дугатын гольдролыг даялуулан, усны хагалбарын хэд хэдэн хэсэгт өөрчилсөн байна. Гол ба/эсвэл түүний цутгалангууд ухагдаж, уурхай, замын дэд бүтцийн улмаас хэд хэдэн газарт таглагдан, боогджээ. Үүний улмаас усны хагалбарын энэ хэсэгт гадаргын болон хөрсний усны урсац өөрчлөгдсөн. Төслийг эхлэхээс өмнө усны хагалбарын энэ хэсгийн гидрологийн нөхцөл байдалд хангалттай мониторинг хийгдээгүй тул гадаргын болон хөрсний усанд гарсан өөрчлөлтийг тоогоор илэрхийлэх боломжгүй.
- ХХБ шүүрч байгаа нь баримтаар тогтоогдсон. Мониторингийн дийлэнх цэгүүдийн мэдээлэл тасалдалтай буюу тун бага байгаа нь шүүрэлтийг тоогоор хэмжихэд хүндрэл учруулж байна. Шүүрсэн усыг тогтоох систем нь шүүрсэн усыг УЛТ-н дотор барьж байхаар хийгдсэн бөгөөд шүүрэлтийг УЛТ дотор барьж байгаа харагдаж байв. Ямартаа ч одоо байгаа мэдээллээс үзэхэд ирээдүйд мониторингийн хөтөлбөрийг маш дэлгэрэнгүй, нарийн ажиглалттай хэрэгжүүлэх шаардлагатай.
- Голын гольдролыг аль хэдийн даялуулчихсан, хоёр хэсэг хоёулаа баригдаж байгаа, ХХБ-ийн 1-р хэсэг нь ашиглагдаж буй болохоор Халив-Дугатын голд нөлөөлөл учруулахаас зайлхийхийн тулд ХХБ-д өөрчлөлт хийнэ гэдэг найдвартай биш. Гэсэн хэдий ч бууруулах, мониторинг хийх зарим нэг хувилбар байгааг энэ тайланд гаргаж тавьсан болно.

5.3.2 Нийгмийн үнэлгээ

- Халив Дугатын ай сав дахь гадаргын усны хаялбар нь зам, карьерууд, Хаягдал Хадгалах Байгууламж, өөрчлөлтийн сувгууд зэрэг дэд бүтцийн байгуулалтын нөлөөнд өртсөн. Энэ болон Халив Дугатын бэлчээрийн газруудыг УЛТ болон бусад дэд бүтцэд алдсан, үүний улмаас бэлчээр хуваагдсан, түүнчлэн тоосны бохирдол, дүү чимээ зэргээс болж бусад бэлчээрт мал бөөгнөрөхөд хүрчээ. Зарим малчин өрхүүд өвөлжөө барьж өгч, нүүхэд нь тусалсан нүүлгэн шилжүүлэлтээр энэ газарт нүүж ирсэн бол зарим нь алдагдсан, нөлөөлөлд өртсөн, хуваагдсан бэлчээрээс холдон нүүх замдаа улирлын чанартай ашиглаж байна.
- Үр дагаварт нь малчдын улирлын чанартай нүүдэл цөөрч, ихэвчлэн өвөлжөөний бэлчээрээ зун ч бас ашиглах болжээ. Малчдын мэдээлэл, малын тоо баримтаас үзэхэд Халив Дугатын өрхүүдийн малын тооны өсөлт сумын нийт өсөлтөөс арай бага, мөн тэд нар бод гэхээсээ илүүтэй бог мал түлхүү маллах болсон байна.
- Бор Овоон задгай, ойр орчмынх нь бэлчээр алдагдсан Ундай голын нэгэн адил малчин хүмүүсийн бэлчээр ашиглах уламжлалт хэв маяг, мал маллагааны арга ажиллагаанд

өөрчлөлт оржээ. Газар нутаг бүрмөсөн алдагдсан болохоор үүнийг эргүүлэн сэргээж хуучин хэвд нь оруулна гэж төсөөлшгүй.

5.4 Зөвлөмжүүд

5.4.1 Гидрологи

- ОТ, орон нутгийн засаг захиргаа, малчдын хамтын оролцоот усны мониторингийг өргөжүүлэн, сайжруулах. Үүнд хур тунадас хэмжигчийн сүлжээг өргөтгөн, ХХБ-ийн доод талд мониторингийн цооног нэмж гаргаж болох юм. Усны чанарын дээж авах ажиллагаанд бүх талуудыг хамруулан, баримт хамтран олж тогтоох хэлбэрээр үүнийг хийж болно.
- Халив-Дугатын голын өөрчлөлтийн сүвгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах. Ингэснээр элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсгана. Үүнийг хийхдээ өөрчлөлтийн бат бөх байдлыг үнэлэх мөн эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохоос аль болох сэргийлэх замаар засаж болох элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохын тулд хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно.
- Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана ямар нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизм бий болгох. Эдгээр газрууд болон нөлөөллийг бууруулах боломжит арга техникүүдийг ГТЗ хамтран хянан үзэж болох юм.
- Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр (ТХХЗ) шүүрэлтийг хянан үзэж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, үрсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах.

5.4.2 Нийгмийн үнэлгээ

- ХШБ ерөнхийдөө ОТМШБ-аас гаргасан зөвлөмжүүдийг дэмжиж байна. ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 1-ийн сумын хэмжээнд уст цэгүүд байгуулах гэсэн зөвлөмжийн тухайд зэрлэг амьтад/биологийн олон зүйл ба мал хоорондоо зөрчилдөх вий гэдгийг бодолцохыг ХШБ хүсч байна.
- Сумын засаг захиргаа бэлчээрийн газар алдагдсаныг харгалзан тохируулга хийхийн тулд бэлчээрийн системийг дахин боловсруулах хэрэгтэй. Бэлчээрийн гол нутаг (зуны бэлчээр) алдагдсан, сумын ашиглагдаагүй байгаа бэлчээр нь газрын гадарга, ургамлын төрлөөсөө шалтгаалан тэр болгон тохиромжтой бэлчээр байж чадахгүй тул үүнийг хийх нь хэцүүхэн даалгавар байх болно.
- Бодит оролцоо бүхий үйл явцаар нүүдэл, мал маллагааны уламжлалт хэв маягийг сэргээх шийдлийг гаргаж чадна. Энэ үйл явцыг мал аж ахуйн бус амьжиргаанд шилжих сонирхолтой өрхүүдийг дэмжих арга хэмжээнүүдтэй нягт уялдуулах хэрэгтэй.
- Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сургалт явуулах зэргээр орон нутгийн захиргаанд (Сум, Аймаг) дэмжлэг үзүүлэх; энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадны хүмүүс гэхээс илүүтэй (ОТ, гадаад шинжээчид) малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, холбогдох мэргэжлийн байгууллагууд) өөрсдийн оролцоог нэмэгдүүлж, хүчин чармайлт гаргах нь чухал.
- Хамааралтай талуудыг татан оролцуулахад ГТЗ чухал үүрэгтэйгээс гадна одоо байгаа байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (ж: багийн хурал, багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулалт гм) гол үүрэг гүйцэтгэнэ.
- ГХГЗЗГ-аас орон нутгийн засаг захиргаатай хамтран малчдын газар ашиглах уламжлалт эрхийг баримтжуулан баталгаажуулахын тулд нөөц ашиглах эрхийг тодорхойлох, газар болон нөөц ашиглалтыг төлөвлөх талаар явуулж буй үйл явцыг ашиглаж болох юм.

- ОТ-с оруулсан орлогоос эдгээр хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж болно (улсад төлж буй татварууд, аймгийн түвшний хамтын ажиллагааны Сан болон бусад); мөн зээл олгогч ОУСК-ийн зүгээс төлөвлөлт, гүйцэтгэлийг орон нутаг хариуцахыг хөхүүлэхийн хамт зарим дэмжлэг туслалцааг нэмж үзүүлж болох юм.
- Орон нутгийн иргэд “Нутгаа”, сэтгэл санааны үнэт зүйлсээ алдсан асуудал байсаар байна. Эдгээр алдагдлыг тусад нь авч үзэж, нийтийн нөхөн олговорт харгалзах хэрэгтэй.
- Малын тоо толгой өсч байгаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл, ил тод байдал шаардагдаж байна. ХШБ-ийн 2-р шатны судалгаа (мөн БСТ-өөс өмнө хийсэн судалгаанууд, 2012) харахад нөлөөлөлд өртсөн өрхүүд (албан ёсоор нөлөөлөлд өртсөн гэгдсэн болон өөрсдийгөө өртсөн гэж үзэж буй аль аль нь) малын тооны өсөлтөнд бараг нөлөөлөөгүй; эсвэл тэдний малын тооны өсөлт дунджаас нэлээд бага байна. Харин ч ерөнхийдөө тэдний дийлэнх нь малын тоо, төрлийг тохируулан зохицуулах болжээ. Малын тооны өсөлт, бэлчээрийн даац хэтэрч буйг илүү сайн ойлгохын тулд ялангуяа өөрсдөө малаа малладаггүй малтай өрхийн асуудлыг цаашид судлах шаардлагатай.
- 2007 оноос өмнө үс шавхсан тухай мэдээлэл байхгүйг ХШБ өмнө дурьдаж байсан билээ. ХШБ 2-р шатны судалгааг хийхдээ орон нутгийн захиргаа, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамнаас мэдээлэл авахыг чармайсан боловч мэдээлэл байхгүй (орон нутагт), эсвэл мэдээллийг хуваалцах боломжгүй (яамны мэргэжилтнүүд) гэдэг хариу авсан. Ийм нөхцөл байдалд шинжээчид нөлөөллийг цаг хугацааны дагуу тоогоор тогтоож чадахгүй; цааш ахихын тулд ядахдаа байгаа мэдээллийг хүртээлтэй болгох хэрэгтэй байна.
- Нөхөн олговрын зорилгоор нөлөөлөлд өртсөн өрхүүдийн ангиллыг хянан үзэх – ХШБ-ийн 2-р шатны тайлан, Хэсэг 2-оос санал болгож буй ангиллуудыг, ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 2-оос үйл явцыг үзнэ үү.
- Янз бүрийн байдлаар нөлөөлөлд орсон өрхүүдийн нэрсийг шинжээч өөрийн боломжоор гарган, бүрэн бус хэдий ч жагсаалтыг энэ тайланд орууллаа. Нэрсийг бүлгийн хэлэлцүүлгээр авсан мэдээлэлд үндэслэн, оролцогчдын зөвшөөрөлтэй авсан. ГТЗ-өөс хүмүүс томилох буюу (эсвэл илүү олон хүн оролцуулж) нэрсийг дахин нягтлахыг зөвлөж байна.
- ХШБ-ийн 2-р шатны тайлангийн 2 дахь хэсэгт дурьдсан өрхүүдтэй амьжиргааг дэмжих стратегийн талаар хэлэлцүүлэг зохиох (ХШБ-ийн 1-р шатны тайлангийн дараа 59 өрхтэй зөвлөлдсөн шиг).
- Малын тэжээл тариалах/үйлдвэрлэх хувилбарт үнэлгээ хийх (Өмнө-Говь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн бусад сумдад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн мэдээлэл, сургамжид үндэслэн, тухайлбал НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Монгол улсын хуурайшилтай, хагас хуурайшилтай бүст хэрэгжүүлсэн “Цөлжилттэй тэмцэх газрын тогтвортой менежмент төсөл”)
- Бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд ОТ эвдсэн/орхисон газруудаа аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг богиносгох, карьерууд дээр гарах ослын эрсдэлийг бууруулах.

6 Ерөнхий дүгнэлтүүд

6.1 ОТМШБ/ХШБ-ийн судалгаанууд

ОТМШБ, ХШБ-ийн баримт хамтран олж тогтоох ажлаар их хэмжээний мэдээлэл, дүгнэлт, зөвлөмжүүд гаргалаа. Эдгээр судалгааг ОТ-н талаар гаргасан гомдлуудын улмаас хийсэн тул зөвлөмжүүдийн дийлэнх нь ОТ-д хандсан. Гэхдээ бүх талуудад ач холбогдол бүхий зүйлсийг ч олж тогтоосон болно.

Олж тогтоосон бүх зүйлсээс бид дөрвөн ерөнхий дүгнэлт гаргаж байна. Үүнд:

- ОТ (болон өмнөх АММИ) хайгуулын эхний үеэс Ханбогд сумын нүүдлийн мал аж ахуйн талаар хангалтгүй ойлголттой байсан нь нөхөн олговор болон малчдын ашигладаг усны нөөцийн тухайд хэд хэдэн буруу алхам хийж, малчдад учруулах нөлөөллийг дутуу үнэлэхэд хүргэжээ. АММИ/ОТ хангалттай суурь мэдээлэл цуглуулаагүй, нарийн дэлгэрэнгүй мониторинг хийх хөтөлбөр (мөн байнгын дүн шинжилгээ, мониторингийн үр дүнгийн мэдээлэл) хэрэгжүүлээгүй явдал энэ байдлыг улам хүндрүүлжээ. Үүний үр дагаварт нөхөн олговор авбал зохих зарим малчдад нөхөн олговор өгөөгүй, түүнчлэн суурь мэдээлэл байхгүй учраас ОТ малчдын усны нөөцөд хохирол учруулсан эсэх, тийм бол хэдий хэмжээний хохирол учруулсан тухайд тодорхой дүгнэлтэнд хүрэх боломжгүй байна. Тийм болохоор малчдын хэрэглэж болох байсан ус багассан, үүний гол хариуцлагыг ОТ хүлээнэ гэсэн сумын нийт малчдын дунд түгээмэл байгаа бодлыг өөрчлөхөд маш хэцүү гэсэн үг. ОТ малчдын усанд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй гэж үүрэг хүлээснийг харгалзан мал бэлчих шинэ газар нутагтай болгохын тулд ОТ уст худаг нэмж барихад хөрөнгө оруулж, мөн нөхөн олговор авах эрхтэй малчдын хүрээг өргөжүүлэх ёстой гэдэг дүгнэлтийг бид гаргаж байна.
- Ханбогд сум дахь мал маллагааны арга барил, амьжиргаа 2003 оноос хойш өөрчлөгдсөн. Тухайлбал, зарим малчид цөөн нүүдэллэдэг; чадал чинээний ялгаа ихсэж байгаа; олон айл өрх тусгаарласан, өндөр үнэ, өртөгтэй машин тэрэг гэх мэтээр өр зээлд өргөнөөр автсан. Эдгээр өөрчлөлтүүдийн зарим нь ОТ байгаагаас шалтгаалсан, харин зарим өөрчлөлтүүд нь малчдын сонголт гэх мэт Монгол улсын малчдын дунд нийтлэг байгаа хандлагын тусгал эсвэл бэлчээр таслан хувааж буй нүүрсний зам, төмөр зам зэрэг суманд саяхнаас бий болсон бусад байгууламжуудаас үүдсэн байна. Зарим малчид ажлын байр, бизнес эрхлэлт гэх мэт шинэ боломжийг ашиглан, хөгжин дэвшиж байхад зарим нь арга ядаж байна. Бид Ундайн голын бүсээс өөр амжилт эсвэл асуудлыг ОТ-н нөлөөлөлтэй системтэй холбож болох тодорхой хандлага тогтоосонгүй. Гэвч зарим малчид өөрсдийн ихэнх асуудлыг ОТ-гоос болсон гэж байна.
- ОТ, олон тооны малаас гадна дэд бүтэц, хамгаалалттай газрууд, сумын төвийн тэлэлт гэх мэт газар, усны хэрэглээний төлөөх өрсөлдөөнтэй нөхцөл байдалд бэлчээрийн менежментийн стратегийг сумын хэмжээнд боловсруулан, хөрөнгө зардал гаргаж, хэрэгжүүлэх нь чухал. Бэлчээрийн дарамт ихэссээр байхаар байгаа тул алсыг харсан стратеги тун чухал.
- Одоо ажил хэрэгч байдлаар урагшлах боломж байна. ОТМШБ/ХШБ-ийн судалгаагөөр гаргасан зөвлөмжүүдэд нөхөн олговор, мониторинг болон ОТ, малчид, Ханбогд сумын хоорондын харилцааны дутуу дулимаг цоорхой асуудлуудыг авч үзлээ. Нөхөн олговортой холбоотой нэхэмжлэлүүдийг шийдвэрлэх, малчид, ОТ болон сумын төлөөллүүд хоорондоо хэлэлцүүлэг хийх газар бол ГТЗ юм. 2015 оны Хамтын Ажиллагааны Гэрээгээр ус, бэлчээрт чиглэсэн, гэрээний дагуу зарцуулах, бодитой, урт хугацаанд зарцуулах санг бий болгож байна; үүний тодорхой хувийг 5 жилийн туршид Ханбогдод зориулж олгох хэрэгтэй. Энэ нь мал аж ахуй, уул уурхай, дэд бүтэц зэрэгцэн оршин тогтнох стратегийг тусгасан сумын мал аж ахуйн салбарын урт хугацааны хөгжлийн төлөвлөгөөнд хувь нэмэр оруулах болно.

6.2 Нэмэлт ажиглалтууд

ОТМШБ судалгаа, хээрийн ажилд нэлээд цаг хугацаа зарцуулсан. Үүний үр дүнд манай ажлын даалгаварт тусгайлан заагаагүй асуудлуудтай холбоотой, ГТЗ болон бусдад сонирхолтой байж болох хэд хэдэн зүйлийг ажиглалаа. Талуудын ажил урагшлахад тэд анхааран хэрэгжүүлэхийг хүсч магадгүй хэмээн доор дурьдсан ажиглалтуудыг санал болгож байна.

- ОТ дахь ажлын байр – сумын төв дэх уурхайн байранд илүү олон ажлын байр гаргаж болох уу, мөн уурхайд ээлжийн бус энгийн ажлын долоо хоногийн хуваарьтай ажлууд, жишээ нь захиргааны ажил, цайны газар, цэвэрлэгээ гэх мэт туслах ажлын байр илүү гаргаж болох уу? Ингэвэл нутгийн оршин суугчид гэр бүлээсээ холдолгүй, өрхийн хэв маягаа хадгалан ажилтай байж чадах юм.
- Carbon. The potential benefit of carbon (CO₂) offsets can be explored with OT/Rio Tinto pioneering carbon credits or voluntary offsets from the Khanbogd environment. Deserts are scientifically identified as large carbon sinks, sequestering CO₂ below ground. Thus the carbon market may pay the community for offsetting CO₂ provided by the soum's arid land, or the sequestration can serve to offset Rio Tinto's carbon production elsewhere.
(Нүүрстөрөгч. ОТ/Рио Тинто нүүрстөрөгчийн кредит эсвэл Ханбогдын байгаль орчны сайн дурын дүйцүүлэх нөхвөр зэргийг эхлүүлж нүүрстөрөгчийн (CO₂) дүйцүүлэх нөхвөрийн боломжит давуу талыг судалж үзэж болох юм. Цөл газар бол CO₂-ийг газрын доор тусгаарлан хадгалдаг, нүүрстөрөгчийг ихээр шингээгч гэж шинжлэх ухаан тодорхойлдог. Ийм байдлаар нүүрстөрөгчийн зах зээл сумын хуурайшилтай газрын CO₂-ийн дүйцүүлэх нөхвөрийн төлөө мөнгө төлж магадгүй, эсвэл Рио Тинтогийн хаа нэгтээ үйлдвэрлэсэн нүүрстөрөгчийн дүйцүүлэх нөхвөр нь тусгаарлан хадгалалт байж болно.)
- Нөлөөллийн бүх үнэлгээ, холбогдох судалгаануудад уул уурхай, тээвэр болон мал аж ахуй харилцан ашигтай байдлаар зэрэгцэн оршихын ач холбогдлыг харгалзсан газар ашиглалт, дэд бүтцийн цогц төлөвлөгөө Ханбогд суманд (түүнчлэн Өмнийн Говийн өргөн бүсэд) хэрэгтэй байгааг тодорхойлж өгсөн байдаг. Гэвч бодит байдал дээр хэрэгжсэн зүйл тун бага. ОУСК (ОТ-д хөрөнгө оруулалт хийсний хувьд) болон Дэлхийн Банкны Групп (бэлчээрийн тогтвортой менежментийн талаар өмнө нь ажиллаж байсны хувьд)⁷ ямар нэг үүрэгтэй байж чадах уу - бүс нутгийн газар ашиглалт, дэд бүтцийн төлөвлөгөөг үр дүнтэй боловсруулах, хэрэгжилтийг түргэтгэхийн тулд тэдэнд буй мэдлэг, нөөц, хөшүүргийг ашиглах тал дээр?
- ОТ-н нөлөөллийн үнэлгээ нь өөр өөр газрын, янз бүрийн төрлийн, том хэмжээний төслүүдэд нийтлэг байдаг сул талыг харуулж байна.
 - Шинжээчдийн үнэлгээнүүд агаар, ус, хөрс, газар ашиглалт зэрэг төрөл бүрийн асуудлаар хийгдсэн, нутгийн иргэдэд болон биологийн олон талт байдалд учирсан шууд нөлөөллүүдийг тодорхойлсон, гэвч үнэлгээ бүрийн үр дүнг цогцоор нь шинжилж үзээгүй байна. ОТ болон малчдын жишээг авч үзвэл тодорхойлсон бүх нөлөөллүүд нийлэхээрээ малчдад ямар нөлөөлөл учруулах вэ гэдгийг ерөнхийд нь харуулсан, холбогдох хэсэг тус бүрээс хамааралтай мэдээллийг оруулж өгсөн хэсэг нөлөөллийн үнэлгээнүүдэд

⁷ Тогтвортой Амьжиргаа 3 дахь Төсөл. 36.2 ам.долл. - <http://projects.worldbank.org/P125232/third-sustainable-livelihoods-project?lang=en>

алга. Эцсийн энэ алхмыг хийж өгвөл учирч болзошгүй асуудлууд, гомдлыг гарахаас нь өмнө тодорхойлж, илүү үр дүнтэй бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж чадна хэмээн бид санал болгож байна.

- Нийгмийн судалгаанууд төслөөс нөлөөлөл учруулсан байж болох төрөл бүрийн газар ашиглагчид ба газар ашигладаг арга замуудыг бүгдийг нь тодорхойлохын тулд цаг хугацаа, байршлийн хувьд хангалттай өөр өөр цэгт хийгдээгүй учраас нүүдэлчин/хагас нүүдэлчин ард иргэдийг бүрэн хамраагүй байна.

7 Зөвлөмжүүдийн эмхтгэл

Доорх хүснэгтэд судалгаа тус бүрийн зөвлөмжүүдийг хамтатган орууллаа. ГТЗ болон талууд дараагийн алхмаа тохироход дөхөмтэй болгохын тулд зөвлөмжүүдийг дараах сэдэвчилсэн гарчгийн дагуу зохион байгуулав:

- Бэлчээртэй холбоотой зөвлөмжүүд
- Ус болон усны нөөцөд учруулсан ОТ-н нөлөөллийн менежменттэй холбоотой зөвлөмжүүд
- Мониторинг, мэдээлэл, орон нутгийн харилцаатай холбоотой зөвлөмжүүд
- Нөхөн олговортой холбоотой зөвлөмжүүд.

Бэлчээртэй холбоотой зөвлөмжүүд

1	<p>Орон нутгийн засаг захиргаа алдагдсан бэлчээрийн бүст тохируулга хийхийн тулд бэлчээрийн тогтолцоог дахин боловсруулах.</p> <p>Сумын зүгээс малчид уламжлалт байдлаар нүүдэллэх, ус, бэлчээрийг чөлөөтэй хүртэх байдлыг хөхүүлэн дэмжиж, худаг, бэлчээрт малчид хориг тавьдагыг багасгах. Худаг барих хөтөлбөрөөр дамжуулан шинэ бэлчээр нэмж бий болгох. Малчдын эзэмшлийн эрхийг тодорхой болгож, хэрэгжүүлэх.</p> <p>Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сургалт явуулах зэргээр орон нутгийн захиргаанд (Сум, Аймаг) дэмжлэг үзүүлэх; энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадны хүмүүс гэхийн оронд (ОТ, гадаад шинжээчид) малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, холбогдох мэргэжлийн байгууллагууд) санаачлагыг гартаа авч, бүгд хүчин чармайлт гаргах нь чухал.</p> <p>Хамааралтай талуудыг татан оролцуулахад ГТЗ чухал үүрэгтэйгээс гадна одоо байгаа байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (ж: багийн хурал, багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулалт гм) гол үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь, малчид ч мөн газар, устай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэж ирсэн уламжлалт арга барилаа сэргээх эсвэл бэхжүүлэн хэрэглэх замаар машин тэрэг ихээр ашиглах болсон, тэдгээр нь бэлчээрийг гэмтээдэг, худаг цоожилдог гэх мэт ОТ-той хамааралгүй мал маллагаанд холбоотой асуудлаа хэрхэн шийдвэрлэж болох талаар бодолцох нь зүйтэй.</p> <p>Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газраас (ГХГЗЗГ) орон нутгийн засаг захиргаатай хамтран малчдын газар ашиглах уламжлалт эрхийг баримтжуулан баталгаажуулахын тулд нөөц ашиглах эрхийг тодорхойлох, газар болон нөөц ашиглалтыг төлөвлөх талаар явуулж буй үйл явцыг ашиглах.</p> <p>ОТ-с оруулсан орлогоос эдгээр хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж болно (улсад төлж буй татварууд, аймгийн түвшний хамтын ажиллагааны Сан болон бусад); мөн зээл олгогч ОУСК-ийн зүгээс төлөвлөлт, гүйцэтгэлийг орон нутаг хариуцахыг хөхүүлэхийн хамт зарим дэмжлэг туслалцааг нэмж үзүүлж болох юм.</p> <p>Малын тооны өсөлт, тавиул малын өмчлөлийн талаар нарийн судалгаа шинжилгээ хийх шаардлагатай.</p>
2	<p>ОТ-н зам дээрх хөдөлгөөний хурдыг багасгахын тулд малын гарамуудын хоёр талд нь хурд сааруулагч хийж өгөх шаардлагатай. Ялангуяа барилгын ажил нэмэгдэн, үйлдвэрлэл ихсэх үед тун чухал; энэ нь бэлчээр хуваагдлын үр дагаврыг бууруулна</p>
3	<p>Бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд ОТ эвдсэн/орхисон газруудаа аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг богиносгох, карьерууд дээр гарах ослын эрсдэлийг бууруулах.</p>

Устай холбоотой зөвлөмжүүд

1	<p>ОТ цоожилж болохооргүй, гүехэн гар худгууд барих хөтөлбөрийн хэлбэрээр нийтийн нөхөн олговор олгох ёстой (ОТ-оос малчдад саяхан барьж өгсөн бетонон гүехэн худгууд шиг).</p> <ul style="list-style-type: none"> • малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг хөхүүлэн, тэдэнд уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломж олгохын тулд худгуудыг 4 багийн нутагт тараан байрлуулах. • Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршлыг гүний усны судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай, мөн түүнчлэн зэрлэг амьтдад нөлөөлөл учруулах эсвэл тэднээс ирэх нөлөөллийн тухайд малчид санаа зовдог гэх мэт малчдын санаа бодлыг харгалзах. <p>ОТ болон сум хамтран худгуудын нөхцөл байдлыг хянаж, засвар үйлчилгээ хийх хүмүүсийн баг байгуулах (хагас цагийн болон байнгын ажилчидтай байхаар). Хамтын ажиллагааны гэрээнээс санхүүжилт хүсэх хэрэгтэй.</p>
2	<p>ОТ болон сум одоо байгаа малчдын худгууд болон дээр санал болгосон худгуудад засвар үйлчилгээ хийх сайн тогтолцоо бий болгох: доод тал нь 5 жилийн хугацаанд Хамтын ажиллагааны гэрээгээр үүнийг санхүүжүүлэхийг бид санал болгож байна.</p>
3	<p>ОТ газар зүйн хувьд тараан байрлуулсан цэгүүд дээр аллювын уст давхаргын жишээ загварчлал гаргаж, мониторинг хийх, мөн ОТ-н өнгөрсөн, одоо, ирээдүйн нөлөөллийг хамгийн боломжит хугацаагаар тоон үзүүлэлтээр тооцсон аллювын нөөцөд чиглэсэн гидрологийн судалгаа явуулах хэрэгтэй. Ингэснээр малчид хараат байдаг гүехэн гүний усны динамикийн талаар илүү сайн ойлголттой болж, загварчлалыг сайжруулан, ирээдүйд усны нөөцийн өөрчлөлтийг хэмжиж чаддаг болно.</p>
4	<p>Малчдыг усаар хангаж байгаа нь түр зуурын арга хэмжээ бөгөөд зугуухан болих хэрэгтэй. Тодорхой хугацаа тохироод, одоо ус зөөж өгч байгаа газруудын усны нөөцөд үнэлгээ хийлгэх; хэрэв ажиллагаатай худаг тэнд нь байгаа бол хөтөлбөрийг зогсоох; худаггүй бол санал болгож буй худаг барих хөтөлбөрийн хүрээнд нэгийг барьж өгөх нь зүйтэй.</p>
5	<p>Элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсгахын тулд ОТ Халив-Дугатын голын өөрчлөлтийн сувгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах хэрэгтэй. Үүнийг хийхдээ өөрчлөлтийн бат бөх байдлыг үнэлэх мөн эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохоос аль болох сэргийлэх замаар засаж болох элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохын тулд хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно.</p>
6	<p>Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана ямар нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизмийг ОТ бий болгох хэрэгтэй. Эдгээр газрууд болон нөлөөллийг бууруулах боломжит арга техникүүдийг ГТЗ хамтран хянан үзэж болох юм.</p>
7	<p>ОТ Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр (ТХХЗ) шүүрэлтийг хянан үзэж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах.</p>

Мониторинг, тайлагналт, орон нутгийн харилцаатай холбоотой зөвлөмжүүд

1	<p>Малчид болон бусад хүмүүст үнэмшилтэй, найдвартай, үрт хугацааны мэдээ мэдээлэл гаргахын тулд малчдын худаг, тоос, бэлчээр/ургамлын байгаль орчны мониторингийн хөтөлбөрүүдийг дахин боловсруулж, шинээр зохион байгуулах шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> • Оролцоог хангахын тулд хөтөлбөрүүд мал маллагааны хэв маягт тохирсон, малчид хянан баталгаажуулах боломжтой, хатуу шинжлэх ухаанч байдал, итгэл үнэмшлийг хангасан, хүртээлтэй байлгахын тулд баримт хамтран олж тогтоох аргачлалыг ашиглан боловсруулж, хэрэгжүүлэх. • мониторингийг гадагш нь гэрээлж хийлгэж байгааг больж, орон нутгийн мониторингоор солих шаардлагатай. • Хөтөлбөрт хамруулах зүйлс: • Малчдын худгийн үс (тоо хэмжээ ба чанар) • ХХБ-ийн доод талд мониторингийн худгууд нэмэх • тоос • ургамал/бэлчээрийн чанар. NB - Ургамлын мониторингийг явуулахад хашаалсан талбайг санал болгож байна. Үүнийг малчид, сумын албан тушаалтнуудтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй. • хөрсний чийг • хур тунадас хэмжигчийн сүлжээг өргөтгөх. <p>Малчид чин сэтгэлээсээ оролцож, хариуцлагатай хандах нь мониторингийг амжилттай хэрэгжүүлэхэд зайлшгүй чухал.</p>
2	<p>БХОТ үйл явцаар гаргасан зөвлөмжүүдийн дагуу хийгдэх аливаа шинэ нөхөн олговрын ахицад мониторинг хийж, улирал тутам ГТЗ-д танилцуулах, жишээ нь Нөхөн Олговрын Хороонд ирсэн өргөдлүүд; хүлээн зөвшөөрсөн өргөдлүүд; тохиролцоонд хүрсэн нөхөн олговрын гэрээ; олгосон нөхөн олговор гэх мэт.</p>
3	<p>ОТ мониторингийн тайлан мэдээ, түүний үндсэн дээр авсан эсвэл санал болгосон аливаа арга хэмжээг байнга тайлагнан, малчид, орон нутгийн иргэдэд тогтмол танилцуулж байх хэрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээлэл шууд, ойлгомжтой, малчидтай холбоотой; сумд өгөх тайлангууд мэргэжилтнүүдэд ойлгогдохоор байх шаардлагатай. • Австралийн Пилбара-д хэрэглэсэн тоосны бодит цагийн мониторинг гэх мэт Рио Тинтогийн ашигладаг аргуудыг Ханбогдод хэрэглэх нь зүйтэй.⁸ • ОТ илэрсэн зүйлийн талаар бүх багийн төв, сумын төв дээр танилцуулж байх шаардлагатай.
4	<p>ОТ өнгөрсөн оныхоо гүйцэтгэл, ирэх оны төлөвлөгөө, орон нутгийн эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл - ажил олголт, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутгийн худалдан авалт; байгаль орчны нөлөөлөл – байгаль орчны нөлөөллийн мониторинг ба менежментийн хөтөлбөрүүд, холбогдох тоо баримт; нийгмийн гүйцэтгэл - нөхөн олговрын хөтөлбөр, эмзэг хүмүүст тусалсан байдал, сургалт, бизнес эрхлэлт, Хамтын ажиллагааны гэрээний төслүүд, хандив зэргийг хамарсан мэдээллийг жил бүр гаргаж байхыг бид бас санал болгож байна. Үүнийг Монгол хэл дээр, малчдад хүртээлтэй хэлбэрээр гаргах нь зүйтэй.</p>
5	<p>Орон нутгийн харилцааны багийг өргөжүүлэх. Багийг ОТ ба малчдын (мөн орон нутгийн бусад иргэдийн) хооронд хоёр талын үр дүнтэй харилцаа бий болгох үүрэг бүхий, бэлтгэгдсэн хүмүүсээс бүрдүүлэх. Үүнд мөн албан ёсны үүлзалтуудад оролцох, жишээ</p>

⁸ riotinto.com/documents/FAQ_air_quality_monitoring.pdf

	<p>нь багийн хуралд суух, орон нутгийн захиргаа болон сонгогдсон албан тушаалтнуудтай ойр холбоотой байх; 'эмзэг' гэж тогтоогдсон хүмүүс гэх мэт явагдаж буй нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан хүмүүстэй байнгын холбоотой байх, цаг зав гарган сумын хэмжээгээр явж, хүмүүстэй албан бус харилцаа тогтоох зэрэг орно.</p> <p>ОТ-н үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээллийг (ялангуяа барилгын ажлын үеэр, УЛТ-н гадна ажиллаж буй гэрээт байгууллагуудын үйл ажиллагаа, хэн хаана юуг хэдий хугацаагаар хийж буй, хүмүүсийг ажилд яаж авч байгаа гэх мэт) малчид, орон нутгийн бусад иргэдэд хүргэх, мэдсэн сонссон асуудлуудаа эргэж удирдлагадаа танилцуулж байхын тулд орон нутгийн харилцааны ажилтнууд ОТ компани дотроо маш сайн харилцаа холбоотой байх хэрэгтэй.</p>
6	<p>Далд уурхайн төсөлтэй холбоотой нэмэлт нөлөөллийг (ба нөлөөллийн бууруулах арга хэмжээ); тодорхойлж зөвлөлдөхийн тулд ажлаа эхлэхээс өмнө ОТ нэг эсвэл хэд хэдэн нэмэлт БОННУ-ний үр дүн; эрчим хүчний гэрээ; ажиллах хүчний орон байрны төлөвлөгөөнд орсон өөрчлөлт; төмөр замын барилгын ажил; Ханбогд сум ОТ хоорондын замын хучилт; 2012 оны БОННУ гарснаас хойш төсөлд гарсан томхон өөрчлөлтүүд болон бусад дэд бүтэц, уул уурхай/газрын тосны төслийн улмаас үүсэх хүримтлагдах нөлөөллийн дүн шинжилгээний талаарх сүүлийн үеийн мэдээллийг ОУСК-ийн стандартын дагуу олон нийтэд ил тод мэдээлэх хэрэгтэй. Сумын төв ОТ-н хоорондын зам хучилттай болсноор тээврийн хөдөлгөөн ба хурд нэмэгдэж, мал амьтны хөдөлгөөнийг хязгаарлах эсэхийг үнэлгээнд анхаарч үзэх ёстой</p>
7	<p>ОТ болон ГТЗ-ийн бусад гишүүд гомдлыг барагдуулах механизмд хөндлөнгийн этгээдэд хандах тухай хувилбарыг тодорхой болгож одоо ашиглаж буй гомдлыг барагдуулах механизмын талаар малчид, орон нутгийн бусад иргэдэд танилцуулж, зөвлөлдөх; шаардлагатай бол засаж сайжруулах, ОТ-н талаар гомдолтой иргэдийг тус механизмыг ашиглахыг хөхүүлэх</p>

Нөхөн олговортой холбоотой зөвлөмжүүд

1.	АММИ 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд хэрэглэсэн арга барил нь ялангуяа харилцаа холбооны тухайд асуудалтай байсныг ОТ малчдын өмнө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.
2.	ГТЗ нь доорх зөвлөмжид заасан ангиллын малчид 2004, 2011 оны хөтөлбөрийн дагуу нөхөн олговор авах эрхтэй эсэхийг шийдвэрлэх Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газрын (ЭЗХНЗОГ) адил хөндлөнгийн бие даасан нарийн бичгийн даргын тусламжтайгаар малчдын төлөөлөл, сумын захиргаа, ОТ-гоос тус бүр нэг гишүүнээс бүрдсэн 3 гишүүнтэй “Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо” байгуулах шаардлагатай.
3.	<p>Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хорооны журамд дараахь зүйлс орно:</p> <ul style="list-style-type: none">• Өргөдөл хүсэлтийг судлан, хүчинтэй эсэхийг тогтоох, өөрөөр хэлбэл тухайн малчин 2004 эсвэл 2011 оны үед суманд бүртгэлтэй байсан эсэх гэх мэт. Хороо өөр бусад байдлаар шалгаж болно.• Нөхөн олговрын нэхэмжлэхэд нотолгоо хавсаргасан байхыг шаардах, жишээ нь:<ul style="list-style-type: none">○ 2004 эсвэл 2011 аль онтой холбоотой нэхэмжлэх гаргаснаас шалтгаалан тухайн үед сумд малчнаар байсан бүртгэл,○ холбогдох газарт өвөлжөөний бүртгэлтэй эсвэл түрээсэлж байсан, эсвэл○ холбогдох газарт хаваржааны бүртгэлтэй эсвэл түрээсэлж байсан, эсвэл○ холбогдох газрын худгийн бүртгэл, эсвэл○ Бууцны бүртгэлгүй, 2004 эсвэл 2011 оны нөхөн олговрын бүсийн дотор эсвэл дөнгөж гадна бэлчээр, ус ашиглаж байсан малчдын нэхэмжлэлийн тухайд сумын эрх бүхий байгууллагуудын мэдэгдэл, нутгийнхний зөвшөөрөл, мал өмчилж байсан тухай сумын тоо бүртгэл, сумын газрын зураг гэх мэт зүйлсийг нотлох баримтанд оруулж болно.

4.	<p>2004 оны нөхөн олговрын тухайд дор дурьдсан бүлгийн малчдад 2004 оны нөхөн олговорт хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөн олговрын нэхэмжлэлийн хороонд тавих боломж олгох хэрэгтэй (дээр дурьдсан баримт нотолгооны хамт):</p> <ul style="list-style-type: none"> ○ Судалгаа авч байх үед эсвэл гэрээ хэлэлцэх явцад байгаагүй учраас нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдаж чадаагүй боловч 2004 оны нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай гэж заасан бүс нутагт өвөлжөөтэй байсан өрхүүд. ○ 2004 онд нүүлгэн шилжүүлэлт хийхээр тогтоогдсон бүсэд хаваржаатай байсан аливаа өрх ○ Нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур өвөлжөө эсвэл хаваржаатай байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсныг нь нотлох баримттай байх. ○ Өвөлжөөний газраа хуваан эзэмшиж байсан, ямар ч нөхөн олговор аваагүй айлууд. ○ Бууцны гэрчилгээтэй ч нөхөн олговор олгох үед байгаагүй өрхүүд. ○ 2004 оны нөхөн олговрын бүсийн дотор эсвэл яг гадна бэлчээр, ус ашиглаж байсан нь суманд бүртгэгдсэн, бууцны гэрчилгээгүй, нөхөн олговор авсан өрхүүдтэй нэг бэлчээр, ус ашиглаж байгаад тэрийгээ алдаж нөлөөлөлд өртсөн өрхүүд. ○ 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд бусад малчдыг нүүлгэн шилжүүлсэн бүсэд суурин өвөлжөө ба/эсвэл хаваржаатай байсан, уг нүүлгэн шилжүүлэлт тэдний бэлчээр усны хүртээмжид сөрөг нөлөөлөл учруулсныг нотолж чадах малчид .
5.	<p>2004 оны нөхөн олговрын бүрэлдэхүүний тухайд:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо (эсвэл дэд хороо) орлуулан барьж өгсөн малын хашаа хороо нэг бүрийг үзэж, нөхөн олговор авах тухайн үед өрхийн маллаж байсан малын тоонд (энэ тоог нөхөн олговрын гэрээ тус бүрт дурьдсан байдаг) хангалттай эсэхийг үнэлж дүгнэхийг бид зөвлөж байна. Хэрвээ хашаа хороо нь хангалтгүй гэж үнэлэгдвэл тухайн хашаа хороог хангалттай түвшинд хүргэхийн тулд ОТ-оос засаж сэлбэх эсвэл сольж барих нь зүйтэй. • Ажилд орсон хүн нь ажлаасаа халагдсаны улмаас гэр бүлийн гишүүн нь одоо ОТ-д орон тооны ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 2004 онд нөхөн олговор авсан өрхүүдэд (мөн дээр 6.2 дахь Хэсэгт дурьдсан үйл явцын үр дүнд нөхөн олговор авах айл өрхийн жагсаалтанд нэмэгдсэн аливаа өрхийг оролцуулан) далд уурхайн барилгын ажил (энэ нь түр байна) эсвэл уурхайн үйл ажиллагаанд гэр бүлийн нэг гишүүнээ ажиллуулах боломжийг ОТ-с санал болгох хэрэгтэй. Тайлбар: Гэхдээ ОТ-н ажлын байранд тавигдах шаардлага, ажилд авах шалгуурыг хангаж чадах өрхийн гишүүн байгаа эсэхээс шалтгаална. Ажилд орсон хүн нь тэтгэвэрт гарах, ажлаасаа чөлөөлөгдөх эсвэл халагдах гэх мэт шалтгааны улмаас ОТ-д хөдөлмөр эрхлэлт нь дуусгавар болсон тохиолдолд тухайн өрхийн өөр нэг гишүүнийг ажлын байраар хангах үүргийг ОТ хүлээхгүй гэдэг тодруулгыг нөхөн олговрын гэрээнүүдэд нэмж оруулах нь зүйтэй. Гэхдээ малчин өрхийн гишүүд ОТ-д ажилд орохоор өргөдлөө гаргаж болох бөгөөд ОТ-н ажилд сонгон шалгаруулж авах бодлого журмын дагуу авч үзнэ.

6.	<p>Дараах ангилалд буй малчид 2011 оны нөхөн олговорт хамрагдах нэхэмжлэлээ Нөхөн Олговрын Хороонд гаргах эрхтэй байх ёстой:</p> <ul style="list-style-type: none"> • Нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур өвөлжөөтэй байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсныг нь нотлох баримттай байх. • 2011 оны нөхөн олговрын үед нөхөн олговрын бүсэд хаваржаа эзэмшдэг лицензтэй эсвэл нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур хаваржаатай байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсныг нотлох баримттай байх⁹. • Бууцны лицензгүй боловч нөхөн олговор авсан хүмүүстэй нэг бэлчээр/худаг ашиглаж байсныг нь батлах нотолгоо өгч чадах аливаа малчид. Нотлох баримтанд өрхийн байршлийг харуулахуйц худгийн паспорт гэх мэт бүртгэл, гараар зурсан газрын зураг, бууцны гэрчилгээ олгохоос өмнөх үеийн аливаа бүртгэлийн материалыг оруулж болно. • 2011 оны нөхөн олговорт хамрагдсан өвөлжөөг хуваан ашигладаг байсан гэхдээ ямар нэгэн нөхөн олговор аваагүй өрхүүд.
7.	<p>2011 оны нөхөн олговрын бүрэлдэхүүний тухайд:</p> <ul style="list-style-type: none"> • ОТ 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн аудит хийлгэх шаардлагатай. • 2011 онд нөхөн олговор авсан ч орлогоо нүүлгэн шилжүүлэгдэхээс өмнөх үеийнх шигээ сэргээж чадаагүй, орлого буурсан нь ОТ-н эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээс болсон гэж үзэж болох өрхүүдэд туслах тусгай хөтөлбөр боловсруулах хэрэгтэй. • Бүрэлдэхүүн 1-ийн судалгаанд зөвлөсөн худаг барих хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд худаг барих, засвар үйлчилгээ хийж, мониторинг явуулах баг байгуулах (Усны тухай Зөвлөмжийг үзнэ үү). Энэ багт 2011 онд нөхөн олговор авсан ч амьжиргаагаа сэргээж чадаагүй өрхүүдэд энэ ажлыг хийх сонирхолтой, чадвартай хүн байгаа бол эдгээр ажлын байрыг эн тэргүүнд тэдэнд санал болгох нь зүйтэй. • Алслагдсан, хүн ам цөөтэй Ханбогд суманд бизнес эрхэлнэ гэдэг хүндрэлтэйг харгалзан малчид мал аж ахуйтай хамааралтай болон өөр бусад бизнесийн санал боловсруулж, Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэх хүсэлт гаргахад нь туслалцаа үзүүлж буй зөвлөхүүдийг ОТ үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй.
8.	<p>ОТ нь 2004 ба 2011 оны нөхөн олговрын гэрээний нууцлалыг хадгалах тухай зүйл заалтыг цуцлах нь зүйтэй. Ингэснээр нөхөн олговор авсан иргэд нөхөн олговрын талаарх мэдээллээ бусдад ил болгохыг хүсвэл энэ боломж нээлттэй байна.</p>
9.	<p>Ундай голын системд учирсан нөлөөлөлтэй холбоотойгоор ХШБ-ийн 2-р шатны тайлангийн 2 дахь хэсэгт дурьдсан өрхүүдтэй амьжиргааг дэмжих стратегийн талаар хэлэлцүүлэг зохиох (ХШБ-ийн 1-р шатны тайлангийн дараа 59 өрхтэй зөвлөлдсөн шиг). Шинжээчийн тодорхойлсон нэрсийг ГТЗ эсвэл илүү олон хүнийг хамруулан нягтлан үзэх хэрэгтэй.</p>
10.	<p>Уст давхаргын хоорондын холбоо, газар хуваагдал зэргийг хамруулан ОТ-н нөлөөллүүдийг орон нутгийн нөхөн олговроор дамжуулан засч залруулахыг</p>

⁹ Малчдын бүлэг урьдчилсан тайланд өгсөн саналдаа нөлөөллийн бүсийг 5 км-ээр ахиулж, одоогийн нөлөөллийн бүстэй ойрхон гэхдээ тигээс гадуур малчдад учирсан нөлөөллийн асуудлыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Дахиад дурын хил зааг тогтоох нь зөв шийдэл биш гэж бид үзэж байгаа ба нөхөн олговор авсан малчидтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсан тул өөрийгөө мөн нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй малчид асуудлаа санал болгож буй 'Нөхөн олговрын хороонд' гаргах хэрэгтэй.

	санал болгож байна. Ялангуяа, байршил тогтоох гидрологийн судалгаа хийгдсэний дараа хэд хэдэн гүехэн гүний худаг барих хөтөлбөрийг ОТ сумтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй. Худгуудыг сумын хойно, зүүн, өмнө талд буй ашиглалт багатай газруудад байршуулах, ингэснээр боломжит шинэ бэлчээр, мал хариулах газар гаргаж, уламжлалт мал аж ахуйг дэмжин, ус, бэлчээрийн асуудлыг шийднэ. Энэ нь суманд уламжлалт мал аж ахуй эрхлэх боломжийг ханган, нутгийн иргэдэд өгөөжтэй нийтийн нөхөн олговроор ОТ-н ерөнхий нөлөөллүүдийг шийдвэрлэх юм.
11.	БХОТ ажиллагаанаас гаргасан зөвлөмжүүдийн хэрэгжилтийг баталгаажуулахын тулд ирэх таван жилд Хамтын ажиллагааны гэрээний санхүүжилтийн тодорхой хэсгийг Ханбогд сумын малчдын бэлчээр/ус/амьжиргааны төслүүдэд зориулах шаардлагатай.

Товчилсон үгүүд

ГХГЗЗГ	Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн Газар
ЭЗХНЗОГ	Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмены Газар
НОНХ	Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо
ХШБ	Хөндлөнгийн Шинжээчдийн Баг
ОУСК	Олон Улсын Санхүүгийн Корпораци
АММИ	Айвенхоу Майнз Монголиа Инк.
ТХХЗ	Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөл
БХОТ	Баримт Хамтран Олж Тогтоох
ОТМШБ	Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Баг
УЛТ	Уурхайн Лицензит Талбай
ОТ	Оюу Толгой
ТББ	Төрийн Бүс Байгууллага
АД	Ажлын Даалгавар
ГТЗ	Гурван Талт Зөвлөл
ХХБ	Хаягдал Хадгалах Байгууламж

Зургууд

ОТМШБ Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц



Ярилцлага өгч буй нь



Малын үзлэг




Ус хэмжилт



Нисдэг төхөөрөмж



Гадаргын ус, Баян баг



Тоосны занга тогтоож байгаа нь



Цоожтой худаг



Сумын засаг захиргаа



Катарын Зэрлэг Амьтад Хамгаалах Газар



Хил дээр дугаарлаж буй нүүрсний тэрэгнүүд

2017 ОНЫ 1 ДУГААР САР



БАРИМТ ХАМТРАН ОЛЖ ТОГТООХ ҮЙЛ ЯВЦ
ОТМШБ-ИЙН ТАЙЛАНГУУД

ЖЭЙ ЭС ЭЛ КОНСАЛТИНГ ЛТД.
ОКСФОРД, НВУ
www.shankleman.com

Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын усны чанар, хүртээмжийн үнэлгээ

Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд

Бүрэлдэхүүн 3: Нөхөн Олговрын Хөтөлбөрийг Хянасан нь Шинжээчдийн Тайлан

1. УДИРТГАЛ	2
1.1 Арга	2
2. ХАНБОГД СУМЫН БЭЛЧЭЭРИЙН ХЭМЖЭЭ, БЭЛЧЭЭРИЙН ЧАНАР, МАЛЫН УСАНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОГТООХ	3
2.1 Хам сэдэв	3
2.1.1 Уур амьсгал ба Байгаль орчин	3
2.1.2 Малын тоо	4`
2.2 Бэлчээр	5
2.2.1 Бэлчээрийн үнэлгээ	5
2.2.2 Ургамалжилтын хөндлөн огтлол	6
2.2.3 Алсын зайн тандалт	7
2.2.4 Бэлчээрийн чанар	7
2.2.5 Газрын хуваагдал, Дэд бүтэц	8
2.2.6 Нисдэг төхөөрөмж	9
2.2.7 ОТ-н Газрын хэрэгцээ	9
2.3 Ус	10
2.3.1 Усны эх үүсвэрүүд	10
2.3.2 Усны ай савын хоорондын холбоо	12
2.3.3 Үгүй болсон булаг, ус	13
2.4 Тоос	14
2.5 Манлай сумтай харьцуулсан нь	17
2.6 Малчдын байгаль орчны талаарх ойлголтын судалгаа	18
3. ХАНБОГД СУМЫН БЭЛЧЭЭР БА УСАНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД	19
4. ЗӨВЛӨМЖҮҮД 1) ЭКОСИСТЕМ БОЛОН УЛАМЖЛАЛТ МАЛ МАЛЛАГААГ СЭРГЭЭХ/ХАДГАЛАХ 2) ИРЭЭДҮЙД ОТ-С УЧРУУЛАХ НӨЛӨӨЛЛИЙГ ДААХ ЧАДВАР	22
5. ХАВСРАЛТУУД	26

1 Удиртгал

Энэ тайланд дараах асуудлуудыг авч үзлээ:

- 2003 оноос хойш Ханбогд сумын бэлчээр, малчдын усанд гарсан өөрчлөлтүүд
- Эдгээрийн аль хэсэг нь ОТ-н улмаас учирсан, ирээдүйд ОТ-с учруулах нөлөөллүүдийг даах бэлчээр болон малын усны хүчин чадал
- Экосистемийг хадгалж/сэргээх, уламжлалт мал маллагааг үргэлжлүүлэн авч явахын тулд юу шаардлагатай болох.

Энэ бүрэлдэхүүн хэсгийн ажлын даалгаврыг бүрнээр нь Хавсралт 1-д оруулав.

1.1 Арга

Энэ бүрэлдэхүүн хэсгийн ажлын даалгаварт хэрэгтэй мэлээллүүдийн дийлэнх нь бэлэн тайлангуудад байгаа (хоёрдогч эх үүсвэр) гэхдээ тайлангуудыг нөхөхийн тулд хээрийн судалгаа нэмж хийх шаардлагатай гэсэн. Хэрэг дээрээ бид ОТ-н баримт бичгүүдээс гадна хоёрдогч эх үүсвэрийг ихээр ашиглан, хээрийн судалгааг ч өргөн цар хүрээтэй хийлээ. Хээрийн судалгаагаар 2016 оны 5-7 сарын нөхцөл байдалд үнэлгээ хийж; хоёрдогч эх үүсвэрээс байгаль орчны асуудлаар их мэдээлэл авч, урьд өмнө байгаль орчны нөхцөл байдал ямар байсан тухай ойлголттой болсон.

- Хоёрдогч эх үүсвэрт уур амьсгалын мэдээ¹, ургамлын бүрхэвчийн түүхийг харуулсан хиймэл дагуулын алсын зайн тандалт,² уур амьсгалын нэмэлт тоо баримт³ болон тоосны ажиглалт⁴, ОТ-н болон зээлдүүлэгчээс заавал хийхийг шаарддаг тайлангууд⁵, байгаль орчинтой холбоотой бусад холбогдох судалгаа, ажлууд, засгийн газрын мэдээлэл, ярилцлагууд⁶ орно.
- Шинээр тоо баримт цуглуулах хээрийн судалгааны үеэр ургамалжилтийн хөндлөн огтлолын үнэлгээ, усны эх үүсвэрийн үнэлгээ, тоосны мониторинг, байгаль орчны ажиглалт (3,500 км газрыг хамарсан) малчдаас авсан байгаль орчны болон малын судалгаа, Манлай сумын мал маллагааны нөхцөл байдалтай харьцуулалт хийлээ. Хээрийн судалгааны дэлгэрэнгүй үр дүнг Хавсралт 3-9-д үзүүлсэн болно.
- Малчдаас авсан байгаль орчны болон малын судалгаа

¹ Сум, ОТ-с авсан.

² MODIS (NASA)

³ Уур Амьсгал Судлалын Нэгж, АНЭУ, ИБ. Харрис нар. 2014

⁴ Аэрозолын бүтээгдэхүүн MOD-4, NASA

⁵ Хавсралт 2-т жагсаасан

⁶ Хавсралт 2

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

2 ХАНБОГД СУМЫН БЭЛЧЭЭРИЙН ХЭМЖЭЭ, БЭЛЧЭЭРИЙН ЧАНАР, МАЛЫН УСАНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОГТООХ

2.1 Хам сэдэв

2.1.1 Уур амьсгал ба Байгаль орчин

Дасан зохицох, нүүдэллэх, амьжиргааны оновчтой стратеги баримтлах замаар байгаль орчны хомс гачаалыг даван туулдаг нүүдлийн мал аж ахуйн орчныг уур амьсгал бий болгодог. Монгол улсын хөгжлийн явцад мал аж ахуй уламжлалт хэв маягаасаа гарч зохион байгуулалттай, хяналттай Нэгдлийн хэлбэрт шилжиж байсан бол одоо бие даасан, зах зээлийн эдийн засагт суурилсан систем рүү орж байна. Амьжиргааны арга маяг, технологи, машин, бүтээн байгуулалт мал аж ахуйг өөрчилж байгаа ч байгаль орчин говь цөл хэвээрээ л байна. Уур амьсгалаас бэлчээр, усанд учруулж буй нөлөөллүүд нь бэлчээрийн ургамалжилт, усны эх үүсвэр ба боломж, түүнчлэн ган, зуд тохиохыг тодорхойлогч гол хүчин зүйл хэвээр байна.

Ханбогд суманд жилдээ дунджаар 95.3 мм хур тунадас ордог (сумын мэдээ). Үүний улмаас ургамалжилтийн түвшин бага, чийгшил өчүүхэн, гүний усны ундрага хязгаартай, зундаа ууршилт ихтэй. Жилийн дотор болон жил хооронд уур амьсгал ихэд хувьсамтгай байх нь хэвийн үзэгдэл (Зураг 1).

Монгол улсын Ус, Цаг уур, Орчны Шинжилгээний Газрын тодорхойлсноор 1940 оноос хойш агаарын хэм 2⁰ С хэмээр дулаарч, цэвдэг хайлан, хур тунадасны хэмжээ хувьсч, хатуу ширүүн ган, зуд болж Монгол орны уур амьсгал эрс өөрчлөгдөж байна⁷. Ханбогд сумын нөхцөл байдал ч улс даяарх хандлагатай адил; сумын хэмжээнд 40-жилийн туршид дулаарах хандлага мэдрэгдэж, жилийн дундаж хур тунадасны хэмжээ ялимгүй нэмэгджээ (Зураг 1) (Хавсралт 3).


Ургамлын гарц, улмаар малын өвс тэжээлд зуны хур бороо зайлшгүй чухал. Дэлхийн торлосон сүлжээний мэдээллийг⁸ (зургууд, Хавсралт 3) ашиглан Ханбогд (6 зонд хуваасан) болон Манлай (3 зонтой) сумын хур тунадасны мэдээнээс харахад:

- Бүс нутгийн хэмжээнд уур амьсгалын параметрууд ялимгүй ялгаатай.
- Ханбогд суманд зарим жилүүдэд хур тунадас ихтэй байсан (2003, 2008, 2010) ба 1989, 2012 онуудад ган болсон.

⁷ УЦУОШГ. Үндэсний Харилцаа Холбоо 2, UNFCCC. 2010.

⁸ Харрис нар. 2014

- Ханбогд сумын 6 зоны уур амьсгал цаг хугацааны туршид адил байсан (Хавсралт 3).
- 2002 оноос хур тунадасны хандлага бага зэрэг эерэг болж иржээ (Хавсралт 3).



Зураг 1. Ханбогд сумын хур тунадас, агаарын хэмийн жилийн дундаж, 1976-2014.

Эх үүсвэр: Ханбогд сум.

1960-2013 онуудын 6,7,8 саруудын тоо мэдээнээс хугацааны турш дахь зуны хур тунадасны хэмжээг маш нарийн тодорхой харж болохоор байна. Ялангуяа ургамал улмаар малын өвс тэжээл ургахад хур тунадасны цаг хугацаа маш чухал ач холбогдолтой. 2016 оны 5,6 сард хэд хэдэн өдөр бороо орсон нь (64 мм) бэлчээрийн гарцад нөлөөлсөн (Уур амьсгал, Хавсралт 3). Нэг малчин 'та нар энэ жилээр тооцож болохгүй – бороо их орж байна' гэсэн нь байгаль орчинд нөлөөлдөг уур амьсгалын үндсэн үүргийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг.

2.1.2 Малын тоо

Сумын тоо баримтаас үзэхэд 2003-2015 оны хооронд Ханбогд сумын малын тоо ихэд нэмэгджээ.

- Нийт малын тоо 53,346 байснаа 133,013⁹ болж 149%-иар өссөн.
- Бог ба бод малыг нийлүүлэн хонин толгойд шилжүүлэн үзвэл (тэмээ = 7 хонь; морь, үхэр = 6 хонь, ямаа = 0.9 хонь)¹⁰ малын нягтшил ихээр нэмэгдэж; 2015 оны байдлаар сумын хэмжээнд 321,160 хонин толгой малтай болсон байна.

Малын тооны өсөлт, бод мал ихэссэн нь бэлчээр, усны нөөцөд шууд нөлөөлж байна.

- Мал илүү их өвс идэж, ус ууна.
- Эрчимжүүлсэн мал аж ахуй эрхлэлт

⁹ Сумын тоо баримт 2015

¹⁰ Штернберг 2012.

- Уст цэгүүд дэх бөөгнөрөл
- Мал маллагааны нөөцийн төлөөх өрсөлдөөн

Малын тоо олширсноор ус, бэлчээрийн нөөцөд ихээхэн ачаалал авчирч байна. Мал олшрох тусам ус их шаардагдан, усны түвшин улам багасна. Бүс нутгийн мал бэлчээрийн хязгаарлагдмал өвс ургамлыг талхлагдахад хүргэж болох юм. Малын тоо толгойг өсгөснөөр усан хангамж багасч, худаг ундрэн дүүрэх хугацаа уртсан, ус хомсдож байгаа гэсэн ойлголтод хүргэж болох юм. Бүх багт малын тоо нэмэгдсэн нь сум даяарх хандлагыг илтгэж байна. УЛТ-н ойр орчим болоод уурхайн талбайн алсад ч нөлөөлөл нь адил байна. (Хавсралт 4).

Монголын уламжлалт мал маллагаанд малын тоог байгаль орчны нөхцөл байдалтай тохируулдаг. Нүүдэл, малын тоо толгой ба сүргийн бүтцийг зохицуулах нь амьжиргааны гол чухал стратеги байсан бөгөөд бэлчээрийг чөлөөтэй ашиглахын ашиг тусыг тодотгодог. Малчид малынхаа тухайд шийдвэр гаргахад өнөөгийн нийгэм эдийн засгийн хүчин зүйлс гол үүрэг гүйцэтгэн, шийдвэр гаргалт, нүүдлийн мал маллагааны хэв маягт шилжилт авчирч байна. ОТМШБ багийн хуралд суух үед хүмүүс “манай төчнөөн тооны малд ус хэрэгтэй байна” гэж хэлж байсан нь байгалиас тогтоосон тооны малтай байх байдал өөрчлөгдсөний илэрхийлэл. Үүнийг бодит байдалд буулгавал шинээр нэмэгдсэн малд илүү их ус, өвс тэжээл хэрэгтэй гэсэн үг. Малчид хэчнээн хүслээ ч сумын эсвэл малчдын хувьд шинээр худаг гаргах хүчин чадал хязгаарлагдмал гэдгийг умартаж байна. Нэмэгдсэн малынхаа хэрэгцээг хангах уст цэгтэй болох хүсэл нь ОТ-н үйл ажиллагааны үр дагавар биш. Энэ үзэгдэл нь орон нутгийн зарим иргэд улсын хийх ёстой ажил үүргийг ОТ гүйцэтгэнэ гэж хүлээж буйг харуулж байгаа юм. 2016-2025 онд сумын мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрт усны дэд бүтцийг нөхөн сэргээж (худаг, усан сан, шахуурга), бэлчээрийн судалгаа хийн, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр тусгажээ.¹¹ Ажлын Даалгаварт “зохистой/хүрэлцэхүйц/хангалттай,” гэдэг үгийг (бодит хүрэх/хүртэх боломж нөгөөх нь худгийн нөөц) монгол хэл рүү хөрвүүлсэн орчуулга зарим нэг байдлаар будилуулсан болохыг бид цохон тэмдэглэж байна.

2.2 Бэлчээр

2.2.1 Бэлчээрийн үнэлгээ

Хээрийн судалгаа, алсын зайн тандалтаар бэлчээрийг үнэлэхдээ ургамалжилтын динамик цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдсөнийг шалгаж үзэв. Бид бэлчээрийн үнэлгээ хийж, Оюу Толгой уурхайтай холбоотой биет хүчин зүйлс ургамалжилтанд нөлөөлсөн эсэхийг тогтооход анхаарлаа төвлөрүүлсэн.

¹¹ Ханбогд сумын Мал Аж Ахуйн Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр 2015

- Ханбогд сумын ургамлын бүрхэвчийг 12 хөндлөн огтлолд судлав (доорх Зураг 2). Малчдын ашиглаж буй газар нутаг дахь ургамлын нягтрал, бүтэц, малд тэжээллэг чанар зэргийг тодорхойлохын тулд хөндлөн огтлол тус бүрийг усны эх үүсвэр дээр авлаа.
- 2003-2015 онуудад ургамалжилт, газар ашиглалтын байдал ямар байсныг тогтоож, тайлбарлахын тулд хиймэл дагуулын алсын зайн тандалтын өгөгдлийг ашиглав (Хавсралт 6). Хуурайшилтай газарт ургамлын гарц хур тунадаснаас хамааралтай, тиймээс бэлчээрийн үр дүн үүр амьсгалтай нягт холбоотой.

2.2.2 Ургамалжилтын хөндлөн огтлол

Түүврийн аргаар сонгосон 12 худгийн мэдээллийг 1 км хөндлөн огтлолуудын дагуу авлаа. Хөндлөн огтлолуудыг бүгдийг нь худгийн хойд талд гаргасан. Худгаас холдох тусмаа бүрхэвч ямар байгааг харуулахын тулд ургамлын хэмжилтийг усны эх үүсвэрээс 25, 50 100, 200, 500, 1,000 метрийн зайд тус тус хийв. Зай тус бүрт бэлчээрийн 50 метр хэсэгт судалгаа хийгдсэн. Шугамын дагуу 1 метр тутамд ургамлын үндсэн бүрхэвчийн эзлэх хувийг ургамлын нягтралын хэмжээс болгон тэмдэглэн авлаа. Ургамлын бүтэц, тэдгээрийн малд тохиромжтой байдлыг тодорхойлохын тулд хөндлөн огтлолын дагуу ургасан ургамлуудын дээжийг цэг тус бүрээс авав (Хавсралт 5). 2016 он онцгой хур сайтай байлаа, ОТМШБ 5 сард хээрийн судалгаа хийж байхад хэдэн өдөр бороо орсон. Иймээс энэ жилийн ургамлын бүрхэвч бусад жилүүдийнхээс өндөр гарах төлөвтэй.

Хөндлөн огтлолуудаас тогтоосон нь:

- Сумын нийт цэгт ургамлын бүрхэвч бага, 12 цэгт бүрхэвч дунджаар 6.2-8.4% (Зураг 2).
- 9-р цэгт, сумаас зүүн хойшоо бүрхэвч илүү байхад УЛТ орчимд арай алслагдсан цэгүүдийнхтэй адилавартай байна.
- Ийм үр дүн нь байгаль орчны хүчин зүйлс, хур тунадас, газар ашиглалт (хойно авч үзнэ) зэргийн тусгал юм. Түүнчлэн судалгаануудыг 5 сард хийсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй, 7 эсвэл 8 сард явуулсан бол үр дүн өөр гарах байсан байж болно.
- Судалгааны үр дүн ОТ-н хийсэн үнэлгээний баримт бичгүүдэд заасан шиг сонгосон цэг бүрт 8-25% ба түүнээс дээш гэснээс доогуур гарсан^{12,13,14}.

¹² ОТ БОННУ Техникийн бус хураангуй БОННУ 2012, х.72.


¹³ БОННДУ 2006, х. 263.

¹⁴ Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг. Биологийн гол төрлүүдийн мониторинг, 2016, х.70.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman



Зураг 2. Ханбогд сум дахь хөндлөн огтлолын 12 цэгийн ургамлын бүрхэвч.

2.2.3 Алсын зайн тандалт

MODIS¹⁵-н алсын зайн тандалтын мэдээлэл 2003-2015 онуудад Ханбогд суманд бэлчээрийн ургамалжилт ямар байсан түүхийг харуулж байна. ОТ-н хойд хаалга, Ханбогд сум, багийн төвүүд зэрэг чухал цэгүүдэд гол анхаарлаа хандуулав. Үр дүнд нь үндэслэн газар ашиглалт, доройтол, ургамалжилтанд гарсан өөрчлөлтүүдийг үнэлж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас бэлчээрийн газар нэмж багассан эсэхэд үнэлгээ хийлээ.

Өгөгдлөөс үзэхэд 2003, 2008, 2010 онуудад ургамлын бүрхэвч харьцангуй өндөр байсан нь дээр харуулсан дундаж хур тунадастай тохирч байна. Үүний адил 2012 онд хур бороо ч бага, бэлчээрийн ургамлын хэмжээ ч бага байв. Ургамлын Нормчилсон Ялгаварын Индексийн (Normalized Difference Vegetation Index, NDVI) газрын зургууд дээрх ялгаа нь жилээс жилд газрын гадаргын байдал өөрчлөгдөж байсныг илтгэнэ (Хавсралт 6). Ургамлын бүрхэвчид учирсан гол нөлөөлөл нь хур борооноос шалтгаалсан гэж бид дүгнэж байна.

2.2.4 Бэлчээрийн чанар

Бэлчээрийн чанарыг ойлгоход хамааралтай хэдэн зүйлс байдаг.

- Тэжээллэг чанар. 2016 оны хөндлөн огтлолуудаар ургамлын бүрхэвч, төрлийг тодорхойлсон бөгөөд ихэнх ургамал мал идэхэд тохиромжтой гэж тогтоов.

¹⁵ MODIS (NASA): modis.gsfc.nasa.gov/data/dataproduct/mod13.php

- Малын тоо. Энэ нь бэлчээрийн ачаалал, гарцад нөлөөлдөг. 2003-2015 онуудад сумын малын тоо хоёр дахин өссөн нь (Хавсралт 5) бэлчээр ашиглалт, гарцад нөлөөлсөн байна.
- ОТ-н одоогийн үйл ажиллагаа – явагдаж буй ажлууд, тээврийн хөдөлгөөн УЛТ дотор болон холбоотой дэд бүтцийн хүрээнд хийгдэж байгаа тул одоогийн байдлаар бэлчээрт учруулж буй нөлөөлөл нь доод хэмжээнд байна. Бэлчээрт хөнөөл учруулахуйц үйл ажиллагаа явуулж буйг нотлох баримт байхгүй; малчдад өмнө учирсан нөлөөллүүдийг Бүрэлдэхүүн 2-т, мөн ХШБ-ийн ажлаар авч үзсэн болно.
- Биомасс, хөрсний чийгийг үнэлэх талаар Ажлын Даалгавар, ажлын төлөвлөгөөний алинд ч тусгаагүй тул үнэлгээ хийгээгүй.

Бэлчээрт нөлөөлж буй нэмэлт хүчин зүйлст засаг захиргаа ба малчдаас буюу хүмүүсийн гаргаж буй шийдвэр орж байна. Малчдын бууцыг (ихэвчлэн өвөлжөө, хаваржаа) тогтоож өгөх, худгийн хүрэлцээ, засвар үйлчилгээ, нүүдэл суудал болон бэлчээрийн нөөцийн хүртээмжийг зохицуулах, усны эх үүсвэрийг цоожлох гэх мэт де-факто эзэгнэх явдлыг хязгаарлах, зөрчлөөс сэргийлэх, шийдвэрлэх, малын бэлчээр ашиглахад нөлөөлдөг гол чухал хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой зохион байгуулалт хийх/хариуцах нь засаг захиргааны үүрэгт ордог. Жишээ нь: Таван Толгойн зам, төмөр зам, замууд болон хүнд даацын тэргүүд, онцгой байдлын үед малын тэжээл тараах, Катарын зэрлэг амьтныг хамгаалах газар (сумын төвөөс зүүн тийш хашаалсан өргөн уудам хориотой газар), онцгой хамгааллын бүс, бусад замын ажлууд болон компаниудын үйл ажиллагаа гэх мэт. Малчид ч мөн малын тоо, төрөл, нүүдэл, отор, нэг худаг дээр олуулаа бөөгнөрөх, бусдын малыг тавиулж маллах, нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэхийн оронд малын тоо толгойг өсгөн ашиг олохыг илүүд тавьдаг хөдөлмөрийн асуудлууд гэх мэтээр бэлчээрт нөлөөлөл учруулж байдаг. Өмнө дурьдсан хүчин зүйлс нийлээд бэлчээрийн бүтээмжид муугаар нөлөөлдөг аж. Бодож байснаас эсрэгээрээ УЛТ-н орчим мал бэлчээрлүүлэх явдал үзтэл их байсан нь малчид энэ хавийн газрыг боломжийн гэж үздэгийг харуулж байна. Дахин хэлэхэд 2016 оны элбэг хүр бороо уур амьсгал бэлчээрт түлхүү нөлөөлдгийг үзүүлж байна.

Бэлчээрийн ашиглалт, мал маллагагааны арга ажиллагааг сайжруулахын тулд ОТ малчдын 14 нөхөрлөл болон бэлчээрийн бүлгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлжээ¹⁶. Энэ санаачлага нь байгаль орчны ижил нөхцөлд байгаа малчдын амьжиргааны асуудал, дарамтыг шийдвэрлэх, газар ашиглалтын төлөвлөгөө гаргахад нь зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн. Гаднаас дэмжлэг авсан бүлэг эсвэл бэлчээр, ус ашиглах үр ашигтай менежментийн үр дүнгийн талаар бодитой баримт байхгүй байна.

2.2.5 Газрын хуваагдал, Дэд бүтэц

УЛТ-н орчим газар хуваагдсан нь малчид тэр хавийн бэлчээрт хүрэх боломжид ноцтой нөлөөлжээ. Бусад тусдаа хүчин зүйлүүдээс гадна ихээхэн газар нутгийг таслан хуваасан нь (ж:

¹⁶ Оюу Толгойн Бэлчээр, Амьжиргаа Сайжруулах Стратеги 2013.

замууд, нисэх буудал гм) мал маллагаанд саад учруулж байна¹⁷. ОТ-той холбоотой дэд бүтцүүд нэг дор байгаа нь тэр хавьд мал бэлчээхэд саадтай, уламжлалт нүүдлийн мал аж ахуйн хэв маяг, орон нутгийн газар ашиглалтыг алдагдуулсан хориотой бүсийг бий болгожээ. Энэ нь байгаль орчны байр байдлыг өөрчилсөн дэд бүтцүүд оршдог УЛТ-н зүүн хойд хэсэгт илүүтэй ажиглагдлаа:

- Ханбогдын зам; нисэх буудлын зам; нисэх буудал; Гүний Хоолойн (ГХ) зам; ГХ-н шугам
- Хайрган ба хучилттай замууд бэлчээрийг хуваан, малын хөдөлгөөнд саад учруулж байна. Хаа нэгтээ тааралдах малчдын машин тэргэнд тийм нөлөөлөл байхгүй.

Уурхайгаас хил хүрсэн ОТ-н зам мөн бэлчээрийг хувааж, мал, зэрлэг амьтад нэвтрэхэд хүндрэл учруулдаг. Нутгийн хүмүүсийн хэлснээр мал амьтан зам гарахаасаа цэрвэдэг, тэмээ болон бусад зэрлэг амьтад ихэнхдээ шөнө зам гардаг аж. Амьтдад зориулсан гарам байгаа хэдий ч нэгэн малчны хэлснээр амьтад 'тэр тэмдгийг уншиж чадахгүй шүү дээ'. ОТ болохоор зам дээр малчдын мал үхэж үрэгдсэн явдал гараагүй гэж байхад тэмээд нь зам дээр дайруулсан гэж буй малчин ч байна. Гол нь мал амьтны гарам үр дүн муутай хийгдсэн, амьтад зам гарах хэсэгт ачааны тэрэгнүүд хурдаа хасдаггүй байдал ажиглагдсан.

2.2.6 Нисдэг төхөөрөмж

Бэлчээр, ус, байгаль орчныг агаараас үнэлэхийн тулд нисдэг төхөөрөмж - дрон ашиглав (зураг авах чадвартай агаараар нисдэг төхөөрөмж). Зорилго нь ургамлын нягтрал, хэв маягийг тодорхойлох, газрын гадаргууг бодитоор зураглах, уст цэгүүд дээрх малын байдлыг судлах, уурхайн хориотой бүс, худгууд, суурин газруудын ойр орчмын газрын талхагдлыг үнэлэхэд чиглэсэн. Гэвч цаг агаар таарамжгүй байснаас нисдэг төхөөрөмжийн ажиллагаанд саад боллоо. Хэдэн өдөр бороо орж, хүчтэй салхилснаас нисдэг төхөөрөмжийг аюулгүй нисгэх боломж олгоогүй. Хэд хэдэн удаагийн оролдлого амжилтгүй болж, үнэлгээнд хэрэглэх фото зураг ч үгүй сүртэй сүйрээд өнгөрсөн.

2.2.7 ОТ-н газрын хэрэгцээ

ОТ-н хөндсөн газар нь сумын 15,200 км² нутаг дэвсгэрээс¹⁸ 200 км² талбайг¹⁹ эзэлж байна. УЛТ, холбогдох дэд бүтцүүд нийлээд 104.1 км² газарт²⁰ оршдог. Үүний дийлэнх буюу 86.2 км²-ыг УЛТ эзэлдэг, дараагаар нь усны шугам хоолой болон нисэх буудал орж байна. Сум даяар хөндлөн гулд явах өргөн цар хүрээтэй тээврийн хөдөлгөөн 200 км² газарт нэмэлт биет

¹⁷ Оюу Толгойн Нийгэм Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээний эцсийн тайлан. 2009.

¹⁸ Ханбогд сумын Мал Аж Ахуйн Салбарын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр 2015.

¹⁹ Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо, 2012 оны БОННУ, В-10.

²⁰ ОТ БОННУ 2012, В-10.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

Албан бус орчуулга – Орчуулгын утга зөрж байвал бичиг баримтын эх хувийн утгыг баримтлана.

нөлөөлөл учирч байна. Энэ нь сумын нийт нутаг дэвсгэрийн 1.3% - 0.6% нь хашаагаар тусгаарлагдсан, орох боломжгүй (УЛТ) болсон, 0.7% нь эвдэгдсэнийг харуулж байна (замууд, шугам хоолой, хуваагдал). Ханбогд сумын Бэлчээрийн чанар, нөхцөл байдлын талаарх мэргэжлийн хяналтын тайланд (ГХГЗЗГ)²¹ 2003-2010 оны хооронд бэлчээрийн бүст 'дөнгөж ялихгүй өөрчлөлт' орсон гэж тодорхойлжээ. Уг тайланд сумын хэмжээнд 13,476 км² бэлчээрийн газар байна гэж тогтоосон.

2.3 Ус

2.3.1 Усны эх үүсвэрүүд.

Усны хомсдол, худгийн усны түвшин багасч байгаа, гүний худаг хэрэгтэй тухай Ханбогдын малчид болон сумын албан тушаалтнууд олонтоо ярьж байсан. Усны асуудал, малчдын усны эх үүсвэрт гарсан өөрчлөлт, ОТ-с усанд үзүүлж байж болзошгүй нөлөөллүүд зэргийг судлахаар хээрийн судалгаа зохион байгуулав. Үүгээр усны эх үүсвэрүүд, түгээлт, чанар, хүрэх боломж, мөн усны динамикт 2003 оноос хойш гарсан өөрчлөлт зэргийг үнэллээ. Усны суурь мэдээлэл байхгүй тул усны нөөцөд цаг хугацааны түршид гарсан өөрчлөлтийг нарийн тогтоох боломжгүй байлаа.

- Усны талаарх мэдээлэл, тайлангуудыг үнэлж үзлээ. Ингэхдээ БОННУ-нүүд, RPS Акуатеррагийн тайлан, Байгаль Орчин, Нийгмийн Хөндлөнгийн Зөвлөхийн тайлан болон бусад тайлангууд, ОТ-н усны мониторингийн мэдээлэл зэрэгт төвлөрөв. (Хавсралт 2-ыг үзнэ үү).
- Усны хүрэлцээ хангамж нь уур амьсгал, хур тунадастай холбоотой
- Малыг тоо хэрэгцээнд нөлөөлж байна
- ОТ ус татаж байгаагаас учирч болзошгүй нөлөөлөл ноцтой асуудал
- Ус хангамжийн тодорхойгүй байдал усны мониторингийг тогтмол хийж байх хэрэгтэйг илтгэж байна.

Гол 4 багийн хүрээнд түүврийн аргаар сонгосон 67 эх үүсвэрийг (Хүснэгт I) судалж тогтоосон нь:

- уст цэгийн 69% нь гүехэн гар худгууд байна
- Эдгээрээс >80% усны түвшин 2 метр хүрэхгүй
- уст цэгийн 21% нь моторт гүний худгууд
- Гүний худгийн 85% нь цоожтой байсан.

²¹ Ханбогд сумын Бэлчээрийн чанар, нөхцөл байдалд хийсэн мэргэжлийн хяналтын тайлан. 2010. Газрын Харилцаа, Геодези, Зураг Зүйн газрын захиалгаар Ланрес Ко. Лтд гүйцэтгэсэн.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

Албан бус орчуулга – Орчуулгын утга зөрж байвал бичиг баримтын эх хувийн утгыг баримтлана.

Энэ нь хоёр гол асуудлыг тодотгож байна – усны дийлэнх хувийг гүехэн гар худгаас авдаг (малчид, сумын албан тушаалтнууд хэн хэн нь моторт гүний худгийн хэрэгцээг онцолж байсан боловч) (Хүснэгт 1) ба одоо байгаа усанд хүрэх боломж тэдгээрийг эрхшээлдээ байлгаж буй биет (цоожтой худаг) болон болзолт (өвөлжөө) арга хэлбэрийн улмаас бүүрсан (Хавсралт 7). Малчид уст цэгийг хамгаалах үүднээс цоожилдог гэж байхад сумын зүгээс худгууд улсынх тул нийтээрээ хэрэглэж, арчлах ёстой гэж байв. Усны эх үүсвэрүүдийн дийлэнх нь сайн буюу боломжийн чанартай; заримийнх рН эсвэл хатуулгийн (TDS) түвшин их байв (Хавсралт 7). 2016 оны хавар бороотой байсан нь усны түвшинд эерэгээр нөрөөлж, худгуудаас гадна түр зуурын гадаргын усны эх үүсвэрүүд бий болгосон. Худгийн гүн болон ундаргын хэмжээ Ажлын даалгаварт ороогүй тул үнэлгээ хийгээгүй.

Хүснэгт I. Усны эх үүсвэрийн төрөл; гар худгийн усны түвшин.

Water Well Type	#	%	Hand Well - Level		
			Metres	#	%
Hand	46	69	≤ 1	12	26.1
Motor	14	21	≤ 2	24	52.2
Surface	5	7	≤ 3	4	9
Delivery	2	3	≤ 5	2	4.3
			≤ 9	2	4.3
			unknown	2	4.3

Хээрийн судалгаа, ОТ-Малчдын усны мониторингийн тайлан зэргээс үзэхэд мониторинг хийгдэж байсан хэд хэдэн худгийн усны түвшин 2011-2016 онуудад ойролцоо байсан байна²². ОТ барьсан буюу сэргээн засварласан худгийн тооны тухайд ОТ-н тайлан (103) болоод сумын бүртгэлийн (37) хооронд зөрүү гарсан. Энэ нь сум дахь бүлгүүд хоорондоо холбоо харилцаа муутайг мөн усны нөөцийг үнэлэх баримтат үндэслэлийг үнэлэх хэр хүндрэлтэйг харуулж байгаа юм. 2003-2015 онуудад малын тоо хоёр дахин өссөн нь (4.2 хэсгийг үзнэ үү) малын тоо их хэмжээгээр өсөхөд хангалттай усны эх үүсвэр суманд байсныг илтгэж байна (Хавсралт 4). Малын тооны өсөлт малчны гаргасан шийдвэрийг харуулж байгаа бөгөөд ОТ-той холбоогүй юм (Бүрэлдэхүүн 2-ын тайланг үзнэ үү). Малын тооны өсөлт байгаль орчинд шууд нөлөөлөл үзүүлсэн, усны хэрэгцээ, хэрэглээ ихэсч, хэмжээ нь буурсан, усны эх үүсвэрүүдийн дэргэд олон мал цугларч, бэлчээрийн нөөцийг илүү хэрэглэх болжээ. Түүнчлэн энэ нь малчдын дунд бэлчээр, усны төлөөх өрсөлдөөнийг гааруулсан. Малын тоо толгой уурхайн талбайд ойрхон байгаа Жавхлант, Гавилууд багуудад илүү их нэмэгджээ (Хавсралт 4). Малчид ус байгаа газар руу нүүдэллэж оторт гарсан хэвээр, учир нь бэлчээрт хүрэх боломжтой эсвэл хязгаарлагдмал байх нь үүнээс шалтгаалдаг.

Малчдын ус хүртэх арга өөрчлөгдөж байна. Моторт шахуурга ашиглан ус татдаг болж. Үүнийг гүний худагт хэрэглэдэг бол гүехэн гар худагт шахуурга ашиглах явдал ихэсчээ. Ингэснээр ус

²² ОТ Усны мониторингийн тайлан, харьцуулсан график. 2016.

авах ажиллагаа илүү үр дүнтэй болох ч гараар ховоодсоноос илүү хурдтайгаар ус татаж байна гэсэн үг. Үүний үр дагварт худаг хурдан доошилж, ундрах хугацаа нь уртсана, мөн мал нэг удаад уух хэмжээнээс илүү их ус татагдаж онгоц дүүрэн үлдээж байна. Усыг моторт шахуургаар татаж байгаа тохиолдолд хуучин шигээ худгийн ус буцаж ундрэн дүүрэх хугацаагаар худгийн усыг үнэлж байгаа нь тохиромжтой хэмжүүр биш. Ийм элбэг үрэлгэн байдал харьцуулсан сумынхаас өөр байна.

2.3.2 Усны ай савын хоорондын холбоо

ОТ-той холбоотой Ханбогдын усны томхон асуудал бол сумын хэмжээгээр гүехэн болон гүний усны давхаргууд хэдий ялимгүй ч холбоотой байж болзошгүй явдал гэж ОТМШБ үзлээ²³. Усны талаар өчнөөн тайлан байвч асуудал тодорхойгүй хэвээр.²⁴ 2009 онд ОТ ямар ч холбоогүй гэж баталж байсан²⁵ бол одоо сумын гүехэн болон гүний усны давхаргууд холбоотой байж болохыг хүлээн зөвшөөрчээ.²⁶ Ийм 9 худгийг ОТ тогтоож, засан залруулах ажил явагдаж байна. Тоо хэмжээ болон ямар нэгэн ирээдүйн нөлөөлөл байгаа эсэх тодорхойгүй. Усны нарийн төвөгтэй түүхийг үнэлэхийн тулд гидрологийн баримт бичгүүдийг судалж үзээд тогтоосон нь:

- УЛТ-н дотор аллювын уст давхаргууд өгөршсөн ул чулуулгатай холбоотой нь тогтоогдсон. Гүний усыг авснаар аллювын уст давхаргаас ус алдагдан сум дахь зарим нэг худгийн ундарга багассан байх өчүүхэн магадлалтай. Ингэж болзошгүйг Акуатеррагийн бүс нутгийн гүний усны загварчлалд дурьдсан байсан²⁷.
- Ул чулуулгын ай саваас ус татах нь аллювын уст давхаргын гидравлик налууг ихэсгэх хандлагатай.
- Аллювын уст давхаргын ямар нэгэн загварчлалын тухайд тодорхой мэдээлэл байхгүй байна. Бусад улс оронд хийснээр энэ нь өгөөжийн хувьсамтгай болон тогтвортой байдал, загварчлалын тухай ойлголтыг сайжруулах параметруудийг нэмж өгч, хангамжийн удирдлага, хяналтанд тус болдог.
- ус алдагдаж байгаагүйг батлах ус авч эхэлснээс хойш өнөөг хүртэлх аллювын ай савын мониторингийн мэдээ дутмаг.
- малчдын мал усалдаг арга барил, усны хэрэгцээний талаарх суурь болоод шинэчилсэн мэдээллийг тайлагнаж байгаагүй. ОТ-н үйл ажиллагаатай

²³ Дэлхийн Банк. 2010. Монгол улс - Өмнийн говийн бүсийн байгаль орчны үнэлгээ.

²⁴ Энэ тайланг өгсний дараа Гүний Хоолойн газрын гүний усны загварчлалд өөрчлөлт орсныг тэмдэглэе.

²⁵ БОННУ 2009, х. 104.

²⁶ ОТМШБ-ийн тайлангийн төсөлд ОТ-н ирүүлсэн тайлбар. 2016 оны 11 сарын 2

²⁷ Усны Мониторингийн Төлөвлөгөө, Акуатерра. 2013.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

холбоотойгоор орон нутгийн усны ай савын боломж ямар байхыг тодорхойлохын тулд ус хангамжийн жил хоорондын хувьсал эсвэл малчдын усалгааны арга барилыг газар зүйн хувьд зураглаж гаргах тухайд хийсэн ямар нэгэн хэлэлцүүлэг байхгүй байна.

- Барилгын ажлын үеэр зарим нэг ус алдагдсаныг хүлээн зөвшөөрсөн²⁸.
- Аллювын гүний усыг хэрхэн зохицуулж байсан тухай нарийн мэдээлэл байхгүй.
- Ундай голын гольдролын өөрчлөлт үрсгалын дээд талын аллювын ай савын хуримтлалд нөлөөлсөн.

ОТ-н усны цооногийн²⁹ тайлангуудад бүс нутагт мониторингийн түвшин нь харилцан адилгүй 476 цооног байгааг тодорхойлжээ. Тэдгээрийн нэлээдийг нь ОТ үйл ажиллагааг хариуцан явуулж эхлэхээс өмнө өрөмдсөн. Хоорондоо холбоотой байдал гарсан; сумын бусад хэсэгт уст давхаргын нэвчилт үүсэхгүй гэдгийг ямар ч эргэлзээгүйгээр тогтоож чадахгүй. Ирээдүйд холбогдох магадлал өчүүхэн байлаа ч асуудлын гол нь тодорхой байршилдаа биш харин ОТ бусад газарт ийм байдал бий болоогүй эсвэл бий болохгүй гэдгийг харуулж чадахгүйд оршиж байна. Хэрэв хоорондоо холбоотой бол малчдын хэрэглэдэг гүехэн гүний усны түвшин багасч байж магадгүй. Үүнийг Гүний Хоолойн тайланд тодорхойлсон байна³⁰. Гидрологийн хяналтаар холбоотой байх магадлалтайг тодорхойлсон; уурхайн үйл ажиллагааны улмаас малчдын усны нөөц алдагдахаас сэргийлэх хариуцлагаа Оюу Толгойн хүлээн зөвшөөрдөг.

2.3.3 Үгүй болсон булаг, ус

Хэд хэдэн худаг, булаг алдагдсанд санаа зовинож буйгаа (ОТМШБ-ийн 2 дахь явцын тайланд дурьдсан) малчид ХШБ-т илэрхийлсэн ба энэ нь³¹ ОТМШБ-ийн хээрийн судалгаагаар нотлогдсонгүй. Хэд хэдэн цэгүүд устай байсан (усны шинжилгээний хариу 60-67, Хавсралт 7), үсгүйгээс биш харин засварлаагүй эсвэл ойрхон усны өөр эх үүсвэр байдаг тул ашигладаггүй юм байна. Нэг тохиолдолд 'үгүй болсон' гэсэн 3 эх үүсвэр ОТ-н барьж өгсөн ажиллагаатай гүний худгийн хажууд байсан (N 43.0964; E 106.7171). Жагсаалтанд байгаа булаг задгай өмнө нь ямар бүтээмжтэй байсныг үнэлэх аргагүй; 2 нь ажиллагаатай худгын хажууд байсан, нэгийг нь худаг болгосон, нэг нь бага зэргийн чийгтэй байлаа. Усны эх үүсвэр эсвэл түвшинд гарсан өөрчлөлт мал аж ахуйн амьдрах чадварт нөлөөлсөн гэдэг тодорхойгүй, өөрчлөлтүүд ч ОТ-той шууд хамаатай биш байна. Булгийн асуудал бол хаа нэгтээ цооног руу ус алдаж байгаа том асуудлын нэг хэсэг юм.

²⁸БОННУ В5. 2012.

²⁹ ОТ Цооногийн ID хураангуй, гм. 2015.

³⁰ Гүний Хоолойн Газрын Доорх Усны Загварчлалын Тайлан. RPS Акуатерра 2013. 2015.

³¹ ХШБ-ийн 1-р шатны тайлан 2015

Ундай голын талаар ХШБ-ийн усны тайланд авч үзсэн.

2.4 Тоос

Ханбогд сумын мал аж ахуйд учирч буй байгаль орчны томоохон асуудал бол тоос гэж малчид тодорхойлсон. Тоосны нөлөөлөлд мониторинг хийхээр 2016 оны 5 сард сумын хэмжээнд 43 тоосны занга суурилуулсан нь малчдад чухал ач холбогдолтой газруудад үнэлгээ хийх боломж олгов (аргууд ба газрын зураг - Хавсралт 8). Зорилго нь сумын өөр өөр цэгүүдэд аэрозол тоосны хэмжээг тогтоож, төвлөрлийн бүсийг тодорхойлох байв.

- УЛТ-н ойр болон алсад буух тоосны хэмжээг тогтоохын тулд занга суурилуулахдаа хориотой бүс, уурхайгаас алслагдсан бүс аль алиныг хамруулав.
- Үүнд Ханбогд-ОТ зам, уурхайн лицензит талбайн орчим (УЛТ), малчдын бууц, багийн төвүүд, усны эх үүсвэрүүд болон сум дахь цэгүүдийг хамрууллаа (Хавсралт 8). Зарим цэгийг малчид санал болгож, дийлэнх байршлийг ОТМШБ тодорхойлов.
- Сумын хэмжээнд тоосны хаягдлыг тодорхойлохын тулд цэгүүдийг өргөн газар нутагт байрлуулах зайлшгүй шаардлагатай байлаа.
- Занга ашигласнаар суман дахь тоосыг орон нутгийн түвшинд үнэлсэн.
- Зай, цагийн хуваариас шалтгаалан зангуудыг өөр өөр өдөр суурилуулсан, тийм болохоор цаг агаар, байгаль орчны нөхцөлийг шууд харьцуулах боломжгүй.

Онцлог нь 2016 оны 5 сард хэдэн өдөр бороо орж, салхитай байсан нь өөр өөр цэгүүдэд тоос хуримтлагдах, түүнийг цуглуулах ажилд нөлөөлсөн байж болзошгүй. Иймээс үр дүн суман дахь тоосны тархалтын тухайд санаа л өгч байгаа болохоос яг таг эцсийн биш юм. Олж тогтоосон зүйлээс үзэхэд сумын хэмжээнд тоос янз бүр байна (Хавсралт 8-г үзнэ үү).

- Ханбогдын замын дагуух 2 цэгт хамгийн өндөр хэмжээтэй байв, гэтэл бас л замын дагуу байх өөр бусад цэгүүдэд тэр хэмжээний 1/4 - 1/7 тэй тэнцэх тоостой байлаа.
- Сумын төв болон өндөр хүчдэлийн шугам дагуух алслагдсан цэгт адил өндөр хэмжээний тоос илэрсэн.
- Жавхлант, Гавилууд багуудаас илүүтэй Номгон багийн төв хамгийн их тоостой гарсан.
- Хуучин нисэх буудал, замын хучилттай хэсэг, Ханбогдын замаас 250 метр дэх цэгүүдэд тоосны хэмжээ бага байлаа.
- ОТ-н ойр орчмын зарим цэгт харьцангуй бага байхад сумын төвөөс зүүн тийшх газруудад илүү их байв.
- Уурхайд ойр, хуучин нисэх буудал, хучилттай зам, малчдын бууц гэхээс илүүтэй байрлал, салхи, цаг агаар, байгаль орчин зэрэг бие даасан хувьсагчүүд илүү холбогдолтой байв.
- Химийн бодисын шинжилгээ хийхийг Ажлын даалгавар, ажлын төлөвлөгөөний алинд ч заагаагүй. Ямар ч байсан химийн бодисын шинжилгээ эх үүсвэртэй холбодоггүй

(зөвхөн дүгнэлт гаргана). Хэрэв ирээдүйд химийн шинжилгээ хийгдвэл энэ нь ОТ-н эх үүсвэрийг нүүрсний зам, Говийн тоос зэргээс ялгахын тулд УЛТ-н доторх химийн бодисын шинж чанартай холбогдож байна уу гэдгийг тодруулахад л зөвхөн хэрэгтэй.

Ханбогдын замын хучилтгүй хэсгүүдэд бага, өндөр хэмжээтэй холимог бүртгэгдсэн. Үр дүн, ажиглалтаас харахад Ханбогдын замд ойрхон хэсгээс (250 метр) цааш тоосны нөлөөлөл хязгаарлагдмал байгаа нь тоосны үнэлгээний олон улсын нормын³² дагуу; замын хөдөлгөөний хувь хэмжээ ОТ-той бус орон нутгийн машин тэрэгнүүдтэй холбоотой байна.

УЛТ-гаас гадагш хэд хэдэн тоосны болзошгүй эх үүсвэрүүд байгаа нь:

- Төмөр замын барилгын ажил,
- Таван Толгойн зам дээрх нүүрсний тэргүүд,
- Манлай сум хүрэх зам,
- Хайрга, шорооны карьерууд,
- өндөр хүчдэлийн шинэ шугамын барилгын ажил,
- Хятадын хилийн ойролцоох Хайрхан баг дахь машин тэрэгний хөдөлгөөн,
- хуурайшсан голын сайрууд,
- мал бөөгнөрсөн нутаг
- малчдын машин тэрэгнүүд.

Шороон замууд Жавхлант багт 75 метр, Баян багт 55 метр өргөнтэй байна (Ханбогдын 11 метр өргөн, 2-4 метр зөөлөн шороон энтэй замтай харьцуулахад). Шороон замаар явах хүнд даацын машины хөдөлгөөн (ялангуяа нүүрсний тэрэг), шинээр шороон зам гаргах, голын гольдролыг орон нутгийн (ОТ-н биш) барилгын материал авах зорилгоор ухах зэрэг нь элэгдлийн явцыг түргэсгэж, тоос дэгдэх эс үүсвэр бий болгож болох юм.

Анхан шатны болон хоёрдогч судалгаагаар тоосны хэмжээ, тархалтанд анхаарлаа хандуулав. Хүний эрүүл мэндэд тоосны үзүүлэх нөлөөллийг үнэлэх нь судалгааны хүрээнээс хальсан зүйл. Говь цөл Хөдөө газарт уушиг, амьсгалын замын эрүүл мэндийг шинжлэхийн тулд а) амьсгалын замын хамгийн том эрсдлийг авчрагч тамхи таталт б) зуухны утаа в) орчны тоосонд үнэлгээ хийх хэрэгтэй³³. Хуурай орчинд хүмүүс нь тоостой нөхцөлд өсдөг, тийм болохоор 'нэмэлт' тоос эсвэл тоосны эх үүсвэрийг үнэлэх хүндрэлтэй³⁴. Ханбумбатын нисэх

³² Зөвхөн замаас 200 метрт байрлаж буй газруудыг агаар бохирдуулчийн нөлөөнд өртсөн гэж үздэг.

НВУ Замын Газар. Зам, Гүүрийн Зураг Төслийн Заавар. standardsforhighways.co.uk/ha/standards/dmrb/vol11/section3/ha20707.pdf. PM₁₀ impacts are considered negligible beyond >200 m.

³³ П. Бакстер, Кембриджийн Анагаахын Сургууль, хувийн захидал харилцаа, 2016.

³⁴ Дээрхэд.

буудал 2016 оны 5 сарын 22-нд шороон шуурганы улмаас түр хаагдсан нь үүний жишээ. Энэ нь газар нутгийг нэлд нь хамарсан үзэгдэл, цөлийн орчинд уудам нутгийг хамарсан тоосны үзэгдэл болж байдлын баримт юм; тоосны эх үүсвэрийг яг таг тодорхойлох эсвэл ялгаж салгах боломжгүй. 2015-2016 онд Ханбогд сумын эмнэлэгт тоостой холбоотой шинж тэмдгийн улмаас хэвтэж эмчлүүлсэн тохиолдол гараагүй байсныг бид тэмдэглэе.

Тоосны түүхэн тоо баримт гаргахын тулд бид МОДИС-ын тоостой нөхцөл байдалд хэмжилт хийдэг алсын зайн тандалтын мэдээллийг ашиглан Ханбогд сумын аэрозолын үзэгдэх гүний судалгаа хийв.³⁵ Үр дүнгээс харахад 2000-аад онд их хувьсалтай байгаа нь уурхайн сайтын барилгын ажил, Таван Толгойн хучилтгүй замын тээврээс үүдэлтэй байх. Сумын хэмжээнд 2005-2010 онуудад тоосны хэмжээ хамгийн их байсан байна (доорх Зураг 3). 2010 оны намраас хойш тоос мэдэгдэхүйц буурчээ. 2011 – 2015 онуудад жилийн доторх хэлбэлзэл хавартаа арай өндөр (салхины аястай холбоотой), намар арай бага, 0.1-ээс (маш цэвэр агаар) 0.3-ын (тоостой нөхцөл) хооронд байсан байна. ОТ-н тоосны мониторингоор тоосны түвшин ойролцоо болон багавтар харагдаж байна; эдгээрээс үзэхэд тоос бол байгаль орчны амгалан тайван байдлыг алдагдуулах гол эх үүсвэр биш байна.

2013 онд талбайн дотор болон гадна талд Монголын тоосны стандартаас давж байсныг БОНХЗ тогтоожээ.³⁶ ОТ-н одоогийн мониторингоор тоосны хэмжээ гайгүй байгаа ч өмнө нь давж байсныг харгалзан мониторингийг үргэлжлүүлэн, нутгийн иргэдэд үр дүнг тодорхой мэдээлж байх хэрэгтэй.

Малын эрүүл мэндэд тоос нөлөөлж байж магадгүй ч тоосноос болж мал өвчилсөн тухай өргөдөл гомдлыг Өмнийн говийн бүст шалган магадласан нь хязгаарлагдмал.³⁷ 2011 онд Монгол Улсын Мал Эмнэлгийн Үндэсний Төв нүүрсний тоосноос үүдэлтэй малын өвчлөлд урьдчилсан судалгаа явуулжээ.³⁸ 2015 оны НШТ-нд³⁹ дурьдсан хөндлөнгийн судалгаагаар Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдын 'дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэж буй бүсийн малын эрүүл мэндийн нөхцөл байдалд том өөрчлөлт гараагүй' гэж тодорхойлсон байна. ОТ-н 2015 оны Малын Эрүүл Мэндийн Үнэлгээгээр⁴⁰ 109 малын 238 дээжийг үнэлжээ. 41 малаас авсан дээжид лабораторийн шинжилгээ хийхэд 12 малын уушиг зарим нэг өөрчлөлттэй, 9 нь

³⁵ Аэрозолын мониторинг МОД-4, НАСА

³⁶ Байгаль Орчин, Нийгмийн Хөндлөнгийн Зөвлөх, Оюу Толгой. Д'Аполлониа S.p.A, х. 67, 2015


³⁷ Жексон С. Л., 2015. Тоостой замууд ба холбоогүй байдал: Монгол улсын Өмнийн Говь дахь уул уурхайн хучилтгүй замуудын тоосны талаарх ойлголт. Геофорум, 66, хх. 94-105

³⁸ Д. Оргил нар 2011. Өмнөговь аймгийн байгаль орчны хяналт ба уул уурхайн салбараас малын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөө. Улсын Мал Эмнэлгийн Эрүүл Ахуйн Төв Лаборатори.

³⁹ ОТ Нүүлгэн Шилжүүлэх Төлөвлөгөө (НШТ), 2015

⁴⁰ ОТ Малын Эрүүл Мэндийн Үнэлгээ 2015

стандартаас хол зөрөөгүй байсан байна. Малын эрүүл мэндэд тоос нөлөөлж болзошгүйг үнэлэхийн тулд малын эрүүл мэндийн мониторингийг үргэлжлүүлэх шаардлагатай.



Зураг 3. MODIS-ын аэрозолын программыг ашиглан хийсэн Ханбогд сумын тоосны алсын зайн тандалтын үнэлгээ (NASA 2016; giovanni.gsfc.nasa.gov/giovanni). Үнэлгээ 0.1 = маш цэвэр – хөх тасархай зураас; 0.4 = их тоостой – улаан тасархай зураас. Хар зураас - 2002 оны 7 сараас 2016 оны 7 сар хүртэлх аэрозол тоосны байдал цаг хугацааны туршид багахан буурсныг харуулж байна ($r^2= 0.033$).

Одоогийн байдлаар ОТ-с үүсэлтэй тоосны нөлөөллийг батлах зүйл бага байна. УЛТ/хориотой хэсэгт ОТ-с хийж буй PM_{10} тоосонцрын мониторингоор тухайн хэсэгт тоосны бөөгнөрөл бага байгааг тогтоосон байна⁴¹. Уурхай өргөжихөд тоосны мониторингийг үргэлжлүүлэх хэрэгтэй.

2.5 Манлай сумтай харьцуулсан нь

ОТМШБ харьцуулах цэг болгон Манлай сумын байгаль орчны нөхцөл байдалд үнэлгээ хийв (Хавсралт 9). Олон удаагийн явалтаар Ханбогд сумтай ижил орчин бүхий бэлчээр, усны эх үүсвэр, малчдын үйл ажиллагаа, байгаль орчны тулгамдсан асуудлаарх төсөөллийг үнэллээ.

⁴¹ ОТ Тоосны өдрийн дунджийн мэдээ, 2016

Манлай сумын бэлчээрийн мал аж ахуйн тухайд уул уурхай хажууд нь байхгүй, байгаль орчноо түшиглэн, уламжлалт аргаа илүү дагадаг. Малчид Оюу Толгой, Таван Толгойн талаар мэддэг, нутгийн зарим иргэд уурхайд ажилладаг юм байна.

Манлай сумын малчид цаг агаар, уур амьсгалын өөрчлөлтийг тулгамдсан асуудал гэж онцлон хэлсэн бөгөөд гаднаас тусламж ирнэ гэж хүлээдэггүй аж. Хоёр сумын аль алиных нь малчид зохион байгуулалт, усны эх үүсвэр эсвэл дэд бүтэц гэх мэт малчдад тулгарч буй асуудлыг засаг захиргаа багасгаж чадна гэж үздэггүй. Ажиглалт, судалгаанаас үзэхэд Манлай сум:

- ургамалжилтын хэмжээ бага,
- цаг уурын эрс үзэгдэл их болдог
- бэлчээрийн чанар, ус хангамж, малын эрүүл мэндийн тухайд эерэг бодолтой.
- Дийлэнх нь <300 малтай, тэгэхэд Ханбогдод ихэнх нь >300 малтай
- Усны түвшин арай бага

Уур амьсгал цаг хугацааны явцад өөрчлөгдсөн, очиж үзсэн худгийн 70% нь гар худаг байв, Ханбогдынхтой харьцуулахад илүү олон айл худгаа хуваадаг, малчдын малын тоо цөөн (Хавсралт 7). Нүүдэл, отор, цаг агаар, тоос, зэрлэг амьтад цөөрсөн тухай ойлголт ижил. Манлай сумын мал аж ахуйн асуудал нь байгаль орчин, уур амьсгалд төвлөрсөн байхад Ханбогдод байгаль орчин, нийгэм-эдийн засгийн багц асуудал чухал ач холбогдолтой.

Манлай сумын тухайд мал аж ахуйн динамик, байгаль орчны асуудлууд нь түгээмэл, Ханбогдыг бодвол Монголын малчдын нөхцөл байдлыг илүү төлөөлж байна^{42,43,44}. Энэ нь уурхай байгаа нь Ханбогдын малчдын үзэл бодолд нөлөөлж, хөрш сумынхнаас өөр ойлголт бий болгосныг харуулж байна.

2.6 Малчдын байгаль орчны талаарх ойлголтын судалгаа

Малчид байгаль орчны хүчин зүйлийн тухайд маш сөрөг бодолтой байна. Ханбогдын 53 малчнаар 24 асуулттай богино судалгаа бөглүүлсэн. Ерөнхийдөө уур амьсгалын нөхцөл байдал дараах зүйлээс болж улам муудаж байгаа гэж үзжээ. Үүнд:

- өвөл (судалгаанд оролцогчдын 68% нь), зуны (судалгаанд оролцогчдын 63% нь) агаарын хэмийн өөрчлөлт

⁴² Штернберг, 2012 б

⁴³ Миддлтон нар. 2015

⁴⁴ Ахерн 2016

- хур тунадас багассан (94%) тоос ихэссэн (77%)
- 67% нь малд хангалттай ус байхгүй гэсэн, 40% нь усны чанар муудсан гэв
- 60% нь бэлчээр муудсан гэж үздэг.
- Малчдын 91% нь нүүдэл хийдэг, 72% нь жилдээ 3 ба түүнээс дээш нүүдэг, 66% нь жилдээ 20 км-с хол нүүдэг.
- Гангийн талаар ховор дурьдсан, 18% нь 2009 эсвэл 2010 оны зудыг тэмдэглэсэн.
- Зэрлэг ан амьтан, биологийн төрлүүд багасч байна гэж үздэг.

Уур амьсгалын мэдээ баримтаар цаг агаар янз бүр байсан байхад байгаль орчны талаарх сөрөг бодол сум даяар өргөн тархсан. Малчдын амьжиргаанд учирч буй төрөл бүрийн, хэд хэдэн нөлөөлөл, нийт 16 өөр өөр хүчин зүйлийг тодорхойлсон. Уур амьсгал, байгаль орчны асуудлууд тэргүүнд, дараа нь нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг оруулжээ. Газрын гадаргын бүтээмжийг бэлчээр гэж үзэх, 2003-2015 онуудад малын тоо хоёр дахин өсөхөд ус хангалттай байсан гэх тухайд ойлголтын мэдэгдэхүйц ялгаа байна. Нүүдэллэсэн хэвээр байгаа нь малчдад хангалттай бэлчээр олдож байгаа, газар, усны хүртээмжийн асуудлыг шийдэж чадаж байгааг харуулж байна.

3. ХАНБОГД СУМЫН БЭЛЧЭЭР, УСАНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

3.1 Ханбогд сумын бэлчээр, усанд гарсан өөрчлөлт

Ханбогд сумын мал маллагааны нөхцөл байдалд нөлөөлөх хэд хэдэн хүчин зүйлс байна: уур амьсгал ба байгалийн хүчин; малчдын ажиллагаа; засаг захиргаа, хувийн хэвшлийнхний шийдвэр ба авч буй арга хэмжээ, түүнчлэн ОТ-н үйл ажиллагаа. Эдгээр нь тус бүрдээ Ханбогд сумын малчдын бэлчээр, усны нөөцийн боломжид нөлөөлсөн эсвэл өнөө ч нөлөөлж байна гэж бид үзэж байна.

- Үндсэн хүчин зүйл нь Ханбогд сум жилдээ 95 мм хур тунадас унадаг, гэхдээ энэ нь жилээс жилд ихээхэн өөрчлөлттэй, хуурай цөлийн орчинд оршдог явдал. Малчид хүртэх боломжтой бэлчээр, усны нөөцийг гол төлөв уур амьсгал тодорхойлно.
- Ургамалжилтийн алсын зайн тандалтын мэдээг хур тунадасны тоо баримттай харьцуулан үзэхэд хур тунадас болон түүнтэй холбоотой ургамалжилт, усны түвшин жилээс жилд ихээхэн өөрчлөлттэй байжээ.
- Бороо хурын хэмжээ болон малчдын ажиллагаанаас хамаараад зарим жилүүдэд зарим газарт бэлчээр, ус тун их ачаалалтай байдаг, гэхдээ малын тоо өсч байгаа нь тус суманд мал маллаж болоод байгааг илтгэнэ.
- Малчдын ажиллагаа бас бэлчээр, усны нөөцөд нөлөөлж байна. Тухайлбал, 2003 оноос хойш малын тоо хоёр дахин өссөнөөр тэр хэмжээний их ус, өвс ургамал шаардагдаж байгаа. Нэмж хэлэхэд хэд хэдэн хүчин зүйлийн улмаас нүүдэл багасч, сумын зарим бүсэд мал төвлөрчээ. Үүнд:

- өрх тасарсан, сумын төвд ойрхон байх гм суурьшил
- уст цэгийн орчимд мал бөөгнөрснөөр зарим бэлчээрийг талхалсан
- худгийн засвар үйлчилгээ муу
- зарим малчид усны эх үүсвэрийг цоожлох гэх мэтээр нөөцийг эзэгнэдэг
- өвөлжөө эзэмшиж байгаагаа бэлчээрийг нь ашиглах эрхтэй гэж ойлгон тэр эрхээ хамгаалахад хэрэглэх
- 200 км² бэлчээрийн газар эвдэгдсэн буюу ОТ-н дэд бүтэц, УЛТ, замуудад алдсан.

Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлс өөрчлөгдөхийн хэрээр (машин тэрэг, зардал өсөх, боловсрол, үйлчилгээ авахын тулд сум руу нүүх) Ханбогд сумын мал аж ахуй Говийн ба Монголын бусад сумдаас ялгаатай болж байна.

2003 оноос хойш Ханбогд сумын байгаль орчныг малчид хэрхэн ашиглаж, ойлгож байгаад ихээхэн шилжилт гарсан гэж бид олж тогтоолоо. Ялангуяа ОТ-н уурхай байгаатай холбоотойгоор эвдэрч нурсан, тодорхой бус сэтгэгдэл газар авч; өөрийн болон бусдын ус, газар эзэмших эрхийн талаарх хүмүүсийн ойлголт өөрчлөгдөн, мал маллагаанд машин тэрэг ихээр ашиглан (үүний хамт бензин шатахууны төлбөрийн дарамт), суурин орон байр барих болжээ. Нөөцөө хуваан ашиглах маягаар газрыг хамтран ашигладаг уламжлалт барилаас өөрийн ашгийн төлөө бэлчээр, усыг дээд зэргээр ашиглах явдал руу шилжиж байна. Малын тоо өссөн, нүүдэл багасч/өөрчлөгдсөн, өрхийн болон хөдөлмөрийн зохион байгуулалт өөрчлөгдсөн зэргээс бэлчээрийн нөөцийн ачаалал нэмэгдэж, илүү их ус хэрэгцээтэй болсон байна. Нүүдлийн мал аж ахуйн арга барилд гарсан өөрчлөлт байгаль орчинд нөлөөлж буйг малчид хүлээн зөвшөөрч, тэдний гаргах шийдвэр нүүдлийн мал аж ахуй урт удаан хугацаанд оршин тогтноход нөлөөлнө гэдгийг ухамсарлан ойлгох хэрэгтэй.

- Улсын, орон нутгийн засаг захиргаа, бусад компаниуд төмөр зам барих, Таван Толгойн зам, Катарын зэрлэг амьтны хамгаалалтын газар гэх мэт мал аж ахуйд нөлөөлөх хөрөнгө оруулалт хийсэн. Үүн дээр нэмж хэлэхэд сумын засаг захиргааны байгууллагууд нүүдлийн мал аж ахуй, байгаль орчинд нөлөөлж буй хүчнүүдтэй учраа олоход хүчин мөхөс бололтой. Сумын эрх мэдлээс давсан хүчин зүйлс хязгаарлагдмал төлөвлөлт, удирдлагатай хавсарснаар нүүдэллэх боломж олгохын тулд бэлчээрийг үр дүнтэй зохион байгуулах, худгийн засвар үйлчилгээ хийх, ашиглагдаагүй байгаа бэлчээрийг хүртээлтэй болгохын оронд сум үйл явдал өнгөрч, дарамт шахалт ирсэн хойно хариу үйлдэл хийдэг болжээ. 2015 онд батлагдсан сумын Мал Аж Ахуйн Салбарын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрт холбогдох асуудлууд тусгагдсан, түүний хэрэгжилтийг сайн дэмжих хэрэгтэй. Засаг захиргааны дутагдал нь орон нутгийн удирдлагын үүрэг, үндэсний төр засгаас суманд тавих анхаарал бага байгаа зэргээр илэрч байна. Мал аж ахуйн зохион байгуулалт, сумын хөгжил зэрэг нь ОТ-н гэрээгээр хүлээсэн үүргээс ангид хэдий ч малчид, сум хэн хэн нь үнэндээ ОТ-н амыг харж, мөнгө горилох болжээ.

- Өмнө нь ОТ-н хориотой бүс, дэд бүтцээс (УЛТ, нисэх буудал, замууд, усны шугам хоолой) малчдыг өөр тийш нүүлгэн төвөг учруулсан (ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 2 ба 3-т хэлэлцсэн). Одоогоор ОТ-с бэлчээр, ургамалд учруулж буй мэдэгдсэн шууд нөлөөлөл хязгаарлагдмал. Уурхайн газартай харьцах байдал сайн зохион байгуулагдсан, замаас гарч явахгүй байх зэрэг тодорхой стандарттай дүрэм журам баримталдаг. Байгаль орчинд учруулах нөлөөлөл нь ОТ-н зам дээрх хөдөлгөөнөөс малд учрах эрсдэл, Ханбогдын замд (хучилттай болгох ажил хийгдэж байгаа) ойр байгаа газрын тоос зэргийг хамарч байна.
- Гэвч ОТ-н өмнөөс гаргасан 476 цооногийн улмаас гүехэн болон гүний усны ай сав хоорондоо холбоотой байж болзошгүй нэлээд ноцтой асуудал байна. Мониторингийн суурь мэдээлэл дутмаг байгаа нь малчдын худгийн усны түвшинг (өрөмдлөг эхлэхээс өмнөх) өнөөгийнхтэй харьцуулж болохуйц урт хугацаанд хийсэн мониторингийн найдвартай мэдээлэл алга гэсэн үг. RPS Акуатеррагийн 2013 оны тайланд Гүний Хоолой орчмын хэдэн худгууд нөлөөлөлд өртөж болзошгүй гэсэн байдаг. Цооногийн барилгын анхны аргачлал, бүртгэл мэдээ тааруу байсны улмаас нэвчилтийг эргэлзээгүй үгүйсгэх боломжгүй. Олон малчин тэдний усны нөөцөд хохирол учирсанд сэтгэл нь зовж байна. Ус алдаж буй 9 цооногийг тодорхойлж, ОТ асуудлыг шийдэхээр ажиллаж байгаа ба энэ нь сумын хаа нэгтээ ингэж хоорондоо холбогдсон байх өчүүхэн ч гэсэн магадлалтайг харуулж байгаа юм. Усан хангамжийн тодорхойгүй байдал нь усны мониторингийг байнга хийх хэрэгтэйг тодотгож байна.

Мониторинг - ОТ орон нутгийн бодит болон нийгмийн орчны талаар хэсэгчилсэн мэдлэгтэй, гүний ус, бэлчээрийн менежмент гэх олон ажлыг өөрсдийн зүгээс хязгаарлагдмал хяналт эсвэл оролцоотойгоор суманд байдаггүй этгээдүүдтэй гэрээлж хийлгэжээ. Үүний улмаас ОТ-д байгаль орчны асуудлаар нэгдсэн арга барил дутмаг, байгаль орчны мониторингийг бэлчээрийн менежментийн үйл ажиллагаатай бүрэн уялдуулахгүй байна. Ажилтнууд нь өөрийн хариуцсан зүйлийг мэддэг ч нэгдмэл арга ажиллагаа байхгүй. Үр дүн нь бөөн мэдээлэл, ядмаг тайлбар эсвэл нотолгоо, үр ашиг муутай харилцаа, орон нутгийн иргэдийн итгэл доогуур. Суманд бэлчээрийн мониторингийг зохих ёсоор хийх цаг зав, хүн хүч байхгүй ч зарим ажлыг сум руу шилжүүлсэн. Мөн мал аж ахуйг сайжруулахын тулд малчдын нөхөрлөл байгуулах талаар гаргасан хүчин чармайлтын үр дүнг харуулсан баримт байхгүй.

- Тоос – Одоогийн байдлаар ОТ (замууд), орон нутгийн иргэдийн (шороон замууд) бий болгосон тээврийн хонгилуудаас өөрөөр тоосноос байгаль орчинд учруулж буй томхон нөлөөлөл алга байна. Сумын тоосжилтийн дээд хэмжээ 2010 онд дээд цэгтээ хүрч байсан, одоо ерөнхийдөө гайгүй; тодорхой цэгүүдэд, гол төлөв Ханбогдын зам дээр, зам дагуу тоос босч байгаа ч тархалт нь хязгаарлагдмал, замын хучилт хийгдэж дуусахаар тоос босохгүй болно. Хөдөлгөөнд ОТ-н болон ОТ-н бус машин тэрэг оролцдог, тэгэхээр ОТ орон нутаг дахь замын тоосыг бүгдийг биш нэг хэсгийг нь гаргаж байна. Бас малчдын машин тэрэг явдаг суманд хаа сайгүй байх шороон замуудаас тоос босдог.

- Ерөнхийдөө, асуудал байгаа хэдий ч – тухайлбал усны ай савын хоорондын холбоо - мониторинг зэрэг - Ханбогд сумын малчдын бэлчээр, усанд учирч буй үндсэн нөлөөллүүд нь ОТ-оос өөр эх үүсвэрээс учирч байна гэж бид дүгнэж байна. Малчдын ашиглаж буй усны зарим эх үүсвэрийг ОТ засч, дахин барьж өгснийг сайшаан хүлээн зөвшөөрөх явдал бага байв. Үр дүнтэй бэлчээрийн мал аж ахуйн засаглал дутмагаас засгийн газрын үүргийг ОТ-гоор гүйцэтгүүлэхээр хардаг болсон байгаа нь Манлай сумаас тод ялгарч байна.

4. ЗӨВЛӨМЖҮҮД 1) ЭКОСИСТЕМ БОЛОН УЛАМЖЛАЛТ МАЛ МАЛЛАГААГ СЭРГЭЭХ/ХАДГАЛАХ 2) ИРЭЭДҮЙД ОТ-С УЧРУУЛАХ НӨЛӨӨЛЛИЙГ ДААХ ЧАДВАР

Бэлчээр ба усны дүн шинжилгээнд үндэслэн доорх дүгнэлт, зөвлөмжүүдийг бид гаргаж байна.

- Бэлчээрийн тухайд:
 - Ургамалжилтын байдал хувьсдагийн үндсэн эх үүсвэр нь хур тунадас юм.
 - Малчид ба сумын захиргаанаас гаргасан шийдвэр нь бэлчээр ашиглалт, хуваарилалт, нягтралд ихээхэн нөлөөлж байна. Зарим газрын бэлчээрийн ашиглалт хэт өндөр байгаа байдлыг өөрчлөгдтөл засаг захиргааны зүгээс малчид уламжлалт байдлаар нүүдэллэх, ус, бэлчээрийг чөлөөтэй хүртэх, худаг, бэлчээрт малчид хориг тавьдагыг багасгахыг хөхүүлэн дэмжих талаар хүчин чармайлт гаргах шаардлагатай. Уламжлалт мал аж ахуйг үр ашигтай эрхлэх туршлагыг сурталчилах, малын бэлчээрт зориулан шинэ газар нутаг гаргаж өгөх зэргээр сум идэвхтэй үүрэг гүйцэтгэх хэрэгтэй. Ашиглаагүй бэлчээрийн газар их байна, тухайлбал хойд, зүүн, үрд зүгийн нутаг дэвсгэрт устай бол бүтээмжтэй байх газрууд байна; үүнд Онцгой хамгаалалтын бүсүүд ороогүй болно. Малчны эзэмшлийн эрхийн тодорхойлолт (өвөлжөө, хаваржааны бууц, худгууд гм.) болон бусад малчид газар, худгийг ашиглахын тухайд эдгээр эрх нь ямар утгатайг тодорхой болгох шаардлагатай.
 - Ханбогдын замыг хучилттай болгосноор (одоо ажил нь явагдаж байгаа) замын хонгил дагуух тоосны асуудал шийдэгдэнэ, төлөвлөснөөрөө 2017-18 онуудад барьж дуусгах хэрэгтэй.
 - ОТ-н зам дээрх хөдөлгөөний хурдыг багасгахын тулд малын гарамуудын хоёр талд нь хурд сааруулагч хийж өгөх шаардлагатай. Ялангуяа барилгын ажил нэмэгдэн, үйлдвэрлэл ихсэх үед тун чухал; энэ нь бэлчээр хуваагдлын үр дагаврыг бууруулна.
 - ХШБ-ийн тайланд дурьдсан УЛТ-н зүүн хойд талд газар хуваагдсан асуудлыг нийтийн нөхөн олговроор шийдэж болох юм.
- Усны тухайд:

- Гүехэн болон гүний усны ай савууд хоорондоо бага ч гэсэн холбоотой байж магадгүй нь малчдын устай холбоотой өнөөгийн асуудал бөгөөд ОТ үүнийг бууруулах шаардлагатай. Одоо байгаа тохиолдлууд энэ асуудал нийт сумын асуудал гэдгийг тодруулж байгаа юм. Нийтийн нөхөн олговрын (дор дурьдсан) хүрээнд сумын хэд хэдэн газарт ялангуяа бэлчээртэй ч худаггүй газарт гүехэн гар худгууд барихыг бид ОТ-д зөвлөж байна. Худгууд гүехэн (гүний биш), бөх, эдэлгээтэй, нийтэд хүртээмжтэй, түгжээгүй байх хэрэгтэй бөгөөд ОТ-оос малчдад саяхан барьж өгсөн бетонон гүехэн худгуудыг санал болгоё.

Үүний зорилго нь:

- 1) 4 багийн нутагт шинээр нэмж бэлчээр нээн өгч, малчид нүүдлээ хийн, бэлчээрийн нөөцийг ашиглахыг хөхүүлэн, тэдэнд уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломж олгох
- 2) ашиглагдаж байгаа бэлчээрийн бүст хэрэглэж болох усны цоорхойг нөхөх.

Малчид нүүдлээ хийн, өөр шинэ бэлчээр ашиглахыг хөхүүлэн, тэдэнд уламжлалт амьжиргаагаа үргэлжлүүлэн эрхлэх боломж олгохын тулд худгуудыг 4 багийн нутагт тараан гаргах хэрэгтэй. ОТ-н усны нөөцөд учруулсан нөлөөллийг бууруулах, ОТ-н улмаас газар хуваагдсан, сумын дэд бүтцийн хязгаарлагдмал зохион байгуулалт, малчдын газар ашиглалтын оновчгүй төлөвлөлт зэргийг багасгахын тулд сум ба ОТ энэ хөтөлбөрт хамтран ажиллах шаардлагатай. Сумын зүгээс малчдын бэлчээрт хүрэх боломжийг өргөжүүлэн, бататгаж өгөх хэрэгтэй.

Шинжээчид бидний бодлоор энгийн, бат бөх загвартай, нэгж өртөг багатай гар худгууд нь өндөр өртөгтэй, нарийн загвартай худгаас илүү үнэ цэнэтэй бөгөөд ус, бэлчээрийн хүртээмжийг илүү ихээр нэмэгдүүлнэ. ОТ-гоос 2007,⁴⁵ 2010⁴⁶ онд хийлгэсэн тайланд ойролцоогоор 320 гар худаг байна гэсэн; түүнээс хойш малын тоо ихээхэн өссөн. Холын бэлчээр рүү нүүх явдлыг хөхүүлэхийн тулд 75-с дээш тооны худаг барихыг бид санал болгож байна. Бог малын нүүдлийг хангахын тулд хэд хэдэн худаг гаргах; тэмээний бэлчээрт худгууд хол хол зайтай байж болох юм.

Шинэ худгуудыг бүтээмж сайтай, одоо байгаа худгуудад нөлөөлөхгүй байлгахын тулд тэдгээрийн байршлыг гүний усны судалгаанд үндэслэн гаргах шаардлагатай. Нийт малчдад аль болох их бэлчээрийн боломж олгохын тулд байршлийг

⁴⁵ Ханбогд сумын ус ашиглалтын төсөөлөл судалгаа. 2007. Бодлого судлалын төв.

⁴⁶ Ханбогд сумын Тогтвортой Мал Аж Ахуйн Менежментийн Төсөл. 2010. Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоо.

- сумтай хамтран тогтоох. Нийтийн нөхөн олговрын өмнөх цоорхойг худгууд нөхөх болно.
- Аллювын уст давхаргын мониторинг, загварчлалыг газар зүйн хувьд тараан байрлуулсан цэгүүд дээр хийх, мөн ОТ-н өнгөрсөн, одоо, ирээдүйн нөлөөллийг тоон үзүүлэлтээр тооцсон аллювын нөөцөд чиглэсэн гидрологийн судалгаа явуулахыг зөвлөе. Ингэснээр малчид хараат байдаг гүехэн гүний усны динамикийн талаар илүү сайн ойлголттой болж, загварчлалыг сайжруулан, ирээдүйд усны нөөцийн өөрчлөлтийг хэмжиж чаддаг болно.
 - Малчдыг усаар хангаж байгаа нь түр зуурын арга хэмжээ бөгөөд тэднийг бусдаас хамааралтай, санаа түгшсэн (больчих болов уу, хэзээ зогсоох бол хэмээн малчдын сэтгэл зовдог) байдалд оруулсан, урт хугацаанд тогтвортой байж чадахгүй тул аажмаар болих хэрэгтэй. Тодорхой хугацаа тохироод, одоо үс зөөж өгч байгаа газруудын усны нөөцөд үнэлгээ хийлгэх; хэрэв ажиллагаатай худаг тэнд нь байгаа бол хөтөлбөрийг зогсоох; худаггүй бол санал болгож буй худаг барих хөтөлбөрийн хүрээнд нэгийг барьж өгөх хэрэгтэй.
 - Суманд одоо байгаа малчдын худгууд болон дээр санал болгосон худгуудад засвар үйлчилгээ хийх сайн систем хэрэгтэй. Нөхөн олговрын цоорхойг нөхөх нийтийн нөхөн олговрын хөтөлбөрийн нэг хэсэг энэ байж болно гэж бид үзэж байна.
 - Усны суурь мэдээлэл дутмаг байгаа нь усны нөөцөд гарсан өөрчлөлтийг тодорхойлох боломжгүй болгож байна.
 - Усны тайлан, мэдээг нутгийн иргэдэд ил тод мэдээлэхгүй байх ямар нэгэн шалтгаан бид олж харсангүй.
- Мониторинг болон ОТ, малчид, сумын засаг захиргаа хоорондын харилцааны тухайд:
 - Малчид болон бусад хүмүүст үнэмшилтэй, найдвартай, урт хугацааны мэдээ мэдээлэл гаргахын тулд малчдын худаг, тоос, бэлчээр/ургамлын байгаль орчны мониторингийн хөтөлбөрүүдийг дахин боловсруулж, шинээр зохион байгуулах шаардлагатай. Оролцоог хангахын тулд хөтөлбөрүүд мал маллагааны хэв маягт тохирсон, малчид хянан баталгаажуулах боломжтой байвал зохино. Хөтөлбөрт малчдын худгийн ус (тоо ба чанар), тоос, ургамал/бэлчээрийн чанарын асуудлыг хамарч, хатуу шинжлэх ухаанч байдал, итгэл үнэмшлийг хангасан, хүртээлтэй байлгахын тулд баримт хамтран олж тогтоох аргачлалыг ашиглан хэрэгжүүлэх; мониторингийг гадагш нь гэрээлж хийлгэж байгааг больж, орон нутгийнхаар солих шаардлагатай.
 - ОТ мониторингийн тайлан мэдээ, түүний үндсэн дээр авсан эсвэл санал болгосон аливаа арга хэмжээг байнга тайлагнан, малчид, орон нутгийн иргэдэд тогтмол танилцуулж байх; одоогийн харилцаа холбоо сайхан сэтгэлээр хийгдэж байгаа байх гэхдээ энэ нь хангалтгүй байна. Мэдээлэл шууд, ойлгомжтой, малчидтай

холбоотой; сумд өгөх тайлангууд мэргэжилтнүүдэд ойлгогдохоор дэлгэрэнгүй байх шаардлагатай. Австралийн Пилбарад хэрэглэсэн (riotinto.com/documents/FAQ_air_quality_monitoring.pdf) тоосны бодит цагийн мониторинг гэх мэт Рио Тинтогийн ашигладаг аргуудыг Ханбогодод хэрэглэх нь зөв. ОТ илэрсэн зүйлийн талаар бүх багийн төв, сумын төв дээр танилцуулж байх шаардлагатай. Мониторингийг амжилттай хэрэгжүүлэхэд малчдын зүгээс чин сэтгэлээсээ оролцох явдал тун чухал.

- Ургамлын мониторингийг явуулахад хашаалсан талбайг санал болгож байна. Үүнийг малчид, сумын албан тушаалтнуудтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Газар ашиглалтын тухайд:
 - Шинэ дэд бүтэц, магадгүй бусад уурхайнууд болон эрдэс баялаг олборлохтой холбоотойгоор Ханбогд суманд одоо болон ирээдүйд газрын эрэлт хэрэгцээ их гарахаар байна. Өнөөгийн байдлаар эдгээр бүтээн байгуулалтуудаас учирч буй асуудлуудыг шийдвэрлэх хүчин чадал, эрх мэдэл сумын засаг захиргаанд дутмаг. Газар ашиглалт, хөдөөгийн амьжиргааг хамгаалах цогц стратеги яаралтай хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр өөрчлөлтийн хүрээнд малчдын амьжиргааг тогтвортой байлгах үүднээс ОТ ба түүнд зээл олгогчид (ялангуяа Дэлхийн Банкны группийн нэг бүрэлдэхүүн ОУСК) өөрсдийн харилцаа холбоо, мөн үндэсний ба орон нутгийн засаг захиргаа, гадны (олон улсын) агентлагуудтай ажиллаж байсан туршлагаа сумын түвшний стратеги, өөрчлөлтийн нөхцөлд малчдын амьжиргааг авч явах төлөвлөгөө боловсруулахад дайчлахыг хүсч байна.
- Нийтийн нөхөн олговор:
 - Уст давхаргын хоорондын холбоо, газар хуваагдал зэргийг хамруулан ОТ-н нөлөөллүүдийг орон нутгийн нөхөн олговроор дамжуулан засч залруулахыг санал болгож байна. Ялангуяа, байршил тогтоох гидрологийн судалгаа хийгдсэний дараа хэд хэдэн гүехэн гүний худаг барих хөтөлбөрийг ОТ сумтай хамтран хэрэгжүүлэх хэрэгтэй. Худгуудыг сумын хойно, зүүн, өмнө талд буй ашиглалт багатай газруудад байршуулах, ингэснээр боломжит шинэ бэлчээр, мал маллах газар гаргаж, уламжлалт мал аж ахуйг дэмжин, ус, бэлчээрийн асуудлыг шийднэ. Энэ нь суманд уламжлалт мал аж ахуй эрхлэх боломжийг хангах, нутгийн иргэдэд өгөөжтэй нийтийн нөхөн олговроор ОТ-н ерөнхий нөлөөллүүдийг шийдвэрлэх явдал юм.

5. Хавсралтууд

Хавсралт 1 – Ажлын даалгавар

Хавсралт 2 – Хянаж шалгасан бичиг баримтууд

Хавсралт 3 – Уур амьсгал

Хавсралт 4 - Мал

Хавсралт 5 - Бэлчээр

Хавсралт 6 – Алсын зайн тандалт

Хавсралт 7 - Ус

Хавсралт 8 – Тоос

Хавсралт 9 – Манлай сум

Хавсралт 1- Бүрэлдэхүүн хэсэг 1, Ажлын удирдамж

Component 1:

Бүрэлдэхүүн хэсэг 1: Бэлчээр ба усны ашиглах боломж мөн чанарын үнэлгээ

Малчид хичнээн тооны малтай байж болохыг илтгэх гол чухал тодорхойлолт нь усан хангамж болоод ашиглах боломжтой байгаа бэлчээрийн чанар, хэмжээ байдаг. Нөгөөтэйгүүр уламжлалт нүүдлийн мал аж ахуйтай малчдын амьжиргааг мөн тодорхойлдог.

Бүрэлдэхүүн хэсэг 1 нь малчдын амьжиргааны эдгээр чухал хэсэгт анхаарах ба 3 хэсгээс бүрдэнэ.


А Хэсэг- Анхдагч ба хоёрдогч мэдээн дээр үндэслэн 2003-аас одоог хүртэлх Ханбогд сумын ус, бэлчээрийн чанар, хэмжээг боломжит байдлаар өөрчилөж болох тоон ба чанарын үнэлгээ мөн бэлчээрийг тооцоолон тодорхойлох.

В Хэсэг- Ялангуяа ОТ төсөлтэй холбоотой ус бэлчээрийн өөрчлөлтийг хамгийн боломжит байдлаар зураглах.


А Хэсэг- Зөвлөмж ба үнэлгээг боловсруулах. Үүнд: (1) Говийн бүсийг бүхэлд нь мөн Ханбогд сумын уламжлалт нүүдлийн мал аж ахуй ба байгалийн экосистемийг хамгаалан хадгалах арга зүй; ба (2) ОТ төслөөс үүдэлтэй ирээдүйд гарах бүхийл нөлөөллийг давах чадамж байгаа эсэх

Хавсралт 3- Уур амьсгал

1. Жилийн дундаж хур тунадас, 1976-2015
Чиг хандлагын шугам (хар) нь бага зэргийн өсөлтийг харуулна ($r^2=0.03$).



2. Жилийн дундаж температур, 1976-2015
Чиг хандлагын шугам (хар) нь өсөлтийг харуулна ($r^2=0.22$).



3. Хур тунадас, 5-р сар, 1976-2016.
Чиг хандлагын шугам (хар) нь бага зэргийн өсөлтийг харуулна ($r^2=0.05$).




4. Хур тунадас, 6-р сар, 1976-2016.
Чиг хандлагын шугам (хар) нь өсөлтийг харуулна ($r^2=0.22$).



5. Ханбогд сумын 8-р сар хүртэлх 12 сарын гангийн үзүүлэлт, 1976-аас 2015 он.
 Чиг хандлагын шугам (хар) нь бага хэмжээний өөрчлөлтийг харуулна ($r^2=0.00$).
 Тасархай улаан зураас (-1) нь ганг илтгэнэ.




6. Ханбогд сумын 6-р сар хүртэлх 12 сарын гангийн үзүүлэлт, 1976-аас 2016 он.
 Чиг хандлагын шугам (хар) нь өсөлтийг харуулна ($r^2=0.22$).
 Тасархай улаан зураас (-1) нь ганг илтгэнэ.



7. Ханбогд ба Манлай сум. Дөрвөлжингөөр уур амьсгалын мэдээллийг торон хэлбэрээр харуулав, 1960-2013.


1. Ханбогд Баруун өмнөд хэсэг
2. Галуут баг, ОТ- нь хойд хаалга
3. Манлай баруун хэсэг
4. Жавхлант баг
5. Ханбогд
6. Манлай
7. Номгон баг
8. Баян баг
9. Манлай зүүн хэсэг

Торолсон газар бүрийн мэдээллийг доор харуулав.




Эх сурвалж: NASA Giovanni цахим интерфэйсийн (<http://giovanni.gsfc.nasa.gov/giovanni> Deep Blue Collection 6 Aerosol Optical Depth (AOD) мэдээлэл. Sayer ба бусад., 2013.


1. Ханбогдын Баруун өмнөд хэсэг




4. Жавхлантаг баг




7. Номгон бар




2. Галуут баг, ОТ- нь хойд хаалга




5. Ханбогд сум




8. Баян сум




3. Манлай баруун хэсэг



6. Манлай




9. Манлай зүүн хэсэг




Хавсралт 4. Ханбогд сумын мал аж ахуй

1. Ханбогд сумын малын тоо толгой 2003-2005 он, сумын захиргаанаас авсан малын тоон мэдээлэл




2. Малын тоо толгой, Хонин толгойгоор, 2003-2015. (тэмээ= 7 хонь, адуу, үхэр = 6 хонь, ямаа = 0.9 хонь. Sternberg-ийг харах 2012a)



3. Малын тоо толгой баг тус бүрээр


Номгон баг




Галуут баг



Жавхлант баг




Баян баг



Хавсралт 5- БЭЛЧЭЭР

Ургамлын трансект



Ханбогд сум дахь ургамлын трансектийн талбайнууд





Талбайн мэдээлэл Google Earth

Ургамлын трансектийн GPS байршил


ХАНБОГД

Site

Талбай	GPS	
	North Хойд	East Зүүн
1	43.18819	106.51221
2	42.91961	107.13648
3	43.15496	107.29905
4	42.92044	107.72688
5	42.79624	107.00436
6	42.8802	106.97153
7	42.76279	107.06673
8	42.92419	106.71723
9	43.22588	107.18538
10	43.14161	107.55861
11	43.07145	106.77863
12	43.12420	106.90439
13	average of twelve sites	

Ханбогд сум дахь 12 трансектийн ургамлын бүрхэц %

Site Талбай	Ургамлын бүрхэц %- худгаас метрээр					
	25	50	100	200	500	1000
1	3.7	8.1	8.6	10.5	8.1	9.4
2	9.2	1.1	2.0	1.9	14.2	16.5
3	3.7	1.5	1.7	3.2	6.6	8.4
4	1.7	2.7	6.1	6.2	15.7	10.7
5	2.7	1.2	1.1	1.3	5.2	0.3
6	3.3	4.2	9.7	5.1	11.5	4.2
7	10.4	5.9	5.9	2.0	5.6	4.0
8	4.7	2.8	6.3	8.9	4.3	2.0
9	15.4	8.5	8.7	20.2	14.0	14.8
10	7.4	16.9	14.2	4.9	4.8	5.3
11	6.3	18.1	2.4	5.7	5.3	2.2
12	5.9	3.8	3.7	5.4	5.0	8.4
Average per site Талбай бүрдэх дундаж	6.2	6.2	5.9	6.3	8.4	7.2



Ханбогд сум дахь 12 трансектийн ургамлын бүрхэц. Хэмжилтүүдийг уст цэгээс 25, 50, 100, 200, 500 ба худгаас хойд зүгт 1000 метрт хийсэн.

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

– Ханбогд сумын трансект дахь ургамлын бүтэц бүрэлдэхүүн

Site	Latin name	Mongolian Name	Palatability		Life form	Growth
Khanbogd 1	Peganum nigellastrum		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 1	Oxytropis myriophylla		palatable	camel, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 1	Cleistogenes squarrosa		palatable	camel, goat, horse, sheep		
Khanbogd 1	Achnatherum splendens		palatable	camel, goat, horse, sheep		
Khanbogd 1	Sympegma bunge					
Khanbogd 1	Nitraria					
Khanbogd 2	Ptilotrichum canescens		palatable	goat, horse	perennial	forb
Khanbogd 2	Peganum nigellastrum		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 2	Zygophyllum xanthoxylon		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 2	Amygdalus pedunculata		palatable	camel, deer, goat, sheep		shrub
Khanbogd 2	Lespedeza dahurica		palatable	cattle, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 3	Cleistogenes squarrosa		palatable	camel, goat, horse, sheep		
Khanbogd 3	Oxytropis myriophylla		palatable	camel, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 3	Dracocephalum foetidum					
Khanbogd 3	Artemisia santolinifolia		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 4	Iris bungei		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 4	Oxytropis aciphylla		palatable	camel, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 4	Peganum nigellastrum		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 4	Echinops gmelinii		palatable	camel, horse	perennial	forb
Khanbogd 4	Artemisa anethifolia		palatable	camel, goat, sheep	annual/biennial	forb
Khanbogd 4	Nitraria sibirica		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 4	Convolvulus ammanii		palatable	goat, sheep	perennial	forb
Khanbogd 5	Iris oxypetala		palatable		perennial	
Khanbogd 5	Artemisia santolinifolia		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 5	Peganum nigellastrum		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 5	Pedicularis abrotanifolia		palatable	camel, goat, horse, sheep		
Khanbogd 5	Achnatherum splendens		palatable	camel, goat, horse, sheep		
Khanbogd 5	Sympegma bunge					
Khanbogd 5	Ulmus					
Khanbogd 5	Nitraria					
Khanbogd 6	Iris bungei		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 6	Arnebia guttata		palatable	camel, goat, sheep	perennial	forb
Khanbogd 6	Ptilagrostis pelliotii				perennial	
Khanbogd 6	Stipa gobica		palatable	camel, cattle, goat, horse, sheep		grass
Khanbogd 6	Raemuria soongorica		palatable	camel, goat, sheep	perennial	shrub
Khanbogd 6	Tournefortia sibirica		palatable	camel	perennial	forb
Khanbogd 6	Artemisia santolinifolia		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 6	Iris oxypetala		palatable		perennial	
Khanbogd 6	Amygdalus pedunculata		palatable	camel, deer, goat, sheep		shrub
Khanbogd 6	Kalidium foliatum		palatable	camel		shrub
Khanbogd 6	Olgeae leucophylla				perennial	forb
Khanbogd 6	Zygophyllum rosovii		palatable	cattle, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 6	Scorophularia incisa					shrub
Khanbogd 6	Artemisia scoparia		palatable	camel, cattle, goat, horse, sheep	biennial	forb
Khanbogd 6	Zygophyllum xanthoxylon		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 7	Raemuria soongorica		palatable	camel, goat, sheep	perennial	shrub
Khanbogd 7	Peganum nigellastrum		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 7	Iom		palatable	camel, goat, horse, sheep		shrub
Khanbogd 7	Artemisia scoparia		palatable	camel, cattle, goat, horse, sheep	biennial	forb
Khanbogd 7	Nitraria sibirica		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 7	Oxytropis aciphylla		palatable	camel, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 8	Elymus paboanus		palatable	camel, cattle, goat, horse		grass ⁴¹
Khanbogd 8	Convolvulus ammanii		palatable	camel, deer, goat, sheep		shrub
Khanbogd 8	Salsola passerina		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	grass
Khanbogd 8	Raemuria soongorica		palatable	goat, sheep	perennial	forb
Khanbogd 8	Salsola passerina		palatable	camel, goat, horse, sheep		shrub
Khanbogd 8	Raemuria soongorica		palatable	camel, goat, sheep	perennial	shrub
Khanbogd 8	Olgeae leucophylla					forb
Khanbogd 8	Zygophyllum xanthoxylon		palatable	camel, goat, sheep		shrub

Жей Дэдэл Консалтинг Лтд
Их Фовчанин Илалт Бүрт. 04068123; НӨТ 768 446979
44 (0) 1865 512355 / 44 (0) 7500 729 681 / скаятйи: shankerman

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

Site	Latin name	Mongolian Name	Palatability		Life form	Growth
Khanbogd 9	<i>Elymus chinensis</i>		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	grass
Khanbogd 9	<i>Amygdalus pedunculata</i>		palatable	camel, deer, goat, sheep		shrub
Khanbogd 9	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 9	<i>Caragana leuncophloea</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 9	<i>Eurotia ceratoides</i>		palatable			shrub
Khanbogd 9	<i>Convolvulus ammanii</i>		palatable	goat, sheep	perennial	forb
Khanbogd 9	<i>Arnebia guttata</i>		palatable	camel, goat, sheep	perennial	forb
Khanbogd 9	<i>Nitraria sibirica</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 9	<i>Salsola passerina</i>		palatable	camel, goat, horse, sheep		shrub
Khanbogd 9	<i>Oxytropis aciphylla</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	shrub
Khanbogd 10	<i>Suaeda corniculata</i>		palatable	camel, goat, horse, sheep	annual	forb
Khanbogd 10	<i>Elymus paboanus</i>		palatable	camel, cattle, goat, horse		grass
Khanbogd 10	<i>Raemuria soongorica</i>		palatable	camel, goat, sheep	perennial	shrub
Khanbogd 10	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 10	<i>Ptilotrichum canescens</i>		palatable	goat, horse	perennial	forb
Khanbogd 10	<i>Nitraria sibirica</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 10	<i>Convolvulus fruticosus</i>					shrub
Khanbogd 11	<i>Scorzonera pseudodivaricata</i>		palatable	goat, sheep		shrub
Khanbogd 11	<i>Zygophyllum xanthoxylon</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 11	<i>Iris bungei</i>		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 11	<i>Stipa gobica</i>		palatable	camel, cattle, goat, horse, sheep		grass
Khanbogd 11	<i>Panzeria lanata</i>		palatable	goat, horse, sheep		forb
Khanbogd 11	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 11	<i>Raemuria soongorica</i>		palatable	camel, goat, sheep	perennial	shrub
Khanbogd 11	<i>Nitraria sibirica</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Khanbogd 11	<i>Atriplex sibirica</i>				annual	forb
Khanbogd 11	<i>Bassia dasyphylla</i>		palatable	camel	annual	shrub
Khanbogd 12	<i>Stipa gobica</i>		palatable	camel, cattle, goat, horse, sheep		grass
Khanbogd 12	<i>Eurotia ceratoides</i>		palatable			shrub
Khanbogd 12	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Khanbogd 12	<i>Anabasis brevifolia</i>		palatable	camel	perennial	forb

Манлай сумын трансект дахь ургамлын бүтэц бүрэлдэхүүн


Site	Latin name	Mongolian Name	Palatability		Life form	Growth
Manlai 1	<i>Leymus chinensis</i>		palatable	camel, cattle, goat, horse, sheep	perennial	grass
Manlai 1	<i>Convolvulus ammanii</i>		palatable	goat, sheep	perennial	forb
Manlai 1	<i>Ptilotrichum canescens</i>		palatable	goat, horse	perennial	forb
Manlai 1	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Manlai 1	<i>Nitraria sibirica</i>		palatable	camel, goat, sheep		shrub
Manlai 1	<i>Eurotia ceratoides</i>		palatable			shrub
Manlai 2	<i>Lappula stricta</i>				annual	forb
Manlai 2	<i>Peganum nigellastrum</i>		palatable	camel, goat, horse, sheep	perennial	forb
Manlai 2	<i>Reaumuria soongorica</i>		palatable	camel, goat, sheep	perennial	shrub

Хавсралт 6- Зайнаас тандан судлах

Зайнаас тандан судлахад MODIS-ийн мэдээллийг ашигласан бөгөөд энэ нь Ханбогд сумын 2003-2015 он хүртэлх бэлчээрийн ургамалжилтын мэдээллийг харуулна. Сансрын зурагийн мэдээл ашиглах нь газрын бүрхэцийн өөрчлөлтийг Ургамлын Нормчилсон Индексээр (NDVI) илтгэнэ. Өнгүүд нь өөр өөр бүрхэцийн ангиудыг харуулна (яг бодит тухайн газар нутгийг биш).

6-р сар жилээр


Зайнаас тандан судлахад MODIS-ийн мэдээллийг ашигласан, Ургамлын Нормчилсон Индексээр (NDVI). Ханбогд сум 6-р сар 2003-2015 он.



JULY by year

7-р сар жилээр


Зайнаас тандан судлахад MODIS-ийн мэдээллийг ашигласан, Ургамлын Нормчилсон Индексээр (NDVI). Ханбогд сум 7-р сар 2003-2015 он.



AUGUST by year

8-р сар жилээр


Зайнаас тандан судлахад MODIS-ийн мэдээллийг ашигласан, Ургамлын Нормчилсон Индексээр (NDVI). Ханбогд сум 8-р сар 2003-2015 он.



Багийн хэмжээн дэх NDVI-ийн бүрхэц


2002

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2003

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2004

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2005

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2006

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2007

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2008

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2009

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2010

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар



2011


Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар



2012

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**


цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар



2013


Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**

цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар




2014

Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар



2015


Баг, сум ба ОТ-н хойд хаалга орчмын **NDVI**
 цэнхэр = 6-р сар, улаан = 7-р сар, ногоон = 8-р сар



Хавсралт 7- УС

Дараах мэдээлэл нь Ханбогд сумын 67 хяналт шинжилгээний цэгт хийсэн усны мэдээллийг харуулна.

Ханбогд сум дахь судалгаа шинжилгээний талбайнууд



Ханбогд сум дахь шинжилгээний талбайнуудыг Google Earth газрын зурагнаас үзүүлэв.



Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

Усны судалгаа шинжилгээний талбайгаас авсан усны дээжинд рН, Нийт Ууссан Хатуу бодисын хэмжээ (TDS), Цахилгаан-дамжуулалт (EC) ба хүнд металлын хэмжээг шинжилсэн болно. Шинжилгээг ОТ уурхайн ашигладагтай ижил Hanna HI 98129 төхөөрөмжөөр хэмжсэн. Тус төхөөрөмж нь хээрийн нөхцөлд чанарын түвшинг харуулдаг боловч яг бодит бус байдаг; бодит бус ойролцоо гэж болно. Хүнд металлын Sensafe туршилтын зурвасыг ашигласан.

УС/ХУДАГ

Талбай	GPS Хойд	GPS Зүүн	Д.Т.Д.Ө	рН	TDS	EC	Хүнд метал	Усны түвшин	Эх сурвалж	Төрөл
W1	43.31950	107.42027	967	7.8	840	1585	10	~	Баян	Гар насос
W2	43.31958	107.42017	966	6.3	775	1570	10	2.4	Баян	Гар насос Гүнзгий,моторто
W3	43.25381	107.18646	1051	7.7	350	690	20	~	Баян	түгжээтэй
W4	43.17701	106.79328	1190	7.88	2000	4000	10	~	Галуут	Хүргэлтийн сав
W5	43.18319	106.51228	1318	8.07	2000	4000	20	~	Галуут	Deer, motor, locl
W6	43.21725	106.56519	1240	8.3	404	680	20	8	Галуут	Гар
W7	43.09357	106.71651	1237	7.8	1075	2180	10	1	Галуут	Гар Гүнзгий,моторто
W8	43.09642	106.71712	1230	7.9	415	820	10	~	Жавхлант	түгжээтэй
W9	42.91462	107.03757	1026	8.2	307	616	20	1	Жавхлант	Гар
W10	42.91961	107.13648	1070	8	338	678	10	~	Жавхлант	Гар насос
W11	43.17617	107.26743	1071	9.2	155	318	10	0	Номгон	Гадаргын
W12	43.15496	107.29905	1117	9.2	277	530	10	9	Номгон	Гар
W13	43.08749	107.3819	1149	8.99	254	507	10	2	Номгон	Гар Гүнзгий,моторто
W14	43.01800	107.4055	1008	8.8	520	1040	10	~	Номгон	түгжээтэй Гүнзгий,моторто
W15	42.79673	107.6851	972	8.9	328	655	10	3	Номгон	түгжээтэй Гүнзгий,моторто
W16	42.79657	107.6839	946	8.65	221	444	10	~	Номгон	түгжээтэй Гүнзгий,моторто
W17	42.85503	107.83115	946	8.6	1892	3785	10	6	Номгон	түгжээтэй Гүнзгий,моторто
W18	42.91978	107.72939	898	8.5	744	1492	10	~	Номгон	түгжээтэй
W19	43.01419	107.61688	906	8.45	592	1180	10	2	Номгон	Гар
W20	43.01408	107.61692	906	8.35	582	1159	10	2	Номгон	Гар
W21	43.07056	107.5606	939	8.6	362	722	10	1.9	Номгон	Гар
W22	42.86559	107.12516	1080	8.38	673	1040	10	2	Жавхлант	Гар
W23	42.86559	107.12516	1080	8.64	684	1362	10	2	Жавхлант	Гар
W24	42.79624	107.00436	1066	8.84	519	1036	10	1	Жавхлант	Гар
W25	42.79891	107.00427	1043	8.68	396	793	10	1	Жавхлант	Гар, дугуйтай худ

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

W26	42.88020	106.97153	1088	8.85	459	911	10	2	Жавхлант	Гар
W27	42.91832	106.95353	1113	8.62	340	664	10	2	Жавхлант	Гар
W28	42.96698	106.94002	1115	8.8	223	445	10	1	Жавхлант	Гар
W29	42.60195	107.5211	1008	8.53	202	401	50	0	Хайран	Гадаргын
W30	42.64563	107.33379	935	8.54	122	247	10	0	Жавхлант	Гадаргын
W31	42.76249	107.06673	1007	7.9	1907	3761	10	0.5	Жавхлант	Гар
W32	42.85447	106.84127	1098	8.38	485	971	20	2	Жавхлант	Гар
W33	42.92419	106.71723	1185	8.4	321	643	10	1.5	Жавхлант	Гар
W34	42.97373	106.76186	1178	8.62	306	618	10	2	Жавхлант	Гар
W35	43.06033	106.8642	1169	8.53	595	1210	10	1	Жавхлант	Гар
W36	43.22588	107.18538	1080	8.38	315	631	20	1.2	Жавхлант	Гар
W37	43.14161	107.55861	950	8.28	217	431	10	2	Баян	Гар насос
W38	43.11412	107.8581	883	8.45	95	188	10	0	Баян	Гадаргын Гүнзгий,моторто
W39	43.16365	108.15829	917	7.98	313	628	10	~	Баян	түгжээтэй
W40	43.07008	108.2149	1000	7.74	797	1587	10	~	Баян	Гар насос
W41	42.98248	108.05763	968	8.24	127	256	10	3	Баян	Гар
W42	43.18951	106.96586	1128	7.04	1003	1997	20	2	Жавхлант	Гар
W43	43.07526	106.78434	1247.8	7.8	2000	4000	20	~	Галуут	Зөөврийн
W44	43.07145	106.77863	1225	8.08	579	1230	10	1	Галуут	Гар
W45	43.16536	107.25797	1125	8.02	233	470	10	0	Номгон	Гадаргын
W46	43.19569	107.20698	1112	7.7	178	356	10	2	Жавхлант	Гар
W47	43.23434	106.72324	1251	8.3	440	879	20	2	Галуут	Гар Гүнзгий,моторто
W48	43.27888	106.63879	1284	8.1	722	1441	20	11	Галуут	түгжээтэй
W49	43.11683	106.58518	1294	8.2	892	1790	10	1.5	Галуут	Hand Гүнзгий,моторто
W50	43.12420	106.90439	11655	7.8	638	1277	50	~	Жавхлант	түгжээтэй Гүнзгий,моторто
W51	43.12989	106.97196	1186	8.38	507	1011	10	32	Жавхлант	түгжээтэй Гүнзгий,моторто
W52	43.15605	106.94241	1159	8.05	455	906	10	~	Жавхлант	түгжээтэй
W53	43.38160	106.90309	1182	8.12	362	7.65	10	5	Галуут	Гар
W54	43.42673	106.9164	1151	8.06	540	1076	10	2	Галуут	Гар Гүнзгий,моторто
W55	43.49045	107.22903	1047	7.9	637	1275	20	75	Баян	түгжээтэй
W56	43.51740	107.31641	1014	7.9	788	1571	20	2	Баян	Гар
W57	43.17165	107.34781	1090	7.85	260	520	20	3	Номгон	Гар
W58	43.19236	107.29015	1078	8.5	158	318	20	2	Номгон	Гар
W59	43.19203	107.29199	1078	8.1	542	1081	10	1.5	Номгон	Гар
W60	43.09248	106.71868	1215	8.46	411	822	10	1	Галуут	Гар
W61	42.91779	106.89711	1119	7.51	664	1306	10	1.1	Жавхлант	Гар

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

W62	42.90495	106.95992	1097	8.09	586	1156	20	1	Жавхлант	Гар
W63	43.04323	107.00906	1165	8.06	560	1158	10	3.5	Жавхлант	Гар
W64	43.02590	106.99588	1158	7.58	539	1079	20	1.8	Жавхлант	Гар
W65	43.01889	106.98788	1157	7.58	813	1623	20	1.2	Жавхлант	Гар
W66	43.00198	106.97397	1148	7.92	411	821	10	1	Жавхлант	Гар
W67	43.06033	106.86422	1174	8.47	669	1340	10	1	Жавхлант	Гар

Ханбогд сумын худагны үзүүлэлтүүд- усны түвшин ба эх үүсвэрийн төрлүүд


Water Well Type Усны худагны төрлүүд			Гар худаг- Түвшин		
	#	%	Metres Метр	#	%
Hand Гар	46	69	≤ 1	12	26.1
Motor Моторт	14	21	≤ 2	24	52.2
Surface Гадаргын	5	7	≤ 3	4	9.0
DeliveryЗөөврийн	2	3	≤ 5	2	4.3
			≤ 9	2	4.3
			Unknown Үл мэдэгдэх	2	4.3

Хавсралт 8- ТООС

Тоос шингээлт

Тоос шигээдэг хайрцаг бүр нэг ижил буюу 100 х 60 х 300 мм-ийн хэмжээтэй нэг нарийн цаасан шүүлтүүртэй (жижиг зүйлсийг шингээх) мөн том хэмжээтэй зүйлсийг шингээх хөөсөн шүүлтүүртэй. Эдгээр шүүлтүүр нь газрын эрдэсжисэн тоосны хэсгүүдийг шингээж авахгүйн тулд агаарын тоос тоосонцорыг шингээж авах үүднээс 1.5-2м-ийн өндөрт байрлуулсан.

Ханбогд сум дахь тоосны судалгааны талбайнуудын зураг



- Сумын төв
- ▲ ОТ уурхай
- Улсын хил
- Сумын хил
- === Засмал зам
- Шороон зам

Ханбогд сум дахь тоосын судалгааны талбайнууд Google Earth зурагнаас



Ханбогд сум дахь тоос шингээх хяналтын талбайнууд. Талбайн GPS цэг, байршуулсан болоод цуглуулсан өдрүүд, тоосонд өртсөн өдрийн тоо.

Ханбогд сумын тоосны хяналтын үр дүн. “нэг өдөр дэхь тоосны хэмжээ”-г харьцуулах хэмжигдэхүүнээр илтгэсэн.


Талбай	Хайрцган дахь тоос	Хөөсөнцөр дэх тоос	Нийт тоосны хэмжээ	Нэг өдөр дэхь тоосны хэмжээ
D1	0.857	0.147	1.004	0.072
D2	0.073	0.021	0.094	0.007
D3	0.000	0.015	0.015	0.001
D4	0.210	0.029	0.239	0.017
D5	0.196	0.093	0.289	0.021
D6				
D7	0.000	0.050	0.050	0.004
D8	0.000	0.048	0.048	0.003
D9	0.160	0.048	0.208	0.015
D10	0.000	0.023	0.023	0.002
D11				
D12	0.000	0.040	0.040	0.003
D13	0.088	0.095	0.183	0.013
D14	0.030	0.138	0.168	0.012
D15				
D16	0.131	0.081	0.212	0.015

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц

Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
 ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
 2016 оны 9 дүгээр сар

D17				
D18	0.049	0.104	0.153	0.011
D19				
D20	0.078	0.054	0.132	0.009
D21	0.031	0.053	0.084	0.004
D22	0.000	0.045	0.045	0.002
D23	0.017	0.140	0.157	0.022
D24	0.105	0.098	0.203	0.018
D25	0.056	0.035	0.091	0.008
D26				
D27	0.044	0.162	0.206	0.019
D28	0.024	0.029	0.053	0.005
D29	0.120	0.054	0.174	0.016
D30	0.029	0.053	0.082	0.007
D31	0.133	0.017	0.150	0.010
D32	0.825	0.028	0.853	0.057
D33	0.117	0.032	0.149	0.010
D34	0.128	0.091	0.219	0.022
D35	0.184	0.063	0.247	0.025
D36	0.865	0.049	0.914	0.083
D37				
D38	0.277	0.024	0.301	0.027
D39				
D40	0.808	0.018	0.826	0.075
D41	0.000	0.049	0.049	0.005
D42	0.705	0.050	0.755	0.076
D43	1.478	0.017	0.358	0.040

Ханбогд сумын хэмжээнд тоос шингээлтийн (mg өдөр^{-1}) хуваарилалт. Өдөрт их тоос ялгаруулдагийг том хэмжээний тойргууд нь илтгэнэ.



- Сумын төв
- ▲ ОТ уурхай
- Улсын хил
- Сумын хил
- Засмал зам
- Шороон зам

Хавсралт- МАНЛАЙ СУМ

Ургамлын трансектийн GPS байршил.


МАНЛАЙ

Талбай	GPS	
	N Хойд	E Зүүн
1	43.53825	106.79850
2	43.89782	107.28889
	average of two sites	
3	2 талбайн дундаж	

Манлай сум дахь 12 трансектийн ургамлын бүрхэц

Талбай	Ургамлын бүрхэц %- худгаас метрээр					
	25.0	50.0	100.0	200.0	500.0	1000.0
1	0.6	2.7	3.2	7.3	7.7	8.2
2	2.7	1.9	2.0	1.6	2.6	9.4
Average per site						
Талбай бүрдэх дундаж	1.6	2.3	2.6	4.4	5.2	8.8


Манлай сум дахь 12 трансектийн ургамлын бүрхэц. Хэмжилтүүдийг уст цэгээс 25, 50, 100, 200, 500 ба худгаас хойд зүгт 1000 метрт хийсэн.



Сумаас авсан Манлай сумын хур тунадасны мэдээ



Ханбогд ба Манлай сумын ургамлын бүрхэцийн харьцуулалт. Манлай сумын дундаж (#) нь Ханбогд сумын дундажаас (#13). доогуур байна.



МАНЛАЙ Сум- Ус

Талбай	GPS Хойд	GPS Зүүн	Д.Т.Д.Ө	pH	TDS	ЕС	Хүнд метал	Усны түвшин	Эх сурвалж
1	43.74299	106.79925	1277	8.24	268	535	10	2	Гар
2	43.75262	106.83018	1267	8.28	354	706	10	5	Гар
3	43.92392	106.87753	1328	8.52	951	1920	10	4	Гар
4	43.98947	106.75434	1314	8.4	704	1408	10	~	Гүнзгий, түгжээтэй
5	43.98601	107.75423	1308	8.21	1093	2180	10	3	Гар
6	44.03298	106.71527	1352	7.9	610	1221	10	~	Motor
7	44.10026	106.60374	1310	8.5	858	17	20	3	Гар
8	44.10325	106.59893	1307	8.57	1090	2174	20	2	Гар
9	44.05958	106.40535	1301	7.73	497	993	10	~	Гүнзгий, түгжээтэй
10	43.98005	106.51575	1323	8.2	633	1267	20	~	Гүнзгий, түгжээтэй
11	43.89782	107.29889	1176	8.2	766	1531	50	~	Гүнзгий, түгжээтэй
12	43.75057	107.24842	1182	7.74	422	844	10	5	Гар

Баримт Хамтран Олж Тогтоох Үйл Явц
Малчдын Амьжиргаа болон Орон нутаг/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с үзүүлсэн Нөлөөллүүд
ОТМШБ Бүрэлдэхүүн 1: Бэлчээр ба малын үндны усны чанар, хүртээмжийн үнэлгээ
2016 оны 9 дүгээр сар

13	43.70855	107.22156	1181	8.5	688	1370	20	5	Гар
14	43.66231	107.72988	1189	8	374	746	50	4	Гар
15	43.66192	107.2285	1189	7.8	1361	2707	20	4	Гар
16	43.58891	107.1952	1086	7.7	1723	3451	20	5	Гар
17	43.92331	106.87783	1299	7.23	1552	3015	20	7	Гар
18	43.75162	106.83173	1259	7.91	566	1116	10	2	Гар
19	43.53009	106.80237	1220	7.97	556	1786	10	~	Гүнзгий, түгжээтэй

Манлай сум- усны эх үүсвэрүүд

Well		
Худаг	#	%
Hand		
Гар	14	70
Motor		
Моторт	6	30

Гар худаг- усны түвшин

Metres	#	%
Метр		
≤ 2	3	23
≤ 3	2	15
≤ 4	3	23
≤ 7	5	38

1. УДИРТГАЛ	1
2. АРГАЧЛАЛ	1
3 2003 ОНООС ХОЙШ УЛАМЖЛАЛТ АМЬЖИРГАА ХЭРХЭН ӨӨРЧЛӨГДСӨН БЭ?	3
4 ӨНӨӨГИЙН МАЛЧИД УЛАМЖЛАЛТ АМЬЖИРГААГАА ДАРААГИЙН ҮЕДЭЭ ХАДГАЛАН ӨВЛҮҮЛЭХ ЧАДВАРТАЙ ЮУ?	25
5 ОТ-С ШАЛТГААЛЖ БАЙГАА НЬ ЮУ ВЭ?	25
6 ДҮГНЭЛТ	29
ХАВСРАЛТ 1: АЖЛЫН ДААЛГАВАР	32
ХАВСРАЛТ 2: АСУУЛГА	33

1. Удиртгал

Энэ тайланд дараах асуудлуудыг хамран явуулсан нийгэм-эдийн засгийн судалгаагаар олж илрүүлсэн зүйлсийг тусгалаа. Үүнд:

- 2003 оноос өнөөг хүртэл малчин өрхүүдийн амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд, уламжлалт амьжиргаа, соёл заншил хэр алдагдсан
- Малчин өрхүүд дараагийн үедээ уламжлалт амьжиргаагаа тогтвортой өвлүүлэх чадамж
- Ямар нөлөөллүүд ОТ-с шалтгаалсан болох

Бүрэлдэхүүн 2-ын Ажлын Даалгаврыг бүрнээр нь Хавсралт 1-д оруулав.

2. Аргачлал

2.1 Арга зам

Нийгэм-эдийн засгийн судалгааны үйл явц дараах зүйлсийг хамарсан болно. Үүнд:

- Бичиг баримтыг хянан судлах
- Малчидтай хийсэн зорилтот бүлгийн үүлзалтууд
- 106 малчин өрхтэй хийсэн хагас-бүтэц бүхий ярилцлагууд (дийлэнх тохиолдолд өрхийн нэгээс илүү гишүүнийг хамарсан)
- Малчидтай хийсэн ярилцлагын нэг хэсэг болох оролцоот ажиглалтууд
- Сумын засаг захиргаа, ОТ-н ажилтнуудтай хийсэн үүлзалтууд
- Сумаас мэдээлэл цуглуулах.

Баримт хамтран олж тогтоох аргыг тусган, ГТЗ-тэй тохиролцооноор антропологийн гүнзгийрүүлсэн судалгааны анхны аргачлалыг өөрчлөн (саналыг үзнэ үү) ярилцлага авах өрхийн тоог 100 болгон нэмэгдүүлж, оролцоот ажиглалтанд зарцуулах хугацааг багасгасан болно.

2016 оны 4 сард баримт бичгийг хянан үзэж, 5 сарын эхнээс 7 сарын дунд хүртэл хээрийн судалгаа явуулав. Ярилцлагыг сум даяар хийсэн. Эхний 81 ярилцлагыг хийхдээ хөдөөгүүр явж, малчин өрх бүрийн бууцанд очсон; дараа нь сум, багийн төв дээр малчид ирж бидэнтэй уулзаж байв. Ярилцлага авсан өрхүүдээс арван дөрөв нь ярилцлагын үеэр сумын төвд амьдарч байлаа.

Айлуудаар очиход хүмүүс ихэд дуртай байсан бөгөөд 100 ярилцлагаа аваад дууссаны дараа ч зарим өрхүүд нэмж хамрагдахыг хүсч байлаа.

Хүснэгт 1: Ярилцлагууд


Ярилцлага хийсэн малчин өрхүүд	Жавхлант	Гавилууд	Баян	Номгон	Бүгд
--------------------------------	----------	----------	------	--------	------

Бүгд	42	32	19	13	106
------	----	----	----	----	-----

2.2 Хүн амын түүвэр

Судалгаанд оролцогчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгов. ГТЗ малчдыг гурван бүлэгт хуваасан нэрсийн жагсаалт өгсөн: нөхөн олговор авсан өрхүүд (32 өрх ярилцлага өгсөн), нөхөн олговор олгогдвол зохих гэж ГТЗ-өөс тодорхойлж өгсөн (22 өрх ярилцлага өгсөн), болон сумын бусад малчин өрхүүд. Өрх нэг бүрт дугаар оноож, компьютерын программ ашиглан дугааруудыг түүврээр сугалсан. Түүнчлэн ГТЗ-ийн хүсэлтээр сумын төв дээр байгаа өндөр настай малчдаас тусгайлан ярилцлага авлаа.

Хүснэгт 2: Насны ангилал



2.3 Хагас-бүтэцтэй ярилцлага

Ярилцлагыг өрхийн бүтэц, нүүдэл хөдөлгөөн, бэлчээр ба усыг улирлын чанартай ашиглах, өрхийн орлого, зарлага, газар эзэмших байдал, итгэл үнэмшлийн систем, үнэт зүйлс, нийгмийн өөрчлөлтийн талаарх ойлголт зэргийг хамарсан 73 асуулттай¹ хийсэн. Ярилцлага 30 минутаас гурван цаг үргэлжилж байсан бөгөөд ярилцлага авахаар очих үед гэрийн эздийн хэн нь гэртээ байснаас шалтгаалан ихэнхдээ хоёулангаас нь авсан. Оролцогчид бүгдээрээ бүх асуултанд хариулаагүй. Өрхүүдэд судлаачтай холбоо барих мэдээлэл агуулсан хуудас тарааж өгч байлаа.

Түүвэрт Жавхлант, Гавилууд багийнхан зонхилж байсан нь бидний түүврээ сугалсан гурван жагсаалтанд энэ хоёр багаас илүү олон өрх байсантай холбоотой.

Багийн дарга нар, сумын засаг даргын орлогч, байгаль орчны байцаагчид, газрын харилцааны мэргэжилтнүүд зэрэг засаг захиргааны ажилтнууд болон ОТ-н байгаль орчны мониторингийн болон нийгмийн оролцооны багуудтай ярилцлага хийсэн. Нутгийн оршин суугчид, дэлгүүрийн эзэд,

¹ Хавсралт 2-ыг үзнэ үү.

эмнэлгийн эмч, сувилагч нар, ОТ-н орон нутгийн төвд ажиллаж буй хүмүүстэй албан бус ярилцлага хийв.

Зарим малчид дор дурьдсан нэг буюу хэд хэдэн шалтгааны улмаас нийгэм-эдийн засгийн судалгаанд оролцохдоо санаа зовж байгаагаа илэрхийлж байлаа. Үүнд:

- Судалгаанд оролцоод ямар ч ашиг тус гарч байгаагүй.
- Тэдний тухай бусдын бичсэн аливаа тайлан мэдээллийг олж авах боломжгүйд бүхмддэг
- ГТЗ-ийн тухайд итгэл муутай.
- ГТЗ зөвхөн Жавхланта, Гавилууд багийн малчдын асуудалд анхаардаг гэж үздэг.

2.4 Оролцоот ажиглалт

Оролцоот ажиглалтыг хийхдээ Ханбогд сумын төвд оршин суугчдын дунд хоёр сар амьдарч, сумын нийт нутаг дэвсгэр дэх малчин өрхүүдээр зочлон, Ханбогд Хайрханы тахилга, сумын Наадам зэрэг орон нутагт зохиогдсон арга хэмжээнүүдэд оролцож, тэмээний ноос авах, саахыг ажиглан, малчидтай хамт тэдний худаг, уст цэгийг очиж үзэн, нутаг орноор олонтаа явлаа.

2.5 Зорилтот бүлгүүд

2016 оны 5 сард судалгааны ажлын эхэнд багийн төвүүд дээр дөрвөн зорилтот бүлэг зохион байгуулсан. Жавхланта, Гавилууд багийн зорилтот бүлгүүдийн эрэгтэй, эмэгтэй оролцогсад аль аль нь сайн ирж оролцов. ОТМШБ Номгон, Баян багийн төвүүдэд уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн ч Хайрханы тахилга, тэмээний ноос хяргах ажлууд давхцсанаас Номгон багийн уулзалтыг цуцалсан. Баян багийн малчидтай сумын төвд үүлзлаа.

2.6 Манлай сумтай харьцуулсан нь

Ханбогдтой ижил төстэй болон өөр зүйлүүдийг шинжлэхийн тулд Манлай суманд судалгаа хийв. Малчид, орон нутгийн иргэдийг судалгаанд хамрууллаа. Манлай суманд хийсэн харьцуулсан судалгааны үеэр 20 хүнээс ярилцлага авсан.

3 2003 оноос хойш уламжлалт амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөн бэ?

3.1 Хам сэдэв

Хөдөлгөөнт буюу нүүдлийн мал аж ахуйн үндсэн цөм нь нүүдэллэх хөдөлгөөн билээ. Нүүдэл нь албан тогтолцоо, технологи, мэдлэг, дадал, түүнчлэн байгаль орчны нөөцийн боломжоос шалтгаалан явагддаг. Технологи гэдэгт зөөврийн орон байр (*гэр*), намрын *отор* гэх мэт улирлын нүүдэл, мөн газар орон ба уур амьсгалын хэв шинжийн талаарх тусгай мэдлэг орно. Хувь хүний дадал туршлага, мэдлэгээс гадна бэлчээр, ус гэх мэт нөөцийг нийтэд хүртээмжтэй болгох замаар нүүдэл хийх боломжоор хангахад засаглалын байгууллагууд бас үүрэгтэй. Захиргааны хууль тогтоомжид орон

нутгийн засаг захиргаа малчдын нутаг орныхоо газрыг өмчилж ирсэн газар эзэмших уламжлалт хэв маягийг² баримтлах гэж заасан байдаг (газар эзэмших, ашиглах байдал хэсгийг үзнэ үү). 2003 оноос хойш Монгол улсын мал аж ахуйд олон шинэлэг зүйлс нэвтэрчээ. Шинэ технологи орж ирснээр хүмүүсийн нүүдэл хийх арга хэлбэр өөрчлөгдсөн хэдий ч уламжлалт амьжиргааны гол мөн чанар бол нүүдэллэх явдал гэж үзэх ёстой. Жишээ нь: халаалтын болон хоол үнд хийх зриулалтаар хэрэглэдэг зүүх сайжирсан, нарны энерги, зурагт радио, гар утас, моторт унаа, ачааны тэрэг гэх мэт. Ийм шинэлэг зүйлс байгаа хэдий ч Монголын мал аж ахуй 'уламжлалт' гэж нэрлэж болохуйц тодорхой шинж чанаруудаа хадгалсаар байна. Монгол Улсын Малчны Үнэмлэх дээр эдгээрийг хүлээн зөвшөөрч оруулсан байдаг, үүнд:

- Нүүдэл хөдөлгөөн
- Уналга, ачилгад ашиглах мал амьтныг сургах мэдлэг, дадлага (морь, тэмээ)
- Монгол цагаан идээ, ноос, мах, арьс шир гэх мэт мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэг, дадлага
- Зочлох, хүндэтгэх нийгмийн зан заншил
- Нутаг орныхоо газрыг ашиглах байдал, байгальд хандах хандлага
- Нүүдэл хөдөлгөөн, бэлчээрийн хүртээмжийг зохицуулах тогтолцоо.

3.2 Бүс нутагт Уул уурхай нэвтэрсэн нь

2003 оноос өмнө Монгол улсын ДНБ-ий 40%-ийг нүүдлийн мал аж ахуй зонхилсон хөдөө аж ахуйн салбар бүрдүүлж байв. 2003 оноос хойш ДНБ-нд уул уурхайн эзлэх хувь тогтмол өсч, хөдөө аж ахуйн харьцангуй буурч байна.^{3,4,5} Эдийн засгийн ийм өсөлт, уул уурхай өргөжилт Монгол улсад нийтэд нь тухайлбал том уурхайнуудын өлгий Өмнөговь аймагт ихээхэн өөрчлөлт авчирсан.

Өмнөговь аймгийн зүүн хэсэгт Таван Толгой, Оюу Толгой гэсэн Монголын хоёр том уурхай, түүнчлэн Нарийн Сухайт, Баруун Наран, Овоо Толгой⁶ гэх мэт бусад хөгжиж буй⁷ уурхайнууд оршдог. Замуудын барилга байгууламж, тээврийн хөдөлгөөн нэмэгдсэн, сумын төвийн хүн амын өсөлт, төмөр зам, эрчим хүчний шугамын барилга байгууламж зэргийг оролцуулан эдгээр уул уурхайн бүтээн

² Фернандез-Гименез, М, Б. Батбуян. 2004. Хууль тогтоомж ба Эмх журамгүй байдал: Монгол улсын газрын хууль орон нутагт хэрэгжиж буй байдал. *Хөгжил ба Өөрчлөлт* 35(1): 141–65.

³ Сузуки Юко. 2013. Монгол улс дахь уул уурхайн хөгжил ба нүүдлийн аж байдлын хоорондын зөрчил. Монголын Экосистемийн Сүлжээ: Уур амьсгалын болон нийгмийн өөрчлөлтийн байгаль орчны асуудлууд. Х. 269

⁴ Шарма, В. 2016. Монголын малчдын хүний аюулгүй байдал: Хувьсан өөрчлөгдөж буй эрсдэл, боломжууд. *Хүний аюулгүй байдлын олон талыг ойлгохуй* (хх. 230-250). Брилл.

⁵ Х 10 Оксфордын бизнес бүлгийн тайлан 2014.

⁶ Кэйн, Изабел. 2015. Уул уурхайтай холбоотой нийгмийн болон хүйсийн нөлөөллүүд, Монгол улс. Адам Смит Интернэйшнл.

⁷ Сузуки Юко. 2013. Монгол улс дахь уул уурхайн хөгжил ба нүүдлийн аж байдлын хоорондын зөрчил. Монголын Экосистемийн Сүлжээ: Уур амьсгалын болон нийгмийн өөрчлөлтийн байгаль орчны асуудлууд. Х. 269

байгуулалт Ханбогдын газар нутгийн төрх байдлыг хурдацтай өөрчилжээ. Оюу Толгой Ханбогдод үйл ажиллагаа явуулж байна.⁸ Барилгын ажлаар олон гэрээт гүйцэтгэгчид уг бүс нутагт орж ирсэн. Таван Толгой компани Ханбогдын нутгаар гардаг замаар нүүрс тээвэрлэж байгаа ба улирлаас шалтгаалан өдөртөө 400-500 том тэрэг явж өнгөрдөг.⁹

Зөвхөн том хэмжээний уул уурхайн компаниуд суманд нөлөө учруулж байгаа биш юм. 2008 оны Өмнөговийн Нийгмийн Суурь Судалгаагаар¹⁰ “гар аргаар олборлолт хийж буй уул уурхайн зохицуулалтгүй үйл ажиллагааны улмаас мөнгөн ус, хүнцэл гэх мэт химийн бодисоор ус, хөрс бохирдсон ноцтой тохиолдлуудын (х.19)” нөлөө Ханбогдод учирсан гэжээ (х.13). Бидний ярицлагын үеэр Номгоноос Дорноговийн хил хооронд байгаа гар ажиллагаатай уурхайн нөлөө Ханбогд сумын Номгон багт туссан гэж малчид ярилцлагын үеэр хэлж байлаа. Ярианы хэлэнд энэ хавийг “Ирак” эсвэл “Ирак толгой” гэж нэрлэдэг. тэр үед нутгийн зарим малчид янз бүрийн газар гар ажиллагаатай уурхайд ажиллаж байсан гэж ярилцлагын үеэр хэлж байв.¹¹ Монгол оронд учирсан айхтар зуднуудын нэг 2000-2001 онд болсны дараа 2000-2004 онуудад энэ бүс нутаг гар ажиллагаатай уурхайн талбар болж байжээ. Зуданд малаа алдсан нь орлогоо төрөлжүүлэх, зудны алдагдлаас гарах нэг арга зам нь мал аж ахуйн бүс боломжууд болохыг мэдэж, сонирхоход хүргэсэн аж.

Байгаль орчин, үндэсний ба орон нутгийн эдийн засагт уул уурхай нөлөөлөн, үндэсний ба орон нутгийн улстөрийн гол асуудал болон хувирч, Ханбогдыг ихээхэн өргөжүүлж, нийгэм, соёлын шинэ уур амьсгалыг бий болгожээ. Ханбогдод уул уурхай бий болсноор нийгэм ба бодит орон зай хувьсан, олон хэмжээст өөрчлөлтийг эхлүүлсэн байна. Эдгээр өөрчлөлтүүд нь Ханбогдын иргэдийн амьдралд шууд ба шууд бусаар эерэгээр ч сөрөгөөр ч нөлөөлсөн. Өмнөговийн хөдөөд том, жижиг уул уурхай нэвтэрснээр гарсан өөрчлөлтүүдийн мөн чанар нь тэдгээрийн олон талт байдал, хэмжээ, цар хүрээ, түүнчлэн сэтгэл зүйн болон улс төрийн шинж зэргээс шалтгаалаад нэлээд нарийн төвөгтэй.

3.3 Ханбогд сумын нүүдэл хөдөлгөөний хэв маяг

Ханбогд сумын малчид нүүдэл хийхдээ цаг агаар, бэлчээр, усны боломжоос ихэд хамаардаг гэж байв. 2014 оны байдлаар уул уурхайн лиценз (бүгд ашиглагдаж байгаа биш) сумын нийт нутаг дэвсгэрийн 38.2% -ийг хамарч байжээ. ¹² Гантай үед малчид бэлчээр, ус хөөн ойр ойрхон нүүдэллэдэг. Өрхийн

⁸ Жигжсүрэн нар. 2015. Малчдын ажиглалтанд үндэслэн уур амьсгалын нөлөөллийг үнэлэн, гидро-уур амьсгалын болон алсын зайн тандалтын мэдээ баримттай харьцуулсан нь. Олон талт судалгааны бага хурлын ажиллагаа: Монголын бэлчээр нутагт даван туулах чанарыг бий болгох, Улаанбаатар.

⁹ С. Чулуун, Г. Бямбарагчаа. (2014) Хиймэл дагуулын нүүдэлчид: Монголын уул уурхайн бүсийн малчдын тактикууд. Өвөр Ази 16, 409-426.

¹⁰ Бодлого Судлалын Төв. 2008. “Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа.”

¹¹ Дэлхийн Банкны Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдийн талаарх 2006 оны тоймд зуд болсон жилүүдийн дараа малаа олноор нь алдсаны үр дагавраар гар ажиллагаатай уурхайд малчдын оролцоо ихэссэн гэжээ (х. 1)

¹² Жигжсүрэн нар. 2015. Малчдын ажиглалтанд үндэслэн уур амьсгалын нөлөөллийг үнэлэн, гидро-уур

гишүүдийн нас, хүн хүчний байдал нь улирлын чанартай хийх нүүдлийн тоо болоод өдөр тутам малаа бэлчээрлүүлж, хариулахад нөлөөлдөг байна. Бэлчээр, усны бололцоо, хүртээмж нь малчид улирлын чанартай нүүдэл хийх чадавхид нөлөөлдөг. Жавхлант, Гавилууд багийн малчдын 90%-с дээш хувь нь “нүүх газар байхгүй болсон” гэж байв. Эдгээр багийн малчид ОТ-н хашаа, нисэх буудал, эрчим хүчний шугамыг барих үеэр гаргасан том нүхнүүд, Жавхлант, Гавилууд багт олон өвөлжөө нэг доор байгаа зэргээс нүүдэл өөрчлөгдсөн буюу саад тотгортой болсон гэж байлаа.

“Бид нүүхгүй, нэг газраа байгаад байвал мал өсөхгүй. Өнгөрсөн хэдэн жилд бид олон нүүдэг байсан. 2013 онд манайх Цогт-Цэцийн зүүн хойно өвөлжсөн, гэтэл хүүхдүүдийн сургууль энд, тэднийг нааш цааш зөөхөд зардал их гарсан. Хүдгийн насос бас их үнэтэй. Зардал их гарч байна. Бидний нүүж очсон газрын хүмүүс сайн, муу янз янзын л авир гаргадаг. Зарим нь усаа уулгана, зарим нь үгүй.” – Баян багийн малчин

Сайн бэлчээр, устай газар ховор тул их нүүдэг болсон гэж малчид олонтаа хэлж байв.¹³ Нөгөө талаар, байгаа бэлчээр, устайгаа ойрхон байхын тулд ерөөсөө нүүдэггүй малчид ч ажиглагдсан. Жишээ нь зарим малчид Цагаан Сараас хойш хаваржаа руугаа нүүлгүй өвөлжөөндөө байдаг, зунжаа руу нэг л удаа нүүдэг аж (хавсралт 2.1-ийг үзнэ үү). Зарим малчид нүүгээд очих газаргүй тул өмнөхөөсөө олон нүүдэг байхад нөгөө зарим нь нүүгээд очих газаргүйн улмаас огт нүүхээ больсон байдал харагдлаа. Ийм эсрэг тэсрэг байдал нь газар эзэмшил баталгаагүйн илэрхийлэл юм.

Баян багийн малчид бэлчээр байгаа ч худаг цөөн учраас хол нүүж чаддаггүй гэв. Гүний Хоолойн цооногийн талбайн ойролцоо байдаг Баян багийн малчид өндөрдүү газарт ус байхгүй болсон, айлууд устай худаг бараадан доошоо нүүж, нэг дороо бөөгнөрч байна гэж тайлбарлалаа. Номгон багийн малчид тэмээний хувьд сайн бэлчээр байна, бог малын тухайд тэр хавийн өвс ургамлаа идээд сурчихвал болохоор гэж байв. Номгон багийн малчид усны асуудал тун чухал, худаг ялангуяа гүний худаг дутмаг гэлээ.

2016 оны 2 сараас 7 сарын хооронд малчид нэгээс гурван удаа нүүсэн гэж байв. Жилийн дотор малчдын нүүх тоо нэлээд өөр байна.¹⁴ Ерөнхийдөө олон малтай айлууд илүү олон нүүдэг, жилд доод тал нь 10 удаа нүүдэг аж. Огт нүүдэггүй гэсэн малчид Жавхлант, Гавилууд багт нутагладаг.

Хүснэгт 3: Нүүдэл малын тоогоор, Өрхийн түүвэр, 2015

амьсгалын болон алсын зайн тандалтын мэдээ баримттай харьцуулсан нь. Олон талт судалгааны бага хурлын ажиллагаа: Монголын бэлчээр нутагт даван түүлах чадвар бий болгох, Улаанбаатар.

¹³ Хавсралт 2.1-с малчдын хэлснийг үзнэ үү.

¹⁴ Үүнийг Сара Жексон баталдаг (2015) Тоостой замууд ба тусгаарлалт: Монголын Өмнөговь аймгийн уурхайнуудын замаас босч буй тоосны тухай. *Геологийн хэлэлцүүлэг*. 66, х. 94-105.

Жей Эс Эл Консалтинг Лтд. 38 Хэйфилд роуд, Оксфорд, ОХ БТТ, Их Британи
Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73
+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

Албан бус орчуулга – Орчуулгын утга зөрж байвал бичиг баримтын эх хувийн утгыг баримтлана.

Малын тоо	Жилийн нүүдлийн тоо
>100	0-2
100-250	1 - 10 удаа
250-500	2 - 6
500-800	3 - 12 удаа
800 +	20 хүртэлх удаа

Малчдын нүүдэлд нөлөөлж буй хүчин зүйлс:

- Бусад айлуудтай шөргөөцөлдөх эсвэл хэл ам гарахаас эмээх (хар хэл ам).
- Нутаг орноосоо нүүн сумын бусад газарт байгаа айл өрхүүдтэй зөрчилдөж хаширсан.
- Дэд бүтцийг тойрон нүүхэд бэрхшээлтэй.
- Төмөр зам ба нүүрсний замын хооронд хавчигдах.
- Засгийн бодлого, зохицуулалт дутмаг.
- Усны боломж (дор үзнэ үү).
- Бэлчээрийн боломж (дор үзнэ үү).
- Малын төрөл, тоо толгой (өөрөөр хэлбэл тэмээ эсвэл ямаа гм)

Хүснэгт 4: Өвөлжөөнүүдийн хоорондох зай, жилийн нүүдэл баг тус бүрээр, 2015

Баг	Өвөлжөөнүүдийн хоорондох зай	Жилийн нүүдэл
Жавхлант	Их ялгаатай, зарим нь ойрын саахалтаасаа 2-4 км-т, зарим нь 10 км хол байдаг	Их ялгаатай, зарим айлууд нүүдэггүй, зарим нь 10 ба түүнээс дээш удаа нүүдэг.
Гавилууд	Ерөнхийдөө 2-5 км зайтай	Их ялгаатай, зарим айлууд нүүдэггүй, зарим нь жилдээ 2-10 гаруй удаа нүүдэг.
Баян	Доод тал нь 5 км, хамгийн хол нь 20 км-т	Ялгаатай, жилдээ 2 удаа ба 10-с дээш удаа нүүдэг.
Номгон	Их ялгаатай, зарим нь 1 км-т, зарим нь 7 – 20 км	Ялгаатай, цаг агаар, усны боломжоос шалтгаалдаг

Бусад өөрчлөлтүүд:

- Моторт унаагаар малаа хариулах

Ханбогдод судалгаанд хамрагдсан өрхүүдийн дийлэнх нь малаа мотоцикл, моторт унаагаар хариулдаг болсон байна. Уламжлалт нүүдэлд морь тэмээ гэх мэт ачилгын мал хэрэглэдэг. Малаа моторт унаагаар хариулах болсноор газар ашиглах арга болон мал хариулгын хэмнэлийг өөрчилжээ. Үүний зэрэгцээ уналгын тэмээ, морь сургах чадвартай өрхийн тоо ихэд цөөрсөн гэж малчид хэлж байлаа.

- Өвөлжөөний бууцан дээрх байнгын орон сууц

Улирлын чанартай байнга нүүдэллэхэд зөөж барьж буудаг уугуул эсгий майхан буюу гэр чухал хэрэгсэл байдаг бөгөөд өвөлжөөний бууцандаа байнгын орон сууцтай болсон нь уламжлалт нүүдэлд

өөрчлөлт гарсныг харуулж байна. Өөр нэг хувилбар нь Ханбогд сумын зарим айлууд өөр маягийн нүүдлийн орон сууц хэрэглэх болсон бөгөөд энэ нь ачааны тэрэг эсвэл жипээр чирээд явдаг дугуйтай байшин юм. Бидний очсон өрхүүдийн 15% орчим нь хөдөө суурин орон байшинд амьдарч байв. Монголын бусад хэсэгт өрхүүдийн 1% хүрэхгүй нь хөдөө байнгын орон сууцанд амьдардаг.

Хүснэгт 5: Ханбогдын бүх малчин өрхийн орон сууцны төрөл, 2015 он (сумын тоо баримт)

Багийн нэр	Байшинд амьдардаг өрх		Гэртэй өрх		Суманд байшинтай өрх		НИЙТ
Номгон	7	12%	46	78%	6	10%	59
Гавилууд	21	20%	85	79%	1	1%	107
Жавхлант	9	10%	69	73%	17	18%	95
Баян	23	26%	63	72%	2	2%	88
НИЙТ	60	17%	263	75%	26	7%	349

* Ханбогдын нийт малчдын 17% нь хөдөө байшинтай.

- Өвөлжөөг чухалчилсан газар ашиглалт (доорх хэсгийг үзнэ үү)
- Малчдын хоорондын зөрчилдөөн: Бусадтай муудах, хэл ам гарах, өөр сумын эсвэл Ханбогдын өөр хэсэгт байгаа малчидтай зөрчилдөхөөс эмээхийг нүүдэл хийх явдал багассаны шалтгаан гэж байв.
- Бусад газрын малчид гадны малчдаас бэлчээрээ ашиглуулсны хөлс нэхдэг
- Өрхийн бүтцэд гарсан өөрчлөлт (өрх салангид амьдрах, ээж нь хүүхдүүдтэйгээ суман дээр байх, ажил алдагдах, зардал өсөх)
- Дэд бүтэц
- Уур амьсгал, байгаль орчин
- Нөлөөлөлд өртсөн өрхүүдийг нүүлгэн шилжүүлсэн

Уур амьсгал, хүний барьсан барилга байгууламж, дэд бүтцийн улмаас бодит байгаль орчин хувирсан, засгийн бодлого, эдийн засгийн өөрчлөлтийн улмаас газар ашиглах хэв маяг, нийгмийн харилцаа өөрчлөгдөж байгаа зэрэг нь уламжлалт нүүдэлд өөрчлөлт гарахад хүргэжээ. 2004 онд УЛТ-н дотроос өрхүүдийг нүүлгэн шилжүүлсэн, мөн шинэ дэд бүтцийн байгууламж баригдсанаар бэлчээрийн ачаалал нэмэгдэж, бэлчээр, устай газар олж нүүхэд бэрхшээлтэй болсон гэж Гавилуудын малчид хэлж байв.

3.4 Үр шимтэй бэлчээрийн хүртээмж

Ханбогдод үр шимтэй бэлчээрийн хүртээмж өрхийн гишүүдийн нас, түршлага, суманд байгаа байршил, өмчилдөг малын тоо, төрлөөс шалтгаалан өрх бүрийн хувьд харилцан адилгүй байна. Үр шимтэй бэлчээрт хүрэх нь өрхийн чадлаас хамаардаг. Жавхлант, Номгон багийн бүх малчид бэлчээрийн хүртээмж асуудалтай, зарим малчид Баян, Номгон багт бэлчээр дутмаг гэв. Хадлангийн талбайн талаар яриагүй. Хүртээмж багассан нь хүний болон байгаль орчны хүчин зүйлээс шалтгаалсан гэж байлаа. Үүнд:

- Малчдын 90-с дээш хувь нь уур амьсгал (өөрөөр хэлбэл цаг агаар, хур тунадасны хэмжээ), дэд бүтэц (уурхайтай холбоотой дэд бүтэц, мөн бусад айлуудын өвөлжөө) бэлчээрийн хүртээмжид гол нөлөөлөл учруулсан гэв.
- Устай үгүйгээс шалтгаалан бэлчээрийн хүртээмжид нөлөөлөл учирсан гэж малчид 100 % хэлж байлаа.
- Сумын хэмжээнд бог малын бэлчээр олох тун ярвигтай болсон гэж малчид үзэж байна. Гантай цагт зарим өрхүүд малаа Баян-Овоо, Цогт-Цэций, эсвэл бүр Дундговь руу найз нөхдийндөө аваачиж тавьдаг.
- Айл өрхүүд өмчилсөн өвөлжөөнүүд бэлчээрт бөөгнөрсөн.
- Дараах зүйлс бэлчээрийг эзэлж, ашиглаж, тасалсан буюу эвдэлсэн: ОТ-н лицензит бүс, хуучин ба шинэ нисэх буудал, ОТ-Ханбогдын зам, Таван Толгойн нүүрсний зам, төмөр замын барилгын ажил, карьерууд (сумын байгаль орчны мэргэжилтний хэлснээр зөвхөн төмөр замын барилгын ажилд ашиглаж буй 30 карьер тус суманд байна), Катарын шувууны хүрээлэн, Тусгай Хамгаалалттай Бүс, бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй бусад компаниуд, эрчим хүчний станц, төмөр замын ажилчдын кэмп, ОТ-н амралтын газар, Ханбогд сумын төвийн ойролцоох ус боловсруулах төв, гүний усны шугам хоолой, ОТ ба Цагаан Суваргын хоорондох эрчим хүчний шугамын барилга байгууламж, бүс нутагт ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжүүд.
- ОТ-н уурхайн улмаас зуны бэлчээрээ алдсан.
- Ойр орчим нь усгүйн улмаас ашиглах боломжгүй бэлчээр (Номгон, Баян баг).
- Бэлчээр тоосонд дарагдсан.
- Зэрлэг нохой, чоно олноор сүрэглэсэн.
- Малаа машинаар хариулж бэлчээр талхалдаг.
- Бороо хур бага байгаагаас бэлчээр дутмаг.
- Маш олон тооны мал нэг бэлчээрт дэндүү удаан идээшилдэг.
- Номгонд хулангийн сүргийн тоо толгой олширсон.
- Олон малтай айлын тоо хэт ихэссэн.

3.5 Уламжлалт усны эх үүсвэрийн хүртээмж

Бүх багаас ярилцлагад хамрагдсан өрхүүд 100% усны хүртээмж асуудалтай гэлээ. Ярилцлага өгсөн малчдын дийлэнх нь урсгал болон тогтмол ус ховордсон, худгийн ундарга 24 цаг буюу түүнээс удаан болсон зэргээс усны хүртээмж багассан гэж үзэж байна. Мотороо хулгайд алдахгүйн тулд эсвэл моторын түлшийг авч ашиглахаас сэргийлэх үүднээс өмнө нь нийтийн хэрэгцээний байсан худгуудыг цоожилж түгжих болсон ажээ (ОТМШБ очих үед Баян багт нэг шинэ худгийг цоожилж байсан). Малчин “Худгаа цоожлохгүй бол хүмүүс моторыг нь хулгайлчихна. Харин хүмүүс ирээд ус авна гэвэл түлхүүрээ өгнө. Энэ бол хувийн худаг. Энержи Ресурсынхан манайд гаргаж өгсөн, худгийн паспорт Энержи Ресурст байгаа” хэмээн тайлбарлаж байлаа.

Малчдын үзэж байгаагаар ус ховордсоны шалтгаан нь:

- ОТ-н үйл ажиллагаа гүехэн гүний усанд нөлөөлж байна.
- ОТ-н гоожиж байгаа цооногуудаар дээдэх ус доошоо алдагдаж байна.
- Бор Овоон ойр тойрны газрыг бид ашиглах боломжгүй болсон.

- Номгон, Баян баг зэрэг үр шимтэй бэлчээртэй газруудад хангалттай тооны худаг байхгүй.
- Худгуудыг түгждэг.
- Худгийн ундарга маш удаан, өмнө нь усалдаг байсан адил тооны малыг усалж дийлэхгүй болсон.
- Хур бороо бага.
- 1000 давсан тооны малтай малчид дэндүү олширсон.

Хүснэгт 6: Усны асуудал, Түүвэр бүлгийн өгүүлснээр, 2015

Баг	Тоочсон усны асуудал
Жавхлант	- худгийн ундарга удаан - тогтоол ус, задгай үгүй болсон - цоожтой худгууд
Гавилууд	- худгийн ундарга удаан - тогтоол ус, задгай үгүй болсон - ажилтай худгууд байхгүй болсон
Баян	- өндөрлөг газар ус хомс - худгийн ундарга удаан - сайн бэлчээртэй газарт худаг хангалтгүй - өндөрлөг газар ус дутмаг
Номгон	- гүехэн гүний ус багассан - гүехэн худгууд усгүй болсон тул гүний худаг олныг барих хэрэгтэй - худаг 24 цаг эсвэл түүнээс удаан ундардаг - сайн бэлчээртэй газарт худаг хангалтгүй

Ярилцлагад хамрагдсан өрхүүд бараг 100% ус ховордсон асуудал ОТ-н уурхайн үйл ажиллагаанаас бүрэн эсвэл хагас шалтгаалсан гэв. Жишээ нь ОТ ус хүргэж өгч байгаа нь усны хангамжид учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрч буй хэрэг гэж үзэж байна.

Малчид жил тойрон худгийн усанд найддаг болжээ гэж үзэх үндэслэл байна. Нэг малчны хэлснээр өмнө нь тэд жилд зөвхөн гурван сар худгийн ус хэрэглэдэг, бусад үед булаг задгайн усаа уудаг байсан ажээ. Одоо малаа услахын тулд жилийн туршид худагт найдах болжээ. Хэрэглээний хэв маяг ийнхүү өөрчлөгдөж байгаагаас бүх хэрэгцээг хангах худгийн ачаалал ихэссэн. Жавхлантын нэг малчин “Дээр үед бид их л нүүдэг байлаа. Бэлчээр, ус элбэг байв. Бор Овоон ус Ханбогд даяар хаа сайгүй хүрдэг байсан. Ус авах гэж ховоо ашигладаггүй, газарт хальсан усыг нь уудаг байлаа” гэж батлан өгүүлж байв. Малчид ус хэрхэн ашигладаг байсныг ойлгох, тэр хэв маягыг нь баримтжуулах нь ус ховордсоны цаад шалтгааныг тодорхойлоход чухал алхам болно.

Худгийн засвар үйлчилгээ: малчдын ярьж байгаагаар худгийг хоёр аргаар арчилдаг: худгийн ёроолын лаг шаврыг зайлуулж цэвэрлэх эсвэл бүрэн ‘засвар үйлчилгээ’ хийх. Малчид өөрсдөө гүехэн худгийн лаг шаврыг жилдээ нэг юмуу хоёр удаа зайлуулдагас өөрөөр олонх худгийг 1990-ээд оноос хойш

сэргээн засварлаагүй. Гүний худгийг малчин өрх арчлахад хэцүү, тусгай тоног төхөөрөмж шаардлагатай.

Цөөхөн, ер нь энгийн хөрсний худаг цөөнтэй. Ер нь ус байгаад дандаа хөрсний дор байдаг устай газар, Номгон бол. Байгаа худаг нь ширгэчихсэн. Тэгээд бог багатай газар, Номгон бол. Нэг зуугаад бог усыг хэдхэн тэмээ уучихна. Дор устай. Тэгээд гар худаг цөөхөн. Байгаа гар худагтай ус нь ширгэчихсэн. Тэр нь энэ Оюутолгойгоос болдог юм уу, ширгэчихсэн. Дээр үед тэмээ эргүүлдэг худаг байсан. Тэр нь хичнээн ч жил болсон юм, доогуураа нураад дарчихсан. Зарим нь түгжээд дарчихсан. Тэгээд Оюутолгойн цооног, мооног ашиглана. Оргидгийг гайгүй ашиглаж байсан бөглөөд хаячихсан. Би энэ талаар 5 жил хүсэлт тавиад одоо болтол шийдэж өгөөгүй л байна. Сумын захиргаанд ч тавьсан, Оюутолгойн захиргаанд ч тавьсан. – Номгон багийн малчин

3.6 Газар эзэмших, ашиглах байдал

3.6.1 Монгол улсын Газрын тухай болон Захиргааны Хуулиуд

Үндсэн хуулиар хөдөөгийн газар нутгийг Монголын нийт ард түмний эзэмшлийн гэж тодорхойлсны дээр Газрын хуулинд орон нутгийн засаг захиргаа нь иргэдийн хурлаар дамжуулан малчдын газар ашиглаж ирсэн ‘уламжлалтай’ уялдуулан үйл ажиллагаагаа явуулна гэж заасан.^{15 16} Малчид өвөлжөөний газар эзэмших эрх, мөн хаваржааны газар эзэмших эрхийг 2002 оны Монгол улсын Газрын тухай хуулиар тогтоож өгсөн¹⁷. Газрын тухай хуулийн 30-р зүйлд газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 15-60 жил хүртэл хугацаатайгаар эзэмшүүлж болно гэж заажээ¹⁸. Ханбогд суманд малчид 60 жилийн хугацаатай эзэмшлийн гэрээ байгуулж болно, харин Манлай суманд 30 жилийн хугацаатай. Ханбогд сумийн өрхийн өвөлжөөний гэрчилгээнд хамрагдах газрын хэмжээ 700 - 1600 м² (өвөлжөөний гэрчилгээнд зааснаар).

3.6.2 Ханбогд суман дахь өвөлжөөний эрх

Газрын тухай хуулинд зун, намар, отрын бэлчээрийг хот айлаар хуваарилж, нийтээр ашиглана; сумын засаг дарга зун, намрын бэлчээрийг хэдий хүртэл ашиглах хугацааг тогтооно (1994, 2002 оны Монгол улсын Газрын тухай хуулийн зүйл 51, 52). Сумын тайлан мэдээнээс үзэхэд өвөлжөө бууц эзэмших гэрээ баг тус бүрт харилцан адилгүй байна.

¹⁵ Монгол улсын Газрын тухай хууль 1994, 2002, Цахим эх үүсвэр, www.legalinfo.mn/law/details/216, 2016 оны 8 сарын 7-нд орж үзэв.

¹⁶ Монгол улсын засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, Түүний удирдлагын тухай 1992, 2006, Цахим эх үүсвэр, <http://legalinfo.mn/law/show/Print/7116>, 2016 оны 8 сарын 7-нд орж үзэв.

¹⁷ Фернандез-Гименез, М, Б. Батбуян. 2004. Хууль тогтоомж ба Эмх журамгүй байдал: Монгол улсын газрын хууль орон нутагт хэрэгжиж буй байдал. *Хөгжил ба Өөрчлөлт* 35, 1, 141-165.

¹⁸ Монгол улсын Газрын тухай хууль 1994, 2002, Цахим эх үүсвэр, www.legalinfo.mn/law/details/216, 2016 оны 8 сарын 7-нд орж үзэв.

Хүснэгт 7: Ханбогд суманд өвөлжөө, хаваржаа эзэмшиж буй байдал, 2015 (сумын тоо баримт)

Баг	НИЙТ	Зөвхөн өвөлжөө		Зөвхөн хаваржаа		Өвөлжөө ба Хаваржаа		Өвөлжөө ч үгүй, хаваржаа ч үгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Номгон	59	18	31%	1	2%	23	39 %	17	29%
Гавилууд	107	77	72%	4	4%	15	14 %	11	10%
Жавхлант	95	39	4%	0		48	51%	8	8%
Баян	88	19	22%	1	1%	49	56%	19	22%
Нийт	349	153	44%	6	2%	135	39%	55	16%

Багийн нэр	ХОЁР-с дээш өвөлжөөтэй өрх	ХОЁР-с дээш хаваржаатай өрх
Номгон	2	1
Гавилууд	5	1
Жавхлант	0	0
Баян	2	0

Өрхүүдийн 16% нь өвөлжөө ч үгүй, хаваржаа ч үгүй байгаа нь улирлын чанартай бэлчээр эзэмших албан ёсны эрхгүй, Ханбогд сумын бэлчээр, уснаас хамааралтай, газар ашиглах уламжлалт эрхэд найдсан өрх нэлээд хэд байгааг харуулна. Энэ байдал нь нөхөн олговрын шалгуурыг хангахгүй. Өвөлжөө эсвэл хаваржаагүй өрхүүдийн ихэнх нь дэд бүтцийн нөлөөлөл багатай Номгон, Баян багуудад байна.

3.6.3 Уламжлалт болон Шинэ Газар Эзэмшил

Уламжлалт ёсоор бол газар эзэмших эрх нь эзэгнэн сүүгаа байдал, хэрэглээнд үндэслэдэг байв. Эдгээр эрх нь нөхцөлт бөгөөд малчид болон тодорхой чухал газарт оршин байдаг газрын эзэнд итгэх итгэлийг оролцуулан дээд тэнгэрийн хоорондын үүргээр тодорхойлогддог.

Өнөөгийн байдлаар Ханбогд суманд нийтийн газарт дураар нүүх бололцоо олгодог малчдын уламжлалт газар эзэмших хэв маяг болон үндэсний засгийн газар (жишээ нь Катарын шувууны хүрээлэн, Төмөр зам, ОТ уурхай), орон нутгийн засаг захиргаанаас (малчдын өвөлжөө, компаниуд) янз бүрийн аж ахуйн нэгжүүдэд онцгой ашиглах эрхтэйгээр газар түрээслүүлж байгаагийн хооронд зөрчил үүсч байна.

Мал аж ахуй эдийн засгийн гол салбар байхад илүү баталгаатай байсан малчдын газар ашиглах эрх засгийн газрын байгууллагуудаас олгосон хувийн эзэмшлийн түрээсээс доогуур тавигдаж байна. Засгийн газар, орон нутгийн захиргаа лиценз олгож байгаа болохоор Газрын тухай хууль, Захиргааны хуулиар хамгаалагдах ёстой уламжлалт газар эзэмших тогтолцоо үр дүнгүй харагдаж байна.

Ханбогд суманд газар эзэмшлийн энэ хоёр тогтолцоо мөргөлдөхөд арай илүү чадал тэнхээтэй өрхүүд суурин сууц барих, нэгээс илүү өвөлжөө, хаваржаатай болох зэргээр бэлчээр ашиглах эрхээ баталгаажуулахыг хичээж байна. Жишээ нь нэг өрх гурван өвөлжөө, хоёр хаваржаатай гэж ярьсан. Тэднийх 991 толгой малтай. Ханбогд сумын малчдын газар эзэмшлийн баталгаагүй байдлыг баримтжуулсан байдаг. ОТ-н Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээнд¹⁹ дурьдсанаар:

“...мөнгөгүй ядуу, уламжлалаа алдсанаас болоод “сэтгэлээр унасан” зэргээс гадна улсын ядмаг бодлогоос болж нийгэм, эдийн засгийн дарамт нь улам нэмэгдсэн тул малчид түн эмзэг байдалтай байна. Уул уурхайн бүтээн байгуулалт урагшгүй бодлогын нөлөөллийг улам гааруулсан. Энгийнээр хэлэхэд эдгээр бодлогууд нь малчдын бэлчээр, ус ашиглах эрхэд сөргөөр нөлөөлжээ (өөрөөр хэлбэл малчдад хамгаалалтгүй уламжлалт эрхээс өөр юу ч байхгүй).”

Өмнийн говь цөлийн угаасаа ядаж буй байгаль орчинд том цар хүрээтэй уул уурхай байгаа нь нөөц ашиглагчийн хувьд баталгаагүй эрхтэй малчдын эрсдлийг хурцатгаж байна. Нүүдэлчин малчид алслагдсан нутагт ажил хөдөлмөр эрхэлдэг нь мэдээлэл авах, шийдвэр гаргах хэлэлцүүлэг, үйл явцад оролцох явдлыг улам бэрхшээлтэй болгодог.

3.7 Засгийн Газрын Чадавх

3.7.1 Үндэсний засгийн газар

Үндэсний засгийн газар орон нутгийн малчид, сумын засаг захиргаанд их нөлөөлдөг. Уул уурхай, бусад бүтээн байгуулалтаас Ханбогдод учирсан сөрөг үр дагавар нь дийлэнхдээ засгийн газрын бодлого, зохицуулалт, хяналт, хэрэгжүүлэлт үр дүнгүй байсны үршиг билээ. Хүчин зүйлсийг нэрлэвэл: уул уурхайн орлогыг орон нутагтай хуваах явдал дутмаг, төмөр зам, Катарын шувууны хүрээлэн гэх мэт дэд бүтэц байршуулсан, орон нутгийн динамикийг үл ойшоодог, хууль тогтоомжийн ялангуяа ОТ болон бусад уул уурхайн ус ашиглалтын талаарх дүрэм журмын хэрэгжилтийг тогтмол хангуулах тал дээр дутагдалтай. Засгийн газар улсын бүтээн байгуулалтын төлөө биднийг золиосолж байгаа; орон нутгийн засаг захиргааны хувьд мэргэжил туршлага хангалтгүй, эрх зүйн орчин байхгүй, хүн хүчгүй, техник хэрэгсэл, программ хангамж үгүй тул мал аж ахуйн асуудлыг шийдвэрлэх эсвэл зач залруулах арга хэмжээ авах чадваргүй гэж малчид үздэг.

3.7.2 Орон нутгийн засаг захиргаа

ОТ-г оролцуулан Ханбогдын хэмжээнд байгаль орчны асуудлыг хянах чадавхи нь хязгаарлагдмал. Малчид үүнийг том асуудал гэж тодорхойлсон. Бидний үнэлгээгээр сум хэдий сайн санаа тавьдаг ч том уурхайн үйл ажиллагаатай холбоотой малчдын асуудлыг шийдвэрлэх чадваргүй гэж тогтоолоо.

¹⁹ Крайг Р. Жэйнс, Мегхан Ваглер 2011 (2-р сар), ОТ-н нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээ.

Эдгээр асуудлуудыг үндэсний засгийн газраас авч үзэж, шийдвэрлэх ёстой. Том уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой малчдын асуудлыг сум шийдвэрлэх ёстой юм бол үүнийг зохих ёсоор хийхийн тулд суманд илүү хөрөнгө хүч шаардлагатай. Хэрэв энэ нь үндэсний хариуцлага юм бол гарч болзошгүй асуудалд мониторинг хийж, үнэлэн, засч залруулахын тулд үндэсний засгийн газрын төлөөлөл Ханбогдод байх хэрэгтэй. Одоогоор тал тус бүрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгож, олон нийтэд мэдээлэх нь хэрэгтэй байна. Байгаль орчны мэргэжилтний хэлснээр засаг захиргаа чанарын хяналт тавих ёстой ч сумын баг үр чадвар, мэдлэг, хүн хүчээр дутмаг байна. “Каримдаа манайхан ОТ-г хянахаасаа илүүтэй тэднээс суралцдаг.”

Сумын түвшний засаглалын асуудлуудыг дурьдвал:

- Төсөв – аймагтай зөрчилддөг
- Өвөлжөө, нүүдлийн зохицуулалт
- Засгийн газрын бүх түвшний мэдээлэл солилцоо
- Худгийн засварын ажил, хүч хөрөнгө дутмаг
- Төлөвлөлт тааруу
- Алслагдсан малчидтай холбогдож харилцах.

3.8 Нийгмийн үйлчилгээ, засгийн газрын нөөц, бүсийн дэд бүтцийн хүртээмж

Малчдын хотноос олон километрийн цаана байгаа аймаг, сумын төв дээр байх нийгмийн үйлчилгээний хүртээмж ерөнхийдөө тааруу гэж малчид үзэж байна. Эрүүл мэндийн гэх мэт үйлчилгээ өртөг өндөртэй, ноцтой асуудал гарвал Ханбогдын эмнэлгийг сонгодоггүй, аймаг эсвэл Улаанбаатар орж эмчлүүлдэг. Ингэж явахаар бэлэн мөнгөний зарлага их, дээр нь хөдөө гэрээсээ хол удаан байна, өвчтэй хүний ажлыг хүн хөлсөлж хийлгэх хэрэгтэй болдог. Ханбогдын эмнэлэг шинэ байшин, тоног төхөөрөмжтэй болсон ч эмнэлгийн ажилтнуудын үр чадвар сайжирч байгаа нь харагдахгүй байна гэж байв.

Сүүлийн 10 жилийн дотор Ханбогд сумын хүн ам ихээхэн өсчээ. Сумын засаг даргын орлогчийн хэлснээр 2016 оны 1 сараас 5 сар хүртэл сумын хүн ам 1000 хүнээр нэмэгдсэн, 2015 онд 5300 хүнтэй байсан байна. Сумын засаг даргын хэлснээр сургууль хүчин чадлаасаа гурав дахин ачаалалтай болох вий гэсэн болгоомжлол байна. Сургууль 400 хүүхдийн орон тоотой ч одоо 900 сурагчидтай. 100 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадаагүй.

ОТ-н БОННУ-ний Аудитын тайланд “Илэрхий ахицыг дурьдвал: тэмээ, ямааны ноос авах, малын халдваргүйжүүлэлт хийх, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэг үйлчилгээ үзүүлэх хоршоод, ботгоны ноос самнах төслүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлж байна”²⁰ гэснийг баталчихаар зүйл малчид хэлээгүй.

²⁰ Байгаль орчин, нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан. Оюу Толгой уурхай, 2015 оны 9 сар, х 10.

Хэдийгээр замууд гэх мэт шинэ дэд бүтцийн үр өгөөжийн талаар малчид юм дурьдаагүй ч малчид шинэ замуудыг ашигладаг, мөн Жавхлант, Гавилууд багт үүрэн утасны болон 3G сүлжээ ихээхэн өгөөжөө өгч байгааг ажиглалаа. Баян, Номгон багуудын ихэнх хэсэгт үүрэн утасны сүлжээ байхгүй.

3.9 Гурван Талт Зөвлөл (ГТЗ)

ГТЗ саяхан байгуулагдсан. Сум даяар хээрийн судалгаа хийж байх явцад ГТЗ-ийн тухай огт мэдэхгүй эсвэл ГТЗ-ийн тухай сонссон ч малчдыг хэрхэн төлөөлдөг, өөрсдийг нь төлөөлж буй хүмүүстэй яаж холбогдох талаар мэдэхгүй нэлээд хэд хэдэн хүнтэй таарсан. Оролцоот ажиглалт, Номгон багийн малчидтай хийсэн ярицлагаас үзэхэд ГТЗ зөвхөн Жавхлант, Гавилууд багийн малчдын асуудалд л анхаараад байх шиг байгаад хүмүүс бухимдаж, шүүмжлэн, уурлаж байна.

ГТЗ нээлттэй, ил тод механизм гэдэгт эргэлздэгээ, энэ нь цөөн бүлэг хүмүүсийн эрх ашигт үйлчилж байна гэж боддогоо олон малчид илэрхийлсэн. Малчдын төлөөлөгчдийг хэрхэн яаж сонгосон, малаа малладаггүй зарим нэг хүмүүс яагаад тэргүүлэх үүрэгтэй байгаа юм гэж тэд асууж байв. ОТ болон орон нутгийн засаг захиргаа ГТЗ-ийн хэдэн хувийг 'өмчилдөг' нь тэдэнд ойлгомжгүй²¹, мөн малчид, тэдний амьжиргааны эрх ашгийг ГТЗ төлөөлж чадна гэдэгт эргэлзэж байна.

3.10 Өрхийн орлого, дэд бүтэц, хөрөнгө

3.10.1 Орлого, зарлага

Ханбогд сумын малчдын орлогын үндсэн эх үүсвэрүүд нь мал болон малын гаралтай бүтээгдэхүүнийг зарж борлуулсны орлого, тэтгэвэр, цалин хөлс, зээл ажээ. Тэдний борлуулдаг малын гаралтай бүтээгдэхүүний хэмжээ нь хүн хүч, малын тооноос шалтгаалаад харилцан адилгүй. Орлогын бусад эх үүсвэрт: цалинтай ажил, бизнес, улирлын ажил, төрөл садны ирүүлдэг мөнгөн шилжүүлэг ордог аж. Судалгаанд хамрагдсан өрхүүд 100% малаасаа орлогынхоо тодорхой хэсгийг оруулдаг гэв. Энэ орлого нь хэрэг дээрээ улирлын шинжтэй, хавар ямааны ноолуур борлуулаад хамгийн их мөнгө олдог, дараа нь тэмээний ноосоо зараад олдог орлого орно.

Өрхийн орлого, зарлагын бүтэц, зардлаа нөхөх байдал өрхийн гишүүдийн нас, сургуульд эсвэл их сургуульд сурч буй хүүхдийн тооноос хамааран өөрчлөгдөнө. Ноолуур, ноос, махны үнийн өсөлт бууралтын давалгаа өрхийг эмзэг болгодог гэж малчид хэлж байв. 1990-ээд оны эхнээс хойш л ингэж ирсэн юм байна. Энэ жил тэмээний ноос, хонины ноос ба махны үнэ өмнөх жилүүдийнхээс доогуур байгаа (хавсралт 2.3-ыг үзнэ үү) аж.

Өрхүүдийн зарлага 'уламжлалт' болон 'шинэ' зардлуудаас бүрдэнэ. Уламжлалт зардалд өвөлжөөний засвар, машин тэрэгний засвар үйлчилгээ, мал эмнэлгийн үйлчилгээ, гэр сэлбэх зүйлс, шинэ зардалд

²¹ Хавсралт 2.5-г үзнэ үү

гар утас, эрүүл мэндийн үйлчилгээ, шатахуун, хоёр дахь гэр, өрх салангид амьдрах зардлууд тус тус ордог.²²

Улирлын чанартай орлого, үнийн савалгаа, зардлын өсөлт зэргээс болоод ихэнх хүмүүст амьдрал нь баталгаагүй юм шиг санагддаг. Тэдний хэлснээр өрхийн жилийн төсөв хүрдэггүй шалтгаанууд гэвэл:

- Ханбогдод үндсэн бүтээгдэхүүний үнэ өссөөр байгаа.
- Арьс шир, махны үнэ дэндүү бага.
- Эмнэлгийн зардал өндөр.
- Сургууль, их дээд сургуулийн зардал өндөр.
- Нүүдлийн зардал.

Хөдөө аж ахуйн салбарт мал, ноолуур, хонины мах зэрэг нь ган, зудын эрсдэл болон дэлхийн түүхий эдийн үнийн уналт гэх мэт гадны цочролд тун эмзэг байдаг.²³ Эдгээр эрсдлүүдээс нүүдэлчин малчдын амьжиргаанд хамгийн их цочрол авчирдаг нь зуд гэж Дэлхийн Банк тодорхойлсон байна. 2003 оны 11 дүгээр сард хийсэн уулзалтаар зудын улмаас өөрөөр хэлбэл аливаа нүүлгэн шилжүүлэлтээс өмнө бий болсон ядуурлын тухайд “сүүлийн 3 жилд зарим нь малынхаа 30 хувийг алдсан бөгөөд нутгийн малчдын дунд газар авч буй ядуурлын асуудлыг шийдвэрлэхэд АММИ туслахыг нутгийн иргэд хүсч байна” гэж малчдын хэлснийг БОНННУ-нд тусгажээ.²⁴ Үүнээс гадна Монгол улсын түүхий эдийн зах зээлээс хамааралтай байдал нь (ж: зэс, нүүрс, ноолуур) жишээ нь сүүлийн хэдэн жил шиг үнэ унахад засгийн газрын орлого багасч, валютын ханшид нөлөөлөн, дотоодын үнэд цохилт өгч, халамжийн хөтөлбөр, нийгмийн үйлчилгээ үзүүлэх засгийн газрын чадварт нөлөөлдөг тул гадны цочролд эмзэг болгож байна.²⁵

3.10.2 Зээл

2003 оноос хойш Монголын нийт малчдын дунд зээл авах явдал ихэд түгээмэл болсон. “Бид зээлээс зээлийн хооронд амьдарч байна” гэж Номгон багийн нэг малчин жилийн төсвөө ярихдаа хэлж байв. Зээлгүй, цалингийн болон тэтгэврийн урьдчилгаа аваагүй, банкнаас малчны зээл аваагүй цөөхөн өрх байна. Малчдын банкны зээл жилийн хугацаатай зээл бөгөөд малчид ноолуур зараад олсон орлогоороо өмнөх зээлээ хаагаад дахиад шинэ зээл авдаг аж.

Малчдын зээл ашиглалт:

- Сургуулийн төлбөр төлөх.

²² Хавсралт 2.4-г үзнэ үү

²³ Дэлхийн Банк (2015 оны 3 сар) Монгол улс: Хөдөө Аж Ахуйн Салбарын Эрсдлийн Үнэлгээ. Бичиг баримтын дугаар 101088.

²⁴ Эко Трэйд ХХК. (2006) БОНННУ, Хэсэг IV, Бүлэг 1, х. 37

²⁵ ОУВС (2012) Монгол улсын инфляцийн динамик: Галзуу хулганыг ойлгох нь.

- Өдөр тумын зарлага.
- Эмчилгээний зардал төлөх.
- Мотоцикл, машин гэх мэт өндөр үнэтэй зүйл авах.
- Гэр авах, эсвэл байшин барих барилгын материал авах.
- Цагаан сар.

Ихэнх банкууд малыг зээлийн баталгаанд авдаг; олон малтай айл ахиухан зээл авч болно. Монгол улсын малчдын өрийн талаар хийсэн судалгаанд банкны зээл авах шалгуур болзол хангахгүй ядуу өрхүүд яаж ийж байгаад арай чадалтай өрхийн нэрээр зээл авдаг болохыг дурьджээ,²⁶ тиймээс малчин өрхүүдийн албан бус зээл Ханбогодод хэдий хэмжээтэй байгааг мэдэхийн аргагүй. Монголч эрдэмтэн Давид Снийтийн хийсэн угсаатны зүйн судалгаагаар жишээ нь Баянхонгор аймгийн Баацагаан суманд “чинээлэг өрхүүдээс бусад бүх айл өрх банкны зээлтэй” байсан байна.²⁷

3.10.3 Хөрөнгө хуримтлал

Сумын өрхүүдийн чадал тэнхээнээс хамаараад хөрөнгийн хуримтлал янз бүр байна. Цөөн хэдэн өрх 1000-с дээш малтай, нэгээс илүү машинтай, жижиг бизнес амжилттай эрхэлдэг, суман дээр эд хөрөнгөтэй, хэд хэдэн өвөлжөө, хаваржаатай байхад зээлээ төлөх гэж ядсан, эрүүл мэндийн ноцтой асуудалтай, ажилгүй хүүхдүүд, ач зээгээ тэжээдэг айл өрх олон байна. Нас өндөр болсон малчид малын ажлыг дийлэх чадалгүй, үе мөч өвдөх зэрэг насны доройтлын асуудалтай байдаг тул илүү эмзэг өртөмтгий. Настай хүмүүс малаа хүүхдүүддээ тараачихдаг тул цөөн малтай гэжээ.

3.10.4 Өрхийн хэрэглээ, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт

Мал аж ахуйн борлуулалт улирлын чанартай бөгөөд тухайн өрхийн хөдөлмөр их орсон бүтээгдэхүүн хийх хүн хүчний бололцооноос хамааралтай. Малчдын хамгийн их орлого олдог бүтээгдэхүүн нь хавар зарж борлуулдаг ноолуур. Малчид мөн тэмээ, хонины ноос зардаг. Хонины ноосны нэг кг-ын үнэ маш бага, дээр нь хонины ноос хяргахад их хөдөлмөр шаарддаг тул тэмээний ноос шиг байнга авдаггүй. Орлогын хоёр дахь ангилал нь цагаан идээ (сүү, айраг, ааруул). Олон айл цагаан идээгээ зарахгүй, өөрсдөө хэрэглэдэг. Илүү хийсэн айлууд ихэвчлэн айраг, ааруул борлуулдаг байна.

Малчдыг хоршоотой наймаа хийхийг урамшуулдаг хэдий ч бидний ярилцсан малчид эсрэг байр суурьтай, энэ бол ашигтай хувилбар гэдэгт итгэдэггүй. Малчдын ярьж байгаагаар хоршоод үнийн татаас өгөх ёстой боловч олон малчин бүтээгдэхүүнээ тэдэнд зараад ямар ч татаас олж аваагүй ажээ. Гүшүүнчлэлийн татвар нь 100,000 төгрөг, гэтэл зөвхөн хэдхэн наймаачны ашгийн ажилладаг гэж

²⁶ Давид Снийт, (2012) ‘Зах зээлийн нас’ ба өрийн дэглэм: Нүүдэлчин Монгол улсын шилжилтэнд зээлийн үүрэг. *Нийгмийн антропологи*. 20 (4): 458-473.

²⁷ Давид Снийт (2012) ‘Зах зээлийн нас’ ба өрийн дэглэм: Нүүдэлчин Монгол улсын шилжилтэнд зээлийн үүрэг. *Нийгмийн антропологи*. 20 (4): 458-473.

малчид үздэг²⁸. Зарим өрхүүд тэмээний ноосоо хоршоонд өгдөг, зарим нь сумын төв дээр байдаг худалдан авагчдад зардаг байна. Жишээ нь сүү зардаг малчин сумын төвийн худалдан авагчтайгаа урьдчилаад тохирдог. Нэг өрх ОТ-д сүү, ааруул нэг жилийн гэрээтэй нийлүүлсэн гэж урамтайхан ярьж байв.²⁹

3.11 Сургуульд суух, Айл өрх салангид амьдрах

Монголын хөдөөгүүр айл өрх салангид амьдрах нь түгээмэл (жишээ нь ээж нь сургуулийн насны хүүхдүүдийн хамт хичээл тартал гэр бүлээсээ тусдаа амьдардаг). Энэ нь өрхийн хүн хүч, зардалд нөлөөлдөг. Өрх салангид амьдрах болсон нь нийгэмд гарч буй өөрчлөлтийн тусгал, мөн яагаад залуу малчин цөөн байгаагийн шалтгаан гэж малчид үзэж байна.³⁰ Жишээ нь нэгэн малчны тайлбарласнаар “Нийгэм өөрчлөгдсөнөөр залуу малчид төрж гарахгүй болсон. Хүүхдүүд цэцэрлэгт бага наснаасаа явж эхэлдэг. Урьд бол бэлтгэл ангид ч суудаггүй, 8 нас хүрч сургуульд ордог байлаа. Одоо 6 настай сургуульд орно, өмнө нь цэцэрлэгт явна. Энэ ч нийгмийн өөрчлөлт юм даа.” Өрх салангид амьдран, эмэгтэйчүүд хүүхдүүд өвлийн саруудад сумын төвд байх болсноор нийгмийн капиталыг сул болгож байна.

3.12 Гэрээт маллагаа, хөлсний малчин, тавиул мал

Ханбогдын малчид Монгол даяар их бага хэмжээгээр явагддаг гэрээт маллагаа³¹ гэх мэт олон хэлбэрээр мал маллах ажиллагааг зохицуулж байна³². Судалгаагаар тогтоосон нь:

- Өөрийнхөө малыг өөрөө малладаг ‘Уламжлалт’ малчид.
- Гэрийнхнийхээ болон найз нөхдийнхөө малыг малладаг малчин өрхүүд.
- Ханбогд сумаас өөр газарт малаа, жишээ нь бог малаа байлгадаг малчид.
- Туслах малчин гэрээгээр ажиллуулдаг малчид. Тэд хөлсний малчинтай хамт малаа малладаг.
- Эчнээ малчид: малтай боловч малчидтай адил жилийн түрш хөдөө амьдардаггүй хүмүүс (Монгол улсын Үндэсний Статистикийн Жилийн Тайланд тодорхойлсноор).

3.13 Малын нөхцөл байдал

3.13.1 Малын Тоо

Ханбогд сумын малын тоо толгой 2003 оноос хойш өсч, 2014 онд хамгийн их мал тоолуулжээ.³³ 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдэд нөхөн олговрын нэг хэлбэр болгон мал өгсөн байна.³⁴ Ханбогдод

²⁸ Хавсралт 2.4-г үзнэ үү.

²⁹ Хавсралт 2.4-г үзнэ үү.

³⁰ Ахерн, А., Д. Бум-Очир (2016). Нүүдэлчин малчид хүүхдээ сургуульд суулгахтай холбоотой зөрчил. *Хүний Байгууллага* 75 (1), х. 87.

³¹ Мөрфи, Д. Ж. 2014. Дүрмийн Экологи: Нутаг дэсгэрийн холбоод ба Монголын хөдөө дэх байгаль орчны засагла. *Антропологийн улирал тутмын хэвлэл* 83, 3, 759-792.

³² Хавсралт 2.3-с тоо баримт харна үү.

малын тоо толгой өндөр байгаа нь ялангуяа нүүдэллэх боломж багатай газарт бэлчээр талхлагдахын шалтгаан мөн. Ханбогд сумын малын тоог судалж үзэхэд сүүлийн таван жилд чинээлэг байдлын ялгаа нэмэгджээ. 2015 онд 800 гаруй малтай айл арван тав, үүнээс нэгнийх нь мал 2000 дөхсөн. 2010 онд зөвхөн 6 айл 800-с дээш тооны малтай байжээ. Түүнчлэн Өмнөговь аймгийн Ханбогд сумын 2013 оны Хүн Ам, Орон сууцны тооллогоор “өнгөрсөн таван жилд Ханбогд сумын малын тоо 10% өссөн ч малчдын тоо 34 хувиар буурсан” гарчээ.³⁵

Сумын тоо баримтаас үзэхүл 2015 онд Гавилууд баг хамгийн их буюу 41,544 толгой мал тоолуулсан (малаа өөрсдөө маллаж байгаа малчдын мал болон сумын төвд амьдардаг эчнээ малчдын нэр дээр бүртгэлтэй малыг оролцуулан). Дараа нь Жавхлант 35,377 толгой, Баян 31,965 толгой, Номгон 24,127 толгой малтай гэж бүртгэгдсэн байна. Сумын мэдээ баримтын дагуу сумын хэмжээгээр өрхийн дундаж эчнээ малчдын тавиул малыг оролцуулаад нэг өрхөд 196 мал ногдож байна. Малаа өөрсдөө маллаж буй малчдын малын тоо дунджаар өрх бүрт 288 толгой байна. Малчид ган, зуд тохиох эсвэл хүн хүчгүй болбол Баян-Овоо, Манлай сум руу эсвэл Дундговь аймаг руу нүүдэг гэж байв. Түүнчлэн Ханбогд сумын бэлчээрийг ашиглахаар өөр сумдаас нүүж ирсэн малчидтай ОТМШБ-ийнхан тааралдан, ярилцлага авсан. Малчид бэлчээр, ус хайн сум дагуу хөндлөн гулд нүүдэг тул тодорхой нэг хугацаанд яг хичнээн тооны мал Ханбогдод байгаа нь мэдэгдэхгүй. Энэ бол нүүдлийн мал аж ахуйн мөн чанар. Гэсэн хэдий ч ОТМШБ-ийн цуглуулсан мэдээнээс харахад Ханбогд сумын нутаг дэвсгэр рүү болон түүнээс гадагш нүүх гол шалтгаан нь ус, бэлчээрийн хүрэлцээ ажээ.

Нийт малын тоо, Үндэсний Статистикийн Газар, Монгол Улс

Он	Монгол улс	Өмнөговь	Ханбогд	Манлай
2000	30,227,500	1,489,611	69,296	76,674
2001	26,075,338	1,209,566	47,768	74,308
2002	23,897,569	909,128	52,760	78,985
2003	25,427,699	907,355	53,375	65,517
2004	28,027,946	1,070,058	62,256	79,063
2005	30,398,830	1,121,524	69,098	83,265
2006	34,802,941	1,155,747	71,285	82,238
2007	40,263,838	1,399,996	86,031	95,629

³³ Жигжсүрэн нар. 2015. Малчдын ажиглалтанд үндэслэн үүр амьсгалын нөлөөллийг үнэлэн, гидро-үүр амьсгалын болон алсын зйан тандалтын мэдээ баримттай харьцуулсан нь. Олон талт судалгааны бага хурлын ажиллагаа: Монголын бэлчээр нутагт даван түүлах чадвар бий болгох, Улаанбаатар.

³⁴ Б. Далайбуян, Б. Намхай (2014) Оюу Толгой ХХК: Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (НШТ), Гүйцэтгэлийн Хөндлөнгийн Аудит.

³⁵ Тогтвортой Хөгжлийн Консалтинг (2013) Өмнөговь аймгийн Ханбогд сумын хүн ам, орон сууцны тооллого. (х.92)

2008	43,288,513	1,684,939	102,456	108,380
2009	44,023,900	1,755,215	116,283	118,859
2010	32,729,528	1,010,327	96,084	72,224
2011	36,335,781	1,223,459	112,143	88,298
2012	40,920,915	1,419,253	123,291	102,618
2013	45,144,324	1,653,264	126,003	117,787
2014	51,982,583	1,849,043	126,467	128,835
2015	55,979,781	2,055,765	133,013	133,820

Малын тооны өөрчлөлтийн хувь, Үндэсний Статистикийн Газар, Монгол Улс

Он	Монгол улс	Өмнөговь	Ханбогд	Манлай
2000-2001	-14%	-19%	-31%	-3%
2001-2002	-8%	-25%	10%	6%
2002-2003	6%	0%	1%	-17%
2003-2004	10%	18%	17%	21%
2004-2005	8%	5%	11%	5%
2005-2006	14%	3%	3%	-1%
2006-2007	16%	21%	21%	16%
2007-2008	8%	20%	19%	13%
2008-2010	2%	4%	13%	10%
2009-2010	-26%	-42%	-17%	-39%
2010-2011	11%	21%	17%	22%
2011-2012	13%	16%	10%	16%
2012-2013	10%	16%	2%	15%
2013-2014	15%	12%	0%	9%
2014-2015	8%	11%	5%	4%

Ханбогд сумын малын бүртгэл, малын төрөл нийт малд эзлэх хувиар, Үндэсний татистикийн Газар, Монгол улс³⁶

Он	Нийт	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ
2000	69,296	6%	2%	39%	33%	19%
2001	47,768	6%	1%	33%	36%	24%

³⁶ Үндэсний Статистикийн Газар, Монгол улс. www.en.nso.mn/index.php

Баримт Хамтран Олж Тогтоох
Малчдын Амьжиргаа, Орон Нутгийн/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с учруулж буй нөлөөлөл
ОТМШБ Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд
2017 оны 1 дугаар сар

2002	52,760	6%	1%	30%	41%	22%
2003	53,375	5%	2%	28%	42%	23%
2004	62,256	5%	2%	27%	46%	21%
2005	69,098	4%	2%	27%	47%	20%
2006	71,285	4%	2%	26%	48%	20%
2007	86,031	4%	2%	26%	51%	17%
2008	102,456	4%	2%	26%	53%	15%
2009	116,283	4%	2%	26%	54%	14%
2010	96,084	5%	2%	27%	48%	18%
2011	112,143	5%	2%	27%	49%	17%
2012	123,291	5%	2%	27%	49%	17%
2013	126,003	5%	3%	27%	48%	17%
2014	126,467	5%	3%	27%	47%	18%
2015	133,013	5%	3%	27%	47%	18%

Улс, аймаг, сумын түвшний мэдээг харьцуулахад 2001-2002, 2009-2010 онуудад болсон хоёр хэцүү зудны улмаас малын тоо ихэд хорогдсон байна. Дээр дурьдсанчлан өнөөгийн байдлаар малчдын амьжиргааны хамгийн том эрсдлүүдийн нэг нь зуд гэж эрдэмтэд, олон улсын байгууллагууд тодорхойлжээ. 2009-2010 оны зуд нийт Өмнөговь аймаг болон хөрш Манлай сумыг бодвол Ханбогдод арай гайгүй туссаныг тоо баримт харуулж байна. 2009-2010 онд Манлай сумын малын тоо 39% сөрөг өөрчлөлттэй байсан бол Ханбогдынх 17 хувийн өөрчлөлттэй байжээ. Зудын дараах жилүүдэд Өмнөговь аймаг, Манлай сумтай харьцуулахад малын тооны өсөлтийн хувь нь аажим байжээ. Эдгээр харьцангуй өөрчлөлтүүдийг зудаас бүс нутагт үзүүлсэн нөлөө болон зудын дараах сэргэлтээр хэсэглэн тайлбарлаж болох юм. Түүнчлэн нийт малд эзлэх ямааны тоо аажмаар өсч, нийт малд эзлэх хонины тоо аажим буурсан нь хүснэгтүүдээс харагдаж байна. Энэ нь 1990-ээд оны эдийн засгийн шилжилтээс хойш улирлын чанартай орлогын голлох эх үүсвэр нь ноолуур болсон Монгол даяарх хандлагыг илэрхийлнэ.

ОТ-н өгсөн нөхөн олговор авсан өрхийн жагсаалтанд 93 өрхийн нэр бий. Сумын тооллогын мэдээгээр 2010 – 2015 онуудад энэ жагсаалтын 51 өрхийн малын тоо нэмэгдсэн байна. Хорин нэгэн өрхийн малын тоо буурсан. Дөрвөн өрх өмнөхтэйгээ бараг адил (+/- 5 толгой мал) тооны малтай. 21 өрхийн тооллогын тоо баримт байхгүй.³⁷ 2015 онд эдгээр өрхүүдээс 45 нь 250-с цөөн толгой малтай байв. 250-с цөөн толгой малтай өрхүүдийн хэд нь одоо өөрсдөө малаа маллаж байгаа хэд нь хүнээр маллуулж буй эчнээ малчид болох нь тодорхойгүй. 2015 оны мал тооллогын мэдээнд байгаа 76

³⁷ Хавсралтанд буй малын тооны хүснэгтээс тоо баримт нь байхгүй өрхийн нэрсийг үзнэ үү. Байхгүй 29 бүртгэлийн нэрсийг тодруулах, нэмэлт мэдээлэл авах хүсэлт тавьсан хэдий ч мэдээлэл дутуу хэвээр байна.

өрхийн хувьд нэг өрхөд дунджаар 308 толгой мал ногдож байгаа нь сумын дунджаас өндөр байна.³⁸ Бүртгэл нь байхгүй өрхүүдийн тухайд хэд хэдэн тохиолдолд тэдгээр айлууд 2011 оны нөхөн олговрын үеэр малтай байсан эсэх нь тодорхойгүй, заримынх нь нэрс 2010 оны сумын мал тооллогонд харагдахгүй байна. Түүнчлэн 2015 оны сумын малын мэдээнд ороогүй өрхүүд мал маллаж амьжиргаагаа залгуулахаа бүрмөсөн больсон эсэх нь мөн тодорхой бус.

Номгон багийн нэг малчин хэлэхдээ малаа өсгөн, 1000 давуулсан малчныг шагнаж урамшуулдаг засгийн бодлого нь бэлчээрийн ачааллыг багасгахын тулд мал сүргийн чанарыг сайжруулан, тоо толгойг цөөрүүлэхэд чиглэсэн нөгөө нэг бодлоготойгоо зөрчилдөж байна гэв:

“Бэлчээрийн даац гээд асуудал бий л дээ. Төрийн бодлого нь өөрчлөгдөөд байна ш дээ одоо. Нэг болохоор 1000-т малчин гээд дээрээсээ шагнаад л урамшуулаад байна, тэгээд нөгөө болохоор бэлчээрийн даац хэтэрчихсэн чанартай цөөхөн малтай бол гээд байдаг. Тэгээд ингээд хоёр бодлого чинь хоёулаа эсрэг юм болчихоод байгаа биз? Нэг талаараа өсгө, чи сайн мянгат малчин, бид нар шиг 500 - 600 малтай бол малчин биш, хүн амьтан ирэхгүй, байхгүй. Хоёр мянгат, гурван мянгат малчин гээд хошуураад байна. Манай энд бол бас ч гайгүй. Ер нь тийм болчихож дээ. Манай энд 1000 мал өсгөнө гэвэл зовж байж л өсгөнө. Хангайд бол яахав дээ, голын хөвөөн дээр хэвтэж байгаа юм чинь хэдийг л бол хэдийг өсгөнө ш дээ. Ус байвал хэдэн мянга ч байсан яахав дээ.”- Номгон багийн малчин.

3.13.2 Малын эрүүл мэнд

Өрхүүдийн ерэн найман хувь нь малын элэг, уушиг гэх мэт дотор эрхтэнд тоос нөлөөлж байгаа гэж байв. Уушиг цэртэй, өнгө нь өөрчлөгдсөн байдаг тул зарим малчид гэдэс дотор идэхээ больсон. Малын эрүүл мэндтэй холбоотой өөр асуудал гэвэл ямааны нуруу, шийрний ус зулгарч, гэдэс нь айхтар дүүрдэг гэж хэлж байв. Түүнчлэн Оюу Толгой Цагаан Хад хоорондын эрчим хүчний шугамыг барих үеэр ухсан гүнзгий нүхэнд мал унах гэх мэт аюулгүй байдлын асуудлыг тавьж байлаа. Мал үс хайж яваад нүхэнд унаад гарч чаддаггүй гэж малчид хэлэв.

Малын тарга хүч бэлчээр, усны боломж, өвлийн тэжээлээс шалтгаалдаг гэж малчид ярьж байна. Ган, зудтай үед тарга авна гэдэг бэрх, малчид бэлчээрт хүрэхийн тулд өөр сум руу нүүхэд хүрдэг гэв. 2014 онд хийсэн малын эрүүл мэндийн судалгаагаар замд ойрхон байгаа малын уушигт тоосноос шалтгаалсан өөрчлөлт илэрчээ.³⁹

³⁸ Хавсралтаас бүртгэлийн хүснэгтийг үзнэ үү.

³⁹ Бизнесийн амжилтын гол түлхүүр ТББ. 2015. Ханбогд, Манлай, Баян-Овоо суманд хийсэн малын эрүүл мэндийн судалгааны тайлан.

3.13.3 Малын хашаа хороо

Малын хашааг (хашаа, өвөлжөөний хороо) янз бүрийн материалаар барьдаг: цементэн блок, аргал, модны мөчир, шургааг, барилгын банз, чулуунаас гадна модон ба төмөр хашаа, тавиур гэх мэтийг дахин ашигладаг. Олон малчдын хашаа хороо сайн баригдсан, арчилгаа сайтай байдаг. Судалгаанд хамрагдсан дийлэнх малчид гаднаа дориун барьсан бие засах газартай. Говийн бусад газар жишээ нь Баянхонгорт модон байгууламж үзэгдэх нь ховор, ихэнх хашаа хороог аргал, нутгийн чулуугаар барьсан байдаг ба гаднаа бие засах газаргүй.

3.14 Ирээдүйн талаарх төсөөлөл

Малчдын дийлэнх нь уур амьсгал, ирээдүйд бий болох дэд бүтэц, эдийн засгийн өсөлт уналт тодорхойгүй гэж боддог. “Цаашид юу болох тухайд бидэнд мэдэх юм алга.” Хэдийгээр шинэ зүйлс нэвтэрсэн ч баталгаагүй байдал малчдын амьжиргааны нэг хэсэг болжээ. Нөхөн олговор авсан, аваагүй өрхүүдийн аль аль нь ирээдүйн баталгаа үс, бэлчээртэй байх эсэх, мал аж ахуйн бүтээгдэхүүнээс орлого олж чадах эсэхээс шалтгаална гэж үздэг. 2011 онд нөхөн олговор авч, 5 жилийн ажлын гэрээ байгуулсан малчид одоо авч байгаа цалин нь байхгүй болж, орлого нь гэнэт доошлоход яах билээ гэж санаа зовж байгаагаа илэрхийлж байлаа.⁴⁰

Ирээдүй баталгаагүй гэсэн бодол төрүүлж буй бусад хүчин зүйлсийг дурьдвал:

- Зуд, ган тохиолдох.
- Зэрлэг нохой, чонын дайралт.
- Мал дээр гарах залуус ховордсон.
- Мал маллагааны ажлыг нугалах хүн хүч хөдөөд хангалтгүй.
- Малчид бие биенээ ойлгон, хоршиход садаа болдог нийгмийн зөрчлүүд.
- Үе мөч өвдөх гэх мэт эрүүл мэндийн асуудлаас болж хөдөө амьдрахад бэрхшээлтэй болж байгаа.
- Мал маллаад ашиг орлого олох хүндрэлтэй.
- Газрын эрх баталгаагүй.
- Уур амьсгалын өөрчлөлт.
- Чөлөөтэй дураараа нүүх боломж огт байхгүй болсон.

Зарим малчид малын бүтээгдэхүүнээс ашиг олж байгаа цагт өөрсдийгөө аваад явчихаж чадна хэмээн мал маллан, амьжиргаагаа залгуулахдаа итгэл төгс байна. 5, 7 саруудын хур борооны дараа олон малчин сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж байв.

Хүүхдүүдийн ажил мэргэжлийн сонголтын тухайд олонх малчин хүүхдүүдээ цаашдаа их сургуульд орж суралцан мал аж ахуйн бус мэргэжил эзэмшсэн нь дээр гэж боддог. Тэтгэвэртээ гарч, сумын төвд амьдарч буй настай малчид ОТ-г хүүхдүүдийнх нь амьжиргааг сайжруулах арга хэрэгсэл гэж үзэж байна. Ерөнхийдөө орон нутгийн иргэд ОТ мал маллах орчныг эвдэн сүйтгэж байгаа хэдий ч ажил

⁴⁰ Хавсралтыг үзнэ үү

олж, амьжиргаагаа сайжруулах эх үүсвэр хэмээн нааштай хардаг. Ханбогдын бүртгэлтэй иргэд ажил, ажил мэргэжлийн сургалтанд эн тэргүүнд хамрагдах ёстой гэж малчид үзэж байна.

3.15 Соёлын капитал

3.15.1 Ариун дагшин газрууд

2016 оны 5 сард Ханбогд сумын иргэд, малчид шүтдэг Ханбогд Хайрханаа тахихаар цугларцгаав. Энэ нь олон хүн сайн оролцсон, морины уралдаан, бөхийн барилдаан, шагайн тоглоомтой арга хэмжээ боллоо. Дэмчигийн хийд, энергийн төв, ширээ хад гэх мэт сум даяарх бусад соёлын дурсгалт газруудыг үнэлж шүтсэн хэвээр, хүрэх боломжтой байна.

Сумын хэмжээнд ярилцлага өгсөн малчид уул хайрханаа уламжлал ёсоор тахихын ач тусад итгэдэг, хайрханаа тахиснаар тэр өдөртөө бороо орлоо гэж байлаа. Монгол даяар уламжлагдан ирсэний дагуу сүрэг дотроосоо хонь, морь онголдог хэвээрээ гэж малчид хэлж байв.

3.15.2 Уламжлалаа хадгалах

Малчдын гэрээр зочлоход нэлээд хэдэн айл цагаан идээгээр дайлж байлаа. Мөн чихэр, талх, боов боорцог ч тавьсан. Таван сард ихэнх айлууд хуурай сүүгээр цайгаа сүлж байсан бөгөөд малаа саах болоогүй гэж тайлбарлаж байв. Энэ харин сонин байлаа, учир нь ямаа хавар эрт төллөж, 3 сараас сааж эхэлдэг. Энэ нь цагаан идээ хийж, бэлэг барин, зочлох уламжлалт ёсонд нэг их анхаарахаа байсныг харуулж байна. Сүдлаач хөдөөгийн малчидтай 12 жил ажиллах хугацаандаа анх удаа малчны гэрт цай амсаагүй тохиолдол энэ боллоо. Ачилганы мал сургах, төрөл бүрийн цагаан идээ хийх уламжлалт мэдлэг туршлагыг хадгалах, гэрийн дотор уламжлалт хэм хэмжээг баримтлах явдал багассан тухай сонсож, ажиглалаа.

3.16 Багуудын хоорондын ялгаа

Багуудын гол ялгаа нь хүн амын нягтшил, бэлчээрийн боломж, дэд бүтцэндээ байна. Номгон, Баян багуудад бэлчээр хамгийн элбэг, чанар нь ч сайн, харин үс тун хомс гэж малчид ярьж байна.

3.17 Нийгмийн зөрчил

Бэлчээр, үс, нөөцийн хүртээмжтэй холбоотой нийгмийн зөрчлүүд нь ихэвчлэн ОТ нөхөн олговрыг шударгаар олгоогүй гэж боддогоос үүдэлтэй. Бидэнтэй ярилцсан малчид өөрсдийн байр сууриа илэрхийлэх, нөөц хүртэх эрхээ орон нутгийн захиргаа, уурхай аль алинаар нь баталгаажуулах үр дүнтэй арга хэрэгсэл байхгүйд ихээхэн бухимдаж, ундууцаж байгаагаа илэрхийлж байв. Тэдний хэлснээр дараах нийгмийн зөрчлүүд гарч байна. Үүнд:

- Нэг гэр бүлийн гишүүд боловч нэгд нь нөхөн олговор өгсөн, бусад нь аваагүйгээс болж тусдаа өрхүүд хоорондоо зөрчилдөх болсон.

- Жавхлантаг багийн малчид бусад сум, баг руу нүүж очих гэхээр тэднийг “нутаг орноо худалдагсад” гэж буруутган хөөдөг.
- Өвөлжөөний бэлчээрийн төлөө өрхүүд маргалдах болсон.
- Өөр өөр айлүүд мал бэлчээрт нийлснээс болж зөрчил үүсдэг.
- Өрхүүд, нийгмийн капиталын эх үүсвэрүүд хоорондоо хамтрах нь цөөрсөн.

ОТ-н болон ОТ-н бус дэд бүтэц малчин өрхүүдийн хоорондын зөрчил, нүүдлийн хэв маяг, газар эзэмшилд гарсан өөрчлөлтөд хүч нэмж байна.

4 Өнөөгийн малчид уламжлалт амьжиргаагаа дараагийн үедээ хадгалан өвлүүлэх чадвартай юу?

2008 онд хийгдсэн ‘Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаагаар’⁴¹ “Хүмүүсийн 1.8 хувь нь л уламжлалт ёс заншил сайн хадгалагдсан гэж үзэж (х. 7)” байгааг тогтоожээ. Ярилцлага өгсөн малчид тэдний уламжлалт амьжиргаагаа өвлүүлэх чадвар нь нүүдэл хийх, уламжлалт цагаан идээ боловсруулах, амьжиргаагаа тогтвортой залгуулахын тулд тэдгээрийг борлуулах зах зээл олох, дараагийн үедээ энэхүү мэдлэг, туршлагаа зааж сургах боломж олгох бэлчээр, усны хүртээмжээс шалтгаална гэж үзэж байна. Тиймээс малчдыг дараагийн үедээ уламжлалаа өвлүүлэх чадвартай байлгахын тулд тэдний нүүдэл хийх, ус, бэлчээр зэрэг нийтийн нөөцийг эзэмших эрхийг нүүдэл хөдөлгөөнд саад болохгүй тус болох тогтолцооны хүрээнд баталгаажуулж, малчдын амьжиргаанд таатай засгийн бодлого явуулах шаардлагатай. Засгийн газар энэн дээр алдвал уламжлалт мал аж ахуйд саад учирна.

Нэмээд хэлэхэд, малчдыг уламжлалт амьжиргаагаа дараагийн үедээ хадгалж өвлүүлэх чадвартай байлгахын тулд мал аж ахуй эрхлэхэд зориулан илүү нөөц гарган өгч, сайн сургууль, эмнэлгийн үйлчилгээ авах гэх мэтээр суурин байдалд шилжихэд хүргэж буй дарамтуудыг арилгах хэрэгтэй. Малчид орон нутагтаа газар эзэмших баталгаатай эрхийг засгийн газрын бодлогоор хамгаалаад өгвөл тэд орон нутгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулах чадалтай билээ. Түүнчлэн, өрхийн гишүүд саланги амьдрах болсон нь тэдний хүүхдүүд мал маллагааны арга ажиллагаа, уламжлалт зан заншилд суралцах явдалд нөлөөлж байгааг малчид бодолцох ёстой. Уламжлалт амьжиргаа, түүнтэй холбоотой нийгмийн үнэт зүйлс, ёс заншлыг хадгалан, дараагийн үедээ өвлүүлэхэд гэрийн орчинд сургах явдал чухал ач холбогдолтой.

5 ОТ-с шалтгаалж байгаа нь юу вэ?

5.1 Ерөнхий тойм

ОТ-н гол, шууд нөлөөллүүдэд: нөхөн олговор өгсөн болон ажлын байр гаргасан, малчдыг нүүлгэн шилжүүлсэн, усны хомсдолд оруулсан байж болзошгүй хувь нэмэр, жиш. Баян баг дахь гоожиж буй

⁴¹ Бодлого Судлалын Төв. 2008. “Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа.”

цооногууд, ХХБ-ийн шүүрлийн эрсдэл⁴² болон бэлчээр хуваасан зэрэг орно. Шууд бус нөлөөллүүдэд: малчдын хоорондын нийгмийн зөрчил; сумын засаг захиргааны нөөц бололцоонд учирч буй дарамт; сумын хүн ам өсөхөд хүргэсэн; ажилтай болсноор зарим малчид уламжлалт мал маллагаанаас холдсон, ОТ-н гэрээт компаниуд байгаль орчинд нөлөөлсөн зэрэг орно.

2003 онд Оюу Толгой малчдыг нүүлгэн шилжүүлэх анхны хөтөлбөрөө эхлүүлж, уурхайн лицензит талбайн дотор болон ойролцоо байсан 10 өрхөд нөхөн олговор олгожээ. Тэдгээр өрхүүд сум дотроо өөр газар руу, зарим нь Жавхлант багаас гарч нүүсэн. Гавилууд багийн малчид хэлэхдээ нүүлгэн шилжүүлэх ажиллагааны үеэр тэдэнтэй зөвлөлдөөгүй, нүүлгэсэн айлууд нь тэнд байсан айлуудтай ойрхон бүүж, бэлчээрт ачаалал үүсгэсэн гэж байв. Нүүж ирсэн айлууд, мөн шинэ дэд бүтцийн барилгын ажил зэргээс тэд нүүдэл хийж чадахаа болж, бэлчээр ашиглах эрх нь баталгаагүй санагдах болсон гэж Гавилуудын малчид хэлж байлаа. Малчид энэ бүст өөрийн бэлчээр эзэмших эрхээ баталгаажуулахыг хичээх болсноор Гавилуудад сумын бусад багаас илүү олон өвөлжөөний гэрчилгээ олгогджээ.

Бидний үзэж байгаагаар, ОТ малчидтай илүү үр дүнтэй харилцан, 2004, 2011 онд орхигдсон өрхүүдэд нөхөн олговор олгож, малчдыг тогтвортой амьжиргаанд шилжүүлэхэд үндэсний болон орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах, сүмтэй мэдээллээ байнга солилцон, сумын чадавхийг бэхжүүлэхэд туслалцаа үзүүлэх хэрэгтэй байна. Жишээ нь мониторингийн мэдээллийн талаар хоёр тал харилцан ойлголцож, үр дүнд нь цугтаа үнэлгээ хийж, хамтарсан мониторинг хэрэгжүүлэхийн тулд ОТ, сумын захиргаа уулзалт зохион байгуулах гэх мэтчилэн мэдээллээ арай илүү үр дүнтэй солилцож байх шаардлагатай. Ингэснээр сумын эрх бүхий байгууллагууд олон нийтийг хэлэлцүүлэгт сайн хамруулах боломжтой болно. Тодорхой зөвлөмжүүдийг дүгнэлтээс үзнэ үү. Энэ судалгааны даалгаварт заагаагүй хэдий ч орон нутгийн байгаль орчны мэргэжилтнүүд байгаль орчны өргөн хүрээтэй асуудал хариуцаж ажиллахыг хичээдэг боловч шаардлагатай хөрөнгө хүчээр хангагдаагүй байгааг тогтоолоо. Үүнийг Хамтын ажиллагааны гэрээгээр зохицуулан шийдвэрлэх боломжтой юу? Үндэсний засгийн газар, холбогдох яамд суманд учирсан байгаль орчны асуудлуудад мониторинг хийж, хянах ажиллагаанд оролцох ёстой.

5.2 Малчдын уламжлалт амьжиргаанд учирсан нөлөөллүүд

Доорх хүснэгтэд 2003 оноос хойш ОТ-с шалтгаалан, мөн бусад хүчин зүйлсээс шалтгаалан малчдын уламжлалт амьжиргаанд ямар өөрчлөлтүүд гарсныг гол гол үзүүлэлтээр харууллаа.

Уламжлалт амьжиргааны шинж чанар	ОТ-н нөлөөллүүд	ОТ-д хамааралгүй өөрчлөлтүүд
----------------------------------	-----------------	------------------------------

⁴² 2016 оны 1 сарын 15. Оюу Толгой, ХХБ-ын шүүрлийн мониторингийн тайлан. Усны баг, Байгаль орчны хэлтсийн мониторингийн улирлын тайлан.

Нүүдэл	<ul style="list-style-type: none"> - бэлчээрийн газрыг таслан хуваахад хувь нэмрээ оруулдаг - 2004 оны нүүлгэн шилжүүлэлтээр бэлчээрийн газар шахагдсан - өрхүүд дотроо болон хоорондоо зөрчилдөх болсон, итгэл бага - нүүлгэн шилжүүлснээр бэлчээрт олон мал бөөгнөрч, зөрчилд хүргэх болсон 	<ul style="list-style-type: none"> - төмөр зам, карьерууд, нүүрсний зам, шувууны хүрээлэн гэх мэт ОТ-н бус дэд бүтэц. - орон нутгийн захиргаанд худаг засварлах, арчлах хөрөнгө хүч дутмаг. - бод малын тоо толгой
Ачилга уналгын мал сургах мэдлэг, чадвар (морь, тэмээ)	- байхгүй	<ul style="list-style-type: none"> - моторт унаагаар малаа хариулдаг (ачилга уналгын мал сургах, өдөр тутам хэрэглэх шаардлага бага болсон) - хүүхдүүд сургуульд эрт орж байгаа, өрхийн гишүүд салангид амьдрах болсон
Малын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх мэдлэг, чадвар	<ul style="list-style-type: none"> - ОТ гадны хөтөлбөр, гэрээт ажлууд гэх мэтээр бэлчээрийн менежментийн бодлогод нөлөөлсөн. Энэ нь малаас гарах бүтээгдэхүүнийг сайжруулах зорилготой Мал Аж Ахуйн Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилт гэх мэт эерэг үр дүнд хүргэсэн 	<ul style="list-style-type: none"> - хүүхдийнхээ сургуульд ойрхон байхын тулд гэр бүлийн гишүүд салангид байх болж, эмэгтэйчүүд сааль сүүгээ авч, цагаан идээ боловсруулах цаг багассан
Зочлох, хүндлэх нийгмийн зан заншил	<ul style="list-style-type: none"> - гадныханд итгэхгүйгээс нийгмийн зочломтгой зан заншил зэвэрч байна - богино хугацаанд гаднаас олон хүн ирсэн 	<ul style="list-style-type: none"> - өрхийн амьдралын хэв маяг, үнэт зүйлд гарч буй нийгмийн шинжтэй ерөнхий өөрчлөлтүүд, мөн нийгмийн тогтолцооны өөрчлөлт
Газар ашиглах уламжлалт арга барил	<ul style="list-style-type: none"> - нүүлгэн шилжүүлэлт, өвөлжөөгөө эзэмших сэтгэлгээ газар ашиглах уламжлалт тогтолцоонд нөлөөлж байна - дэд бүтцийн томхон бүтээн байгуулалтуудын улмаас газар ашиглах уламжлал зөрчигдсэн - Баян багийн хувьд гоожиж байгаа цооногууд гол асуудал 	<ul style="list-style-type: none"> - өвөлжөөний талаарх засгийн газрын бодлого - газар, мал аж ахуйтай холбоотой засгийн бусад бодлогууд?

	- малчдыг нүүлгэн шилжүүлснээр бэлчээрийн ачаалал, зөрчил ихэссэн	
Нүүдэл, бэлчээрийн хүртээмжийг зохицуулах тогтолцоо	-Нутаг Түншлэлийн оролцоотойгоор бэлчээрийн менежментийн бүлгүүд байгуулахыг оролдсон; ОТМШБ-ийн судалгаагаар батлах зүйл олдоогүй тул үр дүн нь тодорхойгүй	- төвөгтэй нөхцөл байдалд ажиллаж буй орон нутгийн засаг захиргаа хөрөнгө хүчээр дутмаг

5.3 Цалинтай хөдөлмөрөөс хараат байх

ОТ-гоос малчдын амьжиргаанд учруулсан шууд нөлөөлөл нь малчдыг зам арчилгааны ажилд авч, 2011 онд нөхөн олговор авсан Ханбогдын өрхүүд сард 800,000 орчим төгрөг авах бололцоо олгосон явдал юм. Долоо хоногт 2 өдөр ажиллах хуваарь нь малчид цалин авангаа хөдөө малаа маллахад тохиромжтой байдаг. Их дээд сургуулийн өндөр төлбөрийг төлөх гэх мэтчилэн зардлаа хаахад орлогын энэ эх үүсвэр маш чухал ач холбогдолтой. Цалинтай хөдөлмөрөөс хараат болсон нь уламжлалт амьжиргаанаас анхаарлыг нь хөндийрүүлэх болжээ. Шилжилтийг амжилттай хэрэгжүүлэх системийг хараахан боловсруулаагүй. Жишээ нь зам арчилгааны ажилчид 5 жилийн гэрээ нь дуусч байгаа, мал маллагаанд зуун хувь найдах боломжгүйд санаа нь ихэд зовж байна.

5.4 Малчид ба Оюу Толгойн Нийгмийн Оролцооны Багийн харилцаа

Жавхлантад нэг өрх ОТ-н нийгмийн оролцооны багийн гишүүдтэй тогтмол, идэвхтэй харилцаж, өөрийн бизнесээ хөгжүүлэхдээ тэдэнтэй хамтран ажилласан хэмээн эерэг сэтгэгдэлтэй байв. Нөхөн олговор авсан өрхүүд баярын үеэр ОТ-н төлөөлөгчид утсаар ярьдаг, бусад цагт сонин сэтгүүл, зурагт радио, эсвэл уулзалтанд оролцохдоо ОТ-н тухай мэдээлэл авдаг гэв. Айл өрхүүд өөрсдийнх нь амьдрал ахуй, ашиг сонирхлыг ОТ-д төлөөлөх явдал дутмаг байгаад санаа зовдог. Жишээ нь нисэх буудлаас 15 км-т нутагладаг, малаа энэ бүст хариулдаг нэг айл ямар ч суурь судалгаанд хамрагдаж байгаагүй ажээ.

Хамтын оролцоот мониторингийн хөтөлбөрөөр худгийн усны ундаргыг хэмжиж, малчид усны хэрэглээгээ хянах боломж олгосон нь ОТ-н нийгмийн оролцооны багтай харилцсан нааштай жишээ юм.

5.5 2011 оны Нөхөн олговрын асуудлууд: Нөхөн олговор аваагүй өрхүүд

- Хил заагийг таамгаар авсан, бэлчээрийн уламжлалт хэв маягийг үл хайхарсан.
- Өрхүүд тэр дороо гарын үсэг зураагүй тул зөвхөн хэсэгчилсэн нөхөн олговор авсан.
- Гэрээ шударга бус гэж айл өрхүүд үздэг.

- Нөлөөлөлд өртсөн гэж тодорхойлогдсон нутагт бүртгэл бүхий хаваржаатай өрхүүд бууц эзэмших гэрээтэй хэдий ч тэдэнд нөхөн олговор өгөөгүй. Ямар ч байсан хоёр айлд хаваржаагаа алдсаны нөхөн төлбөр олгоно гэж хэлсэн гэнэ.
- 2003 оны үед бүртгүүлээд гэрчилгээгээ авсан байсан өрхүүдийг л оруулсан гэж зарим малчид тайлбарлав. 2003 оны үед өрхүүд өвөлжөөгөө бүртгүүлэх боломж байгаагүй, мөн 2003 оноос хойш айл гэр болсон өрхүүдийн хувьд тэр цагт бүртгэлтэй өвөлжөөтэй байгаагүй. Нэмж хэлэхэд 2003 оноос өмнө айл өрхүүд өвөлжөөгөө газар эзэмших уламжлалт аргаар ашиглаж байсан бөгөөд өвөлжөө эзэмших гэрээ байгаагүй (АММИ-ийн 2004 оны тайланд “газрын лиценз⁴³” гэгдсэн).
- Айл өрхүүд нөхөн олговор өгөх үед бууцан дээрээ байгаагүй эсвэл гэрээнд нэн даруй гарын үсэг зураагүй тул нөхөн олговрын зарим хэсгийг л авсан гэж үздэг (өөрөөр хэлбэл ажлын байр олгосон, харин бэлэн мөнгө өгөөгүй).
- Нөлөөлөлд өртсөн бүсийн дотор нутагладаг боловч нөхөн олговор олгоогүй хэд хэдэн өрх айл байна.
- ОТМШБ хээрийн судалгаагаар дээр дурьдсан шалтгааны улмаас судлан үзэх хэрэгтэй тохиолдлуудыг нягтлан үзээд ойролцоогоор 15 хүнийг тогтоолоо.

5.6 Ёс заншил, нийгмийн харилцаа

Ханбогдын уламжлалт амьжиргаанд ажиглагдсан нэгэн мэдэгдэхүйц өөрчлөлт бол нийгмийн харилцаа, соёл заншил хувирч байгаа явдал. ОТ байгаатай холбоотой сэтгэл зүйн үр дагавар, дээр нь зарим өрхүүд хожиж, зарим нь юу ч үгүй хоцорсон гэсэн бодол шударга бус гэсэн мэдрэмж, уур бухимдал төрүүлж, малчдын хооронд зөрчилдөөн үүсгэсэн ба энэ байдал бидний ажигласантай буюу эсвэл Монгол улсын бусад бүс нутгуудтай харьцуулахад ихээхэн цар хүрээтэй байна. Түүнчлэн нэг нутаг нуга, бие биенээ гэх сэтгэл тодорхой хэмжээгээр эмтэрчээ. Малчдын итгэл суларсан, уламжлалт ёс заншлын дагуу зочломтгой байхаа больсон зэрэг нь үүнийг нотолж байна.

6 Дүгнэлт

Ханбогдын уламжлалт мал аж ахуйн амьжиргаа бүс нутагт байгаа уул уурхай болон төрж өссөн газар нутгийнх нь төрх байдал өөрчлөгдөж байгаатай дасан зохицжээ. Ийнхүү зохицсон нь малчид болон нүүдлийн мал аж ахуйн амьжиргаа өөрчлөгдсөн нөхцөл байдлыг даван туулах чадвартайг харуулж байна. Малчдын гол үр чадварын нэг нь байгаль орчны хувьсал, Говь цөлийн эрс тэс нөхцөлд уян хатан байх явдал билээ. 2003 оноос хойш нүүдлийн арга барил, өрхийн бүтэц, хөдөлмөр зохион

⁴³ Өвөлжөөний газрыг хууль ёсоор гэрээлэх журамд 2002 оны Газрын тухай хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан. Уламжлалт газар эзэмшлийг 1994 ба 2002 оны Газрын Хууль, 1992 ба 2006 оны Орон Нутгийн Засаг Захиргааны Нэгжийн Хууль аль алианаар нь хамгаалсан байдаг. Тиймээс олон малчин газар эзэмших албан ёсны гэрээ байгуулахгүй, уламжлалт байдлаар амьжиргаагаа залгуулсаар байна.

байгуулалт, санхүү, төсвийн хэлбэр, технологи, нийгмийн үйлчилгээ, газар ашиглах хэв маяг, улс төрийн үйл явц зэрэгт байнгын өөрчлөлт гарсаар ирснийг бид мэднэ.

Ийм өөрчлөлтүүд гарч байгаа ч гэсэн **зөв нөхцөлийг нь бүрдүүлэх** юм бол малчид уламжлалт амьжиргаагаа хадгалан, дараагийн үедээ өвлүүлэх чадвартай. Ийм нөхцөлийг бүрдүүлэхийн тулд сумд тогтвортой тооны малд шаардлагатай бэлчээр, ус шаардлагатай бөгөөд газар эзэмших эрх, нүүх эрхийг баталгаажуулж, мал аж ахуйг амьжиргааны нэг хэлбэр хэмээн үнэлж, дэмждэг нийгмийн тогтолцоо, нүүдэлчин амьдралын хэв маягт тохирсон нийгмийн үйлчилгээ зэргээр хангах хэрэгтэй. Өнөөгийн байдлаар Ханбогд суманд эдгээр нөхцөл бүрдээгүй байна. Орон нутгийн засаг захиргааны хувьд шаардлагатай түвшний менежмент явуулж, зохион байгуулах хүчин чадал, боловсон хүчин дутмаг. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг (цагаан идээ, тэмээний ноос, ноолуур, сүү, бяслаг гм) боловсруулах үйлдвэрүүдийг орон нутагт хөгжүүлэхэд чиглэсэн тогтвортой амьжиргааны хөтөлбөр боловсруулах тухайд хүчин чармайлт бага тавьж байна. ОТ, Таван Толгой, төмөр зам зэргийн нийт цар хүрээ сумын засаг захиргаа үүрэгт ажлаа гүйцэтгэн, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах хүчин чадлаас нь хэтрээд байна.

Ханбогдод олон тооны мал байгаа нь ялангуяа дэд бүтцийн бүтээн байгуулалтын умаас бэлчээр таслагдсан нөхцөлд байгалийн нөөцөд дарамт учруулж байна. Үүнтэй холбогдуулан хэлэхэд малын тоо толгойг олшруулахыг засгийн газраас хөхүүлэн урамшуулдаг ба амьдралын баталгаатай болж, байгаль орчин, эдийн засгийн эрсдлийг бууруулахын тулд малчид ч бас малаа өсгөх сонирхолтой байдаг. Тэгэхээр үр дүнтэй хөтөлбөрүүд, мал аж ахуйд үндэслэсэн орон нутгийн үйлдвэрлэл бий болгох, тэдгээрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд өөрсдөө малаа маллаж буй малчдыг идэвхтэй оролцуулахад асуудлын гол оршиж байна.

Малчдыг дасан зохицоход хүргэж, дарамт бий болгосны цорын ганц шалтгаан биш хэдий ч ОТ-н оролцоо ихээхэн үүрэгтэй. Дээр хэлсэнчлэн тэдний оролцоотой бий болсон ачаалал дарамтыг малчид, сумын засаг захиргаа удирдах, зохицуулах, хариу арга хэмжээ авахад нь ОТ илүү их туслалцаа дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. ОТ олон ажлыг бие даасан үйл ажиллагаа явуулдаг, газрын төрхөнд бас нөлөө учруулж буй хувийн компаниудтай гэрээлэн гүйцэтгүүлдэг; энэ бүх үйл ажиллагаа ОТ-н хэрэгцээ шаардлагын улмаас явагддаг. Нутгийн малчдад учруулсан дарамтаа бодолцон ОТ нөлөөллийг бууруулахаас илүү их зүйл хийнэ гэж хүмүүс хүлээж байна. Ийм хүлээлтүүд болоод ОТ-н үүрэг, амлалтын талаар нээлттэй хэлэлцэж, ярилцах бололцоог бий болгох нь ГТЗ-ийн гүйцэтгэх үүрэг мөн.

Малчидтай илүү идэвхтэй харилцах талаар ОТ-д өгөх тодорхой зөвлөмжүүд:

Орон нутгийн харилцааны багийг өргөжүүлэн, ажлын төлөвлөгөөг нь шинэчлэх. Багийг ОТ ба малчдын (мөн орон нутгийн бусад иргэдийн) хооронд хоёр талын үр дүнтэй харилцаа бий болгох үүрэг бүхий, бэлтгэгдсэн хүмүүсээр бүрдүүлэх. Үүнд мөн албан ёсны уулзалтуудад оролцох, жишээ нь багийн хуралд суух, орон нутгийн захиргаа болон сонгогдсон албан

тушаалтнуудтай ойр холбоотой байх; 'эмзэг' гэж тогтоогдсон хүмүүсийг оролцуулан хэрэгжиж буй нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан хүмүүстэй байнгын холбоотой байх, цаг зав гарган сумын хэмжээгээр явж, хүмүүстэй албан бус харилцаа тогтоох зэрэг орно.

ОТ-н үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээллийг (ялангуяа барилгын ажлын үеэр, УЛТ-н гадна ажиллаж буй гэрээт байгууллагуудын үйл ажиллагаа, хэн хаана юуг хэдий хугацаагаар хийж буй, хүмүүсийг ажилд яаж авч байгаа гэх мэт) малчид, орон нутгийн бусад иргэдэд хүргэх, мэдсэн сонссон асуудлуудаа эргэж удирдлагадаа танилцуулж байхын тулд орон нутгийн харилцааны ажилтнууд ОТ компани дотроо маш сайн харилцаа холбоотой байх хэрэгтэй.

ОТ орон нутгийн эдийн засагт үзүүлсэн нөлөөлөл - ажил олголт, орон нутагт төлсөн татвар, хураамж, орон нутгийн худалдан авалт; байгаль орчны нөлөөлөл - байгаль орчны нөлөөллийн мониторинг ба менежментийн хөтөлбөрүүд холбогдох тоо баримт; нийгмийн гүйцэтгэл - нөхөн олговрын хөтөлбөр, эмзэг хүмүүст тусалсан байдал, сургалт, бизнес эрхлэлт, Хамтын ажиллагааны гэрээний төслүүд, хандив зэргийг хамруулан өнгөрсөн оныхоо гүйцэтгэл, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах тайланг жил бүр гаргаж байхыг бид бас санал болгож байна. Үүнийг Монгол хэл дээр, малчдад хүртээлтэй хэлбэрээр гаргах нь зүйтэй.

Хавсралт 1: Ажлын Даалгавар

Сонирхолоо илэрхийлэх урилга
‘Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин
өрхүүдийн нийгэм, эдийн засгийн судалгаа’

Урилгыг зарлах өдөр: 2015 оны 4-р сарын 1
Хүлээн авах өдөр: 2015 оны 4-р сарын 22

Оюу толгой ХХК нь, Ханбогд сумын захиргаа болон Ханбогд сумын малчдын төлөөлөлтэй зөвшилцсөний үндсэн дээр Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин өрхүүдийн нийгэм, эдийн засгийн судалгаа хийх ажлыг гүйцэтгэх хүсэл эрмэлзэлтэй шалгуурыг хангасан мэргэжилтнүүдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.

Энэхүү судалгаатай төстэй судалгаа өмнө нь хийж байсан туршлагатай мэргэжилтнүүдийг хүсэлтээ илэрхийлсэн материалаа 2015 оны 4-р сарын 22-ны өдрийн 18:00 цагаас өмнө Батсайханы Нандинчимэгт (Нандиа) nandiab@gmail.com хаяг руу илгээнэ үү.

Энэхүү урилга нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй боломжит шинжээчдыг судлахыг хүсч байгаа бөгөөд аливаа хүсэлтээ илэрхийлсэн оролцогчоос ажил, үйлчилгээ авах тухай баталгаа гаргах буюу амлалт өгөхгүй болно. Тиймээс материалыг бэлтгэхэд зарцуулах цаг хугацаа болон зардлаа харгалзан үзвэл зохистой. Мэдээлэл өгөх, хүсэлт бэлдэж, хүргүүлэхтэй холбогдолтой аливаа зардлыг бид хариуцахгүй.

ОЛОН ТАЛТ ШИНЖЭЭЧДИЙН БАГ МОНГОЛ УЛСЫН ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ХАНБОГД СУМЫН МАЛЧИН ӨРХҮҮДЭД НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА
ХИЙХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОХ ХҮСЭЛТЭЭ ИЛЭРХИЙЛНЭ ҮҮ!

2015 оны 3-р сар

Үндэслэл

“Оюу толгой” ХХК (ОТ) өнгөрөгч 10 гаруй жилд Ханбогд суманд Оюу толгойн уурхайг бүтээн босгож, барьж байгуулаад байгаа билээ. Одоогоор тус уурхай нь ил уурхайдаа олборлолт хийж, зэсийн баяжмал боловсруулан, өөрийн барьсан, зориулалтын хатуу хучилттай замаар Хятад улсын хил хүртэл өмнө зүгт 80 километрт ачааны машинаар тээвэрлэж байна. Ханбогд сумын хүн ам одоогоор 5.060 орчим, үүнээс 3.900 орчим нь сумын төвд оршин суудаг бол 1.160 нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчид юм.

Уул уурхайн хөгжилтэй холбоотойгоор нийгэм, эдийн засагт гарч буй өөрчлөлтийн улмаас Ханбогд сумын олон малчин өрхийн ахуй амьдрал өөрчлөгдөж байна. Эдгээр өөрчлөлтүүд ихэнх тохиолдолд малчдын уламжлалт амьжиргаанд аюул учруулж байна. Мөн уламжлалт ахуй амьдралаараа аж төрөн суугаа олон малчин уламжлалт соёлоо хойч үедээ өвлүүлж чадахгүй байх вий хэмээн эмээж байна. Энэ бүх өөрчлөлт хурдан өрнөж байгаа боловч тэдгээр өөрчлөлт нь өрх гэрийн түвшинд хэрхэн тусч буйг нарийн тогтоосон доривтой судалгаа, мэдээлэл өнөөг хүртэл хийгдээгүй ирсэн байна.

“Оюу толгой” компанийн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн гэрээний дагуу нөхөн олговор олгосон байдал нь малчин өрхийн тогтвортой амьжиргаанд хангалттай дэмжлэг үзүүлээгүй, хойч үеийнхэндээ залгамжлуулах уламжлалт ахуй соёлыг алдагдуулсныг нөхөн төлж чадаагүй гэсэн албан ёсны гомдлыг Ханбогд сумын хэсэг малчид “Оюу толгойн хяналт” үндэсний хэмжээний ТББ, “Говийн газар шороо” орон нутгийн ТББ-ын тусламжтайгаар 2012 оны 10-р сард Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний газарт (ЭЗХЗОГ) гаргасан.

Хэдийгээр “Оюу толгой” компани нь өнгөрсөн 10 гаруй жилд малчид, нутгийн нийт ард иргэдийн амьжиргаа, ахуй соёлд гарсан өөрчлөлтийн дүр зургийг бодитойгоор гаргаж, тэр бүх өөрчлөлтийн аль нь тус компанийн үйл ажиллагаатай холбоотой болохыг тогтоохын тулд нийгэм, соёл, эдийн засгийн хэд хэдэн судалгаа хийсэн боловч тэдгээр судалгааг өнөөг хүртэл эмхэтгэж, эцэслэсэн дүн шинжилгээ хийгдээгүй байна. Түүнчлэн, тус дүн шинжилгээний талаар бүрэн дүүрэн мэдээлэл авахын тулд сүүлийн үеийн тоо баримт, өрх гэрийн түвшний антропологийн ажиглалт судалгаа шаардлагатай байна.

Өмнө хийгдсэн судалгааг нарийвчлан судалж, сонгосон өрх гэрийн түвшинд хийсэн ажиглалт судалгааг эмхэтгэн, нэгтгэсэн дүнг задлан шинжилж, Ханбогд сумын малчин өрхүүдийн өнөөгийн нөхцөл байдлын дэлгэрэнгүй дүр зургийг гаргах ажлыг гүйцэтгэх зохих ёсны мэргэшил, ур чадвартай, олон талт шинжээчдээс бүрдсэн багийг тендерт оролцох хүсэлт гаргахыг урьж байна.

Судалгааны зорилго

Тус судалгаагаар малчин өрхүүдийн амьжиргаанд гарч буй өөрчлөлт, Оюу толгойн үйл ажиллагаанаас малчдын амьжиргаа, соёлд үзүүлж буй нөлөө, Оюу толгойн нөхөн олговор хэр хангалттай байгаа талаар хараат бус мэдээлэл гаргуулах зорилготой юм. Тодруулбал, Малчдын төлөөлөл (МТ) болон ОТ нь олон талт шинжээчдийн багаар малчдын амьжиргаатай холбоотой асуудал болох бэлчээр, мал сүргийн ундны усны хүртээмж, чанарт гарсан өөрчлөлтөд үнэлгээ хийх; малчин өрхүүдийн амьжиргаанд гарсан өөрчлөлтийг ерөнхийд нь үнэлж дүгнэх; улмаар энэ бүх мэдээллээ ашиглан ОТ-н 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор хэр хангалттай болсныг үнэлж дүгнэх ажлуудыг хийлгэх хүсэлтэй байгаа юм.

Аргачлал

Сонгон шалгаруулалтанд оролцох баг тус үнэлгээнд ашиглах аргачлалаа өөрсдөө боловсруулна. Аргачлал боловсруулахдаа бэлчээр дагасан нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын амьдралын хэв маягийн онцлог шинж, уул уурхайн төслүүдээс малчдын амьжиргаа болон тэдний байгалийн нөөцөд үзүүлсэн нөлөөг анхаарч үзэх шаардлагатай. Холбогдох төрийн байгууллагуудын тоо баримт, ОТ-д байгаа судалгаа шинжилгээ зэрэг нь тус ажлын үндсэн судлагдахуун хэсэг байна; сонгон шалгаруулалтанд оролцогчдод судалгааны санал боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх үүднээс одоо байгаа судалгааны бүрэн жагсаалтыг нэмж хавсаргав. Хээрийн судалгаа хийж, шинэ тоо баримт цуглуулахдаа одоо байгаа мэдээллийг баталгаажуулан, дутуу мэдээлэлд суурилан, өмнө хийгдсэн ажилтай давхардуулахаас

зайлсхийнэ. Аргачлалыг Орон нутгийн захиргаа, Малчдын төлөөлөл болон ОТ-д танилцуулж, тендерийн шалгаруулалтад оруулна.

Шалгаруулалтад оролцох багууд судалгааны аргачлалаа боловсруулахдаа микро эдийн засаг болон зан төлөвийн эдийн засаг, түүнчлэн социологийн ойлголтыг хамруулсан олон салбар ухааны цар хүрээнд “оролцогчийн ажиглалт” болон антропологийн бусад арга барилыг аргачлалдаа санал болгон оруулах хэрэгтэй. Санал гаргагчид өөр өөр мэргэжил бүхий багийн гишүүдийн бие даасан харилцан ажиллагааны давуу талыг ашиглан нэг баг болж ажиллах бөгөөд өрхийн амьжиргааны хүчин зүйлсийг явцуу авч үзэх бус харин “өрхийн экологийн” тухай ойлголтыг гаргаж ирэх ёстой.

Судалгаагаар салангид боловч бие биеэ нөхсөн дараах гурван бүрэлдэхүүн хэсгээр үнэлгээ хийнэ. Үүнд: (1) Бэлчээр, малын ундны усны чанар, хүртээмжийн үнэлгээний ихээхэн хэсгийг бэлэн байгаа болон одоо хийгдэж буй судалгаануудаас гарган авч болно (судалгааны хавсаргасан жагсаалтыг харах); (2) Сүүлийн 10 гаруй жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн задлан шинжилгээ - бэлэн байгаа болон одоо хийгдэж буй судалгаанд үндэслэн нэмэлт судалгаа хийх шаардлагатай (судалгааны хавсаргасан жагсаалтыг харах); (3) ОТ-н 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор хэр хангалттай байсныг бэлчээр, ус, хөрөнгө, амьжиргаанд туссан нөлөөллийн үнэлгээний дүнгээс нягтлан үзэх.

Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг: Бэлчээр, малын ундны усны чанар, хүртээмжийн үнэлгээ

Уламжлалт нүүдлийн мал аж ахуйд суурилсан малчин өрхийн амьжиргааны түвшин нь мал сүргийн тоо хэмжээнээс шалтгаалах бөгөөд мал сүргийн тоо хэмжээ нь бэлчээрийн хэмжээ, чанар болон ус ашиглах боломжоос шууд шалтгаалдаг. Иймд, малчдын амьжиргаанд ОТ-н нөлөөлөл ямар байгааг үнэлэхийн тулд ОТШБ нь бэлчээр ба усны нөөцөд нөлөөлсөн байдлыг зайлшгүй үнэлэх шаардлагатай. Нэгдүгээр бүрэлдэхүүн хэсэг эдгээр зүйлд голлон анхаарах бөгөөд дотроо дараах гурван хэсэгтэй байна. Үүнд:

Хэсэг А: Үндсэн ба хоёрдогч тоо баримтыг ашиглан, Ханбогд сумын бэлчээрийн чанар, тоо хэмжээ, малын усны хүртээмжид 2003 оноос хойш өнөөг хүртэл бий болсон өөрчлөлтийг байж болох хамгийн оновчтойгоор тодорхойлохын тулд тоон болон чанарын үнэлгээ хийх.

Хэсэг Б: ОТ төсөлтэй холбоотой бий болсон бэлчээр ба усны нөөцийн өөрчлөлтийн зураглалыг байж болох хамгийн оновчтой хэлбэрээр гаргах.

Хэсэг В: Дараах зүйлстэй холбоотой үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулна. Үүнд: (1) Ханбогд сум болон Говийн бүс нутаг даяар байгалийн экосистем ба уламжлалт мал маллагааг сэргээх буюу хамгаалах арга замууд; мөн (2) ОТ төслөөс цаашид учруулж болзошгүй нийт нөлөөллийг даах чадвар байгаа эсэхийг тогтоох.

Хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг: Сүүлийн 10 гаруй жилд малчны хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтийн нарийвчилсан шинжилгээ

Судалгааны хоёрдугаар бүрэлдэхүүн хэсэг нь уламжлалт амьжиргаа, малчин өрхийн соёл заншилд туссан нөлөөнд голлон анхаарах ба дараах хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Хэсэг А: 2003 оноос өнөөг хүртэлх хугацаанд Ханбогд сумын малчин өрхийн амьжиргаа хэрхэн өөрчлөгдсөнийг тогтоох үнэлгээ хийх, ингэхдээ уламжлалт амьдралын хэв маяг, соёл заншил хэр хэмжээтэй алдагдсныг тогтоох, өнөөгийн малчид уламжлалт амьжиргаагаа тогтвортой авч явж, дараагийн үедээ уламжлуулах чадавх хадгалагдах эсэх талаас нь анхаарч үнэлэх.

Хэсэг Б: Нөлөөллийн аль хэсэг нь, ямар хэмжээнд ОТ төсөлд хамаарахыг тогтоох.

А хэсгийн үнэлгээ дараах зүйлсийн үнэмлэхүй түвшин, өөрчлөлтийг бүрэн хамруулах бөгөөд тэдгээрээр үл хязгаарлагдана. Үүнд:

- Өрхийн хөрөнгө ба үйлдвэрлэлийн өгөөжтэй бэлчээрийн хүртээмж (хавар, зун, намар ба өвлийн бэлчээр), улирлын чанартай нүүдэллэх явцад хэрэглэж ирсэн уламжлалт ус, худаг ба булаг задгай, малын хашаа хороо, хадлангийн газар, уналга хэрэглээний адуу, тэмээ болон зах зээлд борлуулагдах эрүүл мал сүрэг;
- Өрхийн дэд бүтэц ба бусад хөрөнгө;
- Мал сүрэг (малын тоо, чанар, тарга тэвээрэг, насжилт, төл авалт ба мал сүргийн бүтэц);
- Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий, боловсруулсан, өрхийн хэрэглээний болон борлуулах зориулалттай;
- Өрхийн хэрэглээ болон малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтанд гарсан өөрчлөлт;
- Мал маллагаа болон нүүдэллэх уламжлалт горимд орсон өөрчлөлт;
- Нийгмийн хөрөнгөд бий болсон өөрчлөлт ба өртөг (өрхийн дотоод хөдөлмөр хоршилт, өрхийн бүтцийн өөрчлөлт);
- Бусад эх үүсвэрээс орох өрхийн орлого;
- Өрхийн зарлагын зураглал;
- Хөрөнгө хуримтлуулалт (мал сүргийн өсөлт/бууралт, банкны хадгаламж, даатгал зэрэг бусад МАА-н бус хөрөнгө);
- Бүсийн дэд бүтцийн хүртээмж, түүний ач холбогдол (жишээлбэл сайжруулсан зам, жижиглэнгийн худалдаа үйлчилгээ, харилцаа холбоо, эрүүл мэндийн яаралтай тусламж, эрүүл мэнд ба боловсролын үйлчилгээ болон соёлын газрууд);
- Өрхийн соёлын өв хөрөнгө (амьдралын уламжлалт хэв маяг хадгалагдсан байдал, өвөг дээдсийн ёс зүй, сургаалийг дээдлэн хэрэгжүүлэх тухайд хувь хүнд гарсан өөрчлөлт); түүнчлэн
- Өөрчлөлтийг хүлээж авах хандлага ба ирээдүйг төсөөлөх үзэл баримтлал (амьдралын түүх, хүүхдийн мэргэжил сонголт, хувь хүмүүс уламжлалт болон шинэ амьдралын хэв маягт өгч буй үнэлэмж).

Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг: Нөхөн олговрын хөтөлбөрийг нягтлан үзэх

Ханбогд сумын малчдад учруулсан өөрийн нөлөөллийг нөхөх зорилготойгоор ОТ хоёр хөтөлбөр хэрэгжүүлсэн: 2004 оны нүүлгэн шилжүүлэлт болон 2011 оны эдийн засгийн суурьшил алдагдалтын нөхөн олговрын хөтөлбөр. Олонх малчид эдгээр арга

хэмжээнүүд нь ОТ-гоос бэлчээр ба усанд учруулсан нийт нөлөөлөл (тэдгээр нь малчдын маллах мал сүргийн тоо хэмжээнд нөлөөлж байна) түүнчлэн уламжлалт амьжиргаа ба соёл заншилд учирсан нөлөөллийг хангалттай нөхөж чадаагүй, гэж үздэг.

Хэсэг 1 ба 2-ын үнэлгээний үр дүнд цуглуулсан мэдээлэлд үндэслэн ОТШБ нь тухайн өрхүүдэд олгосон нөхөн олговрын багц болон сүүлийн арав гаруй жилийн туршид ОТ-гоос Ханбогд суманд үзүүлсэн дэмжлэг туслалцаа зохистой байсан эсэхэд хөндлөнгийн хяналт хийнэ. Тухайлбал, аудит нь дараах асуудлыг шинжилнэ: (1) 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн суурьшил алдалтын нөхөн олговор тогтоохдоо ашигласан нөлөөллийг үнэлэх аргачлал нь зөв, зохистой байсан эсэх; (2) ОТ өөрийн хэрэгцээний дэд бүтэц, байгалийн баялаг ашигласан зэргийг оролцуулан ОТ-н улмаас учирсан сөрөг нөлөөллүүдийг хангалттай нөхөн төлсөн эсэх; (3) тогтвортой амьжиргаанд шилжихэд хангалттай нөхөн олговор олгогдсон эсэх; (4) нөхөн олговор авбал зохих бүх малчдад нөхөн олговор бодитой олгосон эсэх; болон (5) нөхөн олговрын үйл ажиллагаа нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн 5-р стандартад нийцсэн эсэхийг тус тус тогтоох зэрэг болно.

Олон талт шинжээчдийн багийн бүрэлдэхүүн, сонгон шалгаруулах шалгуур

Антропологи, социологи, микро эдийн засгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн, 3-4 хүнтэй баг байхаар төлөвлөж байгаа бөгөөд тэдний мэргэшил ур чадвар, холбогдох туршлагыг нягтлан үнэлнэ. Багт унаган монгол хэлний мэдлэг, чадвартай гишүүн байх зайлшгүй шаардлагатай бөгөөд монгол малчидтай ажиллаж байсан хүмүүсийг эн тэргүүнд авч үзнэ. Үүний нэгэн адил, доод тал нь нэг ахлах судлаач нь олон улсын тэргүүн туршлагатай, өгүүлэл, бүтээлээ нийтлүүлж байсан хүн байх шаардлагатай.

Шинжээчдийн баг нь аль нэг талын эрх ашгийг харж туйлшрахгүй цэвэр мэргэжлийн үүднээс ёс зүйтэй ажиллах шаардлагатай.

Санхүүжилт ба хүлээх хариуцлага

Тендерт оролцогч Олон талт шинжээчдийн баг зардлын төсөв бүхий саналаа бэлтгэж, Малчдын төлөөлөл, Ханбогд сумын удирдлага, ОТ-с бүрдсэн Гурван Талт Зөвлөлд (ГТЗ нь МТ/ОТ хооронд ЭЗХЗОГ-ын чиглүүлэлтэй хийгдэж байсан яриа хэлэлцээрийг залгамжлагч байгууллага) танилцуулна. Зөвлөл саналыг баталснаар Олон талт шинжээчдийн багийн зардал, санхүүжилтийг гаргах үүргийг ОТ хүлээнэ. Тайлангийн төсөл, сүүлийн танилцуулга, эцсийн тайланг хүлээн авах, нийт ажлын чанарыг үнэлж дүгнэх үүргийг Зөвлөл хүлээнэ.

Тайлагнах

Үнэлгээний ажлыг 6 сарын дотор хийж гүйцэтгэх бөгөөд ажил дууссанаас хойш 2 сарын дотор тайлан, зөвлөмжийн төслийг Зөвлөлд танилцуулна. Ажил гүйцэтгэх хугацаанд 2 сар тутамд явцын тайланг Зөвлөлд илтгэнэ. Олон талт шинжээчдийн баг танилцуулгын үед гарсан саналыг тусгасан эцсийн тайланг бичгээр үйлдэж, санал хүсэлт хүлээн авснаасаа хойш нэг сарын дотор Зөвлөлд танилцуулна. Тайлангийн төсөл болон эцсийн хувилбар нь Монгол, Англи хэлээр тус тус бичигдсэн байна.

Саналын Бичиг Баримт

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэнд ажлын товч, тодорхой цар хүрээ, аргачлал, олон талт шинжээчдийн багт ажиллуулахаар санал болгож буй багийн гишүүдийн тодорхойлолт, хувийн товч намтарыг оруулна. Мөн энэхүү урилгад тусгаагүй “үнэ цэнийг нэмэгдүүлэх” саналуудыг тусгаж болно. Тус хүсэлт 10 хуудаснаас хэтрэхгүй байна.

Зөвлөл сонгон шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн хүсэлтүүдээс Зөвлөлтэй нүүр тулан уулзаж саналаа танилцуулах багийг (тээврийн зардлыг ОТ гаргана) сонгох бөгөөд тэдгээрийн дундаас эцсийн шалгаруулалтыг хийнэ.

Хавсралт: “Оюу толгой”-д байгаа судалгаануудын жагсаалт, товч тодорхойлолт

- 1. ОТ төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, 3-р дэвтэр: Олборлох болон боловсруулах нь”, Эко-Трэйд ХХК 2003.** 2003 оны 6-р сард Монголын зөвлөх компани болох Эко-Трэйд ОТ-н уурхайгаас гадагш 20 км-ийн радиуст байгаа бүх айл өрхийг тоолсон. Газар ашиглалт, газрын эрх, өрхийн хөрөнгийн (гол төлөв мал) талаар тоо баримт цуглуулахаар айл өрхүүдэд явуулсан судалгаанд нийтдээ 15 айл өрх (91 хүн) хамрагдсан.
- 2. Нөлөөнд өртсөн малчдын нэмэлт судалгаа, 2004-2005.** 2004-2005 онд малчдыг нүүлгэн суурьшуулах багцад хамруулахаар 10 км-ийн Хамааралгүй бүсээс нүүлгэн суурьшуулах арван малчин өрхөөс нэмэлт тоо баримт цуглуулж авсан.
- 3. Ханбогд суман дахь ОТ-н усны талаарх ойлголтын судалгаа, 2007.** Нутгийн иргэд усны асуудлын талаар санаа зовж буй байдлыг үнэлж дүгнэх, хамтын оролцоотой усны менежментийн арга хэмжээг боловсруулахад энэ судалгааг ашигласан. Худаг, өвөлжөөний зураглал гаргаж, малын тоо толгой, бусад гол тоо баримтыг цуглуулсан. Нийт 280 малчин өрхтэй ярилцлага хийж, дөрвөн бүлэгт тулгуурлан өөр 51 хүнийг “Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг”-т хамруулсан. Монгол улсын Бодлогын судалгааны төв болон Хүн ам, сургалт судалгааны төв энэ ажлыг удирдсан.
- 4. Ус ашиглалтын судалгаа, 2008.** Гүний хоолойн орд газар орчим нутагладаг малчдаас мэдээлэл цуглуулахаар Баян багт ус ашиглалтын нэмэлт судалгаа хийсэн. Тус судалгаагаар 21 малчин өрхийг хамруулан усны уламжлалт зохицуулалтын талаарх бага цар хүрээний хайгуулын хэмжилт судалгааг хийсэн.
- 5. “Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны 2008 оны суурь судалгаа”.** ОТ-н санхүүжилтээр Монгол улсын Бодлогын судалгааны төв болон Хүн ам, сургалт судалгааны төвийн хийсэн энэ судалгаанд Ханбогд сумын төвийн нийт 70 өрх, 37 малчин өрх хамрагдсан.
- 6. Бэлчээрийн газрын зураглал ба үнэлгээний хөтөлбөр, 2009-2010 он.** Энэ хөтөлбөрийн ОТ-ын нөлөөллийн өөр өөр газруудын эргэн тойрны бэлчээрийг ашигладаг малчдыг тодорхойлохоор хийсэн. Тоо баримтыг Жавхлант, Гавилууд, Номгон, Баян багийн 79 малчин өрхөөс цуглуулсан. Үүний гол зорилго нь мал бэлчээрлэдэг газрын хил хязгаар, бэлчээрийн газрын менежментийн зохион байгуулалтыг ойлгох, нөлөөллийн талбаруудын болон ойр орчим дахь газрыг, мөн бусад хөрөнгийг ашигладаг малчин өрхүүдийг тодорхойлох байв. ОТ малчин өрх бүрээр орж бэлдсэн асуултын дагуу ярилцлага өрнүүлэн хариулт авч, улирлын малын бэлчээр газрын хил хязгаарыг малчидтай хамтран газрын зураг дээр тэмдэглэсэн.
- 7. Оюу толгой төслөөс хэрэгжүүлж буй “өмнөговь аймгийн соёлын өвийн хөтөлбөр боловсруулах” төслийн нэгдүгээр үе шатны тайлан:** 2010 оны 6-р сарын 17-нд “Састэйнэбилити Ийст Эйжиа” (СИА) ХХК (Sustainability East Asia LLC) “Оюу толгой” ХХК-д зориулсан урт хугацааны соёлын өвийн хөтөлбөр боловсруулсан. Уг хөтөлбөр хоёр үе шаттай байсан. Нэгдүгээр үе шат соёлын өвийн суурь үзүүлэлт ба зөрүүний үнэлгээ бий болгох, хоёрдугаар үе шат нь нэгдүгээр үе шатанд цуглуулсан мэдээллийг ашиглан соёлын өвийн хөтөлбөр, хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах байсан. Энэ тайланд нэгдүгээр үе шатны ажлын үр дүнг хураангуйлсан байдаг.

8. **“Оюу толгойн 2011 оны Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө”**: Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн талбайгаас 10 өрхийг 2004 онд биет нүүлгэн шилжүүлэлт хийж, зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас 89 айл өрхийг 2011 онд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэнтэй холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.
9. **Өртсөн байж болзошгүй малчин өрхүүдийн судалгаа (2010- 2011 он)**. Нөлөөнд шууд өртсөн айл өрхийг тодорхойлох, тэдгээрийн талаар илүү нарийн тодорхой тоо баримт цуглуулахаар дээр дурдсан бэлчээрийн газрын зураглал, үнэлгээний хөтөлбөрийг өргөжүүлсэн бөгөөд уг судалгааг ОТ 2010 оны 9-р сараас 2011 оны 5-р сар хүртэл хийсэн. Энэ судалгаагаар нөлөөнд өртсөн бүх малчин өрхүүд, мөн Ханбогд суманд дахь бусад өрхөөр нэг бүрчилэн очиж, өрхийн бүтэц, ажил эрхлэлтийн түвшин, орлогын эх үүсвэр, мал сүрэг ба бусад хөрөнгө, бусад хүн ам зүйн тоо баримтыг цуглуулсан. Уг судалгаанд 101 айл өрх хамрагдсан. Ингээд нийтдээ энэ судалгаанд 393 хүнийг хамруулсан нь Ханбогд сумын малчдын 19%-тай тэнцэнэ).
10. **Бэлчээрийн газар ашиглалтын гэрээний талаарх нутгийн малчдын ойлголтын судалгаа, 2012**. Бодлого судалгааны төв, “Цэвэр эрчим хүч”, “Алтан нутаг” гэх дотоодын ТББ-ууд сумын засаг захиргаатай байгуулах бэлчээрийн газар ашиглалтын гэрээний талаарх орон нутаг дахь хандлагыг бүртгэн тэмдэглэхээр Ханбогд сумын малчдын дунд хамтарсан шуурхай судалгааг хийсэн. Уг судалгаанд хамрагдсан 186 малчны 78 хувь нь бэлчээрийн газар ашиглалтын гэрээг дэмжиж буйгаа илэрхийлж, 72 хувь нь тийм гэрээг эцэслэн байгуулахад бэлэн буйгаа илэрхийлж байгаа үр дүн гарсан. Судалгааны дүнг өөр өөрсдийн харгалзах газрын бэлчээрийн менежментийг сайжруулахын тулд сумын удирдлага болон малчдын нэн тэргүүнд авах арга хэмжээг тодорхойлоход ашигласан.
11. **Ханбогд сумын хүн ам, орон сууцны тооллого, 2013**. ОТ-н санхүүжүүлсэн энэ тооллогоор засаг захиргааны хамгийн бага нэгжүүд буюу баг, сумын хүн амын тоог нас, хүйс, байршил, боловсрол, эдийн засгийн үйл ажиллагаа, нүүж суурьшсан байдал, орон сууцны нөхцөл зэргээр ангилсан мэдээллийг гаргасан байдаг. Уг тооллогыг Монгол улсын Засгийн газрын 2010 оны Хүн ам, орон сууцны тооллогод ашигласан аргачлалаар хийсэн бөгөөд энэ нь төр болонхувийн хэвшлийн түншлэлийн схемээр Монголд анх удаа хийсэн хүн амын тооллого болсон.
12. **“Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар-2013**. Оюу толгойн 2011 оны нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар; Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн талбайгаас 10 өрхийг 2004 онд биет нүүлгэн шилжүүлэлт хийсэн болон зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэн 89 айл өрхийн 2013 оны төлөв байдалтай холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.
13. **Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө: 2013 оны 9-р сар**. Үйл ажиллагааны менежментийн энэ төлөвлөгөө бол Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий баримт бичгийн хэсэг юм. Энэ төлөвлөгөө нь менежментийн зохих харилцах

хэсгийг томьёолох; албан тушаал, үүрэг хариуцлагыг тодорхойлох; менежментийн төлөвлөгөөнд хамааралтай төслийн холбогдох стандартыг тоймлон илэрхийлэх; менежментийн төлөвлөгөөтэй холбоотой төслийн үүрэг амлалт, үйл ажиллагааны журмыг тодорхойлох; Гүйцэтгэлийн гол үзүүлэлт гэх мэт хяналт шинжилгээ ба тайлангын журмыг тодорхойлох; сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох; материал ба мэдээлэлд дэмжлэг болох лавлагааг томьёолох тус тус зорилготой юм.

14. ***Зах зээлийн шуурхай судалгаа, 2014 он.*** Энэ судалгааг Бодлого судалгааны төв Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдад хийсэн. Шууд нөлөөнд өртсөн 79 айл өрхийг хамруулсан 200 айл өрхтэй ярилцлага хийсэн. Мөн сумын засаг захиргааны төлөөлөл, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийсэн. Энэ судалгаа нь бизнес эрхлэх боломж, бизнесийн хөгжилд учрах саад тотгор болон сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг олж тогтоох зорилготой байсан.
15. ***Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын малын эрүүл мэндийн байдлын үнэлгээ, 2014 он.*** Энэ үнэлгээг “Бизнесийн амжилтын түлхүүр” ТББ-ийн мэргэжилтнүүд хийсэн. Тэд Ханбогд сумын 161 айл өрхийг үнэлгээнд хамруулсан бөгөөд үүнээс 73 нь төслийн нөлөөллийн бүсийн, 88 нь төслийн нөлөөллийн бус бүсийн айлууд байв.
16. ***“Өмнөговь аймгийн малчдын амьжиргааны түвшин ба эрүүл мэндийн байдлын судалгаа”, 2014 он.*** Ханбогдын малчдын амьжиргаа болон эрүүл мэндийн байдлыг үнэлж, зөвлөмж боловсруулахаар тус судалгааг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Халдварт өвчин судлалын үндэсний төв хийсэн. Төслийн нөлөөнд өртсөн айл өрхүүдээс 9 айл уг судалгаанд хамрагдсан юм. Уг судалгааны хариуг хөдөө нутаг дахь хүмүүсийн амьжиргаа, эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн бодлогын суурь тоо баримт болгох зорилготой.
17. ***“Хоршооны тэргүүлэх чухал төслүүд”-ийн судалгаа, 2014 он.*** Энэ судалгааг Монголын хоршооны сургалт мэдээллийн төв хоршоод болон тэдний тэргүүлэх чухал төслүүдийн өнөөгийн байдлын дүгнэсэн. Уг судалгаанд сумдын 18 хоршоог хамруулсан бөгөөд уг судалгаагаар Ханбогд сумын бүх малчин өрхийн 63.0 хувь нь хоршоонд нэгдсэн гэсэн дүн гарсан.
18. ***“2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээнд хийсэн гадны хөндлөнгийн аудит, 2014 он”.*** 2014 оны 3-р сард бие даасан хоёр Монгол мэргэжилтэн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд аудит хийсэн. Тус хөндлөнгийн шалгалтанд 2004 онд нүүлгэн шилжүүлсэн 10 айл өрхийг хамруулж, компани тэдэнд гэрээгээр тохирсон бүх мөнгөн олговрыг олгосон бөгөөд их, дээд сургуулийн оюутны сургалтын төлбөр, сургуулийн хүүхдийн хичээлийн хэрэглэлд туслах гэх мэт хэрэгжүүлж буй үйл ажиллагаа “Нүүлгэн байршуулах гэрээ”-нд заасан өдөр хүртэл үргэлжилнэ гэсэн дүгнэлт гаргасан.
19. ***“Оюу толгойн Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар-2015”.*** 2013 оны Оюу толгойн нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар; Үйл ажиллагааны менежментийн дагалдах төлөвлөгөө бүхий Зээлдүүлэгчдийн БОННБҮ-ий хэсэг. Уурхайн лицензийн газраас 10 өрхийг 2004 онд бодитоор нүүлгэсэн болон зам, цахилгааны, инженерийн шугам сүлжээ гэх мэт хоёрдогч дэд

бүтцийн барилга угсралтын нөлөөнд түр болон урт хугацаанд өртсөн газраас 89 айл өрхийг 2011 онд эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийсэнтэй холбоотой бүх ажлын иж бүрэн эмхэтгэл.

- 20. Нутаг Түншлэлийн хийж буй Ханбогд сумын Бэлчээрийн Байдлын Судалгаа, 2014 онд эхлээд үргэлжилж байгаа болно.** Энэ судалгааны зорилго нь Ханбогд сумын цөл-талын бэлчээрт гарч буй өөрлөлтийг үнэлэхэд оршино. Хамааралтай талууд (Ханбогд сумын малчид, сумын удирдлага болон засгийн газрын байгууллагууд) богино ба урт хугацаанд бэлчээрийг тогтвортой ашиглах, ургамал дахин ургах нөхцөлийг бүрдүүлэх төлөвлөлтийг хийхдээ уг үнэлгээг ашиглах болно.
- 21. Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн 1-р үе шатны тайлан, 2015.** ОУСК-ийн Эрх Зүйн Хяналт, Зөвлөгөө, Омбудсмэний газрын маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй ОТ болон Ханбогд сумын малчдын төлөөлөгчдөөс томилсон Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн (ХШБ) олж илрүүлсэн зүйлс. ОТ-гоос усны гурван чухал эх үүсвэрт – Ундай гол, Бор Овоогийн Задгай (Ундай голын үндсэн гольдрол) болон Халив-Дугатын гол (Ундай голын цутгалан) – учруулж буй нөлөөллийг үнэлж, тэдгээр нөлөөлөл нь бэлчээр, малчдын усны хүртээмж, чанарт яаж нөлөөлж буйд үнэлгээ хийх зорилготой. ХШБ-ийн ажил хоёр үе шаттай хийгдэхээс 1-р шатанд Ундай гол, Бор Овоогийн Задгайд төвлөрч байгаа болно.
- 22. Төслийн Нөлөөлөлд Өртсөн Өрхүүдийн Судалгаа, 2013, 2014.** Энэ судалгаагаар ОТ-н нүүлгэн суурьшуулалт, нөхөн олговрын гэрээний дагуу олгогдсон зүйлсийг хүлээн авсан байдлыг хөөн судалж, нөлөөлөлд өртсөн айл өрхүүдийг орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт хэрхэн хамруулсныг үнэлэн, өрхийн амьжиргаа ямар нэгэн байдлаар сайжирсан буюу өөрчлөлт гарсныг тодорхойлох зорилготой юм. Судалгааны мэдээллийг урьдчилан боловсруулсан асуулгаар цуглуулсан бөгөөд үр дүнг Оюу толгойн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүд дотооддоо боловсруулсан.

Хавсралт 2: Асуулга

Малчин өрхтэй хийсэн ярилцлага

Гурван талт зөвлөлийн хүсэлтээр Ханбогд сумын малчдын нийгэм, эдийн засгийн байдалд 2003 оноос хойш гарсан өөрчлөлтийг судлах судалгааг хийж байна. Бид 100 малчин өрхийг санамсаргүй түүвэрийн аргаар сонгон авч ярилцлага хийх юм. Энэхүү судалгаанд та бүхэн өөрсдийн мэдэх зүйлсээ хуваалцаж бидний асуултанд хариулж, судалгааны ажилд гүн туслалцаа дэмжлэг үзүүлнэ үү. Эдгээр ярилцлагыг хийж, гарсан үр дүнг шинжлэн дүгнэж Гурван талт зөвлөлд тайлан бэлтгэж хүргүүлэх юм. Өрх бүрийн өгөх мэдээллийн нууцийг чандлан хадгалах ба тайланд хувь хүмүүсийн нэрийг дурдахгүй болно. Танд хариулахыг хүсэхгүй байгаа асуулт байвал заавал хариулах шаардлагагүй гэдгийг анхаарна уу.

1. Нэр
2. Нас
3. Та хүүхэдтэй юу? Тийм бол хэдэн хүүхэдтэй вэ?
4. Таны хүүхдүүд одоо хаана амьдардаг вэ? Тэд юу хийдэг вэ?
5. Яг одоо сургуульд сурч байгаа хүүхэд бий юу?
6. Танайх хаана өвөлждөг вэ? Хүүхэд сургуульд явахад хэн дагаж сум ордог вэ? эсвэл айлд ч юм үү? дотуур байранд өгдөг үү?
7. Хэдэн жил мал маллаж байна вэ?
8. Энэ нутагт хэдэн жил малаа маллаж байна вэ?
9. Малаа анх хаанаас, яаж авсан бэ?
10. Хэдэн ямаа, хонь, үхэр, адуу, тэмээтэй вэ?
11. Таны малын төрөлд өөрчлөлт орсон үү? Яагаад?
12. Хэзээ хамгийн олон малтай байсан вэ?
13. Малын тоо толгойг хангалттай өсгөх боломж байна үү?
14. Малын эрүүл мэндэд өөрчлөлт гарч байна үү? Яагаад?
15. Малаа хөлсний малчнаар маллуулдаг үү эсвэл танай ах дүү садангийн хэн нэг нь малладаг үү? Хэзээнээс эхэлсэн бэ?
16. Тавиул мал малладаг үү? Хэзээнээс эхэлсэн бэ?
17. Та өвөлжөө, хаваржааны бууцаа өөрчилсөн үү? Яагаад?
18. Та өвөлжөө, хаваржааны газрын гэрчилгээтэй юу?
19. Хэдэн өвөлжөө хэдэн хаваржаатай вэ? Өөр хүмүүс хэрэглэдэг үү? Яагаад олон өвөлжөөтэй болохоор шийдсэн бэ?
20. Танайх энэ жил цагаан сараас хойш хэдэн удаа нүүсэн бэ? Ер нь жилд хэд нүүдэг вэ?
21. 2003 оноос өмнө нүүж байсантайгаа адил удаагаар нүүх боломжтой байгаа юу?
22. Оюу толгойн уурхайн үйл ажиллагаа болон зам харгүй эсвэл ажлын хуваарь нь нүүх эсэх шийдвэрт тань нөлөөлж байв үү?
23. Одоо зусландаа байна үү? Таны зуслан, өвөлжөөний газрын хооронд хэр зайтай вэ?
24. Суманд ойрхон газарт амьдрах чухал үү? Яагаад? Ямар шалтгаан байдаг вэ?

25. Усны хүртээмж олдоц ямар байна вэ? 2003 оноос хойш усны хүртээмж хэрхэн өөрчлөгдсөн бэ?
26. Ямар худаг хэрэглэдэг вэ? Гар худаг? Гүний худаг?
27. Мотор хэрэглэдэг үү? Хэрэглэдэг бол үүнд хэдэн литр бензин хэрэглэдэг вэ?
28. Хэзээний худаг вэ? Нэгдлийн үеийнх? Оюу толгой гаргаж өгсөн? Өөрсдөө гаргасан? Улсаас, нутгын захиргаанаас?
29. Танай худаг хэдэн км-ийн зайд байдаг вэ?
30. Хэдэн айл хэрэглэдэг вэ? Худгаа цоожилдог үү?
31. Бэлчээрийн хүртээмж, чанар ямар байна вэ? 2003 оноос хойш бэлчээрийн чанар хэрхэн өөрчлөгдсөн бэ? Бэлчээрт юу юу нөлөөлж байна вэ?
32. Энд хамгийн сүүлд хэзээ зуд болсон бэ? Зудны үеэр юу болсон бэ?
33. Орлогын эх үүсвэр юу вэ? 2003 оноос хойш хэрхэн өөрчлөгдсөн бэ?
34. Танайх одоо хэдэн мал сааж байна вэ? Ямар ямар мал сааж байна вэ? Хэзээ малаа саадаг вэ? жилийн 4 улирал сааж чадаж байна үү?
35. Та нэг өдөрт хэр их сүү авдаг вэ? Сүүгээрээ юу хийдэг вэ?
36. Та гаргасан бүтээгдэхүүнээ хаана зардаг вэ?
37. Малын өөр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэлж борлуулдаг вэ?
38. Банкны зээлийг юунд хэрэглэдэг вэ? Ямар зээл авдаг вэ?
39. Танай хүүхдүүдээс (том болсон нь) малчин болсон үү? Танай хүүхдүүд том болоод малчин болно гэж бодож байна үү? Энэ байдал танд ямар санагдаж байна вэ?
40. Сум, аймаг, Улаанбаатар болон бусад газарт өмч хөрөнгө бий юу? Тийм бол хэзээ үүнийгээ авсан бэ?
41. Ямар тээврийн хэрэгсэлтэй вэ? Машинтай бол хэзээ анх машин авсан бэ?
42. Өмч хөрөнгө худалдан авахдаа хаанаас санхүүжилт авч байна вэ?
43. Өрхийн гол зарлага юун дээр гарч байна вэ?
44. 2003 онтой харьцуулахад өрхийн зарцуулалт өссөн үү? багассан үү?
45. Сумын төв хэр их явдаг вэ? Аймгийн төв? Улаанбаатар?
46. 2003 оноос хойш сургууль, эрүүл мэндийн үйлчилгээ хэрхэн өөрчлөгдсөн бэ?
47. Эрүүл мэндийн хувьд танд ямар асуудлууд байна вэ?
48. 2003 оноос хойш мал эмнэлгийн үйлчилгээ хэрхэн өөрчлөгдсөн бэ?
49. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд мал маллах арга техник хэрхэн өөрчлөгдсөн бэ? Өөрийн мал ахуйд тань чинь Оюу толгойн уурхай болон зам нөлөөлж байвүү?
50. Уламжлалт нүүдлийн хэлбэрээр мал маллахад гол зүйл нь юу вэ? Уламжлалт мал аж ахуй юугаар тодорхойлогдох вэ?
51. Нүүдэлчин уламжлал хэвээрээ байна гэж бодогдож байна үү?
52. Тэдгээр уламжлалыг хэрхэн хадгалж үлдэх вэ?
53. Энд тахилгатай уул ус, газар бий юу? Догшин лүс савдагтай уул ус бий юу? Тахилга хийж тахин шүтэхэд байгаль дэлхий өгөөжөө өгч байгаа нь мэдэгддэг үү?
54. Хэрвээ бусад малчидтай маргаан гарвал юунаас болж гардаг вэ? Хэрхэн шийддэг вэ?
55. Малчид бие биедээ хэрхэн тусалж эсвэл яаж хамтран ажиллаж байна вэ?
56. Оюу толгой уурхай танд ямар нэг байдлаар тус хүргэж байна үү? Ус болон бусад малын өвс тэжээл

- гэх мэтээр хангадаг уу?
57. Таны бодлоор баян ядуугийн ялгаа их болж байна уу? Жишээ байна уу?
 58. Энэ хавиар 1000с дээш малтай хэдэн айл байдаг вэ?
 59. Оюу толгойн уурхайн зүгээс байгаль орчны хувьд ямар нөлөө үзүүлж байна гэж та бодож байна?
 60. ОТ уурхай ажиллах болсоноос хойш амьдрал чинь хэрхэн өөрчлөгдсөн бэ? Сайн өөрчлөлт үү? Муу юу?
 61. Уурхай таны мал маллагаанд хэрхэн нөлөөлсөн бэ? Оюу толгойн уурхай ажиллаж эхэлснээс хойш мал маллахад танд ямар нэг хүндрэл тулгарч байна уу? Ямар асуудал байна вэ? Хэрхэн шийдвэрлэж байна вэ?
 62. Оюу толгой уурхайгаас болоод малчдын тоо цөөрсөн үү? Яг ямар шалтгаан байсан бэ?
 63. Уурхайн ажиллагааны үр дүнд, ямар нэг өмч хөрөнгө, бүүц, усны эх үүсвэр, хужир болон бусад бэлчээрийн хүртээмж алдагдсан үү? Тийм бол чухам аль нь вэ?
 64. Танай гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь ОТ-д ажилладаг уу, эсвэл ажиллаж байсан үү? Ямар ажил хийдэг эсвэл хийж байсан бэ? Амьжиргаанд нэмэртэй байна уу? Сэтгэл ханамж ямар байдаг вэ?
 65. Мал маллаж амьдрахад ирээдүй баталгаатай байж чадах уу?
 66. Ирээдүйн төлөвлөгөөнд чинь Оюу толгой уурхай нөлөө үзүүлж байна үү?
 67. Таны өдөр тутамд хамгийн ихээр сэтгэл зовоодог зүйлс юу вэ?
 68. ОТ уурхайн тухай хангалттай мэдээлэл байгаа юу? Үгүй бол ямар мэдээлэл дутагдаж байна вэ?
 69. Хамгийн сүүлд ОТ-н олон нийттэй харилцах хэлтсээс эсвэл ОТ-н төлөөлөл малчидтай хэзээ үулзсан бэ? Хэрвээ ОТ-той холбоотой ямар нэг асуулт, асуудал гарвал яадаг вэ? Асуудлаа шийдвэрлүүлж чаддаг үү? Хариултаа амархан авч чаддаг үү?
 70. Танайх өвөлжөөнөөсөө нүүгээд нэг л газраа очдог үү? эсвэл хаа сайгүй нүүдэг үү?
 71. Нөхөн олговор таны хувьд шударга байсан үү?
 72. Та нөхөн олговор авбал зохистой гэж бодож байна үү? Ер нь таны бодлоор хэн хамрагдах ёстой вэ?
 73. Таны бодлоор нөхөн олговор гэж юу байх ёстой вэ?

Хавсралт 2.1: Нүүдэл хөдөлгөөн

“Нэг газар очиход л манай өвөлжөө, манай хаваржаа гээд л нүүгээд, нэг газар нүүгээд очихоор ус нь байхгүй. Хоёр хоноод л ус байхгүй болоод нүүгээд явна. Манайх нэг газар очоод өдөртөө нүүж байсан ч удаа бий. Хоёр шалтгаан байна. Нэг нь бол ус байхгүй, нөгөө нь өөр айл байна, тэгээд нүүж байна”

“Цагаан сараас хойш танайх хэдэн удаа нүүсэн бэ” гэдэг асуултанд Жавхлант багийн нөхөн олговор аваагүй малчин “Цагаан сараас хойш бид нүүгээгүй. Нүүх газар олдохгүй байна. Манайх хаваржаагаа Оюу Толгойд алдсан, одоо хаваржаа байхгүй. Манай хаваржаа нисэх буудлын хавьцаа байсан юм.” гэж хариулсан ба судлаач “Ер нь танайх жилдээ хэдэн удаа нүүдэг вэ?” гэж хариу асуухад малчин “Одоо зуны бэлчээрийн бууц руу нэг удаа л нүүдэг болсон. Өөр арга байхгүй, ОТ-г тойрсон айлуудад бэлчээр алга. Манайх өвөлжөө, зуслангийн хооронд л нүүдэг” гэв.

Жавхлант багийн нэг малчин “Мал маллана гэдэг баталгаатай амьжиргаа байхаасаа өнгөрсөн. Уг нь баталгаатай л байлаа, тийм байсан юм шүү. Одоо нүүж бүүгаад малаа бэлчээрлүүлэх газар байхгүй. Цас орох юм бол бүүр асуудалтай. Амьдралын баталгаа байхгүй болсон. Өнөөдөртөө малынхаа дэргэд байж л байна, бороо орохгүй, өвс гарахгүй болманайх хэдхэн малтай, тэгээд л энд харзнаж сууна даа ...”

Жавхлант багийн малчны мэдээлэл

Хишгээ (нэрийг өөрчлөв) 32 настай, 2 хүүхэдтэй. Нэг хүүхэд 8^p анги, нөгөө нь 11 сартай. 2002 онд тэднийх ОТ-н УЛТ-н баруун талд нутаглаж, тэмээ нь нисэх буудлын ойролцоо бэлчээрлэдэг байв. Энэ хавьд бүүх аргагүй, айлууд зай завсаргүй шавчихсан, бэлчээр хүрэлцэхгүй. 2010 оноос нөхрийн хамт нүүн, Баян Овоо, Цогт-Цэций, Ханбогдын зааг хавийн бэлчээрийг ашиглах болжээ. Өнгөрсөн жил байнгын бууц олж чадаагүй, түж машиндаа амьдарсан. Өөр сумын нутагт очиход тэндхийн малчид ус хэрэглэхэд 100,000 төгрөг, бууцанд нь бүүхад 1 сая орчим төгрөг нэхдэг. Өөр газрын хүмүүс тун таагүй ханддаг, бэлчээрт нь орохоор орилж хашгирч хөөдөг байсан гэв.

“Одоо манайх нүүхээ больсон. 2014 онд Духт руу нүүгээд очтол тэнд бэлчээр байгаагүй тул Цогт-Цэций рүү нүүсэн. Тэгж яваад машины осолд орсон. Тийшээ яваад очтол хүмүүс та нар өөрсдийнхөө сайхан газрыг нутгийг зарчихаад юу хийж яваа юм, эндээс зайл гэж хэлж байсан, тэгээд буцаж ирснээсээ хойш дахиж нүүгээгүй ээ.”

Хавсралт 2.3: Дөрвөн багийн малчид болон эчнээ малчид 2015 он

Багийн нэр	Малчин айл өрх		Эчнээ малчин өрх		Нийт өрх
Номгон	59	46.8%	67	53.2	126
Гавилууд	107	58.2%	77	41.8	184
Жавхлант *	95	56.5%	73	43.5	168*
Баян	88	52.4%	80	47.6	168
НИЙТ	349	54%	297	46	646

*Тайлбар: Жавхлантын 29 өрхийн мэдээлэл дутуу тул оруулаагүй болно.

Эчнээ малчдын өвөлжөө, хаваржаа 2015 он

Нэр	НИЙТ Өрх	Өвөлжөөний бууц		Хаваржааны бууц		Өвөлжөө & Хаваржааны бууц		Өвөлжөө, хаваржаа аль аль нь байхгүй	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Номгон	67	20	29.9%	1	1.5%	6	9%	40	59.6%
Гавилууд	77	8	10.4%	4	5.2%	3	3.9%	62	80.5%
Жавхлант	73	33	45.2%	0	0	6	8.2%	34	46.6%
Баян	80	11	13.8%	8	10%	15	18.8%	46	57.4%
НИЙТ	297	72	24.2%	13	4.4%	30	10.1%	182	61.3%

- Эчнээ малчдын ихэнхэд нь өвөлжөө, хаваржааны бууц байхгүй.

Хавсралт 2.4: Өрхийн орлого

Сум руу л оруулж зарна. Зарах санаа бол их байна. Зарагдахгүй байна.Одоо мөнгөтэй хүн байхгүй болсон юм уу, худалдан авах чадвар муудчихсан. Сүүлийн хоёр жил бол эрс муудсан. Энэ Оюутолгой цагаан идээ аваад байсан яасан бэ дээ? Ганц жил аваад байхгүй болсон. Манай цагаан идээний мөнгө өгөөгүй.

“Хүүхэд сургуульд орох, оюутан явах. Оюутны төлбөр, байрны түрээс маш өндөр болсон байна ш дээ одоо. Жирийн малчид бол дийлэхээргүй болсон байна. Зээлээс зээлийн хооронд л байна даа. Нөгөө хүүхдүүдээ бусдаас дутаахгүй гээд л зүтгэх юм. Ядахдаа тарган тэмээ авахаа байчихаж, дандаа туранхай зовлого авдаг болчихсон. Мал өсгөж болж байна, зах зээл байхгүй болохоор мал өсгөөд нэмэр алга. Зах зээл байхгүй болохоор чинь нэмэр алга байна. Түүхий эд үнэгүй болохоор бид нар нам зогсчих юм.” – Номгон багийн малчин

Орлого олдог зүйлс	Залуу гэр бүл (20-35 насны) 364 малтай, 3 том хүн, 1 хүүхэд.	Дунд насны гэр бүл (36-55 насны) 399 малтай, 2 том хүн, 3 хүүхэд	Настай гэр бүл (56+ насны) 31 малтай, 3 том хүн, 5 хүүхэд. ⁴⁴
Ноолуур	6.5 сая Т	7 сая Т	6 сая Т ноолуур & тэмээний ноос нийлээд
Тэмээний ноос	30,000	1 сая Т	
Хонины ноос	48,000	байхгүй	180,000 Т
Ааруул	байхгүй	1 сая Т	Тийм – гурил, будаагаа авахад хангалттай
Айраг, сүү	18 л сүү/өдөрт		Тийм, бага хэмжээтэй
Арьс шир, мах	10 ямаа, 1 тэмээ, 2 үнээ	3 сая Т	3 тэмээ 10 бог
Тэтгэвэр	байхгүй	байхгүй	200,000Т (18 сарын урьдчилгаа авсан)
Цалин	Сувилагч (эхнэр нь)	байхгүй	2011 онд нөхөн олговор авсан

⁴⁴ Энэ айл өөр нэг айлтай бууцаа хуваадаг, мал нь цугтаа байдаг, энэ нь ноолуур, тэмээний ноосны орлогод тусгагдсан.

Баримт Хамтран Олж Тогтоох
Малчдын Амьжиргаа, Орон Нутгийн/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с учруулж буй нөлөөлөл
ОТМШБ Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд
2017 оны 1 дугаар сар

Хүүхдийн төлбөр	20,000Т/сард	байхгүй	байхгүй
Зээл	Малчны болон цалингийн зээл	10 сая Т малчны зээл	байхгүй
Зардлын зүйлс	Залуу гэр бүл (20-35 насны)	Дунд насны гэр бүл (35-50 насны)	Настай гэр бүл (50+ насны)
Сургуулийн төлбөр	байхгүй	2 сая, 2 хүүхдийн сургалтын төлбөр 250,000Т/сардаа	Сургуулийн насны 4 ач зээгээ тэтгэдэг
Шатахуун	100,000/сардаа	45,000Т/сардаа	50 л/сардаа
Хоол, гэр аж ахуйн бараа	50,000 гурил, 25,000 будаа, 3000 төмс, сонгино (сардаа)	тодорхойгүй	50,000 гурил/сард
Гар утас	15,000-20,000/сард	тодорхойгүй	60,000 Т/сард
Эмчилгээний зардал	250,000 эм	тодорхойгүй	20,000 Т/сард
Аялал	800,000	тодорхойгүй	тодорхойгүй
Мал эмнэлгийн зардал	50,000	тодорхойгүй	80,000 Т/жилд
Малын тэжээл	10 уут будаа, 20 боодол өвс	тодорхойгүй	байхгүй
Цагаан сарын баяр	500,000	тодорхойгүй	2 сая Т.
Нүүрс	35,000-50,000	тодорхойгүй	байхгүй

2016 оны үнэ:

Ноолуур: 65,000Т/кг

Тэмээний ноос: 2500-3000Т/Кг

Хонины ноос: 300Т/Кг

Ямаа, тэмээ, адууны мах: 3000Т/кг

Хонины мах: 3500/кг

Үхрийн мах: 4000/кг

Адууны шир: 25,000
Тэмээний шир: 15-20,000
Хонины нэхий: 8-10,000
Ямааны арьс: 15-20,000
Үхрийн шир: 35-40,000

Тэмээний ааруул: 25,000/кг

*“Бид бүгдээрээ хоршооны гишүүн. Хоршооны гишүүн биш бол түүхий эдийн урамшуулалд орохгүй гээд, бүгдийг нь хоршооны гишүүд болгочихсон. Ноосоо хямдхан авчихаад урамшууллын мөнгө нь орохгүй байна. Орсон ч тэмээний ноос орлоо гэхэд хонины ноос орохгүй байна. Ноднин, уржнангийн ноосны урамшуулал ерөөсөө ороогүй, ямар айлынх ороод ямар нь орохгүй байдаг юм мэдэхгүй, заргалдаад хаашаа заргалдахаа мэдэхгүй байна. Зүгээр 6000 –гаараа өгөөд мөнгөө бөөн авбал тэр нь бидэнд илүү. Оюутолгой нэг юм өгөхөөрөө заавал хоршоогоор дамжуулж өгнө гэдэг. Тэр гэр орон зөндөө л юм өгсөн юм байна лээ. Хоршоогоороо дамжуулж өгсөн юм гэсэн. Зөндөө л юм өгдөг. Тэгээд хоршоо нь ахиад зарна гэнэ... Хэдхэн ганзгын наймаачид л байгаа юм. Хоршоогүй шууд малчид өөрсдөө л харьцмаар байгаа юм. Бид нар бол зүгээр л нэг хоршоог хөлжүүлж байна.”
Номгон багийн малчин.*

Хавсралт 2.5: Судалгаа ба Итгэл

“Олон л хүн ирж судалгаа, шинжилгээ хийдэг. Бид үнэндээ тэдэнд итгэхээ больсон. Би хүмүүсээс өөрийн тань тухай асуулаа, нээрээ л ОТ-д хамаагүй юм шиг байна. Та жинхэнээсээ хөндлөнгийн бие даасан судлаач уу? ОТ-д ч ажилладаггүй, малчдад ч ажилладаггүй юу? Бусад судлаачид ОТ-д ажилладаг бололтой санагддаг. Эхэндээ бид өөрт тань итгээгүй ээ. Олон хүнээс асууж, лавласны эцэст нэээрээ чин сэтгэлээсээ ажиллаж байх шиг санагдаад ярилцах гэж энд ирлээ. Байр байдлыг сайн ярьж чадах хүмүүс нь дуугүй болчих юм. Тэдэнд магадгүй дарамт шахалт үзүүлсэн үү, эсвэл [дуугүй байхынхаа төлөө] мөнгө авсан уу. Одоо ч үнэнчээр ажиллахад бэрх болжээ. Би л лав итгэхээ больсон.”
– Баян багийн малчин

Хавсралт 2.6

Нөхөн Олговор авсан Өрхүүдийн Малын Тоо 2010 – 2015, Ханбогд сумын бүртгэл (ОТ-с өгсөн жагсаалт)

Нэр	Баг	Нөхөн олговрын он	2010 нийт	2015 нийт
1	Гавилууд	2011	293	597
2	Вауан	2011	327	964
3	Жавхлант	2011	276	195
4	Баян	2011	208	Нэр нь бүртгэлд байхгүй
5	Баян	2011	288	282
6	Баян	2011	189	267
7	Жавхлант	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	250
8	Жавхлант	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	23
9	Баян	2011	125	199
10	Гавилууд	2011	217	279
11	Жавхлант	2011	264	304
12	Javkhlant	2004, 2011	43	9
13	Гавилууд	2011	430	297
14	Баян	2011	154	157
15	Жавхлант	2011	185	495
16	Гавилууд	2011	149	202
17	Номгон & Гавилууд (2015)	2011	63	157
18	Гавилууд	2011	232	353
19	Жавхлант	2011	201	Нэр нь бүртгэлд байхгүй
20	Номгон	2011	183	76
21	Гавилууд	2011	52	88
22		2011	73	Нэр нь бүртгэлд байхгүй
23		2011	Нэр нь бүртгэлд байхгүй	274
24	Жавхлант	2011	901	991

Баримт Хамтран Олж Тогтоох
Малчдын Амьжиргаа, Орон Нутгийн/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с учруулж буй нөлөөлөл
ОТМШБ Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд
2017 оны 1 дугаар сар

25	Баян	2011	332	546
26	Баян	2011	168	71
27	Баян	2011	10	Нэр нь бүртгэлд байхгүй
28	Баян	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	50
29	Жавхлант	2011	280	552
30	Жавхлант	2011	100	149
31		2011	Нэр нь 2010 ба 2015 оны бүртгэлд байхгүй	
32	Жавхлант	2011	47	53
33	Жавхлант	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	384
34	Гавилууд	2011	145	165
35	Гавилууд	2011	172	355
36	Баян	2011	442	771
37	Номгон	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	181
38	Номгон	2011	93	150
39	Жавхлант	2011	239	443
40	Жавхлант	2011	60	248
41	Гавилууд	2011	73	350
42	Жавхлант	2004	94	187
43	Гавилууд	2011	83	202
44	Жавхлант	2004	825	1285
45	Жавхлант	2004, 2011	170	167
46	Гавилууд	2011	359	128
47	Жавхлант	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	475
48	Жавхлант	2011	308	220
49	Гавилууд	2011	298	212
50	Баян	2011	58	87
51	Жавхлант	2011	137	272
52	Жавхлант	2011	645	1017
53	Жавхлант	2011	85	160

Баримт Хамтран Олж Тогтоох
Малчдын Амьжиргаа, Орон Нутгийн/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с учруулж буй нөлөөлөл
ОТМШБ Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд
2017 оны 1 дугаар сар

54	Баян	2011	30	Нэр нь бүртгэлд байхгүй
55	Гавилууд	2011	34	67
56	Гавилууд	2011	25	80
57	Жавхлант	2011	269	156
58	Баян	2011	171	103
59	Жавхлант	2004, 2011	335	549
60	Номгон	2011	99	51
61	Гавилууд	2011	81	209
62	Жавхлант	2004, 2011	271	258
63	Гавилууд	2011	187	286
64	Баян	2011	136	134
65	Гавилууд	2011	148	31
66	Баян	2011	209	144
67	Нэр нь бүртгэлд байхгүй	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	Нэр нь бүртгэлд байхгүй
68	Жавхлант	2011	118	126
69	Жавхлант	2011	130	198
70	Жавхлант	2011	420	730
71	Номгон	2011	127	296
72	Жавхлант	2011	63	324
73	Гавилууд	2011	123	344
74	Номгон	2011	72	70
75	Баян	2011	66	23
76	Жавхлант	2004	60	132
77	Жавхлант	2011	46	107
78	Жавхлант	2011	267	444
79	Баян	2011	Нэр нь тодорхойгүй	771
80	Жавхлант	2004	587	384
81		2004, 2011	Нэр нь бүртгэлд байхгүй	Нэр нь бүртгэлд байхгүй
82	Жавхлант	2004, 2011	258	222
83		2011	60	248

Баримт Хамтран Олж Тогтоох

Малчдын Амьжиргаа, Орон Нутгийн/Бүсийн Усны Эх Үүсвэрт ОТ-с учруулж буй нөлөөлөл
ОТМШБ Бүрэлдэхүүн 2: Сүүлийн арван жилд малчдын хөрөнгө, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд
2017 оны 1 дугаар сар

84	Гавилууд	2011	19	Нэр нь бүртгэлд байхгүй
85	Жавхлант	2011	168	270
86	Жавхлант	2011	24	17
87	Номгон	2011	191	270
88	Жавхлант	2011	53	281
89	Бүртгэлд байхгүй	2011	Нэр нь бүртгэлд байхгүй	Нэр нь бүртгэлд байхгүй
90	Жавхлант	2011	49	Нэр нь бүртгэлд байхгүй
91	Гавилууд	2011	127	126
92	Жавхлант	2011	196	495
93	Гавилууд	2011	138	168

Хавсралт 2.7 Ашигласан хэвлэл.

2016 January 15. Oyu Tolgoi TSF Seepage Monitoring Report. Water Team, Environmental Department Quarterly Monitoring Report.

Ahearn, A. and D. Bumochir (2016). Contradictions in Schooling Children Amongst Mobile Pastoralists. *Human Organization* 75 (1), p. 87.

Avirmed, A., Gootiiz, B. and Tumurtolgoi, N. 2013 Population and Housing Census of Khanbogd soum, Umnugobi province. Sustainable Development Consulting, LLC.

Assessment of Changes Occurred to Sufficiency and Quality of Pasturelands of Khanbogd Soum's Herders' Households Involved in the Settlement Program and Suggestions. Center for Policy Research. 2012.

Baival, B., Jargalsaikhan, S., Tsevlee, A. 2014. Participatory Rangeland Monitoring Summary Report 2014: Manlay, Khanbogd, Bayan-Ovoo Soums of Umnugobi aimag. Nutag Partners, LLC.

Center for Policy Research. 2007. Oyu Tolgoi Project: Perceptions Study on Water Use in the Khanbogd soum

Center for Policy Research. 2008. "The Umnugobi aimag social, economic and environmental baseline study."

Chuluun, S. and G. Byambaragchaa. 2014. Satellite Nomads: Pastoralists' Tactics in the Mining Region of Mongolia. *Inner Asia* 16, 409-426.

Dalaibuyan, B. and B. Namkhai. 2014. Oyu Tolgoi LLC Resettlement Action Plan (RAP) External Completion Audit.

Evaluation of the Environmental and Social Impact Assessment (ESIA) for the Oyu Tolgoi Copper and Gold Project. Environmental Law Alliance Worldwide. 2012.

Environmental & Social Compliance Monitoring. Oyu Tolgoi Mine Project, Independent Environmental & Social Consultant (IESC). D'Appolonia. October 2013.

Environmental Impact Assessment Report For The Oyu Tolgoi Project, Mining And Processing. Eco-Trade. 2006.

Fernandez-Gimenez, M. and B. Batbuyan. 2004. Law and Disorder: Local Implementation of Mongolia's Land Law. *Development and Change* 35, 1, 141-165.

Gunchinsuren, B., Altschul, J.H., Olsen, J.W. Report on the Phase 1 activities of the OT Cultural Heritage Program Design for Omnogovi Aimag. Document No. IMM033_CHP_201102 PHASE 1 REPORT_ENG_REV0.DOC

Jackson, S. (2015) Dusty roads and disconnections: Perceptions of dust from unpaved mining roads in Mongolia's South Gobi province. *Geoforum*. 66, p. 94-105.

Janes, C.R. and M. Wagler 2011 (February), Evaluation of the OT Community Health, Safety, and Security Impact Assessment.

Jigsuren et al. 2015. Evaluating the impact of climate change based on herders' observations and comparing it with hydro-climatic and remote sensing data. *Proceedings of the Transdisciplinary Research Conference: Building Resilience of Mongolian Rangelands, Ulaanbaatar*.

Ivanhoe Mines. 2004. Herder Relocation Report: Oyu Tolgoi Project.

Key to Business Success NGO. 2015. Report on Livestock Health Study Carried out in Khanbogd, Manlai, Bayan-Ovoo soums.

Oxford Business Group Report. 2014. Mongolia Business Report.

Oyu Tolgoi Social Performance Resettlement Action Plan. October 2015.

Oyu Tolgoi Construction Phase Environmental, Social, Health & Safety Audit. April 2013 Audit Report. Environmental Resources Management.

Oyo Tolgoi Regional Development and Social Performance Pastureland and Livelihood Improvement Strategy. 2013.

Oyu Tolgoi Regional Development and Social Performance, Pastureland Livelihood Improvement Strategy. 2013.

Oyo Tolgoi Non-Technical Summary: Environmental and Social Impact Assessment. 2012.

Oyu Tolgoi Project Socio- Economic Impact Assessment Final Report. 2009. Centre for Policy Research; Population Training and Research Centre

Mongol Ulsiin Khuuli Gazariin Tuhai 1994, 2002, Electronic resource, www.legalinfor.mn/law/details/216,

Жей Эс Эл Консалтинг Лтд. 38 Хэйфилд роуд, Оксфорд, ОХ 6ТТ, Их Британи
Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73
+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

accessed 7 August 2016.

Mongol Ulsiin Zasag Zakhirгаа, Nutag Devcgeriin Negj, Tuunii Udirdлагин Tuhai 1992, 2006, Electronic Resource, <http://legalinfo.mn/law/show/Print/7116>, accessed 7 August 2016.

Murphy, D. J. 2014. Ecology of Rule: Territorial Assemblages and Environmental Governance in Rural Mongolia. *Anthropological Quarterly* **83**, 3, 759-792.

Proposal for livestock support and pastureland management program in Khanbogd soum and evaluation and recommendation on compensation program for herders households impacted by the project. Center for Policy Research. 2012.

Report of the: Independent Environmental and Social Consultant, Oyu Tolgoi Mine, September 2015, pg 10.

Sharma, V. (2016). Human Security for Mongolian Herders: Evolving Risks and Opportunities. In *Understanding the Many Faces of Human Security* (pp. 230-250). Brill.

Spirited away- Mongolia's mining boom and the people that development left behind. 2011. OT Watch.

Sugar, G. 2008. Draft of report on small-scale study of herders' customary water arrangement within Gunii Kholoi

Suzuki, Yukio. 2013. Conflict between Mining Development and Nomadism in Mongolia. In *The Mongolian Ecosystem Network: Environmental Issues Under Climate and Social Changes*. P 269

1	УДИРТГАЛ	1
2	ХАМ СЭДЭВ: НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ, НӨХӨН ОЛГОВРЫН СТАНДАРТУУД БА ТУРШЛАГА	2
3	2004, 2011 ОНЫ НӨХӨН ОЛГОВРЫН ҮЙЛ ЯВЦАД АШИГЛАСАН НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ НЬ ЗОХИСТОЙ, ХАНГАЛТТАЙ БАЙСАН ЭСЭХ?	4
3.1.	Шалгуур	4
3.2.	2004 оны нөхөн олговортой холбоотой нөлөөллийн үнэлгээ	4
3.3.	2011 оны нөхөн олговрын үйл явц	9
3.4.	Ирээдүйд учрах нөлөөллийн үнэлгээ	14
4	ОТ ӨӨРИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛИЙН БАЯЛАГ АШИГЛАСАН ЗЭРГИЙГ ОРОЛЦУУЛАН ОТ-Н УЛМААС УЧИРСАН СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮДИЙГ ХАНГАЛТТАЙ НӨХӨН ТӨЛСӨН ҮҮ?	15
4.1.	Дэд бүтэц	15
4.2	Ус	15
4.3	Сэтгэл санааны нөлөөлөл	16
4.4	Соёлын өв	17
4.5	Зөвлөмжүүд	17
5	НӨХӨН ОЛГОВОР АВБАЛ ЗОХИХ БҮХ МАЛЧДАД НӨХӨН ОЛГОВОР ОЛГОСОН УУ?	18
5.1	Цоорхой	18
5.2	Зөвлөмж	20
6	ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААНД ШИЛЖИХЭД ХАНГАЛТТАЙ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОГДСОН УУ?	21
6.1	Ямар нөхөн олговор олгосон бэ?	21
6.2	Тогтвортой амьжиргаанд шилжих шилжилт - 2004	22
6.3	Тогтвортой амьжиргаанд шилжих шилжилт - 2011	25
6.4	Бэлчээрийн нийт хүртээмж буурсны нөхөн төлбөр –нийтийн нөхөн төлбөр	27
7	НӨХӨН ОЛГОВРЫН ҮЙЛ ЯВЦ НЬ ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН 5-Р (ОУСК-ИЙН ГС5) СТАНДАРТАД НИЙЦСЭН ҮҮ?	28
7.1	ОУСК-ийн 5-р Гүйцэтгэлийн Стандартад юу шаарддаг вэ?	28
7.2	Гүйцэтгэлийн Стандарт 5-тай нийцэж буй байдал	29
7.3	Зөвлөмжүүд	31
ХАВСРАЛТ 1:	АЖЛЫН ДААЛГАВАР: НӨХӨН ОЛГОВРЫН ХӨТӨЛБӨРИЙГ ХЯНАХ	32

1 Удиртгал

Энэ тайлан нөхөн олговрын тухай болно. Энд ажлын даалгаварт¹ тодорхойлсон дараах асуудлуудыг авч үзлээ. Үүнд:

1. 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцад ашигласан нөлөөллийг үнэлэх аргачлал нь зохистой, хангалттай байсан эсэх;
2. ОТ өөрийн хэрэгцээний дэд бүтэц, байгалийн баялаг ашигласан зэргийг оролцуулан ОТ-н улмаас учирсан сөрөг нөлөөллүүдийг хангалттай нөхөн төлсөн эсэх;
3. Олгосон нөхөн олговор нь тогтвортой амьжиргаанд шилжихэд хангалттай байсан эсэх;
4. Нөхөн олговор авбал зохих бүх малчдад нөхөн олговор олгосон эсэх;
5. Нөхөн олговрын үйл ажиллагаа нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн 5-р стандартад нийцсэн эсэхийг тус тус тогтоох болно.

Эдгээр асуудлуудыг авч үзэхийн тулд ГТЗ-тэй тохиролцсоны дагуу бичиг баримтуудтай танилцах, малчид, ОТ, сумын албан тушаалтнуудтай уулзаж мэдээлэл цуглуулах, бэлчээр, усны судалгаа болон нийгэм-эдийн засгийн асуулгын үр дүнг судлах зэрэг аргуудыг хавсруулан ашиглалаа.² ОТМШБ-ийн судалгааны Бүрэлдэхүүн 3-ийн ажлын даалгаврыг Хавсралт 1-д харуулав.

2016 оны 2 сард Ханбогд суманд болсон Баримт Хамтран Олж Тогтоох сургалтын үеэр ГТЗ-ийн малчдын бүлэг нүүлгэн шилжүүлсний улмаас настай малчдад учирсан сэтгэл санааны хохирлыг үнэлж үзэх хүсэлтийг шинжээчдэд тавьсан.

Судалгааны явцад болон судалгаа эхэлсний дараа ГТЗ дэх малчдын бүлэг нөхөн олговрын гэрээний доор дурьдсан заалтуудад анхаарлаа хандуулахыг мөн хүссэн билээ. Үүнд:

- “Гэрчилгээ эзэмшигчийн хууль ёсны эхнэр нөхөр, төрсөн эсвэл албан ёсоор үрчилж авсан хүүхэд хэн боловч Гэрчилгээ эзэмшигчийн гэр бүлийн гишүүн болж болох ба Компанид бичгээр мэдэгдсэнээр (гэр бүл бологсдийн, төрсний эсвэл үрчилж авсан албан ёсны баримт бичгийн хамт) тухайн тохиолдлыг Хавсралт 1-ийн жагсаалтад нэмж оруулж болно.” (2004 оны нөхөн олговрын гэрээний заалт 3.2).
- “Төслийг дэмжих дэд бүтцийн байгууламжуудын барилгын ажил ба үр дагавар, дэд бүтцийн ашиглалтын улмаас бий болсон бөгөөд энэхүү Гэрээнд тодорхойлж оруулаагүй сөрөг нөлөөлөлд нөхөн төлбөр олгохыг Компаниас нэхэх, тэдгээр сөрөг нөлөөллийг судлах, бууруулах, хянах арга хэмжээ авахыг Компаниас шаардах” (2011 оны нөхөн олговрын гэрээний заалт 5.4.)”.

Малчдын бүлэг урьдчилсан тайлантай танилцаад :

¹ Ажлын Даалгавар, ‘Монгол улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын малчин өрхүүдийн нийгэм-эдийн засгийн судалгаа’.

² Хянагдсан эхний явцын тайлан, 2016 оны 4 сар .

- ОУСК-ийн Гүйцэтгэлийн Стандарт 5-ийн шаардлагуудад ОТ нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийх, ингэхдээ ядуу болон эмзэг хүмүүст онцгой анхаарал хандуулах хүсэлт тавьсан.³
- ОТ-н нөлөөллийн үнэлгээний үйл явц хангалттай байсан эсэхэд дүн шинжилгээ хийхдээ соёлын нөлөөллийг орхигдуулсан гэж үзсэн.

Эдгээр сүүлийн асуудлууд Ажлын Даалгавар ба ГТЗ-тэй тохиролцсон ажлын төлөвлөгөөнд ороогүй байсан тул ярилцлага, уулзалтын үеэр ярилцлагч эсвэл зорилтот бүлгийн уулзалтанд оролцогсад хөндсөнөөс өөрөөр хамраагүй болно. Малчдын бүлэг аль ч асуудлаар шинэ мэдээлэл өгөөгүй. Хэдийгээр бид Хэсэг 4.4, 7.2.2-т аль аль асуудлаар нь зарим нэг ажиглалт хийсэн ч дүгнэлт гаргах бидний боломж хязгаарлагдмал байна.

ОТ урьдчилсан тайлантай танилцаад, бэлчээр сайжруулах, малчдын бизнесийг дэмжихтэй холбоотойгоор Ханбогд сумын Мал Аж Ахуйн Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөртэй (10 жил)⁴ танилцахыг биднээс хүссэн. Ингэснээр нийтийн нөхөн олговрын талаарх бидний урьдчилсан дүгнэлтэнд өөрчлөлт орсон болно. Хэсэг 6.4-ийг үзнэ үү.

2 Хам сэдэв: Нөлөөллийн үнэлгээ, нөхөн олговрын стандартууд ба сайн туршлага

Оюу Толгой мэтийн уул уурхайн том төслүүд гол төлөв нөлөөллийн үнэлгээ, нүүлгэн шилжүүлэлтийн талаарх үндэсний хууль тогтоомж болон олон улсын стандартууд, тэргүүн туршлагыг даган мөрдөх зорилго тавьдаг. ОТ-г эхлээд удирдаж байсан Айвенхоу Майнз Монголиа Интернэшнл болон одоогийн Рио Тинто аль аль нь үндэсний болон олон улсын стандартуудыг хангахыг эрмэлздэгээ илэрхийлдэг.

ОТ төсөл эхэлснээс хойш үндэсний болон олон улсын хууль, стандартуудад чухал өөрчлөлтүүд орсон.

- Монгол улс дахь уул уурхайд хэрэглэх байгаль орчны үнэлгээний хууль анх 1998 онд батлагдсанаас хойш 2001 ба 2012 онуудад хоёр удаа өөрчлөлт хийгджээ.
- Дэлхийн Банк 1990-ээд онд “Хамгааллын Бодлогууд” батлан гаргаж, үүний дараа 2006 онд ОУСК нийгэм, байгаль орчны гүйцэтгэлийн нарийн бодлогууд батлан, 2012 онд тэдгээрт нэмэлт өөрчлөлт хийсэн. 2016 оны 8 сард Дэлхийн Банк “Нийгэм, Байгаль Орчны Баримт Бичгүүд” шинээр гаргажээ.⁵

1990-ээд оноос хойш орсон гол өөрчлөлтүүдийг дурьдвал:

- Анх нөлөөллийн үнэлгээ нь дийлэнхдээ төслийг засгийн газраар батлуулах зөвшөөрөл авах хэрэгсэл байв. Одоо цагт нөлөөллийн үнэлгээг хийхдээ төслийн нийт хугацааны

³ ОУСК ГС5, 8-р заалт, “Төслийн зураг төсөл. Зээлдэгч нь биет болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийж, бууруулахын тулд төслийн зураг төслийн өөр үндэслэлтэй хувилбарыг авч хэрэгжүүлэх тал дээр анхаарахаас гадна, байгаль орчин, нийгэм санхүүгийн өртөг ба үр ашгийн тэнцвэрийг хадгалан ядуу, эмзэг хүмүүст учрах нөлөөлөлд онцгой анхаарал тавина.”

⁴ Ханбогд сумын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, 2016-2025

⁵ <http://www.worldbank.org/en/news/press-release/2016/08/04/world-bank-board-approves-new-environmental-and-social-framework>

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

Албан бус орчуулга – Орчуулгын утга зөрж байвал бичиг баримтын эх хувийн утгыг баримтлана.

туршид түүний учруулах нөлөөллүүдийг хэрхэн бууруулах, удирдах, хянах вэ гэдэгт түлхүү анхаарах болсон.

- Өөрчлөлт тус бүрт – үндэсний, олон улсын аль аль нь – олон нийтийн оролцоонд ихээхэн ач холбогдол өгсөн болно. ОУСК-ийн Нийгэм, Байгаль Орчны Гүйцэтгэлийн Стандартуудад энэ нь “мэдээллээр хангагдсан зөвлөлдөөн, оролцоог” хэрэгжүүлэх шаардлагыг агуулж байна⁶. Үүгээр хамааралтай талуудыг тодорхойлон; орон нутгийн иргэдийн бүлэг тус бүрт учирч болохуйц эерэг ба сөрөг нөлөөллүүдийг ойлгуулах; нөлөөллүүдийг ойлгох, тэдгээрийг удирдах, мониторинг хийхэд нөлөөлөлд өртөж болохуйц хувь хүмүүс, иргэд хувь нэмрээ оруулах; төсөл болоод түүний нөлөөллүүдийн талаарх мэдээллийг байнга ил тод болгох, мөн харилцахад ойлгомжтой, хүртээмжтэй гомдлын механизмтай байхыг шаарддаг.
- Эхэндээ нүүлгэн шилжүүлэлтийн стандартууд төслөөс газрыг нь авсан хүмүүст бэлэн мөнгөөр нөхөн олговор олгоход анхаарч байв. Дэлхийн Банкны анхны хамгааллын бодлогуудаас эхлээд мөнгөн олговор ихэнхдээ нөлөөлөлд өртсөн хүмүүст сайн зүйл авчирдаггүй тул тэдэнд бэлэн мөнгө өгснөөс өөр газар эсвэл орон байр олгосон нь дээр гэдэг ойлголт байнга байдаг байсан.
- Цаг хугацааны явцад төслүүд аль болохоор газар чөлөөлж авах явдлыг багасгах; нүүлгэн шилжүүлэлтийн шийдвэр гаргахад нөлөөлөлд өртсөн хүмүүсийг оролцуулах; “эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт” гэх мэт хүмүүс газрыг эдийн засгийн үндэслэлээр ашиглах явдалд төсөл нөлөөлөл учруулах аваас нөхөн олговрын (мөнгөн бус) өөр арга зам хайх; хүмүүс эдийн засгийн хувьд хараат бус болж, урт хугацаанд төсөлд найдахгүй болгохын тулд амьжиргаа сэргэх явц хэрхэн ахиж буйд мониторинг хийх; төсөл оршин байснаар орон нутгийн иргэдэд өгөөж нь хүрэх арга замыг хайхыг илүүтэй анхаарч шаарддаг болсон. Үүнийг “Амьжиргаа Нөхөн Сэргээх” төлөвлөгөөнд тусгадаг.
- 1990-ээд оноос уул уурхайн том компаниуд өөрсдийн бодлого, журам, арга барилаа стандартуудын өөрчлөлтөд зохицуулан боловсруулах болжээ.

Хууль, стандарт, компанийн бодлого зэрэгт гарсан өөрчлөлтүүд нь уул уурхайгаас орон нутагт үзүүлэх сайн муу төрөл бүрийн нөлөөллүүдийн тухай ойлголт өргөжиж байгааг, сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл бууруулах, өгөөжийг ихэсгэхийн тулд уул уурхайн компаниуд, нутгийн иргэд, орон нутгийн засаг захиргаа байнга нээлттэй харилцаа холбоотой байхын ач холбогдлыг тусган харуулж байна. Уул уурхайн төсөл бүр өөрийн техникийн үзүүлэлт, цаг хугацаатай, орон нутгийн иргэд, засаг захиргаа бүрт өөрийн гэсэн эн тэргүүний асуудал, санаа тавих зүйлс бий. Түүнчлэн хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхдээ эсвэл газар, баялагийн хүртээмж багассаны нөхөн төлбөрийг олгохдоо тогтвортой байдлыг хангана гэдэг хэцүү болохыг улам сайн ойлгох болжээ⁷. Үүний тулд уул уурхай ба нутгийн иргэд бусад төслүүдийн хүримтлагдах нөлөөлөл эсвэл засгийн газрын бодлогын өөрчлөлт гэх мэт хувьсан буй нөхцөл байдлыг харгалзсан нарийн төлөвлөлт хийж, өргөнөөр хэлэлцэн, дасан зохицох менежмент хийх шаардлагатай.

ОТ-н нөлөөллийн үнэлгээ, нөхөн олговрын арга нь үндэсний болон олон улсын стандарт, туршлагын хөгжилтэй өргөнөөр зэрэгцэн боловсруулагдсан гэж үзэж байна. Энэ юу гэсэн үг вэ

⁶ ОУСК ГС1, заалт 31-ийг үзнэ үү.

http://www.ifc.org/wps/wcm/connect/topics_ext_content/ifc_external_corporate_site/ifc+sustainability/our+approach/risk+management/performance+standards/performance+standards++2012

⁷ Жишээ нь, Айвенхоу Майнс Монголиа Инк, Газар чөлөөлөлт, Нүүлгэн шилжүүлэлт: Авсан Сургамжууд-ыг үзнэ үү. <http://www.icmm.com/publications/pdfs/9714.pdf>

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

гэхээр 2006 оноос өмнө хийгдсэн нөлөөллийн үнэлгээ, нүүлгэн шилжүүлэх ажиллагаа нь ОУСК-ийн Нийгэм, Байгаль Орчны Гүйцэтгэлийн Стандартууд 2006 онд гарахаас өмнө хэрэгжиж дууссан гэсэн үг. Гэхдээ ОУСК 2013 оны 2 дугаар сард ОТ-д хөрөнгө оруулалт хийхээр баталсан. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас өмнө 2012 оны 8 дугаар сард ОУСК-аас нийтэлсэн Байгаль орчин, нийгмийн хяналтын хураангуйд (БОНХХ) ОУСК-ийн 2006 оны Гүйцэтгэлийн Стандартуудын дагуу ОТ төслийн баримт бичгүүдийг бэлтгэнэ гэсэн бөгөөд харин ОТ 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон шинэчлэгдсэн Гүйцэтгэлийн Стандартуудыг⁸ даган мөрдөнө гэсэн байна. Энэ нь тухайн үед мөрдөгдөж байсан стандартуудын дагуу авсан арга хэмжээ нь тэр үед байгаагүй стандартуудын шаардлагыг одоо хангах хэрэгтэй болсон гэсэн үг.

3 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцад ашигласан нөлөөллийг үнэлэх аргачлал нь зохистой, хангалттай байсан уу?

3.1 Шалгуур

Зохистой, хангалттай нөлөөллийн үнэлгээ нь дараахь шинж чанарыг агуулдаг. Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргаа, амьдралын стандартын талаар дэлгэрэнгүй суурь мэдээлэл өгнө.
- Учирч болохуйц нөлөөллүүдийг тодорхойлсон байна.
- Сөрөг нөлөөллөөс зайлсхийх эсвэл хязгаарлах; зайлсхийх аргагүй сөрөг нөлөөлөлд нөхөн олговор олгох; яг бодитоор юу болж байгаад мониторинг хийх арга хэмжээг санал болгоно.
- Уг үйл явц нь нөлөөлөлд өртсөн байж болзошгүй хүмүүс болон холбогдох мэдлэг эсвэл нөлөө бүхий бусад хамааралтай талуудтай хамт судалгаа хийж, зөвлөлдөх зэргийг хамарна.

Түүнчлэн, хэрвээ хүмүүсийг биетээр нүүлгэн шилжүүлэх шаардлагатай эсвэл тухайн төсөл газрыг ашигласны улмаас хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болгож байгаа бол, дараах агуулга бүхий Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (НШТ) ба/эсвэл Амьжиргааг Нөхөн Сэргээх Төлөвлөгөөг (АНСТ) бэлтгэж, зохих мониторингийг хийдэг:

- Нөлөөлөлд өртсөн тодорхой хүмүүс, газар, газар ашиглалтыг тодорхойлж нүүлгэн шилжүүлэлтийг хамгийн бага, минимум хэмжээнд хийхийг хичээх.
- Өөр хувилбаруудын талаар нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөх.
- Амьжиргаа болон амьжиргааны түвшнээ хадгалах (эсвэл сайжруулах) боломжийг хүмүүст бүрдүүлж өгөхийн тулд нөхөн олговор тогтоох.
- Нүүлгэн шилжүүлэлт болон амьжиргааг нөхөн сэргээхтэй холбоотой аливаа асуудал болон гомдлыг шийдвэрлэх гомдлыг барагдуулах механизмыг бий болгох.

НШТ эсвэл АНСТ нь нөлөөллийн үнэлгээний баримт бичгийн нэг хэсэг байдлаар боловсруулагдсан байх эсвэл тусгай баримт бичиг байдлаар боловсруулагдсан байж болно.

3.2 2004 оны нөхөн олговортой холбоотой нөлөөллийн үнэлгээ

⁸ <http://ifcext.ifc.org/ifcext/spiwebsite1.nsf/ProjectDisplay/ESRS29007>

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

3.2.1 Хэнд 2004 онд нөхөн олговор олгосон бэ?

2004 оны нөхөн олговрын үйл явц нь уурхайн лицензит талбай (УЛТ) эсвэл уурхайн талбайгаас нөлөөллийн бүс тооцох байршлын хязгаарлалт болох 10 км дотор байрлаж байсан өвөлжөөний бууцаа алдсаны нөхөн төлбөр авсан арван зургаан айлаас бүрдэх арван өрхийг хамарсан байна.⁹ (Удалгүй нэг өрх хуваагдаж, одоо энэ бүлэгт 11 өрх харъяалагдаж байна.¹⁰) Айвенхоу Майнс Монголиа Инк нь үнэлгээ болон нүүлгэн шилжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн. “Тухайн газартаа дасах, хүндрэлтэй нөхцөл байдалтай тулгарсан” учраас нэмж гурван өрхөд өвөлжөөний бууц, малын хашаа хороо барьж өгсөн гэж 2011 оны НШТ-д дурдсан байна.¹¹

3.2.2 Нөлөөллийн үнэлгээ ба Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (НШТ)

Оюу Толгойн хайгуулын хөтөлбөр 1999 онд эхэлсэн бөгөөд түр кемп барих ажил зэрэгт 500 орчим ажилчид ажиллаж эхэлсэн байна. Бидний олж тогтоосноор хайгуулын нөлөөллийн үнэлгээ гэж хийгдээгүй, хайгуулын улмаас биет эсвэл эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийгдээгүй ажээ.

Хайгуул амжилттай хийгдэж, улмаар уурхайн бүтээн байгуулалтын нөлөөллийн үнэлгээг Байгаль Орчны Нөлөөллийн Байдлын Нарийвчилсан Үнэлгээ (БОНБНУ) нэрээр 2006 онд боловсруулж Байгаль Орчны Яаманд илгээсэн байна.¹² Энэхүү баримт бичигт яамнаас шаардсан нийгэм, байгаль орчны асуудлын судалгаа, тухайлбал 2003 онд хийгдсэн Нийгэм-Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ¹³ зэргийг хамруулжээ (Хавсралт 3-т БОНБНУ-ний бүрэлдэхүүн хэсгүүдийг жагсаасан). Нийгэм, эдийн засгийн үнэлгээний хүрээнд ОТ-н уурхайн талбайгаас 20 км-ийн радиуст оршин сууж буй бүх өрхийн тооллогын дүнд үндэслэн 2004 оны нөхөн олговор авсан өрхүүдийг тодорхойлсон байна. Тооллогын аргачлалыг тайлбарлаагүй; БОНБНУ нь 2001-2 онд явуулсан суурь судалгааг дурьдсан хэдий ч¹⁴ зөвхөн БОНБНУ-д оруулсан мэдээллээс өөр эдгээр судалгааны суурь тайлан ОТ-д байхгүй байна.

Нүүлгэн шилжүүлэлтийн шалтгаан, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн суурь нөхцөл байдал, зөвлөлдсөн үйл явц, тусламж авах эрх, мониторинг болон гомдлыг барагдуулах үйл явцыг системтэйгээр баримтжуулж тусгасан 2004 оны Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө байхгүй боловч дараах зүйлсийн талаар баримтууд байна. Үүнд:

- Тодорхой он сар өдрийн тэмдэглэгээгүй “Оюу Толгойн Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлого” нэртэй Айвенхоу Майнсын дотоод баримт бичиг бий. “Оюу Толгойн Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлого”-д нүүлгэн шилжүүлэлтийг Дэлхийн Банкны стандартын дагуу хийж гүйцэтгэх ёстой, түүнчлэн уурхайн талбайгаас 10 км-ийн дотогш зайд арван хоёр өрх байна гэж тэмдэглэжээ.¹⁵

⁹ НШТ-ийн Хэрэгжилтийн Хөндлөнгийн Аудит 2004, Далайбуян ба Намхай, 2014 оны 9-р сар.

¹⁰ БОНБНУ-ийн баримт бичигт арван нэгэн өрхийг нүүлгэн шилжүүлсэн тухай дурдсан байна.

¹¹ 2011 оны НШТ, Хуудас.48.

¹² ОТ-н Төслийн Байгаль Орчны Нөлөөллийн Үнэлгээ, 3-р Боть, Уул уурхай ба Боловсруулалт, Эко-Трейд ХХК 2003 (Баримт бичгийн нүүр хуудас 2006 оны огноог харуулсан байна).

¹³ Нийгэм, эдийн засгийн үнэлгээ нь БОНБНУ-ийн IV Бүлэгт тусгагджээ.

¹⁴ Жишээ нь, БОНБНУ, II Хэсэг, Бүлэг 1, Хуудас.8

¹⁵ Айвенхоу Майнс Монголиа Инк., Оюу Толгойн Нүүлгэн Шилжүүлэлтийн Бодлого, он сар өдөргүй.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

- 2004 оны 8-р сард хийгдсэн “ Малчдын Нүүлгэн Шилжүүлэлтийн Тайлан” нь эрх бүхий хүмүүс болон нүүлгэн шилжүүлэх гэр бүлүүдтэй хийсэн хэлэлцээрийн үр дүнг тоймлон дурдаж нүүлгэн шилжүүлэлтийн төсвийг харуулжээ.
- БОНБНУ-д тусгагдсан “Малчдыг Дэмжих Төлөвлөгөө” нь “Тус хөтөлбөрийн зорилго нь төслийн талбай дотор буюу ойролцоо байгаа нүүдэлчин малчин айлуудын амьжиргааны аюулгүй байдал, хөгжлийг төрөл бүрийн багц дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар хянан баталгаажуулахад чиглэсэн болно” гэжээ.¹⁶

3.2.3 Нөлөөллийн үнэлгээ болон холбогдох баримт бичгүүдэд малчдад учруулсан нөлөөллийг хэрхэн тодорхойлсон байна вэ?

2003 онд хийгдсэн Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ нь Ханбогд сумын эдийн засгийн нөхцөл байдлыг уламжлалт нүүдлийн мал аж ахуйд суурилсан гэж зөв тодорхойлсон бөгөөд аймаг, сум, бусад харьцуулсан газрын албан ёсны статистикаас авсан суурь мэдээллийг тусгаж, 1999-2002 оны хугацаанд малчдын тоо, малын төрөл зэргийн он дараалсан чиг хандлагын мэдээллийг оруулсан байна. Нийгэм, эдийн засгийн үнэлгээ нь мал сүрэгт цаг уурын үзүүлж буй ерөнхий нөлөөлөл, сумын бэлчээрийн менежментийн хөтөлбөр, усны нөөцийн талаар өгүүлж, худаг сэргээн засварлах, ашиглаж буй худгийн ойр орчимд газар талхлагдан доройтсон зэрэг асуудал байгаа талаар тайлагнасан байна.

Нийгэм, Эдийн Засгийн Үнэлгээ нь 2003 оны 6-р сард Оюу Толгойг тойрон амьдарч буй өрхүүдийн зарим суурь мэдээллийг дурджээ. Тухайлбал бүгд “уламжлалт нүүдэлчин амьдралын хэв маягтай, мал малладаг айлууд”¹⁷ гээд өрх тус бүрийн ашиглаж буй худгийг тодорхойлон заажээ. Түүнчлэн Оюу Толгойн орчимд саяхан гурван өрх (нэг нь Жавхлант багаас, нөгөө хоёр өрх нь Баян-Овоо сумаас) нүүж ирснийг тодорхойлжээ. Мөн ОТ-оос 30 км-ийн зайд байрлах өвөлжөөний бууц, худгуудын байршлыг харуулжээ.¹⁸ Гэвч мал маллах арга ажиллагаа, эсвэл отор нүүдэл хийх эсвэл ус ашиглалтын тухай дэлгэрэнгүй дүрсэлсэн баримт бичиг (эсвэл баримтжуулахыг оролдож хичээсэн нотолгоо) байхгүй байна. Мөн зарим баримт бичигт 10 айлыг нүүлгэн шилжүүлэх эсвэл 2004 оны нөхөн олговрын гэрээний хүрээнд нүүлгэн шилжүүлсэн тухай өгүүлсэн бол зарим баримт бичигт 11, заримд нь 12 гэжээ.¹⁹

¹⁶ БОНБНУ, Хэсэг IV, Бүлэг 1, Хуудас.18.

¹⁷ БОНБНУ, Хэсэг 1, Бүлэг 4, Хуудас 9.


¹⁸ БОНБНУ, Хэсэг IV, Бүлэг 1, Хуудас.10.

¹⁹ БОНБНУ, Хэсэг II, Бүлэг 9, Хуудас.2. ба Хэсэг IV, Бүлэг 1, Хуудас.18 -д 11 айл; Малчдын Нүүлгэн Шилжүүлэлтийн Тайлан, Хэсэг 1.2-т ОТ-с 10 км-ийн дотор орших 12 малчин өрх байна гэж дурджээ.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman



2003 онд хамааралтай талуудын зарим зөвлөлдөөнийг хийжээ: 2003 оны 3-р сар болон 11-р сард Оюу Толгой, Ханбогд сум, Даланзадгад, Улаанбаатар хотуудад орон нутгийн удирдлага, сонгогдсон төлөөлөгч нартай уулзалтууд, мөн олон нийтийн хурлыг хоёр удаа зохион байгуулжээ. Эдгээр уулзалтуудын хоёр нь Оюу Толгойн кемп дээр малчидтай тусгайлан хийсэн уулзалтууд ажээ. Нийгэм, Эдийн Засгийн Үнэлгээнд 2003 оны 7-р сард малчидтай уулзалт хийсэн гэж тэмдэглэсэн боловч эдгээр уулзалтуудын талаар нэмэлт мэдээлэл оруулаагүй байна. Зөвлөлдөх уулзалтуудын явцад малчдын дахин дахин онцолж байсан зүйлсийг тоймловол бэлчээр, ус, малын эрүүл мэндэд учруулж болох нөлөөллийн тухай, нүүлгэн шилжүүлэлтийн тухай асуултыг анхнаасаа асууж онцолж байсан бөгөөд орон нутгийн удирдлага газрын маргаан, зөрчлөөс зайлсхийхийн тулд малчидтай илүү тогтмол уулзаж ярилцахыг Айванхү Майнс Монголиа Инкээс хүсэж шаардаж байсан байна²⁰. Малчдын Нүүлгэн Шилжүүлэлтийн Тайланд мал нь бэлчээртээ идээшиж дассан байдаг тул нүүлгэн шилжүүлсэн нутагт идээшиж дасахгүй мөн малчдыг нүүлгэн шилжүүлсэн шинэ газар нь бэлчээртэй боловч үсгүй, малчид өөрсдийн ирээдүйн талаар санаа ихэд зовинож байгаа болон цаашид урт хугацааны ямар дэмжлэг авах гэх мэт асуудлыг малчид хөндөж байсныг тайлагнажээ²¹.

Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээнд мал маллагааны соёл, эдийн засаг эсвэл нийгмийн зохион байгуулалтын талаар аливаа дэлгэрэнгүй мэдээлэл оруулаагүй, үнэлгээ хийсэн багийн бүрэлдэхүүнд социологч эсвэл хүн судлаач буюу угсаатны зүйч байгаагүй байна.²² Мал маллагаа нь гол үйл ажиллагаа гэдгийг тодорхойлж, зөвлөлдөх үйл явцын

²⁰ БОНБНУ, Хэсэг 4, Бүлэг 1, Хуудас.57.

²¹ БОНБНУ, Хэсэг 4, Бүлэг 1, Хуудас.9.

²² БОНУ, Хураангуй, Хуудас. 2-3.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

хүрээнд малчдын санааг зовоож буй зүйлсийг олж мэдсэнийг үл харгалзан малчдад учрах нөлөөллийн үнэлгээ, нарийвчилсэн дэлгэрэнгүй суурь мэдээлэл дутмаг байна. Жишээлбэл, сумын хэмжээнд мал маллагааны практик ямар байдгийг олж тогтоох судалгаа хийгдээгүй; улирлын нүүдэл, отор нүүдэл хийдэг хэв маягийн талаар хэлэлцүүлээгүй, зарим малчдын өвөлжөөний бууцыг нүүлгэн шилжүүлснээр бусад малчдад цохилт болохуйц гэнэтийн нөлөөлөл учруулах эсэх талаар огт судалж хэлэлцүүлээгүй байна. Сонирхолтой нь нийгэм, эдийн засгийн үнэлгээнд сөрөг нөлөөллийн жагсаалтанд орсон нөлөөлөл болох тэсэлгээний улмаас тав тухтай байдлыг нь алдагдуулж болзошгүй учраас уурхайн лицензит талбайгаас 10-20 км-ийн радиусын бүсэд амьдарч буй малчдыг цаашид нүүлгэн шилжүүлэх шаардлага гарч болохыг тодорхойлсон боловч энэ талаар тодорхой төлөвлөгөө эсвэл үүнийг хэзээ хийх тухай цаг хугацаа заагаагүй байна.²³ Нөлөөлөл учруулахаас зайлсхийх, бууруулах асуудлын хувьд 2003 оны Нийгэм, Эдийн Засгийн Үнэлгээнд дурдахдаа Айвенхоу Майнс Монголиа Инк нь олон нийттэй зөвлөлдөх хөтөлбөр, Малчдыг Дэмжих хөтөлбөртэй гэж л тайлагнажээ.

2006 оны БОНБНУ-ийн бусад хэсгүүдэд нийгэм эдийн засгийн үнэлгээнд дурдсан дүн шинжилгээнээс харьцангуй илүү байдлаар малчдад учруулах нөлөөллийн шинжилгээг бага зэрэг хийжээ. Уул уурхай нь хөрсний чийгшилд нөлөөлж болзошгүй байдал, эсвэл тоос ихсэх зэрэг нь малчдад нөлөөлж болох талтай гэж дурьдсан зарим тайлбаруудыг оруулсан боловч энэ талаар нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр болон нөлөөллийн хязгаарлалтын бүс тогтоосон баримт бичгээс тодорхой мэдээлэл авахыг тэмдэглэснээс өөрөөр цаашаа судлаагүй байна.²⁴ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хураангуйд орон нутгийн оршин суугчдад учрах сөрөг нөлөөлөл бүс харин эерэг нөлөөллийн жагсаалтыг гаргажээ.²⁵

3.2.4 Олж тогтоосон зүйлс - 2004

2003 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээнд уурхайн талбайгаас яг 22 км-ийн радиуст эсвэл 22 км-ийн дотогш бүсэд амьдардаг арван таван малчин өрх түс бүрийн талаарх мэдээллийг багтаасан байна.²⁶ Мөн малчдад учруулж болох өргөн цар хүрээтэй нөлөөллийн талаар товч дүрсэлжээ. Гэвч уурхайн лицензит талбай дотор эсвэр ойрхон бүсэд өвөлжөөтэй өрхүүдийг нүүлгэн шилжүүлж, эдгээр айлуудад боловсролын дэмжлэг, сургалт, ажлын байрны дэмжлэг үзүүлэх нь нөлөөллийг бууруулна гэсэн хялбар дүгнэлт хийсэн байна. Зөвлөлдөх уулзалтын үеэр малчдад учруулж болох нөлөөллийн тухай малчдын дэвшүүлсэн асуудлуудыг шийдээгүй, уурхайн үйл ажиллагааны хөгжил, тухайлбал дэд бүтцийн улмаас учруулж болох бусад нөлөөллийг үнэлж дүгнээгүй ажээ.

²³ “Тэсэлгээ, тоос тортог болон бусад нөлөөлөл гэх мэт уурхайн үйл ажиллагааны явцад нөлөөлөлд өртөж болзошгүй тул ОТ-н Төслийн Талбайгаас 10-20 км-ийн радиуст амьдарч буй өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх. БОНУ, Хэсэг IV. Бүлэг 1. Хуудас 15.

²⁴ “Байгаль орчны өөрчлөлтийн улмаас бүс нутагт орон нутгийн оршин суугчдад орон нутгийн усан хангамж, бэлчээр, агаарын чанар, дуу чимээний түвшин гэх мэт асуудалд аргагүй байдлаар үүссэн нөлөөлөл учирч болох юм. Айвенхоу Майнс Монголиа Инк нь төслийн талбайн орчимд оршин суугчдад нөлөөлөх нөлөөллийн хязгаарлалтын бүсийг тогтоон хэрэгжүүлж түс бүс нутагт уламжлалт үйл ажиллагааг явуулж дадсан малчдыг нүүлгэн шилжүүлэхэд туслалцаа үзүүлж байгаа болно”. БОНУ, Хэсэг I – 14.

²⁵ БОНУ, Хураангуй, Хуудас.5.

²⁶ БОНБНУ, Хэсэг 4, Бүлэг 1, Хуудас.9

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

Иймд, 2003 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ болон 2006 оны БОНБНУ-нд тусган оруулсан хэсгүүдийн аль аль нь малчдад үзүүлэх нөлөөллийг бууруулах, нөхөн олговрын хангалттай үндэслэл болж чадаагүй байна.

3.3 2011 оны нөхөн олговрын үйл явц

3.3.1 Хэнд 2011 онд нөхөн олговор олгосон бэ?

Уурхай болон холбогдох дэд бүтцийн барилгын ажилтай холбоотой үүссэн эдийн засгийн нөлөөллийн нөхөн олговрыг 89 малчин өрхөд 2011 онд олгожээ. Эдгээр өрхүүдийн зургаа нь 2004 онд өвөлжөөний бууцаа нүүлгэн шилжүүлсний нөхөн олговрыг өмнө авч байсан бөгөөд тэдгээрийн шинэ өвөлжөө нь ОТ-н дэд бүтцийн нөлөөлөлд өртжээ. Түүнчлэн, бэлчээрийн хүртээмж ерөнхийдөө буурсан асуудлыг шийдэхийн тулд сумын хэмжээний малчдад зориулсан нийтийн нөхөн олговрын хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна.

3.3.2 2011 оны нөхөн олговрын нөлөөллийн үнэлгээ

2006 он ба 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрийг боловсруулах хүртэлх хугацаанд малчдад учруулсан нөлөөллийн талаарх ойлголт, мэдлэгийн дутуу орон зайг нөхөхийн тулд ОТ үлэмж их хичээл зүтгэл гаргажээ. Мөн, 2009 оноос хойш, уурхайн удирдлага Рио Тинтогийн “Олон Нийтийн талаар баримтлах Стандарт”, ОУСК-ийн Нийгэм, Байгаль Орчны Гүйцэтгэлийн Стандартууд (ГС) тэдгээрийн нэг нь ГС 5 буюу “Газар Чөлөөлөх ба Албадан Нүүлгэн Шилжүүлэх” тухай стандартыг даган мөрдөх болжээ.

Хүснэгт 1 Малчдад учруулах нөлөөлөлтэй холбоотой хийгдсэн судалгаанууд, 2006-2011

2006 – 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн албан ёсны үнэлгээ. 2007 – Ханбогд суманд ус ашиглалтын талаарх ойлголт, төсөөллийн судалгаа. 2008 – Гүний Хоолойн цооногуудын орчимд ус ашиглалтын судалгаа. 2008 – Өмнөговь аймгийн Нийгэм, Эдийн Засаг, Байгаль Орчны Суурь Судалгаа. 2009 – Оюу Толгойн Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ. 2009 - 2010 – Бэлчээрийн зураглал ба үнэлгээний хөтөлбөр. 2010 – Ханбогд сумын бэлчээрийн эрүүл мэндийн үнэлгээ ба мониторинг. 2010 – Нүүлгэн шилжүүлсэн айлуудын үнэлгээ - 2010 (дотоод баримт бичиг). 2010 - 2011 – Нөлөөлөлд өртсөн байж болзошгүй малчин өрхийн судалгаа. 2010 - 2011 – Ханбогд сумын Бэлчээрийн Тогтвортой Менежмент. 2011 – Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө (НШТ 2011) – энэ нь 2012 онд зээлдүүлэгчдэд илгээсэн Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээний нэг хэсэг байсан.

2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ нь 2003 оны судалгаатай харьцуулбал илүү сайн, дэлгэрэнгүй хийгдсэн байсан бөгөөд газар ашиглалт болон мал маллагааны практикийн талаар нэмэлт мэдээлэл оруулсан байв. Тус үнэлгээ нь Ханбогд сумын бүхий л хэсгийг хамарсан өргөн цар хүрээтэй асуудлыг судалсан бөгөөд судалгаанд тусгасан сэдвүүдэд газар болон бэлчээрт үзүүлж буй дарамт, усны эх үүсвэр, нийлүүлэлт, нүүлгэн шилжүүлэлт буюу эдгээртэй холбоотой тулгамдсан асуудлууд багтжээ. Ханбогд сумаас 55 хүн бүлгийн ярилцлага,

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

9

ганцаарчилсан ярилцлага эсвэл хоёрдагч эх үүсвэрийн өгөгдөл мэдээлэл цуглуулах үйл ажиллагаанд хамрагдсан байна.²⁷

2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Үнэлгээнд ОТ болон түүний дэд бүтцийн улмаас үзүүлж буй нөлөөллийн талаарх малчдын санаа зовоож буй асуудлыг тухайн бүс нутагт үйл ажиллагаагаа явуулж буй бусад уурхай, дэд бүтцийн хөгжлийн агуулгын хүрээнд тоймлон тэмдэглэжээ. Тус үнэлгээнд ОТ болон бусад компаниуд дэд бүтцээ барьж байгуулахын тулд бэлчээрийн нутгийг авсны улмаас үүсэх үр дагавар их хэцүү төвөгтэй, тухайлбал малчдын нүүдэллэх хэв маяг өөрчлөгдөх, мал сүргийн отор нүүдэл хийх давтамжийг багасгахад хүргэх, улмаар бэлчээрийн чанарт нөлөөлөх гэх мэт туйлын төвөгтэй болохыг онцлон тэмдэглэсэн байна²⁸. Тус тайланд замын хөдөлгөөн үлэмж ихээр нэмэгдсэн, дараа нь юу болох нь тодорхой бус, айдас түгшүүртэй байдаг, хүүхэд, залуучуудад үзүүлэх нөлөөллийн талаар санаа зовдог гэх мэт шинэ, тодорхойгүй нөхцөл байдалтай тулгарах бүртээ сэтгэлийн дарамтанд орох зэргээр малчдад сэтгэл санааны хохирол учирч болзошгүйг дурджээ²⁹. Үүний зэрэгцээ малчид уурхайд ажилд орохын тулд мал маллахаа боливол хожим нь ажлын байраа алдсан тохиолдолд эргээд мал маллаж эхлэхэд хэцүү байдаг эрсдлийг онцлон дурдсан байв. Тус тайланд (i) малын тоо нэмэгдсэн, (ii) дэлхийн болон орон нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл, (iii) уурхай болон дэд бүтцийн хөгжилд бэлчээрийн талбайг ашиглахаар авсан³⁰ зэрэг шалтгааны улмаас бэлчээрийн хүртээмж улам багасна, улмаар бусад дэд бүтцийн байгууламжийг барих, уурхайн тэлэлтийн улмаас шинэ газар/талбайг авбал энэ нь нүүлгэн шилжүүлэлтийн шинэ давалгааг авчирж болзошгүй гэж малчид санаа зовж буй талаар тэмдэглэжээ.³¹ Үнэлгээний үйл явцад баг тус бүрт бүлгийн ярилцлага хийсэн, гол мэдээллээр хангагч иргэдтэй ганцаарчилж ярилцлага авсан боловч малчидтай тусгайлан үулзалт хийгээгүй ажээ.

Тус үнэлгээнд “Дүгнэвэл, бэлчээрийг нь авснаар Говийн бүсэд бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдардаг нутгийн иргэдийг нөөцөд-суурилсан амьжиргаагаар тогтвортой амьдрахад ихэвчлэн сөрөг нөлөө үзүүлнэ гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй” гэж дурджээ³². Гэвч үнэлгээг ерөнхий түвшинд хийсэн: нөлөөлөлд өртсөн байх магадлалтай тодорхой байршил эсвэл малчдын талаар тусгайлан өгүүлээгүй байна.

2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ нь 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийг хийхэд гаргасан дутагдалтай талууд болон цаашид нүүлгэн шилжүүлэлтийг хийхдээ сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлж³³, ялангуяа дор дурдсан арга хэмжээг авах нь зүйтэй гэжээ:

- Нүүлгэн шилжүүлэх нөлөөллийг бууруулахад анхаарч уурхайн талбай болон дэд бүтцийн хязгаарлалтын бүсийг тогтоох шалгуурыг хянаж, дахин боловсруулах.
- Хязгаарлалтын бүсэд малаа бэлчээж дассан малчдыг тус бүсэд малаа бэлчээх боломжийг нь олгох.

²⁷ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас.39.

²⁸ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас.109.

²⁹ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас. 57-95.

³⁰ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас. 37

³¹ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас.42.

³² 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас. 109.

³³ 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээ, Хуудас.114-6.

- Нөлөөлөлд өртсөн бүх хүмүүст ижил тэгш хандахын тулд ОТ болон бусад уурхайн улмаас үзүүлж буй хуримтлагдах нөлөөллийг харгалзан нүүлгэн шилжүүлэлтийг удирдах.
- Уурхайн талбайгаас гадагш нүүлгэн шилжүүлэх хүмүүс болон уурхайн талбайгаас гадна барьж байгуулж буй дэд бүтэц, барилгын ажлын нөлөөлөлд өртсөн хүмүүст ижил тэгш хандах
- Дараах асуудлыг шийдэхийн тулд нөхөн олговрын үйл явц(ууд)ыг хянаж засан сайжруулах:
 - Гомдлыг барагдуулах механизм нь шуурхай, хариуцлагатай ажилладаг болох
 - Сумын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах
 - Нөлөөлөлд өртсөн хүмүүсийг ижил тэгш боломжоор хангасан эсэхийг хянан баталгаажуулахын тулд нөхөн олговрын гэрээг хянаж дүгнэх
 - Нүүлгэн шилжүүлэлтийн шалгуур үзүүлэлтийг хянаж засан сайжруулах (нөлөөллийн үнэлгээний явцад олж тогтоосон зүйлс болон бусад судалгаанаас авсан сургамжийг харгалзан үзэх)
 - Малчдыг нүүлгэн шилжүүлэхэд ашигласан аргыг хянан дүгнэж, засан сайжруулах
 - Нөхөн олговор олгох шаардлагатай байж болох нөхцөл байдлыг тодорхойлох, жишээ нь бэлчээрийн нөлөөлөл, мал эндэх гэх мэт
 - Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааг орон нутгийн харилцаатай уялдуулах

Энэхүү үнэлгээнд нөлөөллүүдийг жагсааж, тэдгээрийн чухал, ач холбогдолтой байдлыг үнэлж дүгнэн нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгосон байна. Ялангуяа малчидтай холбоотой хэд хэдэн нөлөөлөл дээр дурдсан жагсаалтанд багтсан байсан бөгөөд 2009 оны Нийгэм, Эдийн Засгийн Нөлөөллийн Үнэлгээгээр “их сөрөг нөлөөлөлтэй” гэж дүгнэн улмаар тэдгээр нөлөөллийг бууруулах арга хэмжээг санал болгожээ. Нөлөөллийг бууруулах арга хэмжээнд ОТ нөлөөллөөс аль болох зайлсхийх, мониторинг хийх, түүнчлэн газар ашиглалтын менежмент, бэлчээрийг сайжруулахад чиглэсэн хамтарсан арга хэмжээ авах гэх мэт ОТ ба бусад уурхайнууд; ОТ болон сумын удирдлага хамтарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжтой бол хамтарч арга хэмжээ авахыг зөвлөжээ.

3.3.3 2011 оны Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөө

2011 оны НШТ-г 2012 онд боловсруулж дуусгасан Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээний нэг хэсэг байдлаар боловсруулж, газар ашиглалтанд нөлөө учруулж болзошгүй бүх үйл ажиллагаа, ОТ-д шаардлагатай/ОТ-н эвдсэн газарт амьдарч буй болон/эсвэл ашиглаж байгаа хүмүүсийн биет ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг удирдах бодлого, төлөвлөгөө, журмыг бэлтгэсэн ажээ.³⁴ БОННУ-ний D15-р Бүлэгт энэ тухай өгүүлжээ. НШТ-ийн хүрээнд олон нийттэй уулзалт зохион байгуулж, төлөвлөсөн дэд бүтцийн ажил, тэдгээрийн явцын талаар мэдээлэл өгч, хэлэлцүүлсэн байна. Мөн Туслалцаа Авах Эрхийн Матриксин эцсийн хувилбар, хэрэгжүүлэх журам үйл явц, хамрагдсан өрхүүдийн талаарх мэдээллийг өгөхийн тулд баг тус бүрт уулзалт зохион байгуулж танилцуулга хийжээ.³⁵

³⁴ 2011 оны НШТ, Хуудас.6.

³⁵ 2011 оны НШТ, Хуудас 57-8.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

2011 оны НШТ-д 2004 оны нөхөн олговрын талаар тайлагнаад, уурхайн талбай, хашаа сунгаж барьсан, тээвэрлэлтийн коридор, онгоцны буудлын талбай, Гүний Хоолойн цооногууд болон шугам татахад авч ашигласан талбайтай холбоотой үүссэн нөлөөлөлтэй холбоотой шинэ нөхөн олговрын тухай өгүүлжээ. Тус тайланд Ундай голын гольдрол өөрчлөх, Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой үүсэх аливаа нөлөөллийн талаар тусгайлан заагаагүй боловч эдгээр болон ОТ-н бусад үйл ажиллагаатай холбоотой нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай бол нөхөн олговор олгохдоо ижил зарчмыг баримтална гэж тэмдэглэжээ. Үүнд дурьдсанаар:

- “Төслийн нөлөөлөлд өртсөн газар нутагт (“нөлөөллийн бүс”) амьдарч байгаа эсвэл газар ашиглаж байгаа бүх хүмүүс нөхөн олговор авах, амьжиргаагаа нөхөн сэргээх эрхтэй”.³⁶
- НШТ нь нөхөн олговор авах эрхтэй хүмүүсийн тодорхойлолтыг багтаажээ:
 - “Газар эсвэл бусад хөрөнгийн хувьд хууль ёсны эрхгүй ч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хууль ёсны эрх авах хүсэлтээ гаргасан, газрын гэрчилгээ гэх мэт эзэмших эрхийн баримт бичигтэй, нөлөөлөлд өртсөн газрыг ашиглах эсвэл тухайн газарт амьдрах зөвшөөрлийг орон нутгийн эрх бүхий байгууллагаас авсан хүмүүс;
 - тухайн ашиглаж буй бэлчээрт илтэд үе удмаараа уламжлан малаа бэлчээрлүүлэн амьдарч ирсэн болохыг нь орон нутгийн эрх бүхий байгууллага болон орон нутгийн иргэдийн зөвшилцлөөр тогтоосон хүмүүс.”³⁷

НШТ-д төрөл бүрийн “нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл” болон тэдгээртэй холбоотой “нөлөөллийн бүсийг” тодорхойлсноос гадна малчид аль ангилалд хамаарахыг тэмдэглэсэн байна. Жишээлбэл В1 нөлөөллийн бүсэд онгоцны буудлаас 5 км-ийн радиус дотор малын хороо, бууцтай, тухайн бүс нутагт малаа бэлчээх уламжлагдсан эрхтэй малчид байгаа бол; В2 ангилалд онгоцны буудлаас 5-11 км-ийн радиус дотор малын хороо, бууцтай, тухайн бүс нутагт малаа бэлчээх уламжлагдсан эрхтэй малчдыг оруулжээ. НШТ –нд ангилал тус бүрт хамаарах өрхийн тоог зааж³⁸, судалгаанд үндэслэн тухайн өрх тус бүрийн ерөнхий өгөгдөл мэдээллийг тусгасан³⁹. Гомдлыг барагдуулах механизмыг ч багтаасан байна. Малчин өрхөд олгох нөхөн олговрын хувьд “Бүх өрх өвөлжөөтэй, харин цөөн хэдэн айл хаваржаатай” учраас өвөлжөөний байршлаар нөхөн олговор авах эрхтэй үгүйг тогтоох нь зүйтэй гэж шийджээ.”⁴⁰ Өвөлжөөтэй малчдад гол анхаарлаа төвлөрүүлсэн; хаваржаатай цөөн тооны айл болон бууцны зөвшөөрлөө аваагүй олон тооны айлыг оруулж тооцоогүй байна.⁴¹

‘Тус бүс нутагт бэлчээрийн ерөнхий хомсдол’ үүсч байгаад ОТ тодорхой хувиар нөлөөлж байгаа гэдгийг НШТ хүлээн зөвшөөрч, үүнийг сумын төвд амьдарч буй иргэдээс бусад сумын бүх малчдад нээлттэй Бэлчээрийн Тогтвортой Менежментийн Хөтөлбөрөөр дамжуулан нөхөхийг санал болгожээ Түүнчлэн сумын удирдлагатай хамтран эмзэг бүлгийн өрхийг тодорхойлж,

³⁶ 2011 оны НШТ, Хуудас.37.

³⁷ 2011 оны НШТ, Хуудас.36.

³⁸ 2011 оны НШТ, Хуудас.32.

³⁹ 2011 оны НШТ, Хуудас.99-104.

⁴⁰ 2011 оны НШТ, Хуудас.40.

⁴¹ 2016 оны 5 – 6 саруудад багийн дарга нартай ярилцлага хийх үеэр авсан сумын мэдээгээр сумын малчдын 16% нь бэлчээр ус ашиглан, малаа маллаж буй боловч өвөлжөө, хаваржаа алины ч гэрчилгээ аваагүй байна.

нөхөн олговрын үеэр болон амьжиргааг нөхөн сэргээх үйл явцад эдгээр 14 өрхөд нэмэлт дэмжлэг туслалцаа үзүүлэх талаар НШТ-д дурьджээ.⁴²

НШТ-ний талаар зөвлөлдөх арга хэмжээг гол төлөв Оюу Толгой ХХК-н төлөөлөл, нөлөөлөлд өртсөн малчин өрхийн төлөөлөл, багийн Засаг дарга нараас бүрдэж 2011 оны эхээр Ханбогд сумын засаг даргын байгуулсан Нөхөн Олговрын Ажлын Хэсгээр (НОАХ) дамжуулан хийж ирсэн байна. НОАХ нь малчин өрхүүдтэй хэлэлцээр хийх ажлыг чиглүүлэн зохион байгуулж, гомдлыг зуучилж байжээ.⁴³ Жишээлбэл, хэрвээ нөхөн олговор авсан өрхийн тоонд багтах ёстой гэж хүмүүс гомдол гаргавал, НОАХ нь тухайн айлд очиж тогтоосон бүс дотор байна уу эсвэл гадна байна уу гэдгийг хэмждэг байжээ; хэрвээ малчид бүртгэлгүй өвөлжөөтэй бол НОАХ-н ахлагч болон багийн засаг дарга тухайн малчныг нөхөн олговор авах ёстой үгүй эсэхийг шийддэг байсан байна.⁴⁴ Сумын захиргааны зөвлөснөөр 2011 онд малчдад нөхөн олговрын гэрээний нөхцлийг сайн ойлгуулж, хэлэлцээр хийхэд хувь хүмүүст туслахын тулд хуульч хөлслөн ажиллуулжээ. Ихэнх өвөлжөөний эзэмшил нь эрэгтэйчүүдийн нэр дээр байдаг; эмэгтэйчүүдэд өөр нөлөөлөл учирч буй эсэх тухай НШТ-д тусгайлан хэлэлцүүлээгүй байна.

Хүснэгт 2: 2011 оны НШТ-д тодорхойлсон нүүлгэн шилжүүлэлтийн нөлөөлөл.

- Уурхайн Лицензит Талбай (УЛТ) ба түүнээс 10 км-ийн зайд оршин суухыг хориглосон бүсээс малчин өрхийг биетээр нүүлгэн шилжүүлэх (2004)
- Онгоцны буудлын талбайд зориулан газрыг нь авснаас зуны бэлчээрээ алдсан ба/эсвэл зуны бэлчээрийн хүртээмж мүүдсаны улмаас нөлөөлөлд өртсөн малчдын эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт
- Төслийн шугаман байгууламжийн барилгын ажлын улмаас бэлчээр хуваагдсан (ОТ-ГС-ын зам ба ус дамжуулах хоолой зэрэг)
- Мал маллагааны үйл ажиллагаанд саад учруулсан
- Худаггүй болсон, усны хүртээмж/чанарт бусад нөлөө учирсан (жишээ нь: Худаг руугаа очиход хүндрэлтэй болсон)
- Ханбогд сумын бэлчээрийн нийт хүртээмж буурснаар бэлчээрийн төлөөх өрсөлдөөн ихэсч, үлдсэн бэлчээрийн ашиглалт хэтэрсэн.⁴⁵

3.3.4 Олж тогтоосон зүйлс

2011 оны нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ болон 2011 оны НШТ нь малчдын газар ашиглалтанд нөлөөлөх ОТ-н үйл ажиллагааг олж тогтоох зохистой, оновчтой аргачлалыг ашиглажээ. Гэвч дараах дутагдалтай зарим асуудлууд байна. Үүнд:

- ОТ-н үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн малчдын тодорхойлолтыг тухайн нөлөөллийг бий болгож буй үйл ажиллагаанаас 5, 10 эсвэл 20 км-ийн радиус доторх өвөлжөөний гэрчилгээ нь 2011 оны 3-р сарын 18-наас өмнө олгогдсон эсвэл авахаар хүсэлт гаргасан гэх мэт нөлөөллийн бүсийн тохиолдлын гэмээр тодорхойлолт, мөн аль малчин

⁴² 2011 оны НШТ, Хуудас.63.

⁴³ 2011 оны НШТ, Хуудас.60

⁴⁴ ОТ, хэлэлцүүлэг, 2016 оны 2-р сар.

⁴⁵ 2011 оны НШТ, Хуудас. 21.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

13

нөлөөлөлд өртөхийг өвөлжөөний гэрчилгээг гол болгон авсан энгийн хялбар тодорхойлолтонд үндэслэн гаргажээ.

- Малчдад үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд санал болгосон чухал арга хэмжээг, ялангуяа Сум болон/эсвэл бусад уул уурхайн компаниудын хамтын ажиллагааг шаардсан арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.
- 2011 оны НШТ-д амьжиргааг нөхөн сэргээх тодорхой стратеги байхгүй.

3.4 Ирээдүйд учрах нөлөөллийн үнэлгээ

2012 оны БОННУ нь ОТ-н үйл ажиллагаа эсвэл холбогдох бүтээн байгуулалтын үйл явцын улмаас малчдад үзүүлж болзошгүй нөлөөллийг ‘Хуримтлагдах Нөлөөллийн’ хэсэгт цухас дурьдсанаас өөрөөр системтэй үнэлээгүй байна:

- ОТ-н хүдрийн гарцын өсөлт өдөрт 100,000-с 160,000 тонн –нэмж газар шаардлагатай, ус, агаарын бохирдол/дуу чимээний нөлөөлөл.⁴⁶
- Монгол Улсын Засгийн Газар болон Оюу Толгой хооронд урт хугацаанд эрчим хүчээр хангах “Эрчим Хүчний Салбарын Хамтын Ажиллагааны Гэрээг” 2014 оны 8-р сард байгуулсны улмаас ашиглах газар, барилгын ажил. Өндөр хүчдэлийн шугамыг төсөл барьж байгуулах аваас ОТ байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг олон улсын стандартаар хийх үүрэгтэйг тэмдэглэе.
- Далд уурхайн барилгын ажил болон үйл ажиллагааны улмаас нэмэгдэх замын хөдөлгөөний нөлөөлөл.
- Уурхайн хашсан талбайд нэмж авах аливаа газар.⁴⁷
- Төмөр замын барилгын ажил болон үйл ажиллагаа – (хэдийгээр 2012 оны БОННУ-д ОТ нь төмөр замаас салаа шугам татахыг хүсэж магадгүй болохыг тэмдэглэсэн хэдий ч).⁴⁸
- Түүнчлэн, 2012 оны БОННУ нь Ханбогд сумын төвд ОТ-н ажилтнуудыг сайтаас гадна их хэмжээгээр байрлуулна гэсэн таамаглалд тулгуурлан боловсруулсан байна. Гэвч энэ төлөвлөгөө ОТ-д одоо байхгүй.

Бидний судалгааны ажил дууссан хойно ОТ нэмэлт оруулсан БОННУ-г⁴⁹ цахимаар тавьсан, гэхдээ түүнд дурьдсан асуудлуудыг бүрэн хамраагүй байв. ОТМШБ-ийн хээрийн судалгаа хийж байх үеэр (2016 оны 5-7-р сар) ОТ нь далд уурхайн төслийн талаар орон нутгийн иргэдэд харилцах ажлаа эхлүүлж байсан.

3.4.1 Зөвлөмж

Далд уурхайн төсөлтэй холбоотой нэмэлт нөлөөллийг (ба нөлөөллийн бууруулах арга хэмжээ); тодорхойлж зөвлөлдөхийн тулд ажлаа эхлэхээс өмнө ОТ нэг эсвэл хэд хэдэн нэмэлт БОННУ-ний үр дүн; эрчим хүчний гэрээ; ажиллах хүчний орон байрны төлөвлөгөөнд орсон өөрчлөлт; төмөр замын барилгын ажил; Ханбогд сум ОТ хоорондын замын хүчилт; 2012 оны БОННУ гарснаас

⁴⁶ 2012 оны БОННУ, Бүлэг А1, Удиртгал, х. 13, ‘Энэхүү БОННУ-нд төслөөс ирээдүйд учруулах нөлөөллийг авч үзээгүй болно’.

⁴⁷ 2016 оны 5 сард тухайн үед ОТ-н нүүлгэн шилжүүлэлт хариуцаж байсан менежертэй уулзахад далд уурхайн төслийн хүрээнд нэмж 4 га газрыг уурхай хашаалж авна гэж бидэнд мэдээлсэн.

⁴⁸ Үүнийг ОТ-н зээлийн гэрээнд тусгасан гэж ОТ хэлсэн. Бид энэ баримт бичгийг үзээгүй.

⁴⁹ Оюу Толгойн Зэс-Алтны Ордны Уурхай, Боловсруулах Төслийн Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний Нэмэлт, <http://ot.mn/reports/environment/> үзнэ үү.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

хойш төсөлд гарсан томхон өөрчлөлтүүд болон бусад дэд бүтэц, уул уурхай/газрын тосны төслийн улмаас үүсэх хуримтлагдах нөлөөллийн дүн шинжилгээний талаарх сүүлийн үеийн мэдээллийг ОУСК-ийн стандартын дагуу олон нийтэд ил тод мэдээлэх хэрэгтэй.

Сумын төв ОТ-н хоорондын зам хучилттай болсноор тээврийн хөдөлгөөн ба хурд нэмэгдэж, мал амьтны хөдөлгөөнийг хязгаарлах эсэхийг үнэлгээнд анхаарч үзэх ёстой.

4 ОТ өөрийн хэрэгцээний дэд бүтэц, байгалийн баялаг ашигласан зэргийг оролцуулан ОТ-н улмаас учирсан сөрөг нөлөөллүүдийг хангалттай нөхөн төлсөн үү?

4.1 Дэд бүтэц

ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 1-ийн судалгааны хүрээнд хийсэн бэлчээрийн дүн шинжилгээний явцад нөхөн олговрын гэрээнд ямар нэг байдлаар тусгаж оруулаагүй, ОТ-н улмаас үүссэн нь тодорхой бэлчээрийн томоохон сөрөг нөлөөллийг олсонгүй (нөхөн олговрын үр өгөөжийн талаар дараа хэлэлцсэн байгаа). Харин дараах зүйлсийг олж тогтоолоо:

- ОТ-н зам, Таван Толгойн зам болон бусад зам, баригдаж буй төмөр замын хооронд бууцтай малчид сөрөг нөлөөлөлд өртсөн байна. Ялангуяа төмөр замын далан өндөрт байрлаж байгаа тул малын нүүдэл, хөдөлгөөнд хүчтэй нөлөөлөхөөр байна. Нүүрсний зам ямар ч байдлаар ОТ-той хамааралгүй; Монгол Улсын засгийн газрын барьж буй төмөр замыг ямар байдлаар ОТ ашиглах эсэх нь бидэнд тодорхойгүй байв. Хэрвээ ашиглахаар бол төмөр замыг ОТ-н “холбоотой байгууламж”⁵⁰ гэж тооцох эсэх нь ч тодорхойгүй байна.
- ОТ-н дэд бүтцийн улмаас уурхайн талбайн зүүн хойд хэсгийн бэлчээр хуваагдсан, энэ бэлчээр нь хамгийн их нүүдэл суудал хийдэг, бэлчээрлэж ирсэн түүхэн уламжлалтай газар тул нөхөн олговор авсан малчдаас гадна бусад малчдад энэ байдал нь нөлөөлжээ.

4.2 Ус

ОТ-н гаргасан худгууд нь “яг л шүүр шанага шиг” байдаг бөгөөд малчдын усан хангамжид нөлөөлж байгаа талаар сумын нийт малчид санаа зовж байгаагаа илэрхийлж байв. Усны асуудлаар хийсэн дүн шинжилгээгээр (Бүрэлдэхүүн 1-ийн тайлан) аллювын уст давхаргын системтэй мониторинг эсвэл загварчлал байхгүй, ОТ-н үйл ажиллагаа нь малчдад нөлөөлөх эсэх талаар системтэй үнэлгээ хийгдээгүй болохыг олж тогтоов. Зарим цооногууд нь аллюв болон үл чулуулгийн нөөцийг холбосон, аллювын уст давхарга алдагдсанаас зарим худгийн усан хангамж буурсан байж болох нотолгоо байна. Иймд ОТ-н үйл ажиллагааны улмаас малчдын усанд хохирол огт учруулаагүй гэж зүтгэх, эсвэл хохирол учруулж байгааг батлах, эсвэл хэр хэмжээний хохирол учруулсныг тогтоохын аль аль нь боломжгүй юм. Түүнчлэн бусад аж ахуйн этгээдийн ухаж гаргасан цооногууд малчдын усанд нөлөөлсөн байж бас болохоор байна.

⁵⁰ “Холбоотой байгууламж, гэдэг нь төслийн нэг хэсэг байдлаар санхүүжүүлээгүй ч хэрвээ төсөл байгаагүй бол барьж байгуулах эсвэл өргөтгөх шаардлагагүй байсан, тухайн байгууламжгүйгээр төсөл оршин тогтнох боломжгүй байгууламжуудыг хэлнэ”. ОУСК, Гүйцэтгэлийн Стандарт 1, 2012, Заалт. 8.

Ус бол малчдын хувьд хамгийн чухал нөөц, тиймээс учирсан байж болзошгүй чухал нөлөөллийн тухай энэхүү тодорхой бус байдал нь учир дутагдалтай зүйл мөн. Бүрэлдэхүүн 1-ийн судалгаанд малчдын худгийн мониторинг ба аллювын уст давхаргын хөтөлбөрийг өргөжүүлэх, түүнчлэн аллювын уст давхаргын талаар мэдээлэл болох, ОТ-с малчдын усанд учруулж буй нөлөөллийн ерөнхий үнэлгээ гаргаж, усгүй бэлчээрийн газарт шинэ худаг гаргах байршлыг тодорхойлохын тулд гидрологийн судлагаа хийлгэхийг зөвлөжээ. (Бүрэлдэхүүн 1-ийн тайланг үзнэ үү.)

4.3 Сэтгэл санааны нөлөөлөл

Биднийг ажлаа эхлүүлсний дараа ОТ-н улмаас учирсан сэтгэл санааны хохирлыг олж тогтоохыг ГТЗ-ийн малчдын төлөөлөл хүссэн юм. Манай багт сэтгэл зүйч байхгүй учраас бид зөвхөн социологийн/хүн судлал, угсаатны зүйн үзэл баримтлалын үүднээс ажиглалт хийх боломжтой байлаа. Бидний ажигласнаар:

- ОТ болон бусад төслүүдийн улмаас гарч буй өөрчлөлтийн тухайд, түүнчлэн эдгээр өөрчлөлтүүд нь малчдад нөлөөлж байгаа ч энэ талаар арга хэмжээ авахад малчид нөлөөлөх боломжгүй байгаад сумын хэмжээний малчид уур, бухимдалаа илэрхийлж байв. “Тэд миний амьдралаар тоглосон.”
 - Социалист нийгмийн төгсгөл үе, улмаар 1990-ээд оны үе гэхэд мал маллагааны арга ажиллагаанд ихээхэн өөрчлөлт орж буйг ахмад настай малчид хэдийн мэдэрч байжээ. Уул уурхайн үйл ажиллагаа нь (эхлээд гар аргаар ашигт малтмал олборлогчид, хожим нь ОТ, Таван Толгой гэх мэт томоохон төслүүд) бас нэг томоохон өөрчлөлт байв. Бидний ярилцлага авсан зарим настангуудын хувьд социалист нийгмийн төгсгөл нь ОТ-н улмаас бий болсон өөрчлөлтүүдээс илүү их сэтгэл санааны нөлөөллийг бий болгосон гэж байхад; бусад хүмүүсийн хувьд гадны хүчин зүйлийн улмаас байнгын өөрчлөлтөд өртөхөд ОТ хүргэсэн гэж үздэг байна.
 - Өнөөдрийг хүртэл үргэлжилж буй ОТ ба малчдын хоорондын үл итгэлцлийг 2004 оны нүүлгэн шилжүүлэлт бий болгожээ. Ундай голын гольдролыг өөрчилсөн, Бор Овоогийн задгайг нүүлгэн шилжүүлсэн зэрэг нь энэхүү нөхцөл байдлыг улам дордуулсан байна. Цаашид өөр ямар өөрчлөлт гарах хэмээн түгшин, санаа зовинож буй нийт малчдын дунд тус үл итгэлцэл байсаар байна. Нэг настан хэлэхдээ “Эхэндээ ОТ маш жижиг байлаа, өөрчлөлт ч бага байсан, харин яваандаа улам их өөрчлөлт гарах байсныг бид ойлгосон юм” гэв.
- ОТ нь газар нутгийн байдлын хувьд үзэгдэхүйц сумын төвөөс холгүй оршдог. ОТ-н энэхүү бараатай харагдахын нэг үр дагавар нь хэдийгээр өөр бусад газар хариуцах ёстой ч хохирол учруулж буй бүхий л өөрчлөлтөнд ОТ хариуцлага хүлээх ёстой гэж үзэхэд хүргэдэг явдал юм.
- Ахмад малчид ОТ болон ОТ-н бус тээврийн хэрэгслийн улмаас амар амгалан, тайван байдал маань алдагдаж байгаа тухай хэлж байв.
- Нөхөн олговор нь малчин өрх дотор, малчин өрхийн хооронд хэн нөхөн олговор авсан эсэх талаар зөрчил, маргаан, хурцадмал хүйтэн харилцааг сэдэлжүүлэн бий болгосон байна.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

16

- Нийт малчид ба малчин хувь хүмүүс ОТ-н талаар эсрэг тэсрэг хандлагатай байна: уламжлалт амьжиргаа өөрчлөгдөж буйд санаа зовиныхын зэрэгцээ илүү их ажлын байртай болох эсвэл ОТ-с бизнес эрхлэхэд дэмжлэг авах хүсэлтэй байх гэх мэт.
- Малчидтай ганцаарчлан хийсэн ярилцлагын явцад малчдын эсвэл сумын үйл ажиллагаа тухайлбал малын тоо өссөн, тээврийн хэрэгслийн ашиглалт хэрэглээ нэмэгдэж малчдын бүүцны орчин тойрны амгалан тайван байдлыг алдагдуулдаг, бусад малчдад ашиглуулахгүй гэж худгаа цоожилдог гэх мэтээр асуудал нэмдэгийг хүлээн зөвшөөрөөд харин бүлгийн ярилцлагын үеэр бүх бэрхшээлтэй асуудлын эх үүсвэр нь зөвхөн ОТ гэж үзэх хандлагатай байв.

4.4 Соёлын өв

ГТЗ дэх малчдын бүлэг урьдчилсан тайлантай танилцаад нөлөөллийн үнэлгээ, НШТ-ний явцад соёлын нөлөөллийг бүрэн хүлээн зөвшөөрөөгүй гээд хувь хүний болон соёлын нөхөн олговорт соёлын алдагдлыг анхаарч үзэх ёстой гэсэн.

Ажлын Даалгавар, Ажлын Төлөвлөгөөг ГТЗ-тэй тохиролцсоны дараа гарч ирсэн бусад асуудлуудын нэгэн адил үүнийг нарийн судлан шалгах мэдээлэл бидэнд байхгүй байна. Гэсэн хэдий ч дараах зүйлсийг тэмдэглэн дурьдъя.

- Соёлын өвийг хамгаалах асуудал үндэсний хууль тогтоомж, ОУСК-ийн ГС8 аль алинд нь тусгасан байдаг.
- 2012 оны БОННУ-нд соёлын өвийн үндэс суурь, нөлөөллийг хамарсан дэлгэрэнгүй бүлэг байгаа ба эдгээр нь биет бус өвийг тун тодорхой тусгасан; ОТ Соёлын Өвийн Менежментийн Төлөвлөгөөтэй – хэрэгжилтийг нь гадны мониторингоор хянадаг (нийгэм, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бусад заалтын адил), Соёлын өвд учруулж болзошгүй нөлөөллийг таньж ойлгох, хариу арга хэмжээ авахын тулд ОТ Монголын тэргүүлэх байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Үүнд ОТ-н нөлөөллийн бүс дэх малчин айлуудын угсаатны зүйн судалгаа багтана, гэхдээ холбогдох дүрсгалт газруудыг хамгаалах үүднээс хүмүүс тэр бүр бүгдийг нь зааж өгдөггүй байж магадгүй гэж судлаачид үзэж байгаа аж.⁵¹
- Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хийгдсэн нийгэм-эдийн засгийн судалгаагаар ярилцлага өгөгчдийн олонх нь соёлын өв тэдний хувьд чухал ач холбогдолтой гэж байсан хэдий ч Бор Овоон задгайгаас өөр соёлын өв эсвэл тахилга шүтлэгтэй газарт ОТ нөлөөлөл учруулсан гэсэн гомдол үгүүлэл гаргаагүй. Үүнийг ХШБ-ийн ажлаар авч үзсэн болно.

Тиймээс соёлын өвийн асуудал орхигдсон гэж бид үзэхгүй байна. Гэхдээ энэ нь тэдгээрийг хангалттай авч хэлэлцсэн гэж байгаа үг биш. Бид мэдэхгүй юм. Соёлын өвийг тодорхойлох, эсвэл менежмент хийх тухайд гомдол байвал ОТ-н санал гомдлын механизмаар дамжуулан шийдвэрлэх ёстой. Соёлын өвийн нөлөөлөл нөхөн олговрын үйл явцын нэг хэсэг биш юм.

4.5 Зөвлөмжүүд

Бүрэлдэхүүн 1-ийн хүрээнд хийсэн судалгаа нь ОТ-с гүехэн гүний усны гар худаг шинээр гаргах, ялангуяа худаг усны хүрэлцээгүйн улмаас одоогоор ашиглахгүй байгаа сумын бэлчээрийн

⁵¹ Өнгөрснөө хамгаалж, Одоогоо хадгалах: Оюу Толгойн 1-р шатны үйл ажиллагааны тайлан. Өмнөговь аймагт зориулсан Соёлын Өвийн Хөтөлбөрийн Загвар', 2011 оны 2 дугаар сар.

нутагт ийм гар худаг гаргах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар нийтийн нөхөн олговор олгохыг зөвлөмж болгосон юм.⁵² Ингэснээр Уурхайн Лицензтэй Талбайн (УЛТ) зүүн хойд талын бэлчээр хуваагдсаны улмаас үүссэн нэмэлт нөлөөлөл болон малчдын усны эх сурвалжид үзүүлсэн аливаа нөлөөллийг нөхөн төлнө.

Оюу Толгойн улмаас учирсан сэтгэл санааны нөлөөллийг найдвартай арга замаар тоон үзүүлэлтээр тодорхойлох боломжгүй. Гэвч энэ асуудлыг харгалзан үзэх боломжтой бөгөөд харгалзан үзэх ч ёстой. Эдгээр нөлөөллийг орон нутгийн түвшний нөхөн олговрын арга замаар хэсэгчлэн шийдвэрлэх боломжтой. Тиймээс бид дараах зүйлийг санал болгож байна. Үүнд:

- ОТ нь 2004 оны нүүлгэн шилжүүлэлтэнд Айвенхоу Майнс Монголиа Инкийн ашигласан арга барилд асуудал байсан болохыг малчдын өмнө хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.
- ОТ нь гомдол барагдуулах механизмаа сумын хэмжээгээр тайлбарлан танилцуулж, малчид болон бусад иргэдэд хүртээмжтэй, ойлгомжтой, найдвартай байдлыг нь баталгаажуулан, өөрийгөө нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй аливаа малчин асуудлаа хэрхэн хаашаа тавихаа мэддэг болгох.
- ОТ орон нутгийн харилцааны үйл ажиллагаагаа сумын хэмжээнд өргөжүүлж, Багуудаар тогтмол яван, тодорхой цаг зарцуулж, аль болох олон малчидтай уулзаж харилцан орон нутагт тогтмол байрлаж ажилладаг орон нутгийн харилцааны ажилтнуудтай болох нь зүйтэй. (Бүрэлдэхүүн 2-ын тайланг үзнэ үү)
- Малчид ч мөн газар, устай холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэж ирсэн уламжлалт арга барилаа сэргээх эсвэл бэхжүүлэн хэрэглэх замаар машин тэрэг ихээр ашиглах болсон, тэдгээр нь бэлчээрийг гэмтээдэг, худаг цоожилдог гэх мэт ОТ-той хамааралгүй мал маллагаанд холбоотой асуудлаа хэрхэн шийдвэрлэж болох талаар бодолцох нь зүйтэй.

5 Нөхөн олговор авбал зохих бүх малчдад нөхөн олговор олгосон уу?

5.1 Цоорхой

Нөхөн олговрын гэрээний арга хэмжээний хэрэгжилтийн мөрөөр ОТ судалгаа хийдэг. Хэрэгжилт нь ихэнхдээ хангалттай түвшинд ахиж буй ажээ.⁵³ Гэхдээ нөхөн олговор авбал зохих бүх малчдыг нөхөн олговрын хөтөлбөрт хамруулсан үгүй эсэх нь гол асуудал юм. ОТМШБ-ийн Ажлын Даалгаварт малчин өрх тус бүрийн нөхөн олговор авах нэхэмжлэлийн үндэслэлтэй эсэхийг нягтлан судалж тогтоох ажил тусгагдаагүй.

⁵² Бүрэлдэхүүн 1-ийн судалгааны тайланд нөхөн олговортой шүүд хамааралгүй бусад зөвлөмжийг санал болгосон болно.

⁵³ Нийгэм, эдийн засгийн судалгааны явцад авах ёстой нөхөн олговороо аваагүй цөөн тооны малчид байгааг олж тогтоосон болно. Бүрэлдэхүүн 2-ын тайланг үзнэ үү. Бид эдгээр гомдлыг хянан баталгаажуулах боломжгүй. Гэрээний дагуу авах ёстой тэтгэмжийг авч чадаагүй тухай гомдлыг ОТ-н гомдол барагдуулах механизмд хандан шийдвэрлүүлэхийг нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан аливаа малчдад ойлгуулан дэмжихийг ГТЗ-д зөвлөж байна. Учир нь эдгээр асуудлыг шүүд шийдвэрлэх боломжтой асуудал гэж үзэж байгаа юм.

ОТМШБ-ийн судалгааны ажлын Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хийсэн Нийгэм-Эдийн засгийн судалгаа нь ОТ-н нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдсан малчид, ОТ-н нөхөн олговрын гэрээнд өөрсдийгөө хамрагдах ёстой гэж үзэж буй малчид, бусад малчид гэсэн гурван бүлгийг төлөөлсөн малчдыг түүврийн аргаар сонгож ярилцлага авсан билээ.

Бид дор дурдсан ангилалд хамаарах малчдын нэхэмжлэл 2004 ба/эсвэл 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдах үндэслэлтэй нэхэмжлэл байж болохыг олж тогтоолоо. Иймээс эдгээр ангилалд хамаарах малчдад хэрвээ тэд холбогдох баримт бичгийг бүрдүүлж чадвал нэхэмжлэлээ гаргах боломжийг олгох нь зүйтэй. (Нийгэм- эдийн засгийн судалгаагаар дор дурдсан ангиллын нэг эсвэл түүнээс дээш ангилалд хамаарч буй арван таван (15) өрхийг тодорхойллоо. ГТЗ нь “нөхөн олговор авах ёстой” гэж өөрсдийгөө үзэж буй ангилалд нийт гучин гурван малчин өрхийг ангилан тодорхойлсон байсан учраас судалгаанд хамрагдаагүй боловч дараах ангилалд хамаарах өөр малчин өрх байж болох юм.)

- 2004 оны нөхөн олговрын тухайд дор дурьдсан бүлгийн малчдад 2004 оны нөхөн олговорт хөөн хэлэлцүүлж орох хүсэлтээ нөхөн олговрын нэхэмжлэлийн хороонд тавих боломж олгох хэрэгтэй. (Хэсэг 5.2-ыг үзнэ үү)
 - Судалгаа авч байх үед эсвэл гэрээ хэлэлцэх явцад байгаагүй учраас нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдаж чадаагүй боловч 2004 оны нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай гэж заасан бүс нутагт өвөлжөөтэй байсан өрхүүд.
 - 2004 онд нүүлгэн шилжүүлэлт хийхээр тогтоогдсон бүсэд хаваржаатай байсан аливаа өрх
 - Нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур өвөлжөө эсвэл хаваржаатай байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсныг нь нотлох баримттай байх.
 - 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөрийн хүрээнд бусад малчдыг нүүлгэн шилжүүлсэн бүсэд суурин өвөлжөө ба/эсвэл хаваржааны бууцтай байсан, уг нүүлгэн шилжүүлэлт тэдний бэлчээр усны хүртээмжид сөрөг нөлөөлөл учруулсныг нотлон харуулж чадах малчид.
- 2011 оны нөхөн олговрын тухайд нөхөн олговрын хөтөлбөрт хамрагдах шалгуур үзүүлэлт нь ОТ-н тодорхой дэд бүтцээс тогтоосон зайд өвөлжөө нь байршдаг үзүүлэлт байжээ. Дараах бүлгийн хүмүүсийг нэмж оруулан, тэдэнд эхлээд нөхөн олговор авсан хүмүүсийнхтэй адил нөхөн олговрын багц олгох шаардлагатай.
 - Нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур өвөлжөөтэй байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсныг нь нотлох баримттай байх.
 - 2011 оны нөхөн олговор олгож байсан тухайн үед нөхөн олговрын бүсэд хаваржаа эзэмшдэг лицензтэй эсвэл нөхөн олговрын бүст ойрхон гэхдээ тигээс гадуур хаваржаатай байсан, нөхөн олговор авагсдын нэгэн адил нөлөөлөлд өртсөн малчид, гэхдээ тэр үед нөхөн олговор авагсадтай нэг бэлчээр, худаг

ашиглаж байсныг нь нотлох баримттай байх.⁵⁴ Тэднийг нөхөн олговрын хөтөлбөрт хамруулахгүй байх нөлөөлөлтэй холбоотой шалтгаан байхгүй. Тухайн үед Хаваржаа эзэмшдэг лицензтэй байсан хоёр (2) малчинд нөхөн олговор олгоно гэж хэлсэн учраас баримт бичгээ ОТ-д өгсөн гэж хэлснийг ярилцлагын явцад бид сонссон болно.

- Бууцны лицензгүй боловч нөхөн олговрын бүсэд өвөлжөөтэй эсвэл хаваржааны бууцтай байсныг сумын захиргаа бүртгэсэн аливаа малчид.
- ОТХШБ-ийн Бүрэлдэхүүн 2-ын хүрээнд хийсэн нийгэм-эдийн засгийн судалгаагаар сумын малчин өрхийн 16% нь гэрчилгээ аваагүй нь тогтоогдсон. 2004 эсвэл 2011 оны нүүлгэн шилжүүлэлттэй холбоотойгоор гэрчилгээгүй ч бууцтай байсан гэдгээ найдвартай баталж чадах малчид асуудлаа Нөхөн Олговрын Хороонд тавих боломжтой байх ёстой.
- Мөн зарим малчид 2004 оны нүүлгэн шилжүүлэлтээс өмнө уурхайн бүсээс нүүж явсан бөгөөд уурхайн улмаас нүүх болсон гэж бидэнд хэлж байсан. Бид эдгээр малчдад нөхөн олговор олгох ёстой гэж үзэхгүй байна, учир нь энэ бол ОУСК-ийн ГС5-д заасан ‘албадан нүүлгэлт’ биш байсан.
- Нөхөн олговрыг тооцох нэгжээр “өрх”-ийг ашиглаж байгаад бид санаа зовж байна. Нөхөн олговор авсан зарим өрх нь нэгээс илүү гэр бүл/айлтай байсан боловч 2004 ба/эсвэл 2011 оны нөхөн олговроор бусад гэр бүл/айлтайгаа хамт нөхөн олговрын нэг нэгж гэж тооцогдсон байна. Тус тусдаа нөхөн олговор авах ёстой байсан гэж үзэж буй гэр бүлүүдэд нөхөн олговрын асуудлаа тавих боломжийг олгох нь зүйтэй.

5.2 Зөвлөмж

ГТЗ нь Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) гэх мэт хөндлөнгийн бие даасан газрын харъяа нарийн бичгийн даргын тусламжтайгаар малчдын төлөөлөл, сумын захиргаа, ОТ-гоос тус бүр нэг гишүүнээс бүрдсэн 3 гишүүнтэй “Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо” байгуулах шаардлагатай. Тус хороо нь дээр дурдсан ангилалд хамаарах малчдаас хүсэлт, нэхэмжлэлийг нь хүлээн авч нэхэмжлэл гаргагчийн ирүүлсэн баримт, нотолгоо болон сумын захиргаа, ОТ-д байгаа холбогдох бусад мэдээллийг үндэслэн шийдвэр гаргах нь зүйтэй. Тус хороогоор асуудлаа хянуулан шийдвэрлүүлэхийн тулд хүсэлт, нэхэмжлэл гаргагч нь шалгуурыг хангаж буйгаа баталгаажуулсан баримт, нотолгоог бүрдүүлэн ирүүлэх ёстой бөгөөд энэхүү үйл явцад сумын захиргаа дэмжлэг үзүүлж, холбогдох албан ёсны баримт бичиг, бүртгэл мэдээллийг авч ашиглахад тусалцаа үзүүлнэ гэдэгт бид найдаж байна. Хүсэлт, нэхэмжлэл гаргах үйл явц нь тодорхой тогтоосон хугацаатай тухайлбал 12 сарын хугацаанд нээлттэй байх нь зүйтэй. Хүсэлт, нэхэмжлэлийг холбогдох баримт нотолгооны хамт ирүүлнэ. Тухайлбал:

- Хүсэлт, нэхэмжлэлтэй холбогдуулан нэхэмжлэл гаргагч нь 2004 эсвэл 2011 онд сумын захиргааны бүртгэлд малчнаар бүртгэлтэй байсан, ба,
- Холбогдох бүсэд өвөлжөөний бууцтай байсан бүртгэл эсвэл түрээслэж байсан баримт, эсвэл

⁵⁴ Малчдын бүлэг урьдчилсан тайланд өгсөн саналдаа нөлөөллийн бүсийг 5 км-ээр ахиулж, одоогийн нөлөөллийн бүстэй ойрхон гэхдээ тигээс гадуур малчдад учирсан нөлөөллийн асуудлыг шийдвэрлэх хүсэлт гаргасан. Дахиад дурын хил зааг тогтоох нь зөв шийдэл биш гэж бид үзэж байгаа ба нөхөн олговор авсан малчидтай нэг бэлчээр, худаг ашиглаж байсан тул өөрийгөө мөн нөлөөлөлд өртсөн гэж үзэж буй малчид асуудлаа санал болгож буй ‘Нөхөн олговрын хороонд’ гаргах хэрэгтэй.

- Малчид бууцны бүртгэгдсэн гэрчилгээгүй байх цөөн тохиолдолд сумын эрх бүхий байгууллагын тодорхойлолт; багийн даргын зурсан уламжлалт бууцны газруудыг тэмдэглэсэн хуучин гар зураг болон орон нутгийн иргэдийн зөвшилцөл нотолгоо болж болох юм.

6 Тогтвортой амьжиргаанд шилжихэд хангалттай нөхөн олговор олгогдсон уу?

6.1 Ямар нөхөн олговор олгосон бэ?

2004 ба 2011 онд олгосон нөхөн олговрын багцыг дор Хүснэгт 3-т тоймлон харууллаа. 2004 оны нөхөн олговор нь алдагдсан эд хөрөнгө (өвөлжөө ба худаг); мал (шүүд хэлээгүй ч цаад санаа нь нүүлгэн шилжүүлэлтийн улмаас учирсан мал эсвэл бүтээмжийн алдагдлыг дүйцүүлэн нөхөх) аль алины нөхвөрийг хамарсан, мөн боловсролын дэмжлэг, ажлын байрны олгох замаар өрхийг урт хугацаанд хөгжүүлэхэд туслах арга хэмжээг мөн тусгажээ. 2011 оны нөхөн олговор нь өрхөд үзүүлэх дэмжлэг туслалцааны тухайд нийт малчдад зориулсан нийтийн нөхөн олговрын хөтөлбөрөөр дамжуулан бэлчээрийн тогтвортой менежментийг дэмжих гэх мэт 2004 оныхтой ижил олон элементийг агуулсан байна.⁵⁵

Хүснэгт 3: Нөхөн олговрын тойм

2004 – Өвөлжөөний биет нүүлгэн шилжүүлэлт ⁵⁶	2011 – Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт ⁵⁷
<ul style="list-style-type: none"> • Банзаар барьсан зуны байшин. • Банзаар барьсан малын хороо. • Шинэ байршилд гэр(үүд), эд хогшлыг нүүлгэх унаа, тээвэрлэлт • Гэрээ байгуулах үед тухайн өрх хичнээн малтай байсан төчнөөн малыг усаар хангахуйц нэгээс доошгүй худаг эсвэл цооногийг засаж тохижуулах эсвэл гаргаж өгөх • Тохирсон тооны мал. • Тухайн айлын нэр заасан хоёр оюутанд боловсролын зардал: • Төлбөр • Тээврийн зардал • Байрны зардал (зөвхөн их сургуулийн оюутанд) • Сургуулийн дүрэмт хувцас, 	<ul style="list-style-type: none"> • Замын туслах ажилтан - хагас цагийн байнгын ажил • Боловсрол • Дээд боловсролын тэтгэлэгт нэг удаа 5 сая төгрөг • Тухайн айлын сургуульд сурдаг хүүхдүүдэд 215,000 төгрөг • Хэрвээ тухайн өрхөд оюутан, сурагч байхгүй бол тухайн өрхийн амьжиргааг сайжруулах хөтөлбөрт 5,215,00 төгрөг хуваарилсан • Монгол Улсад насанд хүрэгсдийн 45 хоногийн сургалтын хөтөлбөрт хамрагдах нэг удаагийн тэтгэлэгт 300,000 төгрөг. • Бэлчээрийн тогтвортой

⁵⁵ ГТЗ дэх малчдын бүлэг ОТ газарт түшиглэсэн амьжиргааг сэргээх стратегийг эн тэргүүнд хэрэгжүүлэх ёстой байтал чадаагүй гэж үзсэн. Бид үүнтэй санал нийлэхгүй, нүүлгэн шилжүүлсэн ч нүүдлийн мал аж ахуй үргэлжлэн оршин тогтнох бололцоо хэвээр байгаа, мал маллагааг дэмжих нөхөн олговрын элемент, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нөхөн олговор зэргийг агуулсан, нөлөөлөлд өртсөн хүмүүсийн эн тэргүүний хэрэгцээг тусгасан ОТ-н аргыг зохистой гэж үзэж байна.

⁵⁶ 2004 нөхөн олговрын гэрээний нэг жишээн дээр үндэслэв.

⁵⁷ Оюу Толгойн Нөхөн Олговрын Гэрээ 2011, ерөнхий, англи хувь

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

<p>хэрэгслийг жилд нэг удаа.</p> <ul style="list-style-type: none">• Гэр бүлийн нэг гишүүнд ажлын байр• Сургалт – тухай бүр үнэлгээ хийж өөрөө сонгох.	<p>менежментийг сайжруулах санд өрхөөс хандивлах 35,000 төгрөг.⁵⁸</p> <ul style="list-style-type: none">• Бизнес эрхлэхэд туслалцаа үзүүлэх (амьжиргааны дэмжлэг).
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

2004 оны нөхөн олговрын гэрээ муу боловсруулагдсан. Тус гэрээ нь уурхайн үйл ажиллагаа хэдэн арван жил үргэлжилж болно гэдгийг хүлээн зөвшөөрөөгүй байна. Ялангуяа нэг айлын нэг гишүүнийг ажлын байраар хангахаар амласан нь зөвхөн нэг хүнд ноогдож буй амлалт (хэрвээ компанийн дүрэм журмыг зөрчсөний улмаас ажлаасаа халагдвал түүний оронд өөр хүнийг сольж авахыг зөвшөөрөхгүй гэж заасан) бөгөөд “нэр заасан/дэвшүүлсэн гишүүнийг” л дурьдсан байна. Гэтэл тус гэрээнд тэтгэмж авах шалгуурыг хангасан гэр бүлийн гишүүний жагсаалтанд өөр хүмүүсийг нэмж оруулахыг зөвшөөрсөн байдаг. Ийм учраас л нэг айлын нэг гишүүнийг ажлын байраар хугацаагүй хангах гэрээг ОТ байгуулсан байх гэж зарим малчид үзэж байгаагаа бидэнд хэлсэн юм.

6.2 Тогтвортой амьжиргаанд шилжих шилжилт – 2004

2004 оны Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөөний Хэрэгжилтийн Аудитыг хөндлөнгийн мэргэжилтнүүд 2014 хийсэн бөгөөд цаг хугацааны дарааллаар өгөгдөл мэдээлэл байхгүй, өгөгдөл мэдээллийн цоорхой байгаа учраас өрхийн амьжиргааг цогцоор нь үнэлж дүгнэхэд хэцүү байв гэж дүгнэсэн. Харин түүний оронд 2004 ба 2014 онд тухайн өрх хичнээн малтай байсан малын тоо, эзэмшиж буй эд хөрөнгийн тоог харьцуулж, нөхөн олговрын гэрээгээр хүлээсэн үүрэг, амлалт хэдий хэмжээтэй хэрэгжснийг баримтжуулжээ. Түүнчлэн нөхөн олговрын талаарх малчдын бодол саналыг тэмдэглэсэн байна. Тогтвортой амьжиргаанд шилжих шилжилтийн хувьд аудитын багийн онцолсон гол асуудал бол нөхөн олговор авсан арван өрхийн найм нь 2014 онд илүү олон малтай болсон; гүн өрмийн арван худгаас зөвхөн хоёр нь ажиллаж байгаа харин орлуулсан гүехэн гүний усны гар худгуудыг ашиглах боломжтой байсан (нэгээс бусад тохиолдолд, гэхдээ энэ айлд гүн өрмийн худаг нь ажиллах боломжтой байсан); арван өрхийн дөрөвт нэр дэвшүүлсэн гишүүн нь ажлаас халагдсан тул байнгын ажлын байраар хангах нөхцөл амжилтгүй болсон.⁵⁹

Энэ нь бидний судалгааны явцад олж тогтоосон ажиглалттай нэлээд нийцэж байгаа юм: зарим өрх мал маллаж амьжиргаагаа амжилттай сэргээж чадсан эсвэл эдийн засгийн бусад боломжийн давуу талыг ашиглахаар зохицож чадсан байхад зарим нь чадаагүй. Нөхөн олговрын багцын боловсролын дэмжлэг үзүүлэх хэсгийг нийтээр дуртайяа хүлээн авсан бөгөөд эерэгээр дүгнэж байгаа боловч 2004 оны нөхөн олговрын бусад бүрэлдэхүүний хувьд бэрхшээлтэй асуудлууд байна. Үүнд:

- Орлуулж олгосон хөрөнгө
 - Өвлийн улиралд ашиглах хашаа хороог модоор барьж өгсөн нь улирлын нөхцөл байдалд сайн тохироогүй. Хашаа хороог барихдаа чулууны оронд

⁵⁸ 2015 оны Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөөнд дурдсанчлан, энэ дүнг малчдад бэлнээр төлсөн.

⁵⁹ 2004 Нүүлгэн шилжүүлэлтийн гүйцэтгэлийн аудит, 2014 оны 9-р сар, өрх тус бүрээр анализ шинжилгээ хийсэн, Хуудас 8-33.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

мод ашиглахыг малчид зөвшөөрсөн гэсэн боловч ашигласан модны төрөл нь тохиромжтой биш байсан байна. Шинээр орлуулан сольж өгсөн зарим хашаа хороо нь орхигдож хаягдсан.

- “Зуны байшин” нь малчдын соёлын нэг хэсэг биш учраас тэдгээрийг хүлээн авсан өрхүүдийн ихэнхэд хэрэгцээтэй байсан нь нотлогдоогүй. Зуны байшин хүлээн авсан нэг малчин модыг нь сумын төв дээр байшин барихдаа ашигласан байна.⁶⁰
 - Орлуулан шинээр барьж өгсөн худаг нь малчидтай тохиролцсон дагуу анх гүн өрмийн худаг байсан ажээ. Эдгээр худгийн ихэнх нь механик болон эдийн засгийн (жишээ нь насос ажиллуулах түлш өндөр үнэтэй) төрөл бүрийн шалтгааны улмаас амжилттай болоогүй гэдгийг ОТ-н мониторингийн баг хүлээн зөвшөөрсөн юм. Нэгээс бусад тохиолдолд ажиллахгүй байгаа гүн өрмийн худгийг гар худгаар сольж барьж өгсөн бөгөөд тэдгээр гар худгууд нь хангалттай түвшинд ашиглагдаж (2014 оны Гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэнд дурдсанчлан) байна.
 - 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийг хийхдээ бусад малчидтайгаа зөвшилцөж өвөлжөө бууцны байршлын хуваарилалт хийдэг уламжлалт үйл явцыг дагаж мөрдөөгүй. Иймээс нүүлгэн шилжүүлсэн зарим өвөлжөө бууцны улмаас тухайн газарт өмнө суурьшин ашиглаж байсан малчид хэрэглэгчдийн дунд маргаан, хурцадмал байдлыг бий болгосон байна.
- Ажлын байр
 - Ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийн тэргүүн түршлагаас харахад хүмүүсийг шууд буюу шууд бус ажлын байртай болох боломж бололцоонд оролцох нөхцлийг бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулахыг зөвлөдөг. Уурхай нь иргэдийг тодорхой ажлын байр тус бүрт шаардлагатай зохих ур чадварыг эзэмшихэд туслах сургалтанд хамруулах асуудлыг амьжиргааг дэмжих багц хөтөлбөрийн хүрээнд тусгаж оруулах нь зүйтэй. Харин ажлын байраар хангах баталгааг амьжиргааг дэмжих багц хөтөлбөрт оруулах ёсгүй.⁶¹
 - ОТ-д ажлын байртай байж, хөдөлмөр эрхлэх нь тухайн иргэний амьжиргаанд маш их дэмжлэг болж байна. 2004 онд нүүлгэн шилжүүлэгдсэн 10 өрхийн зөвхөн нэг нь л өрхийн орлогод нэмэрлэх цалинтай байжээ. 2014 онд арван өрхийн долоо нь цалингийн орлоготой, нэг өрхийн орлогын тал хувь нь ОТ-д автобусаар үйлчилгээ үзүүлэн өрхийн орлогоо бүрдүүлж байна.⁶² 2004 онд нүүлгэн шилжүүлэгдсэн малчидтай ярилцах үед тэд бүгд ажлын байр хичнээн чухал болохыг цохон тэмдэглэж байлаа. Арван өрхийн дөрөвт ОТ-д ажилд орсон гишүүн нь ажлаас халагдсаны улмаас ОТ байнгын ажлын байраар хангах заалт хэрэгжээгүй байна. 2004 онд нүүлгэн шилжүүлэгдсэн малчидтай ярилцах үед, ОТ-д ажлын байртай болж хөдөлмөр эрхлэх боломжийг дахин олгохыг хүсэж байв. Түүнчлэн хөлсөөр ажиллах гэдгийг малчид одоо илүү сайн ойлгодог болсон, одоо тухайн ажлыг хийж чадах илүү чадварлаг залуучууд байгаа гэж хэлж байв. Хувийн хэвшлийн компанид цалин хөлстэй ажил хөдөлмөр

⁶⁰ 2004 Нүүлгэн шилжүүлэлтийн гүйцэтгэлийн аудит, 2014 оны 9-р сар, Хуудас.31.

⁶¹ Айвенхоу Майнс Монголиа Инк, Газар Чөлөөлөх ба Нүүлгэн Шилжүүлэлт, Сургамж, 2015, Хуудас. 32,40.

⁶² 2004 оны Нүүлгэн шилжүүлэлтийн гүйцэтгэлийн аудит, 2014 оны 9-р сар, Хуудас.8-33.

эрхлэх талаар Говийн нүүдэлчин малчид өмнө нь туршлагагүй байсан учраас ажлын байртай холбоотой зүйл заалтын хэрэгжилтүүд ийнхүү бүтэлгүйтсэн нь таамаглууштай зүйл юм.

- Бүлгийн ярилцлага болон ганцаарчилсан ярилцлагын үеэр өрхүүдийн дотор ОТ-д гэр бүлийн гишүүн нь ажилладаггүй лав нэг өрх эдийн засгийн хувьд хүндрэлтэй нөхцөлд амьдарч байгааг бид олж тогтоосон бөгөөд; мөн өөр нэг өрх ОТ-с үл хамаарах хүчин зүйлийн улмаас (жишээ нь. өрхийн тэргүүн зуурдаар нас барсан гэх мэт) ахуй амьжиргаа нь хүндрэлтэй байгаа нь тодорхой байв.

6.2.1 Зөвлөмж

Бид 2004 оны нөхөн олговрын дутагдалтай сул талыг дараах байдлаар шийдвэрлэхийг зөвлөж байна:

- ГТЗ нь Эрх Зүйн Хяналт Нийцэл, Зөвлөгөө, Омбудсмений Газар (ЭЗХНЗОГ) гэх мэт хөндлөнгийн бие даасан газрын харьяа нарийн бичгийн даргын тусламжтайгаар тал тус бүрийн (малчдын төлөөлөл, сумын захиргаа, ОТ) нэг гишүүнээс бүрдсэн 3 гишүүнтэй хороо байгуулж орлуулан барьж өгсөн малын хашаа хороо нь нөхөн олговор авах тухайн үед өрхийн маллаж байсан малын тоонд (энэ тоог нөхөн олговрын гэрээ тус бүрт дурдсан байдаг) хангалттай эсэхийг үнэлж дүгнэхийг бид зөвлөж байна. Хэрвээ хашаа хороо нь хангалтгүй гэж үнэлэгдвэл тухайн хашаа хороог хангалттай түвшинд хүргэхийн тулд ОТ-оос засаж сэлбэх эсвэл сольж барих нь зүйтэй.⁶³
- Ажилд орсон хүн нь ажлаасаа халагдсаны улмаас гэр бүлийн гишүүн нь одоо ОТ-д орон тооны ажил хөдөлмөр эрхэлдэггүй, 2004 онд нөхөн олговор авсан өрхүүдэд (мөн дээр 6.2 дахь Хэсэгт дурдсан үйл явцын үр дүнд нөхөн олговор авах айл өрхийн жагсаалтанд нэмэгдсэн аливаа өрхийг оролцуулан) далд уурхайн барилгын ажил (түр) эсвэл уурхайн үйл ажиллагаанд (урт хугацаанд) гэр бүлийн нэг гишүүнээ ажиллуулах боломжийг ОТ-с санал болгох хэрэгтэй. Учир нь 2004 онд хувийн хэвшлийн цалинтай ажлын байр бараг байхгүй байсан Ханбогд суманд мал маллаж байсан хүмүүс хувийн хэвшил рүү төвөггүй шилжээд ажиллалчих юм шиг дэндүү өөдрөг хандсан бөгөөд тийм ч учраас ажил эрхлэлт нь бүтээгүй өрхүүдэд дахин нэг боломж олговол зохистой. Тайлбар: Гэхдээ ОТ-н ажлын байранд тавигдах шаардлага, ур чадварын шалгуурыг хангаж чадах өрхийн гишүүн байгаа эсэхээс шалтгаална. Ажилд орсон хүн нь тэтгэвэрт гарах, ажлаасаа чөлөөлөгдөх эсвэл халагдах гэх мэт шалтгааны улмаас ОТ-д ажиллах хөдөлмөр эрхлэлт нь дуусгавар болсон тохиолдолд тухайн өрхийн өөр нэг гишүүнийг ажлын байраар хангах үүргийг ОТ хүлээхгүй гэдэг тодруулгыг нөхөн олговрын гэрээнд нэмэлтээр тусгаж оруулах нь зүйтэй. Гэхдээ малчин өрхийн гишүүд ОТ-д ажилд орохоор өргөдлөө гаргаж болох бөгөөд ОТ-н ажилд сонгон шалгаруулж авах бодлого журмын дагуу авч үзнэ.

6.3 Тогтвортой амьжиргаанд шилжих шилжилт, 2011

ОТ нь 2013 оноос хойш Нөлөөлөлд Өртсөн Өрхийн Судалгааг жил бүр хийх замаар 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр өгөөжийг хянан мониторинг хийж байна. Энэ

⁶³ Одоо байгаа малын тоо толгойд нийцэхүйц томоохон хашаа хороотой болохыг малчид хүсвэл, том хашаа хороо барихад шаардлагатай нэмэлт зардлыг малчин өөрөө хариуцах ёстой.

судалгаагаар өрхийн бүтэц, ашиглаж буй худгийн тоо, малын тоо, сүргийн бүтэц, боловсрол, үр чадвар, орлогын түвшин зэргийн талаар мэдээлэл цуглуулдаг. Нөхөн олговор авсан өрхүүдээс ОТ-д гэр бүлийн гишүүн нь ажилладаг, эсвэл бизнесийн хөгжил эсвэл сургалтын хөтөлбөрт хамрагдсан өрхийн талаарх мэдээллийг ОТ мөн хөтөлдөг. Хайрцаг 1-ийг үзнэ үү.

Хайрцаг 1: Нөхөн олговор авсан өрхийн гишүүний хөдөлмөр эрхлэлт ба сургалтанд хамрагдсан байдал (2016 оны 7-р сар)

ОТ-н байнгын ажлын байр

- 2011 оны нөхөн олговрын гэрээтэй 89 өрхөөс 12 хүн ил уурхайд ажилладаг
- 2004 оны гэрээтэй өрхүүдээс 6 хүн ОТ-д байнгын ажилтай

Шинэ үр чадварын ажил

- Ханбогд сумын төвд байрлах ОТ-н мод үржүүлгийн газарт 10 хүн 8 сарын хугацаанд ажилласан
- 25 хүн Хамтын Оролцоот Усны Мониторингийн Хөтөлбөрт хамрагдсан (орон тооны бус)
 - Гар худгийн усны мониторинг – 21
 - Хайлаас модны мониторинг (зураг) – 3
 - Зэрлэг ан амьтдын мониторинг – 1
 - Соёлын дурсгалт газрыг хамгаалах – 7

Сургалтанд оролцсон байдал:

- Ажилд бэлтгэх сургалт- 8
- Дадлагажигч/ ажлын үр чадварын сургалт- 2
- Ботгоны ноосны сургалт- 18
- Эсгий урлалын сургалт- 5
- Тэмээний ноос цахилгаан хайчаар хяргах сургалт – 18

Хоршооны төслүүд

- “Их Ногоон Гурвалжин” Хоршоо – Мал/амьтны эрүүл мэндийн төсөл
- “Төрлийн Мянган Тайж” –Шилдэг хоршоо, Мал эмнэлгийн төсөл
- “Говийн Баян Эрдэнэс” –Хоршоо; Тэмээний ноос хяргах төсөл
- “Хан-Оорцог” Хоршоо – Худаг сэргээн засах төсөл

Оюутны тэтгэлэг: 2011 ба 2004 оны гэрээнээс 14 оюутан; одоо суралцаж байгаа 2.

Эх сурвалж: ОТ, e-мейл, 2016 оны 7-р сар.

2011 оны нөхөн олговрын хөтөлбөр нь нөхөн олговор авсан өрхүүдийн амьжиргаанд эсвэл нийт малчдад үзүүлсэн хэрхэн нөлөөллийн талаар аудит хараахан хийгдээгүй байна.

Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговор олгоход ОТ-н ашигласан арга барил нь түр ажлын байраар хангах, орлогын шинэ эх үүсвэртэй (зарим нь мал аж ахуйтай холбоотой, зарим нь мал аж ахуйтай холбоогүй) болоход нь туслалцаа үзүүлэх, залуу хойч үеийнхэнд боловсролын дэмжлэг үзүүлэх зэргээр тэдгээр хүмүүсийн амьжиргааг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд зохистой байсан байна. Гэвч 2011 оны нөхөн олговрын хэрэгжилт, үр дүнд бэрхшээлтэй асуудлууд байсаар байна. Үүнийг ОТ болон малчдын аль аль нь хэдийн ойлгож мэджээ.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

25

- Зам арчилгааны ажилтнаар хагас цагаар ажиллах нөхцөл нь анх малчид малаа хариулахын зэрэгцээ бэлэн мөнгөний нэмэлт орлоготой байх боломжийг бүрдүүлэх зорилготой байжээ. Энэ бол сайхан санаа байсан. Гэвч хийж гүйцэтгэх уг ажил нь үүрхэйн үйл ажиллагааны цалин хөлсний тогтолцоогоор бус орон нутгийн төсвийн нэг хэсэг байдлаар менежмент нь хийгддэг учраас малчид уг ажлыг утгагүй, хэрэгцээгүй, цаашид өсөж дэвжих боломж хязгаарлагдмал ажил гэж үзжээ. Хээрийн судалгаа хийж байх явцад ахмад настай ажилтантай зарим өрхүүд хагас цагийн энэ ажлаа бэлэн мөнгөнд шилжүүлэн дуусгавар болгосон; зарим нь (сард \$380 ам доллар) авдаг ч ажлаа хийдэггүй, харин зарим хүмүүс ажлаа хийсээр байгаа гэх мэт янз бүр байв. Зам арчилгааны хөтөлбөрт хамрагдан ажиллаж байгаа 27 хүн үргэлжлүүлэн ажиллах сонирхолтой байгаа болохыг ОТ бидэнд дурдсан болно. 2011 оны нөхөн олговрын гэрээнд заасан 5 жилийн хугацаанд ажлын байраар хангах заалт 2016 оны 11-р сарын сүүлээр дуусч байна. Хэдийгээр хийх ажил нь таалагдахгүй ч олон айл өрх уг ажилтай холбоотой олгож буй бэлэн мөнгөний орлогоос хамааралтай амьдрах болжээ.⁶⁴
- Хэдийгээр зарим нь чадаагүй ч, цөөн хэдэн өрх бизнесийн үйл ажиллагаагаа амжилттай эхлүүлжээ. Жишээ нь. Өлзийт Мөнх Овоо ХХК нь ОТ-д ажлын хувцас нийлүүлдэг оёдол эсгүүрийн үйлчилгээ үзүүлэгч, түүнчлэн автобусаар үйлчилгээ үзүүлэгч гэх мэт.

2011 оны нөхөн олговортой холбоотой асуудлыг шийдвэрлэх нь 2004 оны нөхөн олговортой холбоотой асуудлаас илүү хэцүү юм. Ялангуяа, зам арчилгааны ажил хийж гүйцэтгэх гэрээний дагуу олгож буй бэлэн мөнгөнөөс хараат болсон асуудлыг зохицуулах хялбар шийдлийг бид олж харж чадсангүй.

6.3.1 Зөвлөмж

Бид дараах арга хэмжээ авахыг ОТ-д зөвлөж байна:

- 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хөндлөнгийн аудит хийлгэж, тодорхойлж өгсөн засч залруулах арга хэмжээг гүйцэтгэх
- Аудитаар өрхийн орлогоо амжилттай нөхөн сэргээж чадаагүй өрхийг тогтоон, хэрвээ өрхийн орлого буурсан нь ОТ-н эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтээс болсон бол цаашид тухайн өрхөд тохирох тусгайлсан арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэх.⁶⁵
- 2011 оны нөхөн олговрын гэрээтэй, амьжиргаагаа сэргээж чадаагүй айл өрхүүдэд Бүрэлдэхүүн 1-ийн судалгаанд санал болгож зөвлөсөн худаг гаргах, засан сэлбэх, мониторинг хийх техникчдийн багт орж ажиллах сонирхолтой, чадвартай хүн байгаа бол эдгээр ажлын байрыг эн тэргүүнд тэдэнд олгох нь зүйтэй.
- Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжилт авах төслийн санал боловсруулахад нь малчдад туслалцаа үзүүлж буй зөвлөхүүдийн ажлыг үргэлжлүүлэн дэмжих. Алслагдмал байршил, хүн ам цөөнтэй зэрэг шалтгааны улмаас Ханбогд суманд бизнес эрхлэхэд хүндрэлтэй ч эдгээр хүчин чармайлтыг үргэлжлүүлэх нь зүйтэй.

⁶⁴ ОТМШБ/ХШБ-ийн урьдчилсан тайланг хэлэлцсэн ГТЗ-ийн 2016 оны 10 сарын хурал дээр эдгээр гэрээнүүдийг хэрхэн дуусгавар болгох тухай хэлэлцсэн.

⁶⁵ Төслийн НШТ-гөөр хүлээсэн үүргийн дагуу Үр Дүнгийн Үнэлгээ ба Аудитийг хөндлөнгийн шинжээчээр хийлгүүлэхээр төлөвлөж байна гэж ОТ бидэнд мэдээлсэн.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

6.4 Бэлчээрийн нийт хүртээмж буурсны нөхөн төлбөр –нийтийн нөхөн төлбөр

Малчдын ихэнх нь хувь хүнд олгох нөхөн олговрын талаар санаа зовинож буйгаа илэрхийлж байв. Гэвч ОТ-н улмаас бэлчээрийн хомсдол үүссэнд олгох ялангуяа бэлчээрийн олон төрлийн дарамт ихэссэн гэдэг агуулгын хүрээнд нийтийн нөхөн олговор олгох нь чухал бөгөөд энэ нөхөн олговор нь сумын бүх малчдад эерэгээр нөлөөлөх магадлалтай. Бүрэлдэхүүн 1-ийн судалгааны тайланд дүгнэсэнчлэн, “Ханбогд суманд бусад уул уурхай, газрын баялгийн олборлолт, шинэ дэд бүтцийн байгууламжид шаардлагатай газрын хэрэгцээ одоо болон ирээдүйд нэмэгдэх асуудал тулгарч байна.” Сумын бэлчээрийн менежментийг сумын захиргаа хариуцах ёстой хэмээн ОТ үзэж буй нь зөв ч энэ тал дээр ОТ сумтай хамтран ажиллаж чадна, ажиллах ч ёстой. 2015 оны 9 сард Ханбогд сумын Мал Аж Ахуйн Салбарын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр батлагдсан.⁶⁶ Энэ хөтөлбөрийн тодорхой хэсгүүдийг ОТ ба орон нутгийн эрх бүхий байгууллагуудын хооронд байгуулсан Хамтын Ажиллагааны Гэрээний хүрээнд санхүүжүүлнэ гэж заажээ.

Бэлчээрийн менежментийг сайжруулах, сумын малчдад туслалцаа үзүүлэхийн тулд ОТ хэд хэдэн хөтөлбөр боловсруулсан байна.⁶⁷

- 2010 онд Монголын Бэлчээрийн Менежментийн Холбоотой гэрээ байгуулж бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулжээ. Үүнийг 2011 оны НШТ-нд нийтийн нөхөн олговрын арга хэмжээ гэж тайлбарласан байдаг. Хөтөлбөр бэлчээрийн эрүүл байдал, арван таван мониторингийн цэгийн орчмын усан хангамж, бэлчээрийн асуудал ба боломжит шийдлийн талаар малчидтай зөвлөлдөх зэргийг хамарсан бөгөөд үүний үр дүнд Бэлчээр ашиглагчдийн бүлгийн үзэл санаанд үндэслэн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө гаргаж, судалгаа тогтмол явуулан, бэлчээр ашиглагчдийн бүлгийн эргэлтийн сангаас дэмжлэг олгож байна.⁶⁸
- Улмаар газар ашиглалтын зөвлөх байгууллага болох Нутаг Түншлэлтэй гэрээ байгуулан, Хамтын Оролцоот Бэлчээрийн Мониторингийн төслийг Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдад хэрэгжүүлж, хоёр жилийн туршид мэдээ цуглуулсан байна. Нутаг түншлэлээс Ханбогд суманд бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, үүний тулд хэд хэдэн бусад судалгаа, үнэлгээ хийх хэрэгтэй гэж зөвлөжээ.
- 2015 оны 4 сард ОТ, Өмнөговь аймаг, сумдын хооронд байгуулсан (Ханбогдыг оролцуулан) Хамтын Ажиллагааны Гэрээгээр талууд Гэрээний долоон үндсэн сэдвийн нэг болох уламжлалт мал аж ахуй, бэлчээр ашиглах нүүдэлчдийн уламжлалыг хадгалах, хөгжүүлэхэд хамааралтай талуудтай хамтран ажиллах үүрэг хүлээсэн болно. Хөтөлбөр бүрэн хэлбэрээр гараагүй байгаа, 2016 оны 10 сарын байдлаар дараах төслүүд батлагдсан байв, үүнд:
 - Ханбогд дахь сум хоорондын малын эрүүл мэндийн төв
 - Ханбогд сумын “Эрүүл Малчин” хөтөлбөр (батлагдсан)

⁶⁶ Ханбогд сумын Мал Аж Ахуйн Салбарын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр, 2015. Энэ хөтөлбөрийг дараах бодлого, хөтөлбөрүүдийн дагуу боловсруулсан байна: Монгол улсын Их Хурлаас баталсан “Малчдын тухайд улсаас баримтлах бодлого” 2009, Монгол Улсын “Мал Хөтөлбөр” 2010, Монгол улсын засгийн газрын “Эрчимжсэн мал ахуй хөгжүүлэх хөтөлбөр” 2006, Өмнөговь аймгийн “Малчин Хөтөлбөр” 2010, “Ханбогд сумын нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөө 2014-2023” 2014.

⁶⁷ Өнөөгийн байдлаар эдгээр хөтөлбөрүүд үр дүн багатай. Бүрэлдэхүүн 1-ийн тайланг үзнэ үү.

⁶⁸ 2011 НШТ, х. 15, 61, 74, 82.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

- “Мал сүргийн халдваргүйжүүлэлт - 2016” төсөл Өмнөговийн бүх сумдад хэрэгжинэ. Хамтын Ажиллагааны Гэрээ энэ хөтөлбөрийг хамтран санхүүжүүлнэ.

Өөр хоёр төсөл уламжилсан, одоогоор батлагдаагүй байгаа аж.

- Өмнөговь аймгийн зүүн хэсэгт бэлчээрийн даацын үнэлгээ хийх
- Ханбогд сумын бэлчээр, ус, гидрологийн судалгаа
- Түүнчлэн, ОТ зарим худаг, бэлчээрийг шууд нөхөн сэргээж, найман байршилд ус түгээх түр хөтөлбөрийг хэрэгжүүлжээ.

ОТ-н үйл ажиллагааны улмаас бэлчээрийн ерөнхий хомсдол үүссэний нөхөн төлбөрийг орон нутгийн түвшинд олгохыг бид үндэслэлтэй гэж үзэж байна. Орон нутгийн түвшний нөхөн олговор нь малчид бүртгэлтэй бүүцтай байхын зэрэгцээ сумын хэмжээгээр бэлчээрийн газарт чөлөөтэй нүүж сууж явдаг уламжлалт мал маллагааны нүүдэл хөдөлгөөнийг тусгаж байна. ОТ, сумын захиргааны албан хаагчид эсвэл малчдын аль аль нь нийтийн нөхөн олговор үр дүнтэй эсэхэд итгэл үнэмшил багатай байдал бидэнд ажиглагдсан. Гэвч Хамтын Ажиллагааны Гэрээний хүрээнд бэлчээрийн менежмент дээр урт хугацаанд хамтран ажиллах үндэс суурь бий болж байгаа болохоор шинэ арга барилаар ажиллаад үзтэл нь элдэв өөрчлөлт санал болгох нь ухаалаг бус гэж бид бодож байна.⁶⁹ Хамтын Ажиллагааны Гэрээ малчдын асуудлыг авч үзэн, шийдвэрлэсээр байхыг бататгахын тулд 5 жилийн турш санхүүжилтийн тодорхой хэсгийг сумын бэлчээр, малчдын усны арга хэмжээнд зориулан нөөцлөхийг бид санал болгож байна.

7 Нөхөн олговрын үйл явц нь Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн 5-р (ОУСК-ийн ГС5) стандартад нийцсэн үү?

7.1 ОУСК-ийн 5-р Гүйцэтгэлийн Стандартад юу шаарддаг вэ?

ОУСК-ийн ГС 5 нь биет нүүлгэн шилжүүлэлт ба/эсвэл эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн улмаас нөлөөлөлд өртсөн хувь хүн, олон нийтэд олгох нөхөн олговор буюу газар чөлөөлөх үйл явцад баримтлах олон улсын жишиг стандарт түвшнийг тогтоосон байдаг. Энэ нь нилээн урт, нарийн төвөгтэй баримт бичиг байдаг. Гол шаардлагуудыг дурьдвал:

- Төслийн улмаас хэрэгжүүлэх биет нүүлгэн шилжүүлэлт болон эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн тоог аль болох бууруулах.
- Биет нүүлгэн шилжүүлэлт болон/эсвэл эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийх шаардлагатай бол нүүлгэн шилжүүлэлт болон амьжиргааг нөхөн сэргээхтэй холбоотой шийдвэрийг ил тод, нөлөөлөлд өртсөн хүмүүстэй зөвлөлдөн гаргаж, эмзэг хүмүүст учруулах нөлөөлөл, тэдэнтэй харилцахад анхаарах, аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэх гомдол барагдуулах механизмтай байх. Гомдлыг барагдуулах механизм нь тэдний асуудлыг дахин хянаж үзэх хүсэлтийг хөндлөнгийн этгээдэд тавих боломжийг олгох ёстой.⁷⁰

⁶⁹ Урьдчилсан тайлангаар нийтийн нөхөн олговорт арай өөр аргаар хандахыг бид санал болгож байсан, ОТ-н хувьцааг малчдад олгож, ОТ-н амжилтаас шууд ашиг олдог болгох гэх мэт. Гэтэл арван жилийн хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг оногдохгүй гэж сонсоод энэ саналаа татаж авлаа.

⁷⁰ ЭЗХНЗОГ, Хөгжлийн төслүүдийн гомдлын механизмыг боловсруулах, хэрэгжүүлэх заавар, х. 13

- Эдийн засгийн нөлөө учруулж байгаа тохиолдолд төслөөс амьжиргааг нөхөн сэргээх тодорхой төлөвлөгөөг гаргасан байх.
- Нөхөн олговор авч, амьжиргааг нөхөн сэргээх арга хэмжээ авсны дараа нөлөөлөлд өртсөн хүмүүсийн амьжиргаа төслөөс өмнөх үеийн амьжиргааны түвшин болон орлоготойгоо ижил байх эсвэл сайжирсан байх нь гол зорилго байдаг.
- Төслөөс зарласан “Тасалбар болох өдрөөс” хойш нөхөн олговрын бүсэд нүүж ирсэн хүмүүс нөхөн олговор авах эрхгүй.
- Зорилго биелсэн болохыг баталгаатай харуулж чадах хүртэл нөхөн олговор, амьжиргааг нөхөн сэргээх үйл ажиллагаанд мониторинг хийж ахиц гарч буй эсэхийг хянах ёстой.

7.2 Гүйцэтгэлийн Стандарт 5-тай нийцэж буй байдал

7.2.1 Тойм

2004 ба 2011 оны нөхөн олговрын хөтөлбөрүүдийг ОУСК-ийн ГС5 (2012) гарахаас өмнө хийж гүйцэтгэсэн тул энэ тайланд нөхөн олговор тухайн үед байгаагүй стандарттай хэр нийцэж буйд үнэлгээ өгч байна.

Бидний ерөнхий үнэлгээгээр 2004 оны нөхөн олговрын хөтөлбөр нь олон талаараа ОУСК-ийн ГС5-ын шаардлагыг хангахгүй байна:

- 2004 онд ашигласан 10 км-ээс дотогш гэж заасан бүсчлэл болон өвөлжөөний бууцны байршлын хязгаарлалтыг хэрхэн тогтоосон тухай тодорхой тайлбар, үндэслэл байхгүй. Иймээс нүүлгэн шилжүүлэлтийг хамгийн бага буюу минимум болгож бууруулаагүй.
- Айвенхоу Майнс Монголиа Инк нь сумын захиргаа, удирдлагатай зөвлөлдсөн болохыг харуулсан баримтын талаар сонссон боловч хамааралтай малчидтай үр дүнтэй зөвлөлдсөн нь бага байна. Айвенхоу Майнс Монголиа Инк-ийн орон нутгийн харилцааны ажилтнууд малчдын гэрээр байнга, дахин дахин очиж гэрээнд гарын үсэг зурахыг шахаж шаардах, гарын үсэг зурахаас татгалзсан малчдыг олон нийтийн дунд “нэр цохож ичээх”, нэг тохиолдолд өндөр настай эхийг нь хүүгийнхээ өмнөөс гарын үсэг зурахыг шахаж шаардсаны дагуу гарын үсгээ зурсандаа одоог хүртэл харамсдаг тухай хүмүүс бидэнд олонтаа хэлж байлаа.
- Нөхөн олговрын зүйл заалт, нөхцөл тухайн үед ил тод байсан гэдэгт бид эргэлзэж байгаа бөгөөд нөхөн олговрын гэрээнд малчид гэрээний нөхцлийн нууцлалыг хадгалах ёстой гэж заажээ.
- Гомдлыг барагдуулах механизм оновчгүй – 7 хоногийн дотор албан бус шийдвэр гаргах эсвэл Монгол Улсын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд англи хэлээр хандаж тусламж хүсэх гэжээ. Маргааныг шийдвэрлэх энэ хэлбэр нь арилжаа, худалдааны байгууллагуудын дунд үүссэн маргааныг шийдвэрлэхэд тохиромжтой бөгөөд хөдөө орон нутгийн малчин, том компани хоёрын хооронд байгуулсан гэрээтэй холбоотой маргааныг шийдвэрлэхэд таарамжгүй.
- Амьжиргааг нөхөн сэргээх зорилгыг тодорхойлоогүй.
- Хэдийгээр 2010 оноос эхлэн ОТ нүүлгэн шилжүүлсэн өрхүүдийн нөхцөл байдалд мониторинг хийх болсон ч эхний хэдэн жилүүдэд албан ёсны мониторинг хийгдээгүй.

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

29

Албан бус орчуулга – Орчуулгын утга зөрж байвал бичиг баримтын эх хувийн утгыг баримтлана.

Бидний үнэлснээр 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын үйл явц нь 2004 оны үйл явцыг бодвол сайжирсан байна. Гэхдээ ОУСК-ийн ГС5-ийн шаардлага, стандартыг зарим талаараа хангаагүй, нийцээгүй байна.

- Амьжиргааг нөхөн сэргээх төлөвлөгөө байхгүй.
- 2011 оны гэрээ нь 2004 оны гэрээтэй адил гэрээний зүйл, заалт, нөхцлийн нууцлалыг хадгалахыг малчдаас шаарджээ. Энэ нь ил тод байгаагүй.
- Нөхөн олговрын гэрээнд гомдлыг барагдуулах механизмыг нарийн заагаагүй, зөвхөн “сайн санааны үүднээс шийдвэрлэхийг хичээнэ” гэж заажээ. Одоо ашиглаж буй гомдлыг барагдуулах механизм нь (2015 оны НШТ) гомдол гаргагчдыг хараат бүс бие даасан сувагт хандах хувилбарыг оруулаагүй. ЭЗХНЗОГ-т гомдол гаргасан явдал нь дээрх гомдлыг барагдуулах механизм нь үр дүнтэй биш байгааг харуулж байна.

7.2.2 Эмзэг хүмүүст учруулсан нөлөөлөл

2004 онд АММИ нүүлгэн шилжүүлсэн өрх тус бүрээр бүртгэл гаргасан. Малчдыг Нүүлгэн Шилжүүлсэн Тайланд (дотоод) хоёр өрх ‘сайнгүй’ эсвэл “тун хэцүү” байдалтай байгааг тодорхойлсон боловч нөлөөллийг бууруулах нэмэлт эсвэл тусгай арга хэмжээ авсан тухай тайлагнаагүй байна.

2011 оны НШТ, 2012 оны БОННУ-нд (ОТ ОУСК-ийн Нийгэм, Байгаль Орчны Гүйцэтгэлийн Стандартуудын дагуу үнэлгээ хийж, нөлөөллийг бууруулах, нөхөн олговрын төлөвлөгөөг гаргасан гэж дурьдсан) эмзэг хүмүүсийн ангилалыг тодорхойлжээ. Эмзэг өрхүүдийн тодорхойлолтыг сумын мэдээнд үндэслэн гаргасан бөгөөд өгөгдсөн мэдээ баримтаас харахад тийм өрхүүдийг тогтоож өгсөн байна. Эмзэг өрхүүдтэй ажиллах үйл явцыг тусгасан.⁷¹ Энэ аргад хугацааны явцад эмзэг гэгдэх хүмүүс өөрчлөгдөж болно, хүмүүс эмзэг байхаа больж болно гэж үзсэн нь зөв байна.⁷²

2004 оны НШТ-ний Гүйцэтгэлийн Аудитийн тайланд (2014 оны 9 сард хийгдсэн) тэр үеийн засгийн газраас баталсан үзүүлэлтээр үзэхэд 2004 онд нүүлгэн шилжүүлсэн 10 өрхийн 5 нь ядуу буюу нэн ядуу байсан бол 10 жилийн дараа аудит хийхэд 5 өрхийн амьжиргаа сайжирсан, 4-ийнх нь амьжиргаа сэргэсэн, нэг өрхийн амьжиргаа хагас сэргэсэн гэж тэмдэглэжээ. Гэсэн хэдий ч аудитын баг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн өрхүүдэд хэрэглэсэн аргыг хангалтгүй, “Эмзэг хүмүүст зориулсан тусгай хөтөлбөр, онцгой туслалцаа юу ч байхгүй байна” гэж үзсэн. Аудитаар “эмзэг хүмүүсийг тогтоож, тэдний хэрэгцээг НШТ-тэй уялдуулах” зөвлөмжийг ОТ-д өгчээ.⁷³

2015 НШТ-нд аудитын зөвлөмжийн талаар дурьдаагүй, харин эмзэг хүмүүст хандах ОТ-н арга барилын талаар өргөн танилцуулсан байна. Арга нь үндсэндээ 2011 оны НШТ-нийх шиг боловч эмзэг малчин өрхийн жагсаалтыг жил бүр шинэчилж байх, тохиолдол тус бүрээр менежмент

⁷¹ 2012 БОННУ, Бүлэг Б9 Хөдөлмөр эрхлэлт ба Амьжиргаа (9.6.11); Бүлэг 10 Газар (10.3.9); Бүлэг В13 Хуримтлагдах нөлөөлөл (13.7.5); Бүлэг Г15 НШТ (15.6)

⁷² Мониторингийн төлөвлөгөө үзнэ үү. Г15, х. 73, туслалцаа үзүүлсэн эмзэг хүмүүсийн тоог улирлаар бүртгэсэн; эмзэг хүмүүсийн тооны өөрчлөлт, эмзэг байхаа больсон хүмүүсийн тоо.

⁷³ 2004 Гүйцэтгэлийн аудит, х. 38

Жей Эс Эл Консалтинг Лтд.

Их Британи Комп. Бүрт. 04068123; НӨТ 768 4469 73

+44 (0)1865 512365/+44 (0)7500 729 681/скайпи:shankleman

хийх, ингэхдээ сумын засаг захиргаатай хамтран ажиллах, тусгайлан очиж уулзаж туслалцаа үзүүлэхэд чиглэсэн онцгой үүрэг хариуцлагыг оруулж өгчээ.⁷⁴

Хэсэг 2-т тэмдэглэсэнчлэн, хээрийн судалгаа хийгдсэний дараа энэ асуудал тавигдсан тул бидэнд эмзэг өрхүүдээс шууд авсан мэдээлэл алга байна. ОТ-н улирал тутам гаргадаг эмзэг өрхийн тухай тайлангуудыг ч олж хараагүй. ГТЗ-ийн малчдын бүлгээс эмзэг байдалд илүү анхаараач гэсэн хүсэлтэнд эмзэг хүмүүс, өрхүүдийн талаар ямар нэгэн тодорхой мэдээлэл байгаагүй.

Дээр дурьдсанд үндэслэн дүгнэвэл:

- ОТ 2011 оноос эхлэн малчдын эмзэг байдлын асуудлыг нөлөөллийн үнэлгээ, НШТ-нд тусгаж үзэх болсон;
- Эмзэг байдлыг шийдвэрлэхээр авсан арга хэмжээ нь зохистой;
- Гэвч хэрэгжүүлэлт, үр дүнгийн талаар мэдээлэл дутмаг байна.

7.3 Зөвлөмж

Өмнө санал болгосон зөвлөмжүүдэд ихэнх цоорхой асуудлыг авч үзсэн билээ. Нэмж хэлэхэд:

- ОТ нь 2004 ба 2011 оны нөхөн олговрын гэрээний нууцлалыг хадгалах тухай зүйл заалтыг цуцлах нь зүйтэй. Ингэснээр нөхөн олговор авсан тэдгээр иргэд нөхөн олговрын талаарх мэдээллээ бусдад ил болгохыг хүсвэл энэ боломж нээлттэй байна.
- ОТ болон ГТЗ-ийн бусад гишүүд гомдлыг барагдуулах механизмд хөндлөнгийн этгээдэд хандах тухай хувилбарыг тодорхой болгож одоо ашиглаж буй гомдлыг барагдуулах механизмын талаар малчид, орон нутгийн бусад иргэдэд танилцуулж, зөвлөлдөх; шаардлагатай бол засаж сайжруулах, ОТ-н талаар гомдолтой иргэдийг тус механизмыг ашиглахыг хөхүүлэх.
- ОТ эмзэг өрхүүдэд зориулсан хөтөлбөр, хэдэн хүн хамрагдсан, өгөгдсөн бодит туслалцаа, тусламжийн арга хэмжээний талаарх мэдээллийг жил бүр ил тод мэдээлж байх хэрэгтэй.

⁷⁴ 2015 НШТ, Хэсэг 9

Хавсралт 1: Ажлын Даалгавар: Нөхөн олговрын хөтөлбөрийг нягтлан үзэх

Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг: Нөхөн олговрын хөтөлбөрийг нягтлан үзэх Ханбогд сумын малчдад учруулсан өөрийн нөлөөллийг нөхөх зорилготойгоор ОТ хоёр хөтөлбөр хэрэгжүүлсэн: 2004 оны нүүлгэн шилжүүлэлт болон 2011 оны эдийн засгийн суурьшил алдагдалтын нөхөн олговрын хөтөлбөр. Олонх малчид эдгээр арга хэмжээнүүд нь ОТ-гоос бэлчээр ба усанд учруулсан нийт нөлөөлөл (тэдгээр нь малчдын маллах мал сүргийн тоо хэмжээнд нөлөөлж байна) түүнчлэн уламжлалт амьжиргаа ба соёл заншилд учирсан нөлөөллийг хангалттай нөхөж чадаагүй, гэж үздэг.

Хэсэг 1 ба 2-ын үнэлгээний үр дүнд цуглуулсан мэдээлэлд үндэслэн ОТШБ нь тухайн өрхүүдэд олгосон нөхөн олговрын багц болон сүүлийн арав гаруй жилийн туршид ОТ- гоос Ханбогд суманд үзүүлсэн дэмжлэг туслалцаа зохистой байсан эсэхэд хөндлөнгийн хяналт хийнэ. Тухайлбал, аудит нь дараах асуудлыг шинжилнэ: (1) 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн суурьшил алдалтын нөхөн олговор тогтоохдоо ашигласан нөлөөллийг үнэлэх аргачлал нь зөв, зохистой байсан эсэх; (2) ОТ өөрийн хэрэгцээний дэд бүтэц, байгалийн баялаг ашигласан зэргийг оролцуулан ОТ-н улмаас учирсан сөрөг нөлөөллүүдийг хангалттай нөхөн төлсөн эсэх; (3) тогтвортой амьжиргаанд шилжихэд хангалттай нөхөн олговор олгогдсон эсэх; (4) нөхөн олговор авбал зохих бүх малчдад нөхөн олговор бодитой олгосон эсэх; болон (5) нөхөн олговрын үйл ажиллагаа нь ОУСК-ийн Гүйцэтгэлийн 5-р стандартад нийцсэн эсэхийг тус тус тогтоох зэрэг болно.

Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн 2-р Шатны Тайлан (ХШБ)

Ундай Голын Гольдролын Өөрчлөлттэй холбоотой Гомдол

2016 оны 11 сар

Сабине Шмит, Стив Бакли нар¹

¹ Steve Buckley, Independent Expert, Dr. Sabine Schmidt, Independent Expert, e-mail: colt0524@yahoo.com

Ерөнхий Хураангуй

- 1) Халив-Дугатын гольдролыг даялуулан, усны хагалбарын хэд хэдэн хэсэгт өөрчилсөн байна. Гол ба/буюу түүний цутгалангуудад шүүдүү ухаж, уурхай, замын дэд бүтцийн улмаас хэд хэдэн газрыг таглаж, боожээ. Үүний улмаас усны хагалбарын энэ хэсэгт гадаргын болон хөрсний усны урсац өөрчлөгдсөн. Төслийг эхлэхээс өмнө усны хагалбарын энэ хэсгийн гидрологийн нөхцөл байдалд хангалттай мониторинг хийгдээгүй тул гадаргын болон хөрсний усанд гарсан өөрчлөлтийг тоогоор илэрхийлэх боломжгүй. Эдгээр өөрчлөлтийн улмаас бэлчээр болон малчдын амьжиргаанд учрах хуримтлагдах нөлөөллийг Тайлангийн 2 дахь хэсэгт авч үзсэн болно.
- 2) Хаягдал Хадгалах Байгууламж (ХХБ) одоогийн байдлаар шүүрч байгааг “ХХБ-ийн Өндөрлөгийн Зураг Төслийн” 2015 оны Тайланд дэлгэрэнгүй дурьджээ (Голдер Ассошиэйтсийн 4/30/2015 хууд. 10). Голдер Ассошиэйтсийн тайлан гарснаар ХХБ-ийн барилгын зураг төсөлд болон түүний ажиллагаанд өөрчлөлт хийхэд хүргэсэн байна. Үүгээр мониторингийн хаалт, пьезометрүүдийг нүүлгэн ХХБ-ийн далангийн доод талд байрлуулах болжээ. Мониторингийн дийлэнх цэгүүдийн мэдээлэл тасалдалтай буюу тун бага байгаа нь шүүрэлтийг тоогоор хэмжихэд хүндрэл учруулж байна. Шүүрсэн усыг тогтоох систем нь шүүрсэн усыг УЛТ-н дотор барьж байхаар хийгдсэн бөгөөд шүүрэлтийг УЛТ дотор барьж байгаа харагдаж байв. Ямартаа ч одоо байгаа мэдээллээс үзэхэд ирээдүйд мониторингийн хөтөлбөрийг маш дэлгэрэнгүй, нарийн ажиглалттай хэрэгжүүлэх шаардлагатай.
- 3) Голын гольдролыг аль хэдийн даялуулчихсан, хоёр хэсэг хоёулаа баригдаж байгаа, ХХБ-ийн 1-р хэсэг нь ашиглагдаж буй болохоор Халив-Дугатын голд нөлөөлөл учруулахаас зайлхийхийн тулд ХХБ-д өөрчлөлт хийнэ гэдэг найдвартай биш. Гэсэн хэдий ч бууруулах, мониторинг хийх зарим нэг хувилбар байгааг энэ тайланд гаргаж тавьсан болно.
- 4) Халив Дугатын ай сав дахь гадаргын усны хаялбар нь зам, карьерууд, Хаягдал Хадгалах Байгууламж, өөрчлөлтийн сувгууд зэрэг дэд бүтцийн байгуулалтын нөлөөнд өртсөнөөр ай сав дахь малчдын усны хангамжид нөлөөлөл учирсан. 1-р хэсэгт нөлөөллүүдийн талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн болно.
- 5) Эдгээр нөлөөллүүд болон Гурван Модны Халив Дугат (“Дугат”), Хөх Шанд, Дугатын Дугуй, Гурван Модны Халив (“Халив”), Вандан Толгой, Шунхат, Оюут Толгой зэрэг Халив Дугатын бэлчээр шүүд Уурхайн Лицензит бүст орсон эсвэл холбогдох дэд бүтэц рүү алдсан, бэлчээр хуваагдсан, тоосны бохирдол, дуу чимээ зэрэг нь мал нэг дор тухайлбал Уст Баг Мод, Ханан Даваа, Тойн Цохионд олноор бөөгнөрөхөд хүргэжээ.
- 6) Малчдын тайлбар, сумын захиргаанаас өгсөн өрхийн малын мэдээлэл энэ хандлагыг бататгаж байна.

- 7) Үр дагаварт нь малчдын улирлын чанартай нүүдэл цөөрч, ихэвчлэн өвөлжөөний бэлчээрээ зун ч бас ашиглах болжээ. Малчдын мэдээлэл, малын тоо баримтаас үзэхэд Халив Дугатын өрхүүдийн малын тооны өсөлт сумын нийт өсөлтөөс арай бага, бод гэхээсээ илүүтэй бог мал түлхүү маллах болсон байна.

- 8) Ундай голын нэгэн адил, Бор Овоон задгай, ойр орчмынх нь бэлчээр алдагдсанаар жилийн дөрвөн улиралд нүүдэллэн, олон айл зуны бэлчээрээ хуваадаг байсан нүүдлийн мал аж ахуйн уламжлалд өөрчлөлт авчирсан шиг малчин хүмүүсийн бэлчээр ашиглах байдал, мал маллагааны арга ажиллагаа өөрчлөгджээ. Бэлчээр алдагдсан болохоор үүнийг эргүүлэн сэргээнэ гэж төсөөлөхөд бэрх.

Зөвлөмжүүд

- ОТ, орон нутгийн засаг захиргаа, малчдын хамтын оролцоот усны мониторингийг өргөжүүлэн, сайжруулах. Үүнд хүр тунадас хэмжигчийн сүлжээг өргөтгөн, ХХБ-ийн доод талд мониторингийн цооног нэмж гаргаж болох юм. Усны чанарын дээж авах ажиллагаанд бүх талуудыг хамруулан, баримт хамтран олж тогтоох хэлбэрээр үүнийг хийж болно.
- Халив-Дугатын голын өөрчлөлтийн сүвгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах. Ингэснээр элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсгана. Үүнийг хийхдээ өөрчлөлтийн бат бөх байдлыг үнэлэх мөн эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохоос аль болох сэргийлэх замаар засаж болох элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохын тулд хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно.
- Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана аль нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизм бий болгох. Эдгээр газрууд болон нөлөөллийг бууруулах боломжит арга техникуудийг ГТЗ хамтран хянан үзэж болох юм.
- Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр (ТХХЗ) шүүрэлтийг хянан үзэж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах.
- ХШБ ерөнхийдөө ОТМШБ-аас гаргасан зөвлөмжүүдийг дэмжиж байна. ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 1-ийн сумын хэмжээнд уст цэгийг олшруулах гэсэн зөвлөмжийн тухайд ХШБ зэрлэг амьтад/биологийн олон зүйл ба мал хоорондоо зөрчилдөх вий гэдгийг бодолцохыг хүсч, нэлдээ бэлчээр юм шиг харагдаж байгаа газар болгон мал бэлчээрлэхэд тэр бүр тохирдоггүйг хэлмээр байна.

Хэд хэдэн нэмэлт тайлбар, зөвлөмжүүдийг дурьдваас:

- ОТМШБ-ийн тайлангийн бүрэлдэхүүний 1-ийн зөвлөмжтэй холбоотойгоор сумын засаг захиргаа алдагдсан бэлчээрийг харгалзан тохируулга хийхийн тулд бэлчээрийн системийг дахин боловсруулах хэрэгтэй. Бэлчээрийн гол нутаг (зуны бэлчээр) бүрмөсөн алдагдсан болохоор үүнийг хийх нь хэцүүхэн даалгавар байх болно. Нутаг дэвсгэр том хэдий ч газрын гадарга, ургамлын төрлөөс шалтгаалан тэр болгон тохиромжтой бэлчээр байж чадахгүй.
- Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сүргэлт явуулах зэргээр орон нутгийн захиргаанд (Сум, Аймаг) дэмжлэг үзүүлэх; энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадны хүмүүс гэхийн оронд (ОТ, гадаад шинжээчид) малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, мэргэжлийн байгууллагууд) санаачлагыг гартаа авч, бүгд хүчин чармайлт гаргах нь чухал.
- Хамааралтай талуудыг татан оролцуулахад ГТЗ чухал үүрэгтэйгээс гадна одоо байгаа байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (ж: багийн

хурал, багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулалт гм) гол үүрэг гүйцэтгэнэ.

- ГХГЗЗГ (Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар) мэргэжлийн байгууллага хөлслөн 5 жил тутам сум бүрээр үнэлгээ хийлгэдэг. Ханбогд сумын бэлчээрийн “тохируулгын” систем боловсруулахад ГХГЗЗГ-аас мэргэжлийн туслалцаа үзүүлж чадах билээ. ГХГЗЗГ малчдын газар ашиглах уламжлалт эрхийг баталгаажуулан, баримтжуулах зорилгоор нөөц ашиглах эрхийг тодорхойлох, газар болон нөөц ашиглалтыг төлөвлөх ажлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран саяхнаас хийж эхэлсэн.
- Орон нутгийн иргэд “Нутгаа”, сэтгэл санааны үнэт зүйлсээ алдсан асуудал байсаар байгааг тусад нь авч үзвэл зохино.
- ОТ-с оруулсан орлогоос эдгээр хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж болно (үлсад төлж буй татварууд, Аймгийн түвшний хамтын ажиллагааны гэрээ болон бусад); зээл олгогчын зүгээс (ОУСК) төлөвлөлт, гүйцэтгэлийг орон нутаг хариуцахыг хөхүүлэхийн хамт зарим нэг дэмжлэг туслалцаа нэмж үзүүлж болох юм.
- Малын тоо толгой өсч байгаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл, ил тод байдал шаардагдаж байна. ХШБ-ийн 2-р шатны судалгаа (мөн БСТ –ийн 2012 оны судалгаануудаас) харахад нөлөөлөлд өртсөн өрхүүд (албан ёсоор нөлөөлөлд өртсөн гэгдсэн болон өөрсдийгөө өртсөн гэж үзэж буй аль аль нь) малын тооны өсөлтөнд бараг нөлөөлөөгүй; эсвэл тэдгээрийн малын тооны өсөлт дунджаас нэлээд бага байна. Харин ч ерөнхийдөө тэдний дийлэнх нь малын тоо, төрлийг тохируулан зохицуулах болжээ. Малын тооны өсөлт, бэлчээрийн даац хэтэрч буйг илүү сайн ойлгохын тулд өөрсдөө малаа малладаггүй малтай өрхийн асуудлыг цаашид судлах шаардлагатай байна.
- Гүний усны суурь мэдээлэл: ОТМШБ-ийн тайлангийн Бүрэлдэхүүн 1-д гүний болон гүехэн гүний усны ай сав хоорондоо холбогдсоноор аллювийн усанд ямар нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлох суурь мэдээлэл дутмаг гэж дурьдсан. 2007 оноос өмнө ус шавхсан тухай мэдээлэл байхгүйг ХШБ өмнө дурьдаж байсан билээ. ХШБ 2-р шатны судалгааг хийхдээ орон нутгийн захиргаа, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яамнаас мэдээлэл авахыг чармайсан боловч (орон нутагт) мэдээлэл байхгүй, эсвэл (яамны мэргэжилтнүүдээс) мэдээллийг хуваалцах боломжгүй гэдэг хариу авсан. Ийм нөхцөл байдалд шинжээчид нөлөөллийг цаг хугацааны дагуу тоогоор тогтоож чадахгүй; цааш ахихын тулд ядахдаа байгаа мэдээллийг хүртээлтэй болгох хэрэгтэй байна.
- Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн ангиллыг хянан үзэж а) аль нэг улирлын (өвөл, зун /намрын) бэлчээрээ алдсан боловч одоогоор нөлөөлөлд өртсөн гэж тооцогдоогүй, б) нөлөөллөөс дайжин, бэлчээрт нь нүүж ирсэн өрхүүдийн улмаас бэлчээрийнх нь ачаалал нэмэгдсэн, в) хэд хэдэн өрх нэг өвөлжөөг хамтран эзэмшдэг байхад зөвхөн нэгийг нь нөлөөлөлд өртсөнөөр тооцсон, г) (УЛТ дотор, хориотой бүст) өвөлжөөтэй байсан ч ар гэрийн байдлын улмаас түр зууртаа ашиглахгүй байгаа өрхүүд, д) үе уламжилсан өвөлжөөг нь нутгийн иргэд хүлээн зөвшөөрдөг ч албан ёсны гэрчилгээ аваагүй гэх мэт өрхүүдийг оруулах асуудлыг авч үзэх
- Дээр дурьдсан янз бүрийн байдлаар нөлөөлөлд орсон өрхүүдийн нэрсийг шинжээч өөрийн боломжоор гарган, бүрэн бус хэдий ч жагсаалтыг энэ тайланд орууллаа. Нэрсийг бүлгийн хэлэлцүүлгээр авсан мэдээлэл үндэслэн, оролцогчдын зөвшөөрөлтэй авсан. ГТЗ-өөс хүмүүс томилох буюу (эсвэл илүү олон хүн оролцуулж) нэрсийг дахин нягтлахыг зөвлөж байна.

- Энэ тайланд дурьдсан өрхүүдтэй амьжиргааг дэмжих стратегийн талаар хэлэлцүүлэг зохиох (ХШБ-ийн 1-р шатны тайлангийн дараа 59 өрхтэй зөвлөлдсөн шиг)
- Малын тэжээл тариалах/үйлдвэрлэх хувилбарт үнэлгээ хийх (Өмнө-Говь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн бусад сумдад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн мэдээлэл, сургамжид үндэслэн)
- Бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд ОТ эвдээд орхисон газруудаа аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг багасгах, карьерууд дээр гарах ослын эрсдэлийг бууруулах

ХЭСЭГ 1

Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн

2-р Шатны Тайлан (ХШБ)

Ундай Голын Гольдролыг өөрчлөхтэй холбоотой Гомдол

Хэсэг 1 - Гидрологи

Олж тогтоосон зүйлийн хураангуй

Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн (ХШБ) 2-р шатны ажлын даалгавар:

- Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл хожим өөрчлөх эсэх, Ундай, Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсний улмаас энэ бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болзошгүй хуримтлагдах нөлөөлөл;
- Хаягдал хадгалах байгууламж одоо шүүрч байгаа эсэх, ирээдүйд ингэж шүүрэх эрсдэл байгаа эсэх, энэ шүүрэл нь Халив-Дугатын гол болон малчдын, малын усны аливаа эх үүсвэрт ямар нөлөөлөл(үүд) учруулах; мөн
- Халив-Дугатын голд учруулах нөлөөллөөс зайлсхийхийн тулд Төслийн хаягдал хадгалах байгууламжийг өөрчлөх боломжтой эсэх эсвэл холбогдох мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг нь хэр үндэслэлтэй болох.”²

2-р шатны ажил 2016 оны 2 сард Гурван Талт Зөвлөл, ХШБ, шинээр байгуулагдсан ОТМШБ (олон талт мэргэжлийн шинжээчдийн баг), ЭЗХЗОГ-ийн төлөөлөгчид, чиглүүлэгч нарын хамт олон өдрийн уулзалт хийснээр эхэлсэн. Уулзалтын үеэр хамтран баримт олж тогтоох семинар хийж, бүх талууд хамтран ажиллаж, мэдээ мэдээлээ хуваалцах хэрэгтэйг онцлон, ерөнхий арга, ажлын хуваарь, хүлээлтүүд зэргийг тодруулсан. Энэхүү хамтран баримт олж тогтоох ажлын үр дүнд ХШБ-ийн ажлын даалгавартай холбоотой дараах зүйлсийг тодруулав. Үүнд:

- 1) Халив-Дугатын гольдролыг даялуулан, усны хагалбарын хэд хэдэн хэсэгт өөрчилсөн байна. Гол ба/буюу түүний цутгалангууд дээр шуудуу ухаж, уурхай, замын дэд бүтцийн улмаас хэд хэдэн газрыг таглаж, боожээ. Үүний улмаас усны хагалбарын энэ хэсэгт гадаргын болон газрын доорх усны урсац өөрчлөгдсөн. Төслийг эхлэхээс өмнө усны хагалбарын энэ хэсгийн гидрологийн нөхцөл байдалд хангалттай мониторинг хийгдээгүй тул гадаргын болон газрын доорх усанд гарсан өөрчлөлтийг тоогоор илэрхийлэх бололцоогүй. Эдгээр өөрчлөлтийн улмаас бэлчээр болон малчдын амьжиргаанд учрах хуримтлагдах нөлөөллийг энэ Тайлангийн 2 дахь хэсэгт авч үзсэн болно.
- 2) “ХХБ-ийн Өндөрлөгийн Зураг Төслийн” 2015 оны Тайланд дэлгэрэнгүй дурьдсанаар Хаягдал Хадгалах Байгууламж (ХХБ) одоогийн байдлаар шүүрч байна (Голдер Ассошиэйтсийн 4/30/2015 хууд. 10). Голдер Ассошиэйтсийн тайлангийн мөрөөр ХХБ-ийн барилгын зураг төсөл болон түүний ажиллагаанд өөрчлөлт хийгдсэн байна. Үүгээр мониторингийн хаалт, пьезометрүүдийг нүүлгэн ХХБ-ийн далангийн доод талд байрлуулах болжээ. Мониторингийн дийлэнх цэгүүдийн мэдээлэл тасалдалтай буюу тун бага байгаа нь шүүрэлтийг тоогоор хэмжихэд хүндрэл учруулж байна. Шүүрсэн усыг тогтоох систем нь шүүрсэн усыг УЛТ-н дотор барьж байхаар хийгдсэн бөгөөд шүүрэлтийг УЛТ дотор барьж байгаа харагдаж байв. Ямартаа ч одоо байгаа мэдээллээс үзэхэд ирээдүйд мониторингийн хөтөлбөрийг маш дэлгэрэнгүй, нарийн ажиглалттай хэрэгжүүлэх шаардлагатай. ХХБ-ийн доод хэсгийн усны чанарт гарах

² Ундай Голын Гольдролын Өөрчлөлттэй холбоотой Гомдол, Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн Ажлын Даалгавар

өөрчлөлтийн улмаас малчдын бэлчээр, амьжиргаанд учирч болзошгүй нөлөөллийн талаар тайлангийн 2 дахь хэсэгт авч үзэв.

3) Үнэн хэрэгтээ голын гольдролыг аль хэдийн өөрчилсөн, хоёр хэсгийг хоёуланг нь одоо барьж байгаа, ХХБ-ийн 1-р хэсгийг ашиглаж байгаа тул Халив-Дугатын голд нөлөөлөл учруулахаас зайлхийхийн тулд ХХБ-д өөрчлөлт хийнэ гэдэг найдваргүй. Гэсэн хэдий ч бууруулах, мониторинг хийх зарим нэг хувилбар байгааг энэ тайланд гаргаж тавьсан болно.

Удиртгал

ХШБ-ийн 1-р шатны судалгаа 2013 онд эхэлж, голын гольдролыг өөрчлөх ажилтай холбоотойгоор Ундай голын гольдролын өөрчлөлт болон Бор Овоон задгайг алдсаны улмаас усны эх үүсвэр, бэлчээр, малчдын амьжиргаанд учирч болзошгүй нөлөөллөөр хязгаарлагдсан. 2-р шатны ажил 2016 оны 2 сард Гурван Талт Зөвлөл, ХШБ, шинээр байгуулагдсан ОТМШБ (олон талт мэргэжлийн шинжээчдийн баг), ЭЗХЗОГ-ийн төлөөлөгчид, чиглүүлэгч нарын хамт олон өдрийн уулзалт хийснээр эхлэв. 2-р шат ХШБ-ийн ажил даалгаварт заасан дараахь зүйлсийн хүрээнд хийгдлээ. Үүнд:

- Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл хожим өөрчлөх эсэх, Ундай, Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсний улмаас энэ бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болзошгүй хуримтлагдах нөлөөлөл;
- Хаягдал хадгалах байгууламж одоо шүүрч байгаа эсэх, ирээдүйд ингэж шүүрэх эрсдэл байгаа эсэх, энэ шүүрэл нь Халив-Дугатын гол болон малчдын, малын усны аливаа эх үүсвэрт ямар нөлөөлөл(үүд) учруулах; мөн
- Халив-Дугатын голд учруулах нөлөөллөөс зайлсхийхийн тулд Төслийн хаягдал хадгалах байгууламжийг өөрчлөх боломжтой эсэх эсвэл холбогдох мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг нь хэр үндэслэлтэй болох.”

Аргачлал

Бэлэн байгаа тайлан, баримт бичгүүдийг хянан үзэж, ХШБ-ийн ажлын даалгаварт заасан асуудлуудад хариулахад тухайлан анхаарлаа. Сүүлийн үеийн мэдээлэл бүхий гол эх үүсвэрүүд:

- 2015 ХХБ Өндөрлөгийн Зураг Төслийн Тайлан, Голдер Ассшиэйтс, 4/30/2015
- ХХБ Хэсэг 1 2015 Барилгын ажлын товч тайлан, Голдер Ассошиэйтс 1/18/2016
- ХХБ Шүүрэлтийн Мониторингийн тайлан #7, 2016, ОТ

Эдгээр дүн шинжилгээтэй холбоотойгоор ХШБ бие даасан хэмжилт, дээж авалт хийгээгүй. Өнгөрсөн жилүүдэд ХХБ-ийн шүүрэлтийн хэсэг, УЛТ доторх гольдрол өөрчилсөн суваг, Халив-Дугатын гол, УЛТ-н гаднах түүний цутгалангуудыг хэд хэдэн удаа газар дээр нь очиж үзсэн.

Үр дүн

Халив-Дугатын гол нь байнгын бус урсгалтай, зөвхөн ширүүн хур бороо орсон үед л урсдаг. Хажуу дахь Ундай голтой харьцуулахад аллюв багатай, аллювын газрын доорх ус нь мөн хамаагүй бага. Халив-Дугатын голыг УЛТ-н дотор болоод гадна талд хэд хэдэн газар өөрчлөн, даялуулсан. Жишээлбэл: УЛТ-н дээхнэ байгаа хэсгээр Ханбогдын гол зам явдаг, нүхэн хоолой гэх мэт ус нэвтрүүлэх байгууламж байхгүй; урсгал уруудаад элсний карьер, цементийн үйлдвэрийн хавиар дахиад өнгөрдөг. Цутгалан сувгууд таглагдсан, одоо тэнд ХХБ, карьерууд байгаа болохыг дээр

дурьдсан тайлангууд доторх олон тооны барилгын зурагт тусгажээ. Халив-Дугатын голыг УЛТ-г тойруулан гаргахын тулд шуудуулан үхсэн байна. Өөрчилсөн шуудуу нь шаардлага хангахааргүй, хэд хэдэн удаа газар дээр нь очиж үзэх үеэр шуудууг засах буюу байршлыг өөрчлөх ажлууд хийгдэж байсан. Нэмж хэлэхэд, 2015 оны 7 сарын 8-ны өдрийн Хиймэл дагуулын зурагт үерын ул мөр болон Дугат гол дээрх өөрчлөлтийн шуудуу эвдэрсэн харагдаж байна (ОТМШБ-ийн Хиймэл Дагуулын дүн шинжилгээ). Эдгээр өөрчлөлтүүд гадаргын урсац, гүехэн гүний ус эсвэл усны ууршилтанд хэдий хэмжээтэй нөлөөлснийг тогтоох мониторингийн мэдээлэл хангалттай байсангүй. Эдгээр өөрчлөлтийн улмаас малчдын бэлчээр, амьжиргаанд учирч болзошгүй нөлөөллийн талаар тайлангийн 2 дахь хэсэгт гарна.

ХХБ-ийн шүүрэлтийг Голдер Ассошиэйтсийн 2015 оны 4 сарын 30-ны Өндөрлөгийн Зураг Төслийн тайлангийн 10-р хуудсанд баримтжуулсан байна. Голдер Ассошиэйтс 2013 онд ХХБ-ийн барилгын болон зураг төслийн ажлыг өмнөх гүйцэтгэгчээс хүлээн авсан. 3-4 дүгээр хуудсанд бичсэнээр:

“2013 оны 8 сарын сүүлээр Голдер газар дээр анх удаа очиж, тогтсон хаягдлын байр байдлыг ажиглахад хэд хэдэн асуудал харагдлаа. Ажиглагдсан зүйлс:

- i) Зутанлаг хатуулгын агууламж нь зураг төслийн тооцооноос бага 56% орчим байна*
- ii) Хашлагын/эргийн налуу 0.3% орчим*
- iii) Суусан лагийн нягтшил 1.27 т/м3 орчим*
- iv) ХХБ 1-ийн нийт талбайн дүүрэлт ойролцоогоор 8 м/жил байхаар байна.”*

“хадгалагдаж буй хаягдал зураг төслийн тооцоотой дүйцэхгүй байгаагаас доорх үнэлгээ хийгдэв:

ХХБ 1 төлөвлөснөөс хурдан дүүрнэ.

Хаягдлын тухайд:

Хаталтын зэрэг нь тооцоолсонд хүрэхээргүй

Дээд талын далан өндөрсөхөд аюулгүй байдлыг хангахуйц тулгуур/хашилтгүй байна.

- . Эдгээр ажиглалтын үр дүн, хаягдлын далангийн нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн доор дурьдсан өөрчлөлтүүдийг зураг төсөлд оруулахаар санал болгосныг ОТ ХХБ 1-д хэрэгжүүлэхээр хүлээн зөвшөөрсөн:*
- . Бүх далангийн урсгалын доод талыг өндөрсгөх, далангийн доод талын налууг эгц босоо болгох*
- . “Хэрэгцээний” хэрээр хаягдал буулгах. “*

Зураг төсөлд оруулах өөрчлөлтөнд далангийн доод талын шүүрэлт цуглуулах шугамын өөрчлөлт бас багтсан болно (х. 10-11). Шүүрэлтийг хуримтлуулаад буцааж тээрмийн болон хаягдлын систем

рүү урсгах, шүүрэлтийг УЛТ-гаас алдахгүйн тулд эдгээр өөрчлөлтийг хийх шаардлагатай. Шүүрэлтийн мөн чанараас харахад хаягдал ус, гүехэн гүний ус, зарим тохиолдолд гүний үл чулуулгын ус зэрэг хэд хэдэн эх үүсвэрээс үүдсэн бололтой.

Голдер Ассошиэтс, ХХБ Хэсэг 1, 2015 Барилгын товч тайлангийн 40 дүгээр хуудсанд:

“Усны чанарын дээжийн шинжилгээний дүнгээс харахад Станц 5+500 дээрх шүүрлийн усны давсжилт, хатуулга нь нөхөн сэргээх цөөрмөөс шүүрснийг, харин Станц NO+360 дээрх шүүрсэн ус нь хойд далангийн доогуурх голын хуучин гольдролоор орж ирсэн гүехэн гүний ус болохыг харуулж байна. Станц 5+900 дээрх шүүрлийн ус нь нөхөн сэргээгдсэн ус болон гүехэн гүний усны холимог байж болохыг шинжилгээний дүн үзүүлээ” гэжээ.

Хаягдлын далангийн ус болон газар доорх гүний ус хоорондоо холбоотой байж болох нотолгоог 40-р нүүрт дурьджээ:

“Өмнөд далантай хаяа нийлсэн (газрын гадаргаас 20 метр гүн дэх гүний ай савын) усны түвшин 2014 оны 10 сараас 2015 оны 10 сарын хооронд 2 метрээр өргөгдсөн нь 1А дэд хэсэгт хаягдал буулгасантай таарч байна. Усны хатуулаг (TDS) нэмэгдсээр байгаа нь хаягдлын байгууламжийн шүүрэлттэй холбоотой байж болно. Энэ таамаглалыг батлахын тулд илүү олон шинжилгээ судалгаа хийх шаардлагатай.”

Халив-Дугатын усны хагалбарын доод хэсгийн усны эх үүсвэрүүдэд ХХБ-ийн шүүрэлт нөлөөлөх эсэхийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн бол ОТ-н улирал тутмын шүүрэлтийн мониторингийн тайлан юм. Хаягдлын далан шүүрсэн ихэнх тохиолдолд эхний дохио нь урсгалын доод хэсгийн усны сульфат ихсэх явдал байдаг. Бусад металлыг бодвол сульфат илүү уусамтгай, тийм ч болохоороо газрын гүний усанд хурдан бөгөөд хол тархдаг.

Зөвлөмжүүд

- ОТ, орон нутгийн засаг захиргаа, малчдын хамтын оролцоот усны мониторингийг өргөжүүлэн, сайжруулах. Ингэхдээ хур тунадас хэмжигчийн сүлжээг өргөтгөн, ХХБ-ийн доод талд мониторингийн цооног нэмж гаргах. Үүнийг усны чанарын дээж авах ажиллагаанд бүх талуудыг хамруулан, баримт хамтран олж тогтоох хэлбэрээр хийж болно.
- Халив-Дугатын голын өөрчлөлтийн сүвгийн бүрэн бүтэн байдлыг сайжруулах. Ингэснээр элэгдлийг багасган, Халив-Дугатын үерийн усыг үр ашигтай урсгана. Үүнийг хийхдээ өөрчлөлтийн бат бөх байдлыг үнэлэх мөн эрэг ёроолыг бэхжүүлэн, ус тогтохоос аль болох сэргийлэх замаар засаж болох элэгдэл ихтэй газруудыг тодорхойлохын тулд хамтран баримт олж тогтоох судалгааг ашиглаж болно.
- Усны хагалбарт тогтоол ус хуралдах, ууршихаас сэргийлэхийн тулд хаана аль нь тохиромжтойгоос шалтгаалан нүхэн хоолой, нуман эсвэл хуягласан гарам зэрэг ус нэвтрүүлэн зайлуулах зохистой механизм бий болгох. Эдгээр газрууд болон нөлөөллийг бууруулах боломжит арга техникуудийг ГТЗ хамтран хянан үзэж болох юм.
- Техникийн Хяналтын Хөндлөнгийн Зөвлөлөөр (ТХХЗ) шүүрэлтийг хянан үзэж, ХХБ-ийн зураг төсөлд оруулах өөрчлөлтийг санал болгон, урсгалын доод руу гарч болзошгүй нөлөөллийг судлан, үр дүнг бүх талуудад тайлагнах.

Ашигласан хэвлэл:

2015 ХХБ Өндөрлөгийн Зураг Төслийн Тайлан, Голдер Ассошиэйтс, 4/30/2015

ХХБ Хэсэг 1 2015 Барилгын Ажлын Товч Тайлан, Голдер Ассошиэйтс 1/18/2016

ХХБ Шүүрэлтийн Мониторингийн Тайлан #7, ОТ Байгаль Орчны Хөтөлбөр

ХЭСЭГ 2

Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн

2-р Шатны Тайлан (ХШБ)

Ундай Голын Гольдролыг Өөрчлөхтэй холбоотой Гомдол

Хэсэг 2 – Малчдын Бэлчээр, Усны Нөөц, Мал Маллагаанд нөлөөлсөн
байдал

Гарчиг

Ерөнхий Хураангуй	16
1. Удиртгал	17
2. Аргачлал	17
3. Олж тогтоосон зүйлс	18
3.1. Хээрийн ажиглалтууд	18
3.2. Малчдын бэлчээр, усны нөөцөд нөлөөлсөн нь	18
3.3. Өрхийн мэдээлэл – Халив Дугатын Малчин Өрхүүдэд нөлөөлсөн байдал	30
3.4. Халив Дугатын бүст нөлөөлөлд орсон өрхүүд	35
3.5. Өрхүүд болон Малын тоо	36
3.6. Ундай Голын Сав Газар дахь Хуримтлагдах Нөлөөллийн Хураангуй	36
4. Зөвлөмжүүд	38
5. Хавсралтууд	40

Ерөнхий Хураангуй

Халив Дугатын ай сав дахь гадаргын усны хаялбар нь зам, карьерууд, Хаягдал Хадгалах Байгууламж, өөрчлөлтийн сувгууд зэрэг дэд бүтцийн байгуулалтын нөлөөнд өртсөнөөр ай сав дахь малчдын усны хангамжид нөлөөлөл учирсан. 1-р хэсэгт нөлөөллүүдийн талаар дэлгэрэнгүй хэлэлцсэн болно.

Эдгээр нөлөөллүүд болон Гурван Модны Халив Дугат (“Дугат”), Хөх Шанд, Дугатын Дугуй, Гурван Модны Халив (“Халив”), Вандан Толгой, Шунхат, Оюут Толгой зэрэг Халив Дугатын бэлчээр шууд Уурхайн Лицензит бүст орсон эсвэл холбогдох дэд бүтэц рүү алдсан, бэлчээр хуваагдсан, тоосны бохирдол, дуу чимээ зэрэг нь мал нэг дор тухайлбал Уст Баг Мод, Ханан Даваа, Тойн Цохионд олноор бөөгнөрөхөд хүргэжээ.

Зарим малчин өрхүүдийг нүүлгэн шилжүүлж, өвөлжөө барьж өгөн, нүүхэд нь тусалснаар энэ газарт нүүж ирсэн бол нөгөө зарим нь алдагдсан, нөлөөлөлд өртсөн, хуваагдсан бэлчээрээсээ нүүх замдаа улирлын чанартай ашиглаж байна. Малчдын тайлбар, сумын захиргаанаас өгсөн өрхийн малын мэдээлэл энэ хандлагыг бататгаж байна.

Үр дагаварт нь малчдын улирлын чанартай нүүдэл цөөрч, ихэвчлэн өвөлжөөний бэлчээрээ зун ч бас ашиглах болжээ. Малчдын мэдээлэл, малын тоо баримтаас үзэхэд Халив Дугатын өрхүүдийн малын тооны өсөлт сумын нийт өсөлтөөс арай бага, мөн тэд нар бод гэхээсээ илүүтэй бог мал түлхүү маллах болсон байна.

Ундай голын нэгэн адил, Бор Овоон задгай, ойр орчмынх нь бэлчээр алдагдсанаар жилийн дөрвөн улиралд нүүдэллэн, олон айл зуны бэлчээрээ хуваадаг байсан нүүдлийн мал аж ахуйн уламжлалд өөрчлөлт авчирсан шиг малчин хүмүүсийн бэлчээр ашиглах хэв маяг, мал маллагааны арга ажиллагаа өөрчлөгджээ. Бэлчээр нутаг бүрмөсөн алдагдсан байхад үүнийг эргүүлэн сэргээж хуучин хэвд нь оруулна гэж төсөөлшгүй.

1. Удиртгал

Хөндлөнгийн Шинжээчдийн Баг (ХШБ) 2-р шатанд “Халив Дугатын голд учирсан нөлөөлөл, Ундай голын ай савын хуримтлагдах нөлөөллийг үнэлэх үүрэг авсан. Тухайлбал:

- Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсөн эсэх, эсвэл хожим өөрчлөх эсэх, Ундай, Халив-Дугатын голын гольдролыг өөрчилсний улмаас энэ бүс нутгийн ус, бэлчээрийн нөөцөд учирч болзошгүй хуримтлагдах нөлөөлөл;
- Хаягдал хадгалах байгууламж одоо шүүрч байгаа эсэх, ирээдүйд ингэж шүүрэх эрсдэл байгаа эсэх, энэ шүүрэл нь Халив-Дугатын гол болон малчдын, малын усны аливаа эх үүсвэрт ямар нөлөөлөл(үүд) учруулах; мөн
- Халив-Дугатын голд учруулах нөлөөллөөс зайлсхийхийн тулд Төслийн хаягдал хадгалах байгууламжийг өөрчлөх боломжтой эсэх эсвэл холбогдох мониторинг, нөлөөллийг бууруулах төлөвлөгөө зэрэг нь хэр үндэслэлтэй болох.”³

2-р шатны ажил 2016 оны 2 сард Гурван Талт Зөвлөл, ХШБ, шинээр байгуулагдсан ОТМШБ (олон талт мэргэжлийн шинжээчдийн баг), ЭЗХЗОГ-ийн төлөөлөгчид, чиглүүлэгч нарын хамт олон өдрийн уулзалт хийснээр эхэлсэн. Уулзалтын үеэр хамтран баримт олж тогтоох семинар хийж, бүх талууд хамтран ажиллаж, мэдээ мэдээлээ хуваалцах хэрэгтэйг онцлон, ерөнхий арга, ажлын хуваарь, хүлээлтүүд зэргийг тодруулсан.

Тайлангийн 2-р хэсэгт төслөөс Халив Дугатын голын системд учруулсан нөлөөлөл Халив-Дугатын дэд ай сав дахь болон ойр орчмын малчдын бэлчээр, мал маллагааны хэв маягт хэрхэн нөлөөлсөн тухайд голчлон анхаарлаа.

2. Аргачлал

2-р шатны ажлын аргачлалд:

- Хээрийн судалгаа (2016 оны 2 сарын 26, ОТМШБ-тай хамтран, 3 сарын 28 – 4 сарын 1, 6 сарын 7 – 8, 2016 оны 11 сарын 15-16) зорилтот газар нутагт хамтарсан хээрийн судалгаа хийв. 3 сарын 28 – 4 сарын 1-ний хээрийн ажлын дэлгэрэнгүйг Хавсралт 1-д, 6 сарын 7-8-ны ажлын мэдээг Хавсралт 7-д оруулав.
- Зорилтот бүлгүүдтэй хийсэн хэлэлцүүлэг, гол мэдээлэл өгөгч малчидтай хийсэн ярилцлага, орон нутгийн захиргаа, ОТ-н ажилтнууд болон засгийн газрын байгууллагуудын шинжээчидтэй хийсэн уулзалтууд. Хагас бүтэцтэй ярилцлагын асуулт, асуудлуудыг Хавсралт 3-д, малчдын хариултыг Хавсралт 4-д; зорилтот бүлгүүдтэй хийсэн хэлэлцүүлгийн үйл явцыг Хавсралт 5-д; хэлэлцүүлэгт оролцогсдын гаргасан зураг, хүснэгтийг мөн Хавсралт 5-д үзүүлээ. 2016 оны 3, 4 сард Халив Дугатын талбарт авсан зургуудыг Хавсралт 6-д оруулав.
- Халив Дугатын хавийн бэлчээрт мал бэлчих байдалд (тоо) гарсан өөрчлөлтийг үнэлэхийн тулд гол мэдээлэгчид, судалгааны бүс нутаг дахь өрх, мал, төрөл, тоог харуулсан сумын архивын баримт мэдээнд үндэслэн судалгаа хийв. Аргачлалыг Хавсралт 8-д дэлгэрэнгүй дурьдсан.

³ Ундай Голын Гольдролын Өөрчлөлттэй холбоотой Гомдол, Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн Ажлын Даалгавар

- Бичиг баримтуудыг хянан үзсэн, ингэхдээ БОННУ, БОННДУ-ний Ундай голын ай савын хуримтлагдах нөлөөллийн тухай хэсгүүд, ОУСК-ийн Тэргүүн Туршлагын Гарын Авлагат (Хавсралт 2-ыг үзнэ үү) заасан хуримтлагдах нөлөөллийг үнэлэх аргачлалыг хэрхэн ашигласан зэрэгт голчлон анхаарав.

3. Олж тогтоосон зүйлс

3.1. Хээрийн ажиглалтууд

2016 оны 3 сарын 28-наас 4 сарын 1-ний хооронд хийсэн хээрийн судалгаагаар малчид хүсэлт гаргасны дагуу ХШБ-ийн гишүүн тэдний хамт ХХБ, Дугат, Уст голын УЛТ дотор байгаа хэсгүүдэд дахин очиж үзлээ.

- ХХБ-ийн гадаргуу хайлж байв. Задгай усанд хэсэг хун байхыг ажигласан. Шүүрч байгаа хэсэг ус нь гэсээд 2 дугаар сарын үеийнхээс илүү их устай болсон байлаа.
- Шүүрлийн орчмын шуудуугаар (“суваг”) өнгөрсөн жил үерийн ус урссан (ОТ-н Н. Эрдэнэбаярын хэлснээр). “Суваг” гээд байсан нь гадаргын усыг зохих ёсоор даялуулахаар хийгдээгүй, уурхайн талбай руу руу үер орохоос хамгаалсан шуудуу болж таарав.
- Дугатын гол гадаргын усыг урсгах хоолой огт байхгүй замаар УЛТ-н дотор (цементийн үйлдвэрийн ойролцоо) боогдсон байна.
- Уст гол УЛТ дотор элсний карьераар таслагджээ (далд уурхайн барилгад шаардлагатай, элсийг цемент хийхээр олон жил ашиглана гэж Цэрэннадмид хэлсэн ОТ).

Эдгээр ажиглалт, тайлбаруудыг энэ тайлангийн устай холбоотой 1-р хэсэгт хэлэлцсэн.

3.2. Малчдын Бэлчээр, Усны Нөөцөд Нөлөөлсөн нь

Хэлэлцүүлэг, ярилцлагуудын бүтцийг гаргахдаа 2000-2015 болон үүнээс хойшх хугацааны туршид Халив Дугатын бүсийн бэлчээр, усны нөөцийн нөхцөл байдал, хүртээмжид гарсан өөрчлөлтүүдийн талаарх малчдын бодлыг сонсож, мэдээлэл авах, нөхцөл байдал, хүртээмжийг 5 жилийн үечлэлтэйгээр тодорхойлоход чиглүүллээ.

Хэлэлцсэн усны эх үүсвэрүүд: 1. Худгууд: Дугат, Хөх Шанд, Шанд (Мухар Эргийн), Кольцот (Халивын), Хуурай (1998 онд ширгэсэн), Халив, Бор Хошуу, Бор Хошууны Кольцот (80-аад оноос хойш ашиглагдаагүй), Оорцог, Эргүүлэгт (Халивын), Тэсгэт (1999 онд ширгэсэн), Аман Ус, Улаан Худаг, Тойн Цохио 1, Тойн Цохио 2; 2. Задгай/Булаг: Дугатын Задгай, Хажуу Хөөвөр, Будаагийн Задгай, Оорцогийн Булаг, Бор Хошууны Булаг.

Малчдын хариултууд 1-р шатны үеэр Бор Овоо болон Ундай голын дагуух бусад усны эх үүсвэрийг ашиглаж байсан малчдын хэлж ярьж байсантай олон талаар адил байлаа. Малчид 2000-2005 онуудад худгийн усны түвшин доошилж байгаа нь ажиглагдаж эхэлсэн гэв. 2005-2010 оны хооронд олон худаг аль хэдийн ширгэсэн буюу ус нь маш их багасчээ. Худгийн байдалд гарсан өөрчлөлтийг малчид худгуудын усыг шавхаж авсан болон ойр орчим нь байдаг цооногуудаас шалтгаалсан гэж байв. “Задгайн” тухайд 2000- 2005 онуудад эхний өөрчлөлтүүд гарч, 2005-2010 онуудад ихээхэн өөрчлөгдсөн, 2010-2015 онуудад бүх “задгай” алга болсон гэж хэлэлцүүлэгт оролцогсод хэлж байв.

Дээр дурьдсан хээрийн судалгаанд дурьдсанчлан эдгээр усны эх үүсвэрүүдэд зам, дэд бүтэц нөлөөлсөн (арваад жилийн өмнө ус шавхаж байсан гэхээс илүүтэй) гэсэн урьдчилсан дүгнэлтийг ХШБ гаргаж байна. Усны эх үүсвэрүүдийн өөрчлөлт, болзошгүй шалтгааны дэлгэрэнгүйг энэ тайлангийн 2-р хэсгээс үзнэ үү.

Хагас бүтэцтэй ярилцлагын үеэр хэлэлцсэн гол асуудлууд: уурхайн талбайн доторх газарт гарсан өөрчлөлтүүд, шалтгаан, улирлын нүүдэл, бэлчээрийн нөхцөл, бэлчээр хэр тохиромжтой болох, малын бүтээмж, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн шалтгаан. Хамран ярилцсан бэлчээр: Дугат, Хөх Шанд, Дугатын Дугуй, Халив, Уст Баг Мод, Ухаа Овоо, Вандан Толгой, Шунхат, Оюут Толгой, Ханан Даваа, Монгол Хар, Хар Овоо, Тойн Цохио, Оорцог, Бор Хошуу, Будаа.

Ерөнхийдөө малчдын хэлснээр хамгийн их өөрчлөлт/бэлчээрийн “ачаалал” 2000-2005 онуудад гарсан байна. Хэд хэдэн газар УЛТ-д орж, зарим газарт нь усны эх үүсвэр багассан эсвэл алдагдсанаар айлууд өөр газар руу нүүн, тэнд байгаа айлуудын бэлчээрийг хуваах болж, “ачаалал” нэмэгдсэн. Үлдсэн цөөн газрын тухайд Нисэх буудал, Гүний хоолойн шугамын байгууламж зэрэгт отрын бэлчээрээ алдсан нь бэлчээрийн ачаалал нэмэгдэх өөр нэгэн хүчин зүйл болжээ. Дээр нь тоос бэлчээр нөлөөлдөг. Малчид бэлчээрээ алдсан тул ирээдүйн амьжиргааг баталгаатай болгож, зохих нөхөн төлбөр олгохыг хүсч байгаагаа илэрхийлсэн.

Халив Дугатын бэлчээр алдагдсан нь хойд зүгт Эхэн Халивт нутагладаг, Халив Дугатын бэлчээрийг зун, намар ашигладаг байсан өрхүүдэд бас нөлөөлсөн байна. Хавсралт 8-д Эхэн Халивын өрхүүдтэй хийсэн (2016 оны 6 сарын 8-нд) ярилцлага, хэлэлцүүлгийг оруулав.

Бэлчээрийн алдагдал, усны эх үүсвэр багассан/алдагдсан тул малчид улам зүүн тийшээ Ханбогд Хайрханы зүгт малаа бэлчээрлүүлэхээр нүүхэд хүрсэн; тэндхийн өвс ургамал малд тийм ч тохиромжтой бус, мөн зэрлэг амьтдын аюул ихтэй (чоно, шилүүс). Мөн энэ бүсийг ихээхэн ашиглах болсноор зэрлэг амьтад ба байгалийн амгалан тайван байдлыг алдагдуулан, экологийн аюулд хүргэж мэднэ.


Нэрлэсэн бэлчээрийн газруудыг өрхүүд улирлын чанартай хэрхэн ашигладаг тухай мэдээлэл болон Ханбогд сумын архиваас авсан малын тооны мэдээлэл зэрэгт үндэслэн бэлчээрийн үлдсэн хэсэгт малын бөөгнөрөл ямар байгааг тодорхойлов.

Хүснэгт 1. Халив Дугатын бүс дэх малын тоо хонин толгойд шилжүүлснээр 2000 – 2015									
	Гурван Модны Халив- Дугат ("Дугат")	Хөх Шанд	Гурван Модны Халив	Уст Баг Мод	Ханан Даваа	Тойн Цохио	Оорцог	Бор Хошуу	Будаа
<2000	1719.2	263.5	1812.7	113.9	290.6	584.3	437	908	428.8
2000	1328.8	207.5	1685.5	97.5	222.7	529.2	388.4	796.6	336.8
2001	954.7	41.5	957	64.1	122	298.3	193.3	407.5	162.8
2002	1084.1	49.8	536.3	69.5	178.4	426.4	221.8	469.3	173
2003	1037.2	36.9	570.8	60.2	181.6	406.5	200	474.3	100
2004				498.7	176.6	367	260		
2005				939.5	196.7	424.7	252		
2006				912	30	512.9	202.8		
2007				968.3	44.9	549.3	206.9		
2008				912	40	598	223.1		
2009				1095.2	644.7	629.4	234.4		
2010				973	715.7	671.1	238		
2011				1075.2	913.2	787.8	286.4		
2012				997	1072.7	832.8	289.8		
2013				1006.2	1098	1018.6	282.2		
2014				1148	1376	1 286	215.8		
2015				1217	1275	1 224	213.5		

Хүснэгт 1 Халив-Дугатын ай сав дахь бэлчээрийн газрын малын тооны өөрчлөлтийг харуулж байна. Бэлчээрийн газрыг нутгийн иргэдийн нэрлэж заншсанаар тодорхойлов. Өрхүүдийн нэр, бэлчээр ашиглаж байсан байдлыг Л. Батцэнгэлийн (ГТЗ-ийн Дарга) мэдээлэлд үндэслэн, Д. Хүрэлбаатар (Мал аж ахуйн тасгийн дарга), Х. Отгонжаргал (Засаг даргын орлогч) нарын хянаснаар оруулсан. Малын тоог а) тухайн нутагт өвөлжөөтэй өрхүүдийнх дээр уг газарт нутагладаг айлын маллаж байгаа бусад өрхийн тавиул малыг нэмж гаргалаа. Малыг хонин толгойд шилжүүлсэн – тэмээ 5х, адуу 7х, үхэр 6х, хонь 1х, ямаа 0.9 х).

Доорх диаграмд 2000 – 2015 онуудад бэлчээрийн газар тус бүрт байсан малын тоог хонин толгойгоор, жил бүрээр үзүүлэв. Бэлчээрийг улирлын чанартай хэрхэн ашиглаж байсан (дээрх хүмүүсийн хэлснээр) тухай мөн мэдээлсэн байгаа. Зорилтот бүлгүүдтэй хийсэн хэлэлцүүлэг, хагас бүтэцтэй ярилцлагын үеэр малчдын хэлсний дагуу тэдний ажиглалтанд үндэслэн тухайн бэлчээрийн газрын нөхцөл, тохиромжтой байдал, хүртээмж, усны эх үүсвэрийн талаар тайлбар (Малчдын тайлбар гэж) орууллаа.

3.2.1. Гурван Модны Халив Дугат ("Дугат")



Зур. 1. Гурван Модны Халив Дугатын малын тоо хонин толгойгоор (Л. Батцэнгэл, Л. Бат-Эрдэнэ, Л. Мандбаяр, П. Цагаан, Д. Гантогтох, Л. Номинцэцэг, Ц. Нэргүй нарын малыг оролцуулан)

Гурван Модны Халив Дугатын ("Дугат") Бэлчээрийн ашиглалт:

Өвөл: Л.Батцэнгэл, Л.Батэрдэнэ, Л.Мандбаяр, П.Цагаан, Д.Гантогтох, Л.Номинцэцэг, Ц.Нэргүй нарын өвөлжөө энд байсан. Эдгээр 7 өрхийг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн - Батцэнгэл Цагаан Шивээ рүү, Бат-Эрдэнэ Улаан Хошуу руу, Мандбаяр Улаанбаатар руу, Цагааных Оройн Бууц руу, Гантогтох Тойн Цохио руу нүүж, Номинцэцэг өөрийн малыг эцэг эх дээрээ орхиод ОТ-д ажиллахаар явсан, Нэргүйгийнх Улаан Овоо руу нүүсэн байна.

Хавар: Батцэнгэл (Бат-Эрдэнэ, Мандбаяр) одоо хүртэл Дугатад хаваржаатай, харин бусад хүмүүс ирж очих байдалтай байсан. 2014, 2015 онд Бадамсамбуу 2 долоо хоног, 2016 онд Адъяагийнх 10-аад хоног бүүжээ.

Зун, Намар: 2000 оноос өмнө хэд хэдэн өрх Дугатын бэлчээрийг зун, намар ашигладаг байсан. Үүнд, дараах өрхүүдийг оролцуулан, тэдгээрээр хязгаарлагдахгүйгээр: а) Б. Бадамсамбуу, Д. Адъяа, С. Банди, Баяраа (Бандийн хүргэн), б) дээр дурьдсан 7 өрхийн өвөлжөө энд байсан в) Х. Чулуунбаатар, Н. Сүрэнхорлоо, Г. Мэндбаяр, Ц. Цагаан заримдаа, г) УЛТ-н өмнө өвөлжөөтэй байсан өрхүүд 2000 оноос өмнө эндхийн бэлчээрийг намар ашигладаг байв д) 2010 оны үед А. Улам-Ундрах, А. Наранцэцэг нар энэ хавийн бэлчээрт намар бүүдаг байсан.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Энэ бэлчээр УЛТ, нисэх буудалд ойрхон, ус муутай тул 2005 оноос цөөхөн өрх энэ хавийг зуны бэлчээрээр ашигладаг байв. ЗБ-ийн (зорилтот бүлэг) оролцогсод⁴ Дугатын худгийн нөхцөл байдал, усны түвшин 2000 – 2015 оны хооронд 4-с 1 рүү орсон гэв (4 – 0 хүртэлх оноогоор). Усны эх үүсвэрт гарсан өөрчлөлтүүд хайгуулын үед үхсэн гүний олон цооногуудаас шалтгаалсан гэж үздэг, худгийн усыг дээж угаахад ашигладаг байсан байна. Нэгэн настны хэлж буйгаар Дугатын хавийн гүехэн гүний усны түвшин нь мал угаах онгоц усаар дүүрчихгүй газар байрлуулах гэхэд л олддоггүй тийм байсан ажээ.

3.2.2 Дугатын Дугуй

Дугатын Дугуйн бэлчээрийн газар Бор Овоотой ойрхон (3 км орчим) байсан; худаг, задгай, булаг байгаагүй.

Өвөл: Өвөлжөө байгаагүй.

Зун, Намар: Дугатын Дугуй нь өмнө зүгт байх Оюу Толгой, Вандан Толгой, Шунхат зэрэг Дугат, Гурван Модны Халив, Улаан Толгойн айлууд (мөн цагийн байдлаас шалтгаалан бусад газраас ирдэг) олон өрх ашигладаг бэлчээрийн хамт нийтийн бэлчээр байсан. Тэмээний гол бэлчээр.

2003 оноос өрөмдлөг эхэлж, дараа нь уурхайн кемп байгуулагдан, тэмээ бэлчих боломжгүй болсон. 2012 онд УЛТ тэлэгдэхэд хашааны дотор оржээ. Одоо орох боломжгүй (ЗБ оролцогсод 3 сарын 30/31, 2016)

3.2.3 Хөх Шанд

Зур. 2: Хөх Шандын малын тоо хонин толгойд шилжүүлснээр (Т. Пүрэвийн малыг оруулан).



⁴ ЗБ хэлэлцүүлэг 3 сарын 30/31, 2016. Оролцогсод: П. Цэвэгдорж, Д. Мөнхбаяр, Б. Эрдэнэжаргал, Ц. Цэцэгмаа, Д. Түүл, Д. Цэндоо, С. Жаргалсайхан, Л. Батцэнгэл, Б. Оюун-Эрдэнэ, Д. Намсрай, Б. Намсрай, Ц. Цагаан, Б. Охиндүү, Ц. Амартүвшин, Ц. Хандсүрэн, Ц. Самдан, Б. Оюунтулга

Хөх Шандын Бэлчээр:

Өвөл: Т. Пүрэв, цөөн малтай, Хөх Шандад өвөлжөөтэй ганц өрх.

Зун, Намар: Т. Пүрэвийнх энэ хавьдаа зусаж, намарждаг байгаад тэднийхийг 2004 онд нүүлгэн шилжүүлж, 2005 онд сумын төв рүү орсон.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Хөх Шандын бэлчээрийн газар одоо УЛТ-н хашаанд дотор/ойрхон орсон. Хөх Шандын хүдгийг малчид 2000 – 2015 хооронд 4-с 0 (4 – 0 оноо) рүү буусан шалтгаан нь хайгуулын өрөмдлөг, ойролцоох зам, карьер гэж үзсэн.

3.2.4 Гурван Модны Халив



Зур. 3: Гурван Модны Халивын бэлчээрийн малын тоо Ц. Цагааны малыг оруулан


Гурван Модны Халивын бэлчээрийн ашиглалт:

Өвөл: Ц. Цагааны өвөлжөө байсан. Тэднийхийг 2004 онд нүүлгэн шилжүүлж, эхлээд Шавагт нэг жил болсон.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Гурван Модны Халивын бэлчээр одоо УЛТ-н дотор орсон. Малчдын усны эх үүсвэр нь Халивын гар худаг, Халивын Колцот худаг байв.

3.2.5 Уст Баг Мод



Зур. 4: Уст Баг Модны бэлчээрийн малын тоо Ц.Самдан, Ц. Цагаан, Л. Батбаатар, Л. Отгонжав, Л. Мөнхбаатар, Л. Номинцэцэг, Ж. Батмөнх нарын малыг оруулан

Уст Баг Модны бэлчээрийн ашиглалт:

Өвөл: Ц. Самдан цөөхөн бог малтай, өвөлжөөг нь ашигладаг байв, бод нь зүүн тийшээ бэлчдэг байсан. 2004 онд нүүлгэн шилжүүлсэн, сүмын төв рүү нүүсэн. Ц. Цагаан энэ өвөлжөөг 2005 – 2010 онуудад ашиглаж байв. 2005 оноос Л. Батбаатар, Л. Отгонжав, Л. Мөнхбаатар, Л. Номинцэцэг, Ж. Батмөнх нарын мал энд бэлчдэг байсан.

Зун, Намар: Ц. Самдангийнх заримдаа зун, намар буудаг байв

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Уст Баг Модны бэлчээр баруун талдаа уурхайн хашаагаар хязгаарлагдсан, зүүнтээ бэлчээрт тохиромжгүй хадтай уултай. Тоосны нөлөөлөлд өртсөн, ихэнхдээ 5 ба түүнээс дээш айл бэлчээрээ хуваадаг.

3.2.6 Ухаа Овоо



Зур. 5: Ухаа Овоон бэлчээрийн малын тоо, Ц. Хишигчулууны малыг оруулаад

Ухаа Овоон бэлчээрийн ашиглалт:

Нэгдлийн үед зарим нэг өрх айл хааяа энэ өвөлжөөнд буудаг байгаад 1990 оноос хойш Х. Хишигсүрэн өвөлжөөний гэрчилгээ гаргуулж автал айл буугаагүй.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Малчдын хэлж байгаагаар (ЗБ 3 сарын 30/31, 2016), 4 айл энд бэлчээр хуваадаг, баруун талдаа УЛТ-н хашаагаар хязгаарлагдсан, Тоосны нөлөөлөлд өртсөн.

3.2.7 Вандан Толгой (Гурван Модны Халивт байдаг овоо), Шунхат (Бор Овооны орчим) Оюу Толгой


Бэлчээр ашиглалт:

Эдгээр нь нийтийн бэлчээр байв, голчлон тэмээ бэлчдэг, Гурван Модны Халив, Дугат голын дагуух айлууд зундаа ирдэг, мөн ХШБ-ийн 1-р шатны тайланд дурьдсан Ундай голын дагуу өвөлжөө, хаваржаатай 59 өрх ашигладаг байсан.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Малчдын өгсөн мэдээгээр (ЗБ 03/30/31, 2016), хайгуулын үед өрөмдлөгийн нөлөө бэлчээрт учирсан. Хайгуулын үед бохироо Шунхатад асгадаг байсан байна. 2004 оноос УЛТ-н дотор орсон.

3.2.8 Ханан Даваа



Зур. 6: Ханан Даваан бэлчээрийн малын тоо М. Баярсайхан, А. Улам-Ундрах, А. Наранцэцэг, У. Уянга, У. Түвшинтөгс, У. Цацралт, Ц. Шинэ-Төмөр нарын малыг оролцуулан

Бэлчээр ашиглалт:

Ханан Давааны бэлчээрийг зун, намар олон айл өрх ашигладаг байв. Үүнд дараах өрхүүдийг оролцуулан тэдгээрээр хязгаарлахгүйгээр: Ц. Мөнхтөр, М. Баярсайхан, Б. Эрдэнэжаргал, Д. Гантогтох, Б. Намсрайжав, Р. Чулуу, Ц. Цагаан, Ц. Самдан, Б. Эрдэнэбаяр, Ц. Элбэгсайхан, Ц. Төмөртоогоо, Ц. Нэргүй, Ц. Хандсүрэн, С. Жаргалсайхан, Д. Чойжилсүрэн, Ш. Ганбат, М. Пүрэвдорж, Д. Мөнхбаяр

2009 оны үеэс А. Улам-Ундрах, А. Наранцэцэгийнх зун, намар ашиглаж байв.

Нөлөөлөлд өртсөн хоёр өрх, мөн нөлөөлөлд өртсөн гэж тооцогдоогүй бусад өрхүүд нүүж ирсэн.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Дэд бүтцийн улмаас бэлчээрийн хэмжээ багассан (өндөр хүчдэлийн шугам, Гүний Хоолой, газ цэнэглэгч компани, тээврийн компаниуд). Баяжмалын зам баруун талаар гардаг, баруун талд УЛТ хашаа байгаа, хойд талд Гүний хоолойн шугам. Үлдсэн газар нь өвс ховор, хадархаг. Зүүн ба өмнө талд араатан (шилүүс, чоно) бүхий уул байдаг болохоор бэлчээр сунгах аргагүй. Нөөц бэлчээр байсан газарт нь одоо Гүний хоолойн шугам, нисэх буудал байгаа.

3.2.9 Монгол Хар, Хар Овоо

Бэлчээр ашиглалт:

Энд өвөлжөө байхгүй. Монгол Хар, Хар Овоон бэлчээр хадархаг, ууланд байдаг, ойр хавьд өвөлжөөтэй өрхүүд нийтийн бэлчээрээр ашигладаг.

Өрхүүд: Б. Намсрай (Тойн Цохионд өвөлжөөтэй), М. Баярсайхан (Ханан Даваанд өвөлжөөтэй), Ө. Чулуу (Оройн Бууцанд өвөлжөөтэй), П. Өлзийбаяр (Ар Шандад өвөлжөөтэй), Ц. Хандсүрэн (Аман Усанд өвөлжөөтэй), Б. Эрдэнэжаргал (Зараад өвөлжөөтэй), Д. Мөнхбаяр (Бор Хошуунд өвөлжөөтэй).

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Одоо энэ хавийн газар тоосны нөлөөлөлд өртсөн – **ил уурхайн нунтаг цагаан тоос**. (малчдын ажиглалт). Баруун талд баяжмалын зам. Ихэвчлэн тоос мөн машин тэрэгний дуу чимээ нөлөөлдөг.

3.2.10 Тойн Цохио



Зур. 7: Тойн Цохион бэлчээрийн малын тоо Б. Намсрай(жав), Г. Шоовдор, Д. Гантогтох, Б. Болдсүх, У. Эрдэнэ-Булган, Т. Чинзаяа.

Тойн Цохион бэлчээр ашиглалт:

Өвөл: Б. Намсрай 1988 онд малчин болсноосоо хойш Тойн Цохион энэ бүст нутаглан, мал маллаж ирсэн.

Зун: Г. Шоовдор олон жил (Тойн Цохион Хөндий) мал маллан энд амьдарч байгаа, өвөлжөө нь “Түймэртийн Хошуунд” байдаг, Тойн Цохиогоос 3 км, Тойн Цохион усыг уудаг. Г. Шоовдор 10 хүүхэд өсгөсөн, бүгд малчин болж, энэ нутагтаа амьдарч байна. Г. Шоовдорын өрх нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын аль ч хөтөлбөрт хамрагдаагүй. 2004 оны сүүлээр Д. Гантогтохынх эдний нутагт нүүн ирснээс хойш саахалт байгаа.

Дараах өрхүүд зуны бэлчээрээр ашигладаг: Б. Намсрай, Г. Шоовдор, Б. Эрдэнэжаргал, Б. Эрдэнэбаяр, Д. Мөнхбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Л. Батцэнгэл, Л. Мандбаяр, Л. Бат-Эрдэнэ, Ц. Хандсүрэн, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж, Б. Төртайван.


Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

2004 онд Гантогтох (мөн Л. Номинцэцэг, Ц. Самдан?) энд өвөлжөө барьснаас хойш бусад өрхүүдийн зуны бэлчээр багасчээ. Зарим өрх малаа алдаад/мал маллахаа больж; ажилд орох санаатай сумын төв орцгоосон.

Сум руу нүүсэн өрхүүд: Шоовдор Галсанхүү, Б. Эрдэнэбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж.

Малчдын мэдээлснээр (ЗБ 03/30/31, 2016) хэд хэдэн нөлөөлөлд өртсөн өрхүүд ийшээ нүүж ирсэн (Ц. Самдан, Д. Гантогтох, Л. Номинцэцэг), мөн жил бүр 3-4 айл отороор ирдэг аж.

3.2.11 Оорцог



Зур. 8: Оорцогийн бэлчээрийн малын тоо Ж. Өлзий-Орших, С. Жаргалсайхан, Д. Цэндоо нарын малыг оруулан.

Оорцогийн бэлчээрийн ашиглалт:

Өвөл: 2005 хүртэл Өлзий-Орших эндхийн өвөлжөөнд өвөлждөг байгаад сумын төв рүү нүүсэн. С. Жаргалсайхан 2004 оноос өмнө одоо УЛТ-д орсон газарт нүүж ирсэн, 2004 онд нүүлгэн шилжүүлэлтэнд орж, өвөлжөөгөө буцаад Оорцог руу зөөсөн. ОТ эднийд нэг өвөлжөө шинээр барьж өгсөн, өөрсдөө бас нэг өвөлжөө барьсан.


Зун: Дараах өрхүүд зуны бэлчээрээр ашигладаг:

Б. Намсрай, Г. Шоовдор, Б. Эрдэнэжаргал, Б. Эрдэнэбаяр, Д. Мөнхбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Л. Батцэнгэл, Л. Мандбаяр, Л. Бат-Эрдэнэ, Ц. Хандсүрэн, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж, Б. Төртайван

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Малчдын хэлснээр (ЗБ 03/30/31) нөлөөлөлд өртсөн/нүүлгэн шилжүүлсэн гурван өрх бэлчээр хамтран ашигладаг, отороор яваа айлууд мөн буудаг. Зам 1 км зайд байдаг, малд аюултай, осол гарч байсан.

3.2.12 Бор Хошуу



Зур. 9: Бор Хошууны бэлчээрийн малын тоо Д. Мөнхбаяр, Б. Сугахсүрэнгийн малыг оролцуулан

Бор Хошууны бэлчээр ашиглалт:


Өвөл: Д. Мөнхбаяр, Б. Сугарсүрэн 2004 он хүртэл энд өвөлжөөтэй байгаад тэднийг нүүлгэн шилжүүлсэн. Д. Мөнхбаяр ойрхон Хороот руу нүүсэн, ОТ гүний худаг гаргаж өгсөн. Б. Сугарсүрэн ОТ-д нэг хэсэг ажиллаж байсан.

Зун: Б. Мөнхбаяр мөн зуны бэлчээрээр ашигладаг.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Малчдын хэлснээр (ЗБ 03/30/31) отрын айлууд энэ хавиар өнгөрдөг. Зам 1 км-т, малд аюултай, осол гарч байсан.

3.2.13 Будаа



Зур. 10: Будаа дахь малын тоо хонин толгойд шилжүүлснээр Б. Эрдэнэбаярын малыг оролцуулан

Будаан бэлчээрийн ашиглалт:

Өвөл: 2004 он хүртэл Б. Эрдэнэбаярын өвөлжөөний бууц байсан.

Зун: Х. Отгонжав, Ц. Бямба, Д. Билэгсайхан нар зуны бэлчээрээр ашигладаг байв.

Б. Эрдэнэбаярынхыг 2004 онд Зараа руу нүүлгэн шилжүүлсэн, ах Эрдэнэжаргалынх нь тэнд байдаг, 500 метрт өвөлжөө барьсан. 2005 онд тэрээр сумын төв рүү орсон.

Бэлчээр, Усны Эх Үүсвэрүүдийн Нөхцөл Байдал, Хүртээмж:

Малчдын хэлснээр усны эх үүсвэр багассан (худаг); зун хэдхэн өдөр өглөө маш эрт л ус авч болдог.

Дээрх диаграм УЛТ-н дотор орсон эсвэл зам зэрэг дэд бүтэц дээгүүр нь гарч байгаа, эсвэл тоосны нөлөөлөлд орсон гэх мэт шалтгаанаар хүрч болохгүй болсон эсвэл бага ашиглагддаг бэлчээрийн малын тоо буурсныг (мэдээж) харуулж байна.

Эсрэгээрээ, бэлчээрийн бусад газарт тухайлбал Ханан Даваа, Уст Баг Мод, Тойн Цохио зэрэг газруудад нүүлгэн шилжүүлсэн өрхүүд, албан ёсоор нүүлгэн шилжүүлээгүй ч нөлөөлөл (дэд бүтэц, тоос) болон ус багассаны улмаас нүүж ирсэн айлууд, мөн хуучин отрын бэлчээр нь нисэх буудал, Гүний Хоолойн шугам гэх мэт дэд бүтцэд эзлэгдсэнээс энэ хавьд оторлох болсон өрхүүдийн мал бөөгнөрсөн байна.

Ундай голын айлууд Бор Овоо, түүнийг тойрсон бэлчээрээ алдан нөлөөлөлд өртсөний нэгэн адил (ХШБ-ийн 1-р шатны тайлан) Халив Дугатын бүсийн бэлчээр, усны эх үүсвэрээ алдсан нь өрхүүдэд нөлөөлжээ. Нөлөөлөл нь орон нутгийн хэмжээнд байна, учир нь зуны болон отрын бэлчээрээ

алдсан, тэдний бэлчээрийн газарт бусад өрхүүдийг нүүлгэн шилжүүлснээр бэлчээрийг улирлын чанартай ашигладаг хуучин тогтолцоо эвдэгдэн, үлдсэн нутагт мал бөөгнөрөхөд хүргэжээ.

Мал аж ахуйд үзүүлж буй нөлөөнд улирлын нүүдэл багассан; тухайн бэлчээрийг өмнөхөөс олон өрх ашигладаг болсноос гадна зун, намрын бэлчээрт гарч чадахгүй өвөлжөөний хавиараа байдаг болсон зэрэг орно. Өрхүүдээр хийсэн судалгааг доор үзнэ үү.

3.3 Өрхүүдийн мэдээлэл – Халив Дугатын Малчин Өрхүүдэд нөлөөлсөн байдал

Халив Дугатын бэлчээртэй холбоотой малчин өрхүүдийн мэдээллийг зорилтот бүлэгтэй хийсэн хэлэлцүүлэг болон хагас бүтэцтэй ярилцлагын үед өөрсдөө мэдүүлснээр энд оруулав (илүү дэлгэрэнгүй тайлбар Хавсралт 4-т байгаа)

С. Жаргалсайхан, Халив Дугатын голын хавиар зусдаг байсан. Одоо өвөлжөө орчимдоо зусч байна. Урьд өмнө эх үүсвэр нь задгайнууд байв, одоо зөвхөн гар худгийн ус. Өмнө 30 бод, 250 богтой байсан, одоо 20 бод, 200 бог малтай. Бэлчээр багассан тул малын тоог цөөрүүлсэн. Шинэ бэлчээрт нүүж ирснээс хойш ажлын ачаалал ихэссэн. Малын ноос, сүүны хэмжээ, чанар аль аль нь буурсан.

Д. Цэндоо, 2004 онд нүүлгэн шилжүүлсэн, зөвхөн хүүгийнхийг нь (хоёр өрх цугтаа амьдарч/нүүж байсан хэдий ч) нөхөн олговорт хамруулсан, 5-6 өрх бэлчээр хуваадаг тул хүртээмж муу. Малын тоо толгойг өсгөхөд хүнд болж байна. Зам, уурхайн сайтын тоос, ялангуяа салхи баруунаас байхад. Ус хомсдсоор.

Б. Намсрайжав – нөлөөлөлд өртсөн гэж тооцогдсон гурван өрх (Ц. Самдан, Д. Гантогтох, Л. Номинцэцэг) Тойн Цохион дахь тэдний өвөлжөө рүү 2004 онд нүүж ирсэн. Зуны бэлчээр нь Дугатад байдаг байсан, одоо зуны бэлчээр дутмаг; зүүн зүг рүү ууланд мал бэлчээхээр хээрийн амьтдад алддаг (2016 оны хавар 9 ботго).

Б. Намсрайжавын өрх (түүний эхнэр Ц. Цагдуулсүрэн) зуны бэлчээрээ алдсан, өвөлжөөний бэлчээрт нь өөр өрхүүд нүүж ирсэн хэдий ч “нөлөөлөлд өртөөгүй” гэж тооцогдсон.

Ц. Цагаан, 2004 онд нүүлгэн шилжүүлсэн. 2000 онд Халив Дугатад өвөлжөөтэй, бэлчээр зөндөө, мал нутагтаа идээшсэн, усны эх үүсвэр сайтай байжээ. Шаваг дахь шинэ бууцанд өвөлжөө, айл өрх, мал олон, ус хангалтгүй, бэлчээрийн ачаалал их.

Бэлчээр, усаа Мэндбаяр, Нэргүй, Наранцэцэг, Эрдэнэжаргал, Ундрах, Баярсайхан зэрэг өрхүүдтэй хуваадаг. Бор Овоо, Цанхи, Хүрэн Хошуу, Дугатад зусч, намарждаг байсан. Одоо өвөлжөөнийхөө ойр зусч байна.

М. Баярсайхан, Ханан Даваанд өвөлжөөтэй; одоо тоос, зам бэлчээр хувааж байгаа, дэд бүтцийн улмаас бэлчээрээ алдсан гэх мэт нөлөөлөл байгаа. Өөр 5 өрхтэй бэлчээр хуваадаг, зуны бэлчээрээ нисэх буудалд алдсан.

Б. Эрдэнэжаргал; нүүлгэн шилжүүлсэн өрхүүд өвөлжөөгөө Тойн Цохио дахь тэдний зун/намрын бэлчээр рүү нүүлгэсэн; одоо өвөлжөөндөө зусдаг.

Ц. Самдан, 2000 онд Уст Баг Модонд нутагладаг байв, одоо Ихэр Хондонд өвөлжөөтэй. ОТ нүүлгэн шилжүүлсэн, одоогийн өвөлжөө нь өмнөхөөс бэлчээр муутай, мал бэлчээх газар хангалтгүй. Ойр тойронд нь 4 айл байгаа: Мөнгөншагай, Намсрай, Хандсүрэн, Гантогтох. Зун, намрын бэлчээр нь Халив, Дугат, Бор Овоо, Бумбат хавиар байсан. Одоо зун, намарт өвөлжөөнийхөө хавиар байдаг.

Д. Мөнхбаяр, (2004 онд нүүлгэн шилжүүлсэн). 2000 онд Бор Хошуунд нутагтай байгаад ОТ-н тоосны улмаас Хороот руу нүүсэн. Одоогийн өвөлжөө бэлчээр багатай, замууд бэлчээрийг хуваадаг. 3 өрхтэй бэлчээр хуваадаг: Жаргалсайхан, Хандсүрэн, Цагаан. Зүүн талдаа олон айлтай болохоор бэлчээр сунгах болохгүй. Зуны бэлчээр нь Бор Овоо, Будаа, Дугатад байсан. Одоо өвлийн бэлчээрээ зун ч ашигладаг. Бэлчээр дутмаг тул малын тоо өсгөх аргагүй.

Ц. Хандсүрэн, Б. Охиндүү 2000 оноос хойш Хайрцагт Аман Усанд өвөлжөөтэй. Нүүлгэн шилжүүлээгүй, харин бусад өрхүүд нүүн ирснээс болж бэлчээр, ус хомсдож бүх хүмүүсийн амьжиргаа хүндэрсэн. Одоо 5 айлтай саахалт, Мөнхбаатар, Намсрайжав, Самдан, Цагаан, Жаргалсайхныхтай бэлчээр хуваадаг. Халив, Бор Овоо, Ухаа Овоо зэрэг зун, намрын бэлчээр нь ОТ-н хашаанд орсон. Халив, Бор Овоо, Ухаа Овоод зусдаг байв, энэ хавь мөн отрын бэлчээр байсан. Тэдний хүүхдүүдийн малын усны эх үүсвэр одоо бас ОТ-н хашаан дотор орсон тул хүүхдүүдийнх нь мал өөрийнх нь өвөлжөө хавиар байгаа.

Ц. Хандсүрэн, Б. Охиндүү нарт 2011 онд ОТ-н замын нөлөөллийн нөхөн олговор өгсөн. Хэдий тийм ч ОТ-н өөрийнх нь (УЛТ, уурхайн сайт) улмаас бэлчээр, ус багасч, нөлөөлөлд өртсөн гэж боддог. Нөлөөлөл улам ихэсч, бүр л хүнд хэцүү болно гэж үздэг. Тэд сургалтын төлбөр хэзээ ч авч байгаагүй гэв. Зам цэвэрлэгээний гэрээтэй, гэхдээ сунгах бодолгүй. Хандсүрэн, Охиндүү нарын хүүхдүүд:

- Хишигчулууных УЛТ-с 1 км-т байсан (Халивын бүс, Хажуу Хөөвөр); дуу чимээ, бэлчээр, ус багаас болоод одоо ашиглах аргагүй. Усны эх үүсвэр Халивийн Ус худаг, одоо хашаан дотор орсон. Түүнд нөхөн олговор олгоогүй.
- Бас нэг хүүгийнх нь өвөлжөө Эхэн Сэрүүний хавьд байсан (ОТ-н том гэрийн ойролцоо); тэдний тэнд бас өөр айлууд шахаж буусан (ж. Жаргалсайхан); мал маллахаа болиод малаа энд орхисон.
- Нөгөө хоёр хүү нь ч бас мал маллахаа больж, гэрийнхэндээ малаа үлдээжээ. Тэгэхээр тэнд 4 өрхийн мал байна гэсэн үг.

П. Цагаан

2000 онд Дугатад байсан, өвөлжөөний бэлчээр нь Эргэн Усанд. Өвөлжөө нь УЛТ-д орсон тул П. Цагааныг нүүлгэн шилжүүлсэн. Нүүж очсон газрын бэлчээр тохиромжгүй, олон айл, малын ачаалалтай. Өмнө нь Оюу Толгой, Бор Овоо, Бумбатад зусч, намарждаг байсан, одоо зун намрын бэлчээргүй. Өмнө нь 180 бог, 5 бодтой (тэмээ) байсан, одоо малгүй (бэлчээр мүүгаас алдаад дүүссан, уулын бэлчээрээс хөндий рүү буугаад мал идээшээгүй, ус хангалтгүй, малд нөмөргүй байсан.)

Дамдины Гантогтох

2000 онд Хөх Үзүүрт өвөлжөөтэй байсан, 2004 онд Тойн Цохио руу нүүсэн. Өвөлжөө ОТ-н лицензит талбайд орсон тул нүүлгэн шилжүүлсэн. Одоогийн бэлчээрийг олон айл ашигладаг. Зун, намрын бэлчээр Дугатад байв. Одоо зуны бэлчээргүй. Дугатын гар худгийг ашиглаж байсан. Одоо Тойн

Цохион гүний худгийг үүж байгаа. Бог мал, адуу, тэмээтэй, малын тоо нэмэгдсэн. Ажиллагаа, зардал өссөн (өвс тэжээл авах гм.)

Цэвэгдоржийн Түвшинтөгс

Энэ өрх үрд зүгээс (Гашуун Сүхайтын хилийн боомт) нүүн ирж, Халив Дугатад өвөлжөө худалдан авсан, одоо өөр олон айл өрх нэг бэлчээр ашиглаж буй тул ачаалалтай. 5 өрх бэлчээр хуваадаг: Хандсүрэн, Ц. Цагаан, С. Жаргалсайхан, Б. Тогоо. ОТ сайжруулсан зам барьж эхэлснээс хойш бэлчээр, усны эх үүсвэр багассан аж.

Лувсандагвын Мөнхбаатар

Устад өөрийнхөө нэр дээр гэрчилгээ бүхий өвөлжөөтэй. ОТ-д ажилд орох гээд чадаагүй. Ээжтэйгээ малаа малладаг. Устад өвөлжөө авсаных нь дараа ОТ Гашуун Сүхайтын зам (3 км зайтай) барьж эхэлсэн, барилгын дуу чимээ, тоос, том тэрэгнүүд мал маллагаанд нөлөөлж, бэлчээрийн ихээхэн хэсгийг том тэрэгнүүд эвдэж хаясан. Өвөлжөөнөөс нь 800 метрт 600 га газар бүхий элсний карьер байдаг, 20-30 метр гүн нүх гаргасан. Энэ өрхөд нөхөн олговор ч өгөөгүй, ажил ч олгоогүй.

Долгорсүрэн

2005 онд Хөх Хадны өвөлжөөнд өвөлжсөн. Энэ өвөлжөө түүний хүү Намсрайн нэр байсан ч хэд хэдэн өрх нэг дор амьдарч байв. 2005 онд Намсрай нүүж (ОТ-н нүүлгэн шилжүүлэлт), өвөлжөө түүний нэр дээр байсан тул зөвхөн Намсрайд нөхөн олговор өгөөд Долгорсүрэн гуай тооцоогүй. Тэр хамтран эзэмшигч гэж явсан, гэрчилгээ байгаагүй.

2015 онд малчин хөлслөөд хаваржаа нь байсан Байшинтад (Будаа голд) өвөлжөө барьж, гэрчилгээ авсан. Үүнийг нь одоо бага хүү нь тэмээ бэлчээн ашиглаж байгаа. Долгорсүрэн, түүний хүүгийн малыг хөлсний малчин маллаж байгаа, Хөх Шанд, Байшинт хаа өвс байна тэнд бэлчээрлэдэг. Заримдаа Байшинтад айл олширвол малаа Намсрайн одоогийн байгаа газар руу аваачдаг.

Одоогийн өвлийн бэлчээрийн төрөл/чанар дажгүй, харин мал дэндүү их. Хөх Хадны бэлчээрийг өмнө нь хоёр өрх ашигладаг байв (Намсрай, түүний ээж Долгорсүрэн), одоо Байшинтын хавийг Одгариг, Түвшинтөгс, Намсрай, Хүрэлээ нар ашиглаж байна.

Урьд зуны бэлчээр хангалттай байсан, олон айл ашигладаг байлаа. Үүнд одоо УЛТ-д орсон Бор Овоо, Халив Дугатын бүс ордог байв, аль аль нь одоо уурхайн хашаан дотор байгаа. Зуны бэлчээр УЛТ-н өмнө зүгт, өвөлжөөнийхөө хавьд байна. Тэмээ Цанхи, Будаа руу бэлчдэг. Бог мал ихэвчлэн өвөлжөөний ойр байдаг. Зуны бэлчээрийн даац, чанар муудсан. Хойд зүгт байсан бэлчээр хамаагүй сайн, тохиромжтой, тэжээллэг ургамал ихтэй байсан. Халив Дугатын хавь их сайхан, өвсний гарц, шим сайтай байлаа. Урагшлахаар илүү цөлөрхүү.

Долгорсүрэн гуайнх 200-300 малтай байсан бол одоо 50 орчим. Шалтгаан хэд хэд: а) малаа хүүхдүүддээ хувааж өгсөн, б) бэлчээр, ус хангалтгүй тул малынхаа тоог бэлчээрийн даацтай тохируулсан, в) хээлтүүлгийн хэмжээ тийм сайн биш. Сүү, ноосны гарц багассан, өмнө нь 1 ямаанаас 1 кг ноолуур авдаг байсан, одоо 700-800 гр. Тэмээний ноос харин янзаараа.

М. Цээсүрэн

Цээсүрэнгийн өвөлжөө Дугатын Хүрэнгийн Дэлд байсан, Дугатын худгийг ууж байв. Шаардаад байсан тул өвөлжөөндөө цуг байдаг байсан хоёр хүүгийнхээ хамт Буйлсан Хөөвөрт нүүж очсон, зөвхөн нэг өрхийг нөлөөлөлд өртсөн гэж тооцсон. Гэрээнд шахалтаар гарын үсэг зурсан гэж боддог. Буйлсан Хөөвөр нисэх буудлын ойр, олон машин тэрэг бэлчээр туучин гэрийн хаяагаар гардаг байв. Өрөмдлөгийн компани ойрхон байсан. Нүүлгэн шилжүүлсэн газарт ОТ-н гаргаж өгсөн худаг 2-3 жил болоод хатжээ. Тэрээр 2007/8 онд сум руу нүүсэн.

Усны эх үүсвэрт гарсан өөрчлөлтийн талаар Цээсүрэн хэлэхдээ: Хөрсний үс их элбэг байсан, 1990-ээд онд хонь угаах онгоц байрлуулах газар олддоггүй, малын эмчийн үхсэн газар болгоноос үс гараад байдаг байсан. 2010 он гэхэд задгай, булгийн үс ширгэсэн, эхлээд худгийн усны түвшин доошилж, араа нь бүх булаг шанд хатсан.

Билэгсайхан

Билэгсайханы өвөлжөө Ундай голд Хар Толгойн Ханд гэдэг газар байдаг, зун, намарт Халив Дугат хавиар нутагладаг байжээ. 1996 оноос ийм байдалтай явж ирсэн. Дөнгөж гэрлээд, өвөлжөөндөө гэрчилгээ аваагүй байсан, өвөлжөөг гэрчилгээжүүлэх ажил дөнгөж эхэлж байсан. Олон газар өрөмдөөд эхэлмэгц нь энэ хавь цаашдаа мал маллахад тохиромжгүй болох нь дээ гэж бодож байв. Бор Овоо усны гол эх үүсвэр байлаа.

2000 онд Дугатын бэлчээр сайн байсан, харин өрөмдлөг их явагдаж байсан тул нөхцөл нь тохиромжгүй. Билэгсайхан мал маллах ажлаа үргэлжлүүлэхийн тулд тохиромжтой бэлчээр хайн Гавилууд багийн хойгуур 2001 он хүртэл нутаглажээ. Дараа нь сумын төвөөс 30 км-т байх Гурван Шавагтай руу нүүн, тэндээ 7 жил болоод (2001 – 2006) 2007 онд Шавагтайн “Үзүүрийн Ханд” гэдэг газар өвөлжөөний гэрчилгээ авсан. Айл саахалттай асуудал гарснаас 2006 онд 2км цааш нүүж 2013 он болтол байжээ. Тэнд Шавагтайн худгийг 6 айл хувааж байв. 2015 онд сум руу орж ирсэн.

Билэгсайхан Ундайд өвөлжөө төвхнүүлсэн үе нь социализмын бүртгэл, шинэ гэрчилгээжүүлэлтийн завсарт таарсан, дээр нь нас залуу, дөнгөж гэрлэсэн байв. Ундай дахь өвөлжөө нь гэрчилгээгүй байснаас түүнийг нөлөөлөлд өртсөн гэж үзээгүй, нөхөн олговор олгоогүй.

П. Онон, нөхөр Г. Мэндбаяр

Тэдний өвөлжөө нь 1993 - 2002 онуудад Цанхид байв, бэлчээр ихтэй, 4 айл бууцаа хуваадаг. Малаа баруун тийш нь бэлчээдэг. 2003 онд өөрийн гэсэн өвөлжөөтэй болохоор Их Гялаан руу нүүж, Ц. Нэргүйнх байсан өвөлжөөг засч авчээ. Зун, намар Халив Дугатын бэлчээрт нутагладаг байв.

Халив Дугатын хавь өвс ургамал сайтай, хавар, зун, намрын бэлчээр байсан. Социализмын үед шимэгч устгах, мал ялгах зэрэг мал аж ахуйн олон ажил энд явагддаг байв. 2004 онд тэд Дугатад суурьших гэсэн боловч боломжгүй болсон байлаа.

2011 онд эдний өрхийг нөлөөлөлд өртсөнд тооцож, нэг жилийн хугацаатай хог түүх гэрээ байгуулжээ. Нөхөр нь өвдсөн (гэрээ сунгагдана). “Тогтвортой амьжиргаа залгуулах тодорхой нэг зүйл үнэхээр хийх хэрэгтэй байна” гэж Онон хэлж байв.

Нэргүй

Нэргүй хоёр охинтой, нэг нь малчин, нөгөөх нь ажилгүй. Бэлчээр, ус бага болохоор малын тоо толгойг хязгаарлахаас аргагүй, тиймээс амьжиргааг тогтвортой байлгах ямар нэгэн нөхөн олговор шаардлагатай байна гэж Нэргүй хэлж байлаа.

Л. Мандбаяр

Хүрэн Дэлийн худагт байсан, 4 өрх цугтаа. Бэлчээр, ус мал маллахад хангалттай байв. 2004 онд өвөлжөөний гэрчилгээ ээжийнх нь нэр дээр олгосон тул 4 өрхийг нэг айлаар тооцсон. Тэрээр нүүхээс өөр аргагүй болж, олон малаа алджээ. Тэр Улаанбаатарт очин, харуул манаа гэх мэт янз бүрийн ажил хийж байв. Түүнд одоо юу ч байхгүй, тэгсэн хэрнээ нөлөөлөлд өртсөнд тооцогдоогүй. Одоо гэр бүлийн хамт Улаанбаатарт байгаа. Тэрээр газар, амьжиргаагаа ОТ-д алдсан тул нөлөөлөлд өртсөн гэж тооцогдохыг хүсч байна. Хэрэв ОТ байгаагүй бол тэр өөрөө, ах дүү нар нь малчин хэвээрээ байх байсан.

Б. Эрдэнэбаяр

Эрдэнэбаярын өвөлжөө Модот Цанхид байсан (Хүрэн Хошууны бууц), одоогийн УЛТ-н зүүн хойд буланд хашаанаас 400-500 метрт. 1993 оноос Эрдэнэбаяр хороо барьж, гар худаг гаргасан. Тэр үед бэлчээр элбэг дэлбэг, малчид малаа өсгөх боломжтой байлаа. Эрдэнэбаярынх 1999 он хүртэл энд өвөлжсөн. 1999 онд хүр бага байсан болохоор 1999/2000 өвөл зүүн тийшээ нүүж, хоёр жил өвөлжжээ. 2001/2 онд Хүрэн Хошууны бууцандаа эргэн ирж, 2003 оны үед Хүрэн Хошуунаас 4 км-т байх эгчийнх рүүгээ нүүсэн (хүүхдүүд бага байсан болохоор хоёр өрхөөрөө цугтаа байвал хэн нэг нь малдаа гарахад хүүхэд эзэнгүй үлдэхгүй гэж).

2004 он гэхэд Эрдэнэбаярын 2 хүүхэд сургуульд явж байсан бөгөөд, эхнэр нь тэдэнтэй хамт сумын төвд байдаг, Эрдэнэбаярын мал эгч дээр нь, тэр өөрөө сум болоод хөдөөгийн хооронд ирэн очин байв. Түүний өөрийнх нь өвөлжөө хаягдсан мэт санагдсан байх. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын анхан шатны судалгаанд түүнийг оруулаагүй бөгөөд харин өвөлжөөгөө дахиж ашиглаж чадахгүй болсон гэж мэдэгдсэн. Эрдэнэбаяр өөр газар өвөлжөөтэй болоход туслахыг ОТ-с хүссэнээр Царигийн Бурхантад өвөлжөө барьж өгсөн. Энэ нь ердөө модон хашаа (тал сар хэлбэртэй), “зуны байшин” байсан бөгөөд түүнд нөхөн олговор олгоогүй, нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ ч хийгээгүй. Тэднийх тэр үед 200-300 малтай, бэлчээр ус нь байвал мал маллаад амьжиргаагаа аваад явах бололцоотой байсан.

Өнөөдөр (2016 оны 3 сар) **40-50 бог, 4 тэмээ, 17 адуутай. Богоо бодвол олон тооны морь, тэмээтэйн учир нь** нөгөө “зуны сууцны” ойр орчмын газар нь 40 метрийн зайтай өнгөрч буй Гүний хоолойн шугам, эрчим хүчний шугамын нөлөөлөлд орсон. 500 метрт ОТ-н хангамжийн зам (ОТ-Манлай-УБ), зам тун ойрхон, худгийн амсар дээгүүр шахуу гардаг. Баруун талд 4-5 км зайд нисэх буудал. Мал бэлчээрлүүлэх арга байхгүй, заавал зам гарах учраас. 2011 онд Эрдэнэбаярыг Гүний Хоолойн нөлөөлөлд өртсөн гэж тооцсон.

Т. Пүрэв

2004 он хүртэл Хөх Шандын өвөлжөөнд бүх насаараа мал малласан, 2004 онд хүргэн Гантогтохын нь хамт Тойн Цохио руу нүүлгэж шилжүүлсэн. 7 жилийн өмнө Пүрэв гуай сум орж ирсэн, хүү Гантогтох нь (одоо ОТ-д ажиллаж байгаа) түүний малыг харж ханддаг.

3.4 Халив Дугат дахь нөлөөлөлд өртсөн өрхүүд

Халив Дугатад наад зах нь 10 өрх **зуны бэлчээрт** байнга гардаг байсан байна. “Байнгын” хэд нь: **Бадамсамбуу, Жаргалсайхан, Долгорсүрэн, Ц. Цагаан, Банди, Идэрборгил, Намсрай, Одгариг, Түвшинтөгс, Хүрэлээ.**

Мөн “байнгын” хэдэн өрхийн хүүхдүүд болон зуны бэлчээр тааруу бол өөр газраас хааяа ирдэг өрхүүд Халив Дугатын зуны бэлчээрийг ашигладаг байв. Хааяа ирдэгүүд нь 20-иод хоног л байдаг (Долгорсүрэн гуайн хэлснээр).

Халив Дугатын зуны бэлчээрээ алдсан, зуны бэлчээр хүртээмжгүй болсон өрхүүд (зорилтот бүлгийн хэлэлцүүлгээр авсан мэдээлэлд үндэслэв, жагсаалт дутуу байж магадгүй):

Билэгсайхан, Идэрборгил, Сүрэнхорол, Энхчулуун, Б. Эрдэнэжаргал, Ц. Элбэгсайхан, Г. Мэндбаяр, Ц. Нэргүй

Нэмээд энэ бүст өвөлжөөтэй байсан өрхүүд (2000 онд):

М. Цээсүрэн, Л. Батцэнгэл, Л. Мандбаяр, Л. Бат-Эрдэнэ; П. Цагаан, Т. Пүрэв, Д. Гантогтох, Л. Номинцэцэг, Ц. Самдан, Ц. Цагаан, Х. Хишигчулуун, Ц. Хандсүрэн, Х. Хишигцогт, Б. Намсрайжав, Б. Жаргалсүрэн, Д. Мөнхбаяр, Г. Мэндбаяр, И. Сумъяа, Г. Шоовдор

Халив Дугатаас хойш Эхэн Халивт нутагладаг өрхүүд Халив Дугат дахь зуны бэлчээрээ алдсан, зуны бэлчээр нь хүртээмжгүй болох нөлөөнд мөн өртжээ. Үүнд:

Д. Туяа, М. Пүрэвдорж, Ж. Мятаг, Ч. Дэмбэрэл, Ш. Ганбат, Ц. Төмөртоогоо, Ц. Мөнхтөр, Ц. Нэргүй, Ц. Элбэгсайхан, Г. Мэндбаяр, А. Наранцэцэг, У. Нандинцэцэг, Ц. Цагаан, А. Улам-Ундрах, У. Цацралт, У. Түвшинтөгс, М. Баярсайхан, Б. Баатарчулуун

3.5 Өрхүүд ба Малын Тоо

Сүүлийн арван хэдэн жилд Ханбогд сумын мал нийтдээ ихээхэн өссөн. Албан ёсны мэдээгээр⁵ 2003 онд 53.346 байснаа 2015 онд 133.013 болж 149 % өссөн байна. Мөн хугацаанд Жавхлант багийн мал 130% өсчээ.⁶

2003-2015 онуудад Халив Дугатын 16 өрхийн малын нийт өсөлт 60%, Сумын хэмжээний нийт өсөлттэй харьцуулахад нэлээд доогуур байна. Тооцоог хийхдээ 2003 онд малтай байсан, 2015 онд ч малтай байгаа өрхүүдийн бүрэн мэдээг сумын архиваас авч гаргалаа. Харин 2004 оноос хойш мал маллахаа больж, түүнээс хойш өөрийн нэр дээр мал тоолуулаагүй хэдэн өрх айлыг оруулаагүй болно. Одоо байгаа мэдээлэл, Халив Дугатад уулзсан өрхүүдийн хариултаас харахад бэлчээр шахагдсан өрхүүд бод малынхаа тоог цөөрүүлэн, бог мал илүү маллах болж, нийт сүргийн тоо, өсөлтийг бэлчээрийн хүртээмж, үр шим, зохилдлоготой тохируулах хандлагатай болсон байна. Судалгаанд хамруулсан Халив Дугатын 12 өрхийн бод малын тоо 2003-2015 онуудад 44% өсчээ (Сумын хэмжээний өсөлт 117%-тай харьцуулахад). Тэдгээр 12 өрхийн бог малын тоо мөн хугацаанд

⁵ Ханбогд сумын мэргэжилтнүүдийн өгсөн статистик тоо баримт 2016

⁶ Ханбогд сумын мэргэжилтнүүдийн өгсөн статистик тоо баримт 2016

117% өссөн (Сумын хэмжээний өсөлт 162%-тай харьцуулахад). Хавсралт 2-т 2003-2015 онуудын малын тоог харуулав.

Халив Дугатын бүсийн малын мэдээллээс харахад бэлчээрийн ачаалал, доройтлын гол шалтгаан нь зөвхөн нутгийн малчин өрхүүдийн малын тоо өссөн явдал биш харин бэлчээрийн боломжит газар хорогдсон нь байгаа бэлчээрийн дарамтыг улам хурцатгах үндсэн хүчин зүйл болж байна.

3.6 Ундай Голын Ай Савын Хуримтлагдах Нөлөөллийн Хураангуй

ОТМШБ-ийн тайлангийн Бүрэлдэхүүн 1 болон ХШБ-ийн 1, 2-р шатны аль алинд Ундай гол, Халив Дугатын голын гольдролын өөрчлөлт, ХХБ-аас гадна малчдад учирч буй нөлөөллийг хурцатгаж буй нэмэлт нөлөөллүүдийн талаар дурьдсан билээ.

Нөлөөллүүдийг товчхон хураангуйлбал:

- Ундай голын гольдролын өөрчлөлт – Усны хиймэл эх үүсвэр бий болгосон (хоолойгоор урсаж гарах ус). Бор Овооны усны эх үүсвэр анхдагч мөн чанар, зуны бэлчээрийн хамт алдагдсан, бүрмөсөн, уурхайн ажиллах хугацаанаас чинагш
- Халив Дугатын голын өөрчлөлт – Хаялбар өөрчлөгдсөн, гадаргын урсац, гүехэн гүний ус эсвэл ууршилтанд нөлөөлж болзошгүй
- Хаягдал Хадгалах Байгууламж – Халив Дугатын голын цутгалан, сувгууд таглагдсан, бүрмөсөн. Шүүрэлт/нэвчилт, магадгүй усны эх үүсвэрийн бохирдол. Хэдийгээр бохирдлын үр дагавар хуурай орчинд ноцтой биш, мөн одоохондоо УЛТ дотор тогтоож байгаа харагдавч усны чанар/аюулгүй байдлын бүрэн бүтэн байдал алдагдаж байна.
- Ил уурхай – Газар бүрмөсөн эвдэгдэж/алдагдана, гүний усны буурцын хүнхээл урт хугацааны. Ил уурхай усаар дүүрнэ; нүх гүнзгийрэх тусам буурцын хүнхээл улам тэлнэ; эцэстээ **эргэх** (урт хугацаагаар)
- Зам, карьерууд – Бэлчээрт тоос, Хангалттай ус зайлуулах нүхэн хоолой байхгүйгээс гадаргын усны хаялбарт нөлөөлнө. Бэлчээрийн хуваагдал, бүрмөсөн. Малд эрсдэлтэй (хүмүүст ч бас).
- Бутлуур – Уурхай ажиллах хугацааны туршид цагаан тоос бэлчээрт тархана (ажиллах цаг/салхины чигээс шалтгаалан)
- УЛТ-н хашаа – Ус, бэлчээр, соёлын дурсгалт газруудад хүрэх боломжийг хаана. Уурхайн үйл ажиллагааны аюулгүй байдлыг сайжруулах. Уурхайн хугацааны туршид болон чинагш.
- Хаягдал Чулуулгын Овоолго – Бэлчээр алдагдсан/эвдэгдсэн, соёлын/шүтлэгт газруудад хүрэх аргагүй (Бор Овоо) эсвэл бүрмөсөн эвдэгдсэн (Оюут Толгой, Шунхат, Вандан Толгой).
- Далд Уурхай – Гүний ус доошлох/буурцын хүнхээл, урт хугацаанд. Суулт, газар/бэлчээр алдагдах, бүрмөсөн.
- Гүний Хоолой/Шугам хоолой – Бэлчээрийн газрын алдагдал, хуваагдал, урт хугацааны.

Эдгээр нөлөөллүүд нь төмөр замын барилгын ажил, “нүүрсний зам” гэх мэт ОТ-н бус бусад бүтээн байгуулалтын улмаас цаашид лавширна. Өөр өөр оролцогчдын учруулах нөлөөллүүд нь байршлаасаа шалтгаалаад янз бүр байх тул тэдгээрийг тоогоор илэрхийлэхэд төвөгтэй. УЛТ-д ойртох тусам ОТ-н хувь нэмэр өндөр байна; бусад газарт буй айл өрхүүдэд нүүрсний зам эсвэл төмөр зам илүү нөлөөлөл учруулж байгаа, түүнчлэн жишээ нь сүүлийн жилүүдэд төмөр замын

барилгын ажилд хэдий хэмжээний ус хэрэглэсэн гэх мэт мэдээлэл хомс байгаа нь тоон үнэлгээ гаргахад саад болж байна.

Малчдад учрах нөлөөллийг товчхон дурьдвал:

Малчдад учрах хуримтлагдах нөлөөлөлд i) боломжит бэлчээрийн газрын хэмжээ хорогдох, бэлчээр хуваагдал, үлдсэн бэлчээрийн дарамт ихсэх, бэлчээрийн доройтол, ii) мал маллагааны хэв маяг өөрчлөгдөх (бог эсвэл бод мал, улирлын нүүдэл цөөрнө, тохиромжоор тааруу бэлчээр, араатан амьтны аюул ихтэй газарт малаа хариулахад хүрэх), iii) малын ашиг шим буурах, iv) мал маллагааны зардал өсч, ажиллагаа ихсэн v) сэтгэл санааны дарамт (зөрчил маргаан, амьжиргаа тодорхойгүй, хувь хүний мөн чанар үгүй болох, дараагийн үе удамдаа нутаг орон, мал, уламжлалаа өвлүүлэн үлдээх боломжгүй болох) зэрэг орно.

Орон нутгийн түвшинд учрах нөлөөлөлд i) боломжит бэлчээрийн газрын хэмжээ хорогдох, бэлчээр хуваагдал, үлдсэн бэлчээрийн дарамт ихсэх, бэлчээрийн доройтол, ii) нутаг орны хэмжээнд мал маллагааны тогтолцоо алдагдах (Ундай голын ай сав болоод түүнээс чинагш) iii) соёлын үнэт зүйлс алдагдах (Нутаг, зуны бэлчээрийг нийтээрээ ашиглах явдал, тахилга шүтлэгтэй газруудад хүрч чадахгүй болох), iv) малчдын хооронд бэлчээр, усны төлөөх зөрчил маргаан улам их гарах зэрэг орно.

Нөлөөллүүд, тэдгээрээс зайлсхийх, бууруулах явдлыг уур амьсгалын өөрчлөлт түүнчлэн малын тооны өсөлт гэх мэт улс орон даяарх хөгжилтэй уялдуулан авч үзэх шаардлагатай. Жилийн дундаж агаарын хэмийн өсөлт (ихэвчлэн өвлийн дундаж хэм дулаарч байгаагаас) Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийн гол шинж чанар болж буй хэдий ч Говьд хуурайших хандлага ажиглагдахгүй байгаа; харин ч хур тунадасны хэмжээ ялимгүй ихэссэн. Ган, зуд зэрэг цаг агаарын эрс үзэгдлийн давтамж ихэсч, хатуу ширүүн болж байгаа нь хөдөө орон нутгийн ард иргэдийг улам эмзэг болгох уур амьсгалын өөрчлөлтийн урьдчилан харж болохуйц нөлөөлөл юм.

Усны эх үүсвэрийг хадгалан хамгаалах, усны хагалбарын менежментийн зохихтой арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь ард иргэдийн цаг уурын өөрчлөлтийн нөлөөлөлд өртөх байдлыг багасгахад эн тэргүүний зүйл бөгөөд засгийн газрын бодлого мөн. ОУСК-ийн Хуримтлагдах Нөлөөллийн Үнэлгээний Тэргүүн Туршлагын Гарын Авлагад “санал болгож буй бүтээн байгуулалтын болзошгүй нөлөөлөл нь хүний бусад үйл ажиллагааны болзошгүй нөлөөлөл болоод ган эсвэл уур амьсгалын эрс үзэгдэл гэх мэт байгалийн дарамттай хэрхэн хуримтлагдан хавсарч болохыг” (хуудас 21)⁷ олж харах нь гол үүрэг гэж тодорхойлсон. Энэ аргын дагуу нөлөөллийн үнэлгээ, менежментийг явуулахдаа (зайлсхийх ба бууруулах) хуримтлагдах нөлөөллөөс эмзэг ард иргэдэд учруулах үр дагаврыг – уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд төслийн нөлөөлөл иргэдэд ямар нэрмээс дарамт авчрахыг – анхааралдаа авч, зайлсхийх, бууруулах төлөвлөгөөг гаргана.

Халив Дугатын бүсийн малын тооны судалгаанаас үзэхэд тоо толгойн өсөлт Сумын хэмжээний өсөлтийн хэмжээний талаас доогуур байна; тэгэхээр энэ нь уг бүс нутгийн бэлчээрт нөлөөлж буй гол хүчин зүйл биш юм. Үндэсний түвшний мал аж ахуйн бодлогод улс орон даяарх өсөлтийг харгалзан үзэх хэрэгтэй.

⁷ ОУСК 2013: Тэргүүн Туршлагын Гарын Авлага, Хуримтлагдах Нөлөөллийн Үнэлгээ ба Менежмент: Хөгжиж буй зах зээлийн хувийн хэвшилд зориулсан удирдамж.

Нөлөөлөл, эрсдэлийн нөхцөлд өрхүүд өөрийн стратегийг тохируулах, орон нутгийн засаг захиргааны зүгээс үүнийг нь дэмжиж, ОТ мал аж ахуйн болон мал аж ахуйн бус амьжиргааны стратеги боловсруулахад нь туслалцаа үзүүлж мал аж ахуйн үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байна. Гэвч Ундай голын сав газарт төслийн өмнөх үе шиг уламжлалт мал аж ахуйгаа авч явах малчдын нөөцийн чадал/тогтвортой байдал байнгын эрсдэлд оржээ.

4. Зөвлөмжүүд

ОТМШБ-ийн тайлангийн Бүрэлдэхүүн 1 ба 3-т нөхөн олговор, нэмэлт мэдээлэл цуглуулах, мониторинг, судалгаа хийх тухай зөвлөмжүүд өгөгдсөн.

ХШБ ерөнхийдөө ОТМШБ-аас гаргасан зөвлөмжүүдийг дэмжиж байгаа болно. ОТМШБ-ийн Бүрэлдэхүүн 1-ийн сумын хэмжээнд үст цэгийг олшруулах зөвлөмжийн тухайд ХШБ зэрлэг амьтад/биологийн олон зүйл ба мал хоорондоо зөрчилдөх вий гэдгийг бодолцохыг хүсч, харахад нэлдээ бэлчээр юм шиг харагдаж байгаа газар болгон мал бэлчээрлэхэд тэр бүр тохирдоггүйг хэлмээр байна.

Зарим онцлог тайлбар, зөвлөмжүүдийг нэмж дурьдваас:

ОТМШБ-ийн тайлангийн бүрэлдэхүүн 1-д зөвлөсөнтэй холбоотойгоор сумын засаг захиргаа алдагдсан бэлчээрийг харгалзан тохируулга хийхийн тулд бэлчээрийн системийг дахин боловсруулах хэрэгтэй. Бэлчээрийн гол нутаг (зуны бэлчээр) бүрмөсөн алдагдсан болохоор үүнийг хийх нь хэцүүхэн даалгавар байх болно. Нутаг дэвсгэр том хэдий ч газрын гадарга, ургамлын төрлөөс шалтгаалан тэр болгон тохиромжтой бэлчээр байж чадахгүй.

Улсаас үндэсний шинжээчид томилж өгөх, сургалт явуулах зэргээр орон нутгийн захиргаанд (Сум, Аймаг) дэмжлэг үзүүлэх; энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадны хүмүүс гэхээс илүүтэй (ОТ, гадаад шинжээчид) малчид, орон нутгийн байгууллагууд, бүх түвшний засаг захиргаа (баг, сум, аймаг, мэргэжлийн байгууллагууд) өөрсдийн оролцоог нэмэгдүүлэн, хүчин чармайлт гаргах.

Хамааралтай талуудыг татан оролцуулахад ГТЗ чухал үүрэгтэйгээс гадна одоо байгаа байгууллагууд, орон нутгийн иргэдийн болон засаг захиргааны бүтцийн газрууд (ж: багийн хурал, багийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын хурал, мал аж ахуйн тасаг, газар ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулалт гм) гол үүрэг гүйцэтгэнэ.

ГХГЗЗГ (Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар) мэргэжлийн байгууллага хөлслөн 5 жил тутам сум бүрээр үнэлгээ хийлгэдэг. Ханбогд сумын бэлчээрийн “тохируулгын” систем боловсруулахад ГХГЗЗГ-аас мэргэжлийн туслалцаа авч болох юм. ГХГЗЗГ малчдын газар ашиглах уламжлалт эрхийг баталгаажуулан, баримтжуулах зорилгоор нөөц ашиглах эрхийг тодорхойлох, газар болон нөөц ашиглалтыг төлөвлөх ажлыг орон нутгийн засаг захиргаатай хамтран саяхнаас хийж эхэлсэн.

Орон нутгийн иргэд “Нутгаа”, сэтгэл санааны үнэт зүйлсээ алдсан асуудал байсаар байгааг тусад нь авч үзвэл зохино.

ОТ-с оруулсан орлогоос эдгээр хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлж болно (үлсад төлж буй татварууд, аймгийн түвшний Хамтын Ажиллагааны Сан болон бусад); мөн зээл олгогч ОУСК

төлөвлөлт, гүйцэтгэлийг орон нутаг хариуцахыг хөхүүлэхийн хамт зарим дэмжлэг туслалцаа нэмж үзүүлж болох юм.

Малын тоо толгой өсч байгаа талаар дэлгэрэнгүй мэдээлэл, ил тод байдал шаардагдаж байна. ХШБ-ийн 2-р шатны судалгаа (мөн БСТ –ийн 2012 оны судалгаануудаас) харахад нөлөөлөлд өртсөн өрхүүд (албан ёсоор нөлөөлөлд өртсөн гэгдсэн болон өөрсдийгөө өртсөн гэж үзэж буй аль аль нь) малын тооны өсөлтөнд бараг нөлөөлөөгүй; эсвэл тэдгээрийн малын тооны өсөлт дунджаас нэлээд бага байна. Харин ч ерөнхийдөө тэдний дийлэнх нь малын тоо, төрлийг тохируулан зохицуулах болжээ. Малын тооны өсөлт, бэлчээрийн даац хэтэрч буйг илүү сайн ойлгохын тулд өөрсдөө малаа малладаггүй малтай өрхийн асуудлыг цаашид судлах шаардлагатай.

Гүний усны суурь мэдээлэл: ОТМШБ-ийн тайлангийн Бүрэлдэхүүн 1-д гүний болон гүехэн гүний усны ай сав хоорондоо холбогдсоноор аллювийн усанд ямар нөлөөлөл үзүүлж байгааг тодорхойлох суурь мэдээлэл дутмаг гэж дурьдсан. 2007 оноос өмнө ус шавхаж авсан тухай мэдээлэл байхгүйг ХШБ өмнө дурьдаж байсан. ХШБ 2-р шатны судалгааг хийхдээ орон нутгийн захиргаа, Байгаль Орчин, Аялал Жүүлчлалын Яамнаас мэдээлэл авахыг чармайсан боловч (орон нутагт) мэдээлэл байхгүй, эсвэл (яамны мэргэжилтнүүд) мэдээллийг хуваалцах боломжгүй гэдэг хариу авсан. Ийм нөхцөл байдалд шинжээчид нөлөөллийг цаг хугацааны дагуу тоогоор тогтоож чадахгүй; цааш ахихын тулд ядахдаа байгаа мэдээллийг хүртээлтэй болгох хэрэгтэй байна.

Нөлөөлөлд өртсөн өрхүүдийн ангиллыг хянан үзэж а) аль нэг улирлын (өвөл, зун /намрын) бэлчээрээ алдсан боловч одоогоор нөлөөлөлд өртсөн гэж тооцогдоогүй, б) нөлөөллөөс дайжин, бэлчээрт нь нүүж ирсэн өрхүүдийн улмаас бэлчээрийнх нь ачаалал нэмэгдсэн, в) хэд хэдэн өрх нэг өвөлжөөг хамтран эзэмшдэг байхад зөвхөн нэгийг нь нөлөөлөлд өртсөнөөр тооцсон, г) (УЛТ дотор, хориотой бүст) өвөлжөөтэй байсан ч ар гэрийн байдлын улмаас түр зууртаа ашиглахгүй байгаа өрхүүд, д) үе уламжилсан өвөлжөөг нь нутгийн иргэд хүлээн зөвшөөрдөг ч албан ёсны гэрчилгээ аваагүй гэх мэт өрхүүдийг оруулах асуудлыг авч үзэх

Дээр дурьдсан янз бүрийн байдлаар нөлөөлөлд орсон өрхүүдийн нэрсийг шинжээч өөрийн боломжоор гарган, бүрэн бүс хэдий ч жагсаалтыг энэ тайланд орууллаа. Нэрсийг бүлгийн хэлэлцүүлгээр авсан мэдээлэл үндэслэн, оролцогчдын зөвшөөрөлтэй авсан. ГТЗ-өөс хүмүүс томилох буюу (эсвэл илүү олон хүн оролцуулж) нэрсийг дахин нягтлахыг зөвлөж байна.

Энэ тайланд дурьдсан өрхүүдтэй амьжиргааг дэмжих стратегийн талаар хэлэлцүүлэг зохиох (ХШБ-ийн 1-р шатны тайлангийн дараа 59 өрхтэй зөвлөлдсөн шиг)

Малын тэжээл тариалах/үйлдвэрлэх хувилбарт үнэлгээ хийх (Өмнө-Говь, Өвөрхангай, Баянхонгор аймгийн бусад сумдад хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн мэдээлэл, сургамжид үндэслэн) бэлчээрийн боломжийг түргэн нэмэгдүүлэхийн тулд ОТ эвдээд орхисон газруудаа аль болох хурдан нөхөн сэргээх, эвдэгдсэн газраас тоос босох хугацааг багасгах, карьерууд дээр гарах ослын эрсдэлийг бууруулах. Энэ зөвлөмж ерөнхий бөгөөд тодорхой аливаа нэг газрыг тухайлаагүй болно.

5. Хавсралтууд

- Хавсралт 1 – Хээрийн судалгааны үеэр хийсэн ажлууд, Ханбогд сум 2016 III/28 –IV/01
- Хавсралт 2 а) Халив Дугатын бэлчээр, Өрхүүд, Мал 2003 – 2015
2 б) Ханбогд сум ба Халив Дугатын бэлчээрийн малын тооны өсөлт 2003 - 2015
- Хавсралт 3, 4 –Хагас бүтэцтэй ярилцлага, Өрхийн мэдээллийн Асуултууд/Асуудлууд
- Хавсралт 5 – Бүлгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, газрын зураг 2016 III/30-31, Малчдын ойлголт
- Хавсралт 6 – Фото баримт, Хээрийн судалгаа 2016 III/28 – IV/01; VI/7-8, 2016
- Хавсралт 7 – Хээрийн судалгааны үеэр хийсэн ажлууд, Ханбогд сум 2016 VI/7-8
- Хавсралт 8 - Эхэн Халивын өрхүүдийн мэдээлэл, Бэлчээр, усанд гарч буй өөрчлөлт, нөлөөллийн талаарх малчдын ойлголт

Түүнчлэн: ХШБ-ийн 1-р шатны тайлангийн Хавсралт 5 - өрхүүдийн нэрсийн жагсаалтыг залруулан шинэчилж хавсаргалаа.

Хавсралт 1 – 2016 оны 3 сарын 28-наас 4 сарын 1-нд Ханбогд суманд хээрийн судалгааны үеэр хийсэн ажлууд

Хээрийн судалгаа хийхдээ дараах зорилгуудыг тавьсан. Үүнд: а) ГТЗ-ийн гишүүд/төлөөлөгчидтэй хамтран Халив Дугатын голын ай савын нөлөөллийн талаар мэдээлэл цуглуулах/баталгаажуулах, б) Халив Дугат голын ай савын “хуримтлагдах” нөлөөллийг үнэлэх аргачлалын талаар ГТЗ-ийн гишүүдтэй нэг ойлголттой болох в) малчдын бэлчээр, усны нөөцөд учирсан нөлөөллийг үнэлэхийн тулд хамтран мэдээлэл цуглуулах.

Хийгдсэн ажлууд:

1. ОТ уурхайн талбайгаар, ялангуяа Хаягдлын Далан болон шүүрлийн хэсэг, мөн Уст Баг Модны гол, Гурван Модны Халив гол, Халив болон Дугатын голын эх рүү очиж үзсэн. Газар дээр авсан зурагнууд, элс/хайрганы карьер, суваг шуудуу зэрэг гадаргын хаялбарт нөлөөлж буй зүйлсийн зургийг Хавсралт 6-д орууллаа.
2. ГТЗ-ийн гишүүдтэй уулзаж, хээрийн судалгаа хийх арга зам/аргачлалыг хэлэлцэн, “хуримтлагдах” нөлөөллийг үнэлэх аргын тухайд нийтлэг нэг ойлголттой болохын тулд санал бодлоо солилцон, Монгол улсын БОНУ-ний тухай хууль, ОУСК-ийн Хуримтлагдах Нөлөөллийн Үнэлгээний Сайн Туршлага гарын авлагад заасан тодорхойлолтод үндэслэсэн арга барилыг санал болгов. **Үүнийг дор Хавсралт 2-г харуулсан байгаа; уулзалтын үеэр энэ аргыг хэрэглэхээс татгалзсан санал гараагүй.**
3. ГТЗ-ийн гишүүд Халив Дугатын бүсээс бүлгийн цуглаанд оролцуулах өрхүүдийг сонгох, уулзалтуудыг зохион байгуулахад Батцэнгэл, Намсрай нарыг туслалцуулахаар тохиров. 3, 4 дэх өдрүүдэд хувь хүмүүс, Халив Дугатын орчим одоо нутаглаж байгаа 16 өрх, өмнө нь тэр хавиар нутаглаж байгаад мал маллахаа больсон өрхүүдтэй уулзалт хийлээ.

Бүлгийн уулзалт, ярилцлагад оролцсон хүмүүс:

- а). Халив Дугатын хавийн малчид: Б. Намсрайжав, Ц. Цагдуулсүрэн, Д. Мөнхбаяр, Б. Оюун-Эрдэнэ, Ц. Хандсүрэн, Долгорсүрэн, Цээсүрэн, П. Цэвэгдорж, Д. Мөнхбаяр, Б. Эрдэнэжаргал, Ц. Цэцэгмаа, Д. Туул, Д. Цэндоо, С. Жаргалсайхан, Л. Батцэнгэл, Б. Оюун-Эрдэнэ, Д. Намсрай, Б. Намсрай, Ц. Цагаан, Б. Охиндүү, Ц. Амартүвшин, Ц. Хандсүрэн, Ц. Самдан, Б. Оюунтулга;
- б). Өмнө нь Халив Дуатад нутагладаг байсан одоо сумын төвд байгаа малчид: Б. Билэгсайхан, П. Онон, Ц. Нэргүй, Л. Мандбаяр, П. Цагаан (мөн Т. Пүрэв), Эрдэнэбаяр (ГТЗ); в) . ГТЗ-ийн гишүүд: Л. Батцэнгэл (ГТЗ-ийн дарга), Намсрай (ГТЗ), Баттогтох (ГТЗ).

Хагас бүтэцтэй ярилцлагын үеэр хэлэлцсэн асуудлууд: өвөлжөө бууцны байршил, улирлын нүүдэл, бэлчээрийн нөхцөл, бэлчээрийн тохиромжтой байдал, малын бүтээгдэхүүн, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн шалтгаан. Хагас бүтэцтэй ярилцлагын асуудлууд болон асуултуудыг Хавсралт 3-т жагсаалаа.

Эдгээр бэлчээрийн газруудыг хамран ярьсан болно: Дугат, Хөх Шанд, Дугатын Дугуй, Халив, Уст баг мод, Ухаа Овоо, Вандан Толгой, Шунхат, Оюут Толгой, Ханан Даваа, Монгол хар, Хар Овоо, Тойн Цохио, Оорцог, Бор Хошуу, Будаа.

Дараах усны эх үүсвэрүүдийн талаар хэлэлцсэн: 1. Худаг: Дугат, Хөх Шанд, Шанд (Мухар эргийн), Кольцот (Халивын), Хуурай (1998 онд ширгэсэн), Халив, Бор Хошуу, Бор Хошууны Кольцот (80-аад оноос хойш ашиглаагүй), Оорцог, Эргүүлэгт (Халивын), Тэсгэт (1999 онд хатсан), Аман ус, Улаан худаг, Тойн Цохио 1, Тойн Цохио 2; 2. Задгай, булаг: Дугатын задгай, Хажуу Хөөвөр, Будаагийн задгай, Оорцогийн булаг, Бор хошууны булаг.

Ярилцлагад оролцсон хүмүүсийн хариулт, өөрсдийнх нь бичсэн хариу, судлаачийн тэмдэглэлийг Хавсралт 4-с үзнэ үү.

Зорилтот бүлгийн ярилцлагын үйл явц, оролцогсдын гаргасан Халив Дугатын усны эх үүсвэрүүдийн зураглал (зураг, хүснэгт), 2000 – 2015 онуудад нөөцөд гарсан өөрчлөлтүүдийг Хавсралт 5-д үзүүлэв.

3 сарын 28-наас 4 сарын 1-ний хооронд авсан зургуудыг Хавсралт 6-д оруулсан.

4. Мал аж ахуйн хэсгийн дарга (Хүрэлбаатар), Засаг даргын орлогч (Отгонжаргал) Байгаль орчны байцаагч нартай товчхон уулзаж, мэдээлэл солилцов.
5. ГТЗ-ийн гишүүдтэй дүгнэх уулзалт хийсэн.
6. Мөнхбаяртай (ОТ, Хамтын Оролцоот Мониторинг) уулзаж, бэлчээр, ус, тоос, хайлаас, заг мод зэрэгт мониторингийн ямар аргууд ашиглаж байгаа, Нутаг түншлэл, Зэрлэг Амьтдыг Хамгаалах Нийгэмлэг зэрэг гэрээт газруудын бэлэн гарсан тайлан мэдээний талаар ярилцлаа.

Хавсралт 2

2 а) Өрхүүд болон тэдгээрээс Халив Дугатын бэлчээрийг ашиглаж байсан байдал 2003 – 2015 онуудад

Гурван Модны Халив-Дугатын бүс нутгийн бэлчээрийн газарт өвөлжөөтэй өрхүүд																
Дугатын бэлчээр. Усны эх үүсвэр: Дугатын Худаг																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Батцэн гэл Л	Батцэн гэл Л	Батцэн гэл Л	Батцэн гэл Л	Батцэн гэл Л												
Бат-Эрдэнэ Л	Бат-Эрдэнэ Л	Бат-Эрдэнэ Л	Бат-Эрдэнэ Л	Бат-Эрдэнэ Л												
Манд баяр Л	Манд баяр Л	Манд баяр Л	Манд баяр Л	Манд баяр Л												
Цагаан П	Цагаан П	Цагаан П	Цагаан П	Цагаан П												
Гантог тох Д	Гантог тох Д	Гантог тох Д	Гантог тох Д	Гантог тох Д												
Номин цэцэг Л	Номин цэцэг Л	Номин цэцэг Л	Номин цэцэг Л	Номин цэцэг Л												
Нэргүй Ц	Нэргүй Ц	Нэргүй Ц	Нэргүй Ц	Нэргүй Ц												
Эдгээр 7 өрх айлыг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн – Батцэнгэлийнх Цагаан Шивээ рүү, Бат-Эрдэнийх Улаан Хошуу руу, Мандбаярынх Улаанбаатар орсон, Цагааных Оройн Бууц руу, Гантогтохынх Тойн Цохио руу, Номинцэцэг малаа эцэг эхдээ орхин ОТ-д ажиллахаар явсан, Нэргүйгийнх Улаан Овоо руу тус тус нүүсэн.																
Батцэнгэл (мөн Бат-Эрдэнэ, Мандбаяр нар) Дугатад хаваржаатай хэвээр, өөр айлууд хааяа буудаг байсан – 2014, 2015 онуудад Бадамсамбуугийнх 2 долоо хоног, 2016 онд Адъяагийнх 10-аад хоног тус тус буусан.																
2000 оноос өмнө хэд хэдэн айл Дугатын зун, намрын бэлчээрийг ашиглаж байв. Үүнд Б. Бадамсамбуу, Д. Адъяа, С. Банди, Баяраа (Бандийн хүргэн) нар болон бас бусад өрхүүд.																

Х. Чулуунбаатар, Н. Сүрэнхорол, Г. Мэндбаяр, Ц. Цагаан заримдаа, мөн дээр нь тэнд өвөлжөөтэй байсан 7 өрх.																
Энэ хавийн газар Уурхайн лицензит талбайтай (УЛТ) ойр, мөн ус багатай тул 2005 оноос цөөхөн айл зуны бэлчээрээр ашиглаж байсан.																
2000 оноос өмнө УЛТ-н урд талд өвөлжөөтэй байсан зарим өрхүүд энэ газарт намарждаг байсан. 2010 оны үед А. Улам-Ундрах, А. Наранцэцэг зэрэг айлууд намартаа буудаг байсан.																
Хөх Шандын бэлчээр. Усны эх үүсвэр: Хөх Шандын худаг																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
0	Пүрэв	Пүрэв	Пүрэв	Пүрэв												
Пүрэв	Пүрэв	Пүрэв	Пүрэв	Пүрэв												
Т.Пүрэв, цөөхөн малтай, энэ газарт зусч, намарждаг байсан; тэднийхийг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн, 2005 онд тэрээр сумын төв рүү орж ирсэн.																
Дугатын Дугуйн бэлчээр, худаггүй, задгай байхгүй (Бор-Овоонд ойрхон, 3 км орчим)																
өвөлжөө байхгүй																
Дугатын дугуй нь Оюу Толгой, Вандан Толгой, Шунхат зэрэг урд талын нийтийн бэлчээрийн нэг хэсэг бөгөөд Дугат, Гурван Модны Халив, Улаан Толгойн (цаг агаар болон бэлчээрийн байдлаас шалтгаалан бусад газраас ирсэн) айл өрхүүд ашигладаг байсан. Тэмээний гол бэлчээр байв. 2003 оноос өрөмдлөг эхэлж, уурхай кемпээ байгуулснаас хойш тэмээ бэлчих боломжгүй болсон. 2012 онд УЛТ хашаагаа тэлж, энэ хэсэг газар дотор нь орсон. Одоо энэ бэлчээрт орох боломжгүй.																
Гурван Модны Халивын бэлчээр. Усны эх үүсвэр: Халивын гар худаг, Халивын кольцот худаг. Одоо УЛТ-н хашаан дотор орсон.																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
0	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц												
Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц												
Цагаан Ц. 2004 онд нүүлгэн шилжүүлж, Шаваг руу нүүн тэнд 1 жил өвөлжсөн.																
Уст Баг Модны бэлчээр, Усны эх үүсвэр: Уст Баг худаг. УЛТ-н хашааны ойролцоо																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
0	Самда н Ц	Самда н Ц	Самда н Ц	Самда н Ц		Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц					
Самда н Ц	Самда н Ц	Самда н Ц	Самда н Ц	Самда н Ц		Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц	Цагаан Ц					
Ц. Самдангийн бог мал нь өвөлжөө хавиараа, бод нь зүүн тийшээ бэлчээрлэдэг.																
Ц. Самданг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн, сумын төв рүү орсон. Ц. Цагаан 2005-2010 онуудад өвөлжөөг ашиглаж байсан.																

Ц. Самдангийнх энэ бэлчээрийг зун, намартаа хааяа ашигладаг байсан.																
Ухаа Овоогийн бэлчээр																
Нэгдлийн үед энэ өвөлжөөнд айлууд хаяа өвөлждөг байсан бөгөөд 1990-д оноос айл эзэмшээгүй байж байгаад..... оноос Х.Хишигсүрэн эзэмшдэг болсон.																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
? Тайлбар:																
Вандан Толгойн бэлчээр (Гурван Модны Халивт байдаг толгой) Шунхатын бэлчээр (Бор-Овооны орчим) мөн Оюу Толгойн бэлчээр																
Эдгээр нь нийтийн бэлчээр байсан, голцуу тэмээний бэлчээр, ХШБ-ийн 1-р шатны тайланд дурьдсан Ундайн гол дагуу өвөлжөө, хаваржаа эзэмшидэг 59 өрх зундаа ашигладаг ба Гурван модны халив, Дугат голын дагуу нутагладаг малчдын мал ихэвчлэн бэлчээрлэдэг байсан.																
Хайгуулын шатанд маш олон өрөмдлөг хайгуул явагдаж ирсэн нь орчмын малчдын бэлчээрт нөлөөлж эхэлсэн. 2004 оноос хойш эдгээр бэлчээр УЛТ-д орсон.																
Хайгуулын шатанд Шунхатад бохиороо асгаж байсан.																
Ханан Давааны бэлчээр, усны эх үүсвэр – Ханан Давааны 2 гүн өрмийн худаг																
< 2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М	Баяр сайхан н М
Ханан Давааны бэлчээрийг зун, өвөлдөө хэд хэдэн айл өрх ашигладаг байв. Үүнд: Ц. Мөнхтөр, М. Баярсайхан, Б. Эрдэнэжаргал, Д. Гантогтох, Б. Намсрайжав, Р. Чулуу, Ц. Цагаан, Ц. Самдан, Б. Эрдэнэбаяр, Ц. Элбэгсайхан, Ц. Төмөртоогоо, Ц. Нэргүй, Ц. Хандсүрэн, С. Жаргалсайхан, Д. Чойжилсүрэн, Ш. Ганбат, М. Пүрэвдорж, Д. Мөнхбаяр болон бусад айлууд.																
2009 оны орчмоос А. Улам-Ундрах, А. Наранцэцэг нар (нэр нь зөв байна уу?) зун, намар ашигладаг байсан.																
Дэд бүтэц барьж байгуулснаар энэ бэлчээрийн хэмжээ багассан (өндөр хүчдэлийн шугам, Гүний Хоолой, газын болон тээврийн компаниудын авсан																

Энэ хавийг зуны бэлчээрээр ашигладаг байсан айлууд: Б. Намсрай, Шоовдор , Б. Эрдэнэжаргал, Б. Эрдэнэбаяр, Д. Мөнхбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Л. Батцэнгэл, Л. Мандбаяр, Л. Бат-Эрдэнэ, Ц. Хандсүрэн, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж, Б. Төртайван.

2004 онд Гантогтох өвөлжөө барьснаар бусад айлуудын зуны бэлчээр багассан. Зарим өрхүүд малаа алдаж, мал маллахаа больсон; ажил олдох байх хэмээн сумын төв рүү нүүцгээсэн. Сум руу орсон айлууд: Галсанхүүгийн Шоовдор (аавынх нь нэр?), Б. Эрдэнэбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж.

Г.Шоовдор нь Тойн Цохионы хөндийд мал маллан 10 хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд хүүхдүүд нь мөн л энэ орчимд малчин болон амьдарч байна. Тэднийг өөр газар руу нүүлгэн шилжүүлсэн үү? Г.Шоовдорийх нь ОюуТолгой төслийн Нүүлгэн шилжүүлэлт, Нөхөн олговрын төсөл хөтөлбөрт хамрагдаагүй бөгөөд 2004 оны сүүл үеэр Д. Гантогтохынхыг нүүлгэн шилжүүлж ирсэнээр өнөөг хүртэл Д.Гантогтохынх айл хөрш амьдарч байгаа.

Оорцогийн бэлчээр. Усны эх үүсвэр: 1 гар худаг, 1 кольцот худаг

< 2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Өлзий Орших	Өлзий Орших	Өлзий Орших	Өлзий Орших	Өлзий Орших	Өлзий Орших	Өлзий Орших										

2005 онд Өлзий-Оршихынх сум руу нүүсэн

					Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С	Жаргалсайхан С
--	--	--	--	--	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------	----------------

С. Жаргалсайханых 2004 оноос өмнө одоо УЛТ-д орсон газар руу нүүсэн, тэгээд 2004 онд тэднийхийг нүүлгэн шилжүүлсэн, өвөлжөөгөө буцаагаад Оорцог руу нүүлгэсэн. ОТ энэ айлд өвөлжөө шинээр барьж өгсөн, өөрсдөө бас нэг өвөлжөө барьсан.

Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д	Цэндо о Д
-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------	-----------

Энэ хавийг зуны бэлчээрээр ашигладаг байсан өрхүүд: Б. Намсрай, Шоовдор (аавынх нь нэр?), Б. Эрдэнэжаргал, Б. Эрдэнэбаяр, Д. Мөнхбаяр, И. Сумъяа, Б. Жаргалсүрэн, Г. Мэндбаяр, Ц. Мөнгөншагай, Л. Батцэнгэл, Л. Мандбаяр, Л. Бат-Эрдэнэ, Ц. Хандсүрэн, Ё. Должинсүрэн, Б. Пүрэвдорж, Б. Төртайван.

Бор Хошууны бэлчээр. Усны эх үүсвэр: Бор Хошууны гар худаг

<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Мөнхбаяр Д	Мөнхбаяр Д	Мөнхбаяр Д	Мөнхбаяр Д	Мөнхбаяр Д	Мөнхбаяр Д											

Д. Мөнхбаярыг 2004 онд Хороот руу нүүлгэн шилжүүлсэн, ойролцоо нь (ОТ-н гаргасан гүн өрмийн худаг).

Сугар сүрэн Б	Сугар сүрэн Б	Сугар сүрэн Б	Сугар сүрэн Б	Сугар сүрэн Б	Сугар сүрэн Б											
Б. Сугарсүрэнг 2004 онд нүүлгэн шилжүүлсэн (ОТ-д хэсэг хугацаанд ажиллаж байсан).																
Б. Мөнхбаяр энэ хавийг зуны бэлчээрээр ашигладаг байсан.																
Будаагийн бэлчээр. Усны эх үүсвэр: Будаагийн задгай																
<2000	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Эрдэнэ баяр Б	Эрдэнэ баяр Б	Эрдэнэ баяр Б	Эрдэнэ баяр Б	Эрдэнэ баяр Б	Эрдэнэ баяр Б											
Б. Эрдэнэбаярыг 2004 онд Зараа руу нүүлгэн шилжүүлсэн, тэнд байсан ах Эрдэнэжаргалынхаас 500 м зайд өвөлжөө барьсан. Дараа нь сумын төв рүү 2005 оны хавьд нүүж орсон.																
Энэ хавийг Х. Отгонжав, Ц. Бямба, Д. Билэгсайхан зэрэг айлууд зуны бэлчээрээр ашигладаг байв.																

2 б) Ханбогд сумын хэмжээнд болон Халив Дугатын Өрхүүдийн Малын тооны өсөлт 2003 – 2015 онуудад

Малын тооны өсөлт – Сумын хэмжээнд болон Халив Дугатын бүсэд – 2003 – 2015 хооронд			
	2003	2015	Increase
Халив Дугатын Өрхүүд (12)			
Бод малын тоо	1523	2191	44 %
Бог малын тоо	369	840	127 %
Нийт малын тоо	1892	3031	60 %
Ханбогд сумын хэмжээнд			
Бод малын тоо	15690	34202	117 %
Бог малын тоо	37656	98811	162 %
Нийт малын тоо	53346	133013	149 %
Эх үүсвэр: Ханбогд сумын засаг захиргааны архив, малын мэдээ			

Хавсралт 3 – Хагас бүтэцтэй хэлэлцүүлэг – Асуултууд ба асуудлууд

- 2000 онд танай өвөлжөө хаана байсан бэ?
- Одоо хаана өвөлжөөтэй вэ?
- Танайх яагаад нүүх болсон бэ?
- Өмнөх өвөлжөөтэй харьцуулахад одоогийн өвөлжөө хэр тохиромжтой вэ?
- Өмнөх өвөлжөөтэй харьцуулахад одоогийн өвөлжөөний байршил хэр тохиромжтой вэ?
- Өмнөхтэй харьцуулахад одоогийн бэлчээрийн байдал ямар байна вэ?
- Өмнөхтэй харьцуулахад одоогийн өвөлжөөний бэлчээрийн ачаалал ямар байна вэ?
- Бусад өрхтэй бэлчээрээ хуваадаг уу? (Тийм бол: хэдэн айлтай хуваадаг вэ? Хэн хэнийхтэй?)
- Танай зун, намрын бэлчээр өмнө нь хаана байсан бэ?
- Танай зуны бэлчээр одоо хаана байгаа вэ?
- Одоогийн зуны бэлчээрийн нөхцөл байдал, ачаалал ямар байна вэ?
- Усны ямар эх үүсвэр өмнө нь ашиглаж байсан бэ? Одоогийн усны эх үүсвэр хаана байна вэ? Одоогийн усны эх үүсвэрийн нөхцөл байдал ямар байна вэ?
- Малын тоо (бог, бод) өмнө хэд байсан, одоо хэд байгаа вэ. Өөрчлөлтийн шалтгаан юу вэ?
- Өөр өрхийн хичнээн тооны мал өмнө нь маллаж байсан эсвэл одоо маллаж байна вэ Өөрчлөлтийн шалтгаан юу вэ?
- Мал маллагаанд гарсан өөрчлөлт, ажиллагаа, зардал нэмэгдсэн эсэх?
- Малын ашиг шим, эрүүл мэндэд өөргөлөлт гарсан уу? Одоо ба өмнө.
- Ирээдүйд мал аж ахуйг үргэлжлүүлэн авч явах боломж байна уу? Та ямар төлөвлөгөөтэй байна вэ?

Хавсралт 4 – Хагас бүтэцтэй хэлэлцүүлгийн хариулт

Хагас бүтэцтэй ярилцлагын үеэр тавьсан асуултуудад оролцогсдын өгсөн хариултыг дор орууллаа (оролцогсдын өөрсдийнх нь үгээр байгааг налуу бичсэн болно). Ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн үеэр хийсэн тэмдэглэлээс судлаач мэдээлэл нэмж оруулсан.

1. С. Жаргалсайхан (Д. Цэндоогийн хүү)

- Ундай голын Шаваг гэдэг өвөлжөө
- 2004 оны нүүлгэн шилжүүлэлт
- Одоогийн өвөлжөө айл олон учир хүртээмж муу
- 3-н айлтай бэлчээрээ хуваадаг
- Халив Дугатын голд зусдаг
- Одоо зуслан өвөлжөөний ойролцоо
- Зуны бэлчээр ачаалалтай
- Усны эх үүсвэр булаг задгай уудаг байсан, одоо гар худагтай
- Өмнө нь Бог – 30 Бог – 250, Одоо Бог – 20 Бог – 200
- Бэлчээрийн хомсдолоос болж цөөрсөн
- Өөр бэлчээрт ирээд ажиллагаа ихсэж зав муутай болсон
- Малын ноос, сүү муудсан
- Бог малын уушиг өвдөх, нус гоожих, шороо тоостой өвс идэх
- Мал аж ахуйг хойшид авч явахад хүнд хэцүү байх болов уу гэж бодож байна
- Уурхай зөв бодлого хэрэгжүүлж малчдыг дэмжээд хамтраад явбал мал аж ахуйг аврах боломжтой гэж бодож байна.

2. Д. Цэндоо

- Манайх 2004 онд нүүлгэн шилжүүлэх айлд хамрагдан нүүж Оорцогт ирсэн, тэгээд манай хүүгийн нөлөөллийн хүрээнд орсуулсан бөгөөд манайхыг тооцоогүй, надад нөхөн олговор олгоогүй. Тийм

учраас надад нөхөн олговор олгохыг хүсч байна. Хүүхдийн мал цөөнтэй бэлчээрийн даац муу, нэг дор олон айлтай, мөн тоос шороо машин тэрэгний дуу чимээ маш ихтэй, унаа тэрэг муутай учраас хол газар нүүж чадахгүй, хүүхдүүд сумын төвд байдаг, хоёулаа хөдөө амьдарч байдаг, би өөрөө өндөр настай учир хүүхдийнхээ асрамжид байгаа, манай энд 5-6 айл байдаг болхоор бэлчээр мал өсгөхөд тун хэцүү болж байна. Замын шороо тоос ихтэй, баруун талаас салхитай байхад маш их шороо, манан бүрхэж байдаг. Худаг ус хүртэл ховордож байна. Орон нутгийн ашиггүй байгаа залуучуудыг аль болох ажилд оруулж байхыг хүсч байна.

3. Б. Намсрайжав

- 2000 онд бэлчээр сайн байлаа. 2004 оноос одоог хүртэл бэлчээрийн даац ихэсч ОТ-н нүүлгэн шилжүүлэлтээр Ц. Самдан, Д. Гантогтох, Л. Номинцэцэг гэх 3н айл манай бэлчээрт нүүж ирсэн. Манай уугуул нутаг бол Тоон Цохио, урьд нь бид Дугат ба одоогийн ОТ-н нисэх буудлын тэнд зусдаг байсан боловч одоо тэндээ зусах боломжгүй болсон ба өвөлжөөндөө ойрхон зусч байна. Усны эх үүсвэр бололцоотой байсан боловч 2004 оноос булаг шанд ширгэж эхэлсэн. Одоо бид гүний худаг ашиглаж байгаа. Малын тоо 400 гаруй байна. Манай ээжийн мал болон бусад 3н айлын малтай нийлээд 700 гаруй бодтой, малын бэлчээр хол явдаг болсноос хулгай, чоно 2т малаа алдаж байна. Малын эрүүл мэнд маш муу, дотор ба уушиг бол усан хаван, идээ яр шархтай болсон.

4. Цэрэнхүүгийн Цагаан

- Би 1973 онд Ханбогд сумын 8-н жилийн сургуулийн 8-р ангийг төгсөөд Жавхлант багт малчнаар гарч нэгдэл нийгмийн тэмээ маллаж ирсэн. Би Бор Овоогийн өмнө талд 1954 онд төрсөн. Энэ нутагт мал маллаад 40 гаруй жил болж байна. Нөхөр Лувсандагватай айл гэр болж 6 хүүхэд төрүүлж өсгөсөн, нөхөртэйгээ 300 гаруй тэмээ маллаж байсан. Гэтэл 2004 онд ОТ-н үйл ажиллагаа эхэлж олон олон жил суурьшиж амьдарсан, эцэг эхээс уламжлан ирсэн бууц маань бүрэн хашаажуулалтанд орж ямар ч бэлчээрийн газаргүй болсон. 300 гаруй тэмээ усладаг Халив Гурван Мод гэдэг бууцаа алдсан. ОТ үйл ажиллагаа явагдаж буй бүх газар манай бууцийн бэлчээр байсан. ОТ хашаанд цорын ганц айл бол манайх байсан, удаа дараа гомдол гаргасан боловч “танайд өгөх юмаа өгсөн” гэдэг хариулт сонссон. Манайх 6 хүүхэдтэй, 1-ээс бусал нь ажилгүй, би өөрөө замын хог цэвэрлэдэг. Манай хүүхдүүх боловсролтой, тэднийгээ ажилд оруулмаар байна. Уламжлал болсон бууц маань одоо ямар ч мэдэгдэх юмгүй болсон, шороо ухаад булаад алга болгосон. 3н хайлс байсан тайраад хаясан. Хүний сэтгэлийг мэддэггүй. Би энэ нутагтаа хайртай, миний хань 2008 онд бурхан болсон. Би өөрөө малаа малладаг, хүүхдүүд тусладаг ч тэднийгээ мал малла гэж хэлж чаддаггүйн учир нь мал маллаад ямар ч амьдралын баталгаа алга, ус бэлчээр гэх зүйлгүй. Иймд би хүүхдүүдээ ажилд оруулмаар байна. Би энэ нутагт төрж өссөн, бүх насаараа мал маллаж байна. Гэр бүлээ амьдралын баталгаатай байлгаж ноогдол ашиг авмаар байна.
- 2000 онд манайх Халив Гурван Мод гэдэг газар байлаа
- Одоо манайх Шаваг гэдэг газар өвөлжиж байна
- Манайх 2004 онд ОТ-н нүүлгэн шилжүүлэлтээр нүүж ирсэн
- Манайх нүүж очсон газар одоо болтол тохьжиж чадаагүй, мал идээшихгүй дассан сурсан газар руугаа яваад огт тогтдоггүй
- Миний өссөн төрсөн нутаг болоод энэ нутгаа харахад элэг минь эмтэрдэг, би азгүй хүн юм
- Миний байсан Халив Дугат бэлчээрийн талбай ихтэй
- Мал нь их дассан сурсан, бэлчээр ус сайтай, олон тийшээ бэлчээртэй

- Манайх нүүж очсон Шаваг нь тойрсон олон өвөлжөөтэй, айл мал олонтой, ус их ховортой, ганц талын бэлчээртэй, мал бэлчээх газар бага, ачаалал ихтэй
- Манайх бууцандаа Мэндбаяр, Нэргүй, Наранцэцэг, Эрдэнэжаргал, Ундрах, Баярсайхан гэх мэт айлуудтай бэлчээр усаа хуваадаг
- Манайх Бор Овоо, Цанхи, Хүрэн хошуут, Дугат гэх мэт газраар зусаж намаржиж байсан, одоо бол өвөлжөө хавьдаа л зусаж байна
- Зун хол нүүвэл бэлчээртэй газар нь усгүй, устай газар нь бэлчээргүй ийм л байна.
- Манайх Халив Гурван Мод гэдэг газраа байхдаа хуучин засгийн үед 300 гаруй тэмээ услаж байсан, тийм л элбэг устай байлаа
- Одоо бол онгоцны буудлыг барихад гаргасан гүн өрмийн усыг ашиглаж байна
- Манайх 2004 онд Бог 500, Бод 125 тоо толгой байсан, одоо бол мал өсгөх арга алга. Ус бэлчээрийн хомсдол ихтэй, залуучууд мал мэдэхгүй, амьдралын баталгаагүй болсон. Одоо манайх Бог 200, Бод 80 орчим бий
- Манайд хүүхдүүдийн хэдхэн тооны мал байгаа, гэвч миний чадал хүч барагдаад мал маллах чадвар муу, түүн дээрээс ус бэлчээр алга даа. Ил далд засгаар хохирсон
- Мал маллах горим алдагдаж байна. Ус бэлчээр, бууц хороо хорогдсон. Мал иддэг ургамал нь хүртэл алга болсон
- Тоос шороо их
- Манай Шавагийн бууцны урдуур 1км Ханбогд руу явдаг зам бий, иймд тоос шороо их, машин тэрэг мал дайрчих гээд байдаг. Замын дуу чимээ их, мал тайван байлгадаггүй, үргэлж цочих нь тарга тэвээрт муугаар нөлөөлдөг
- Мал нутаглаж байсан газар руугаа алдагдан (ялангуяа бод мал) чонод идүүлэх, алдагдах зэрэг хохирол их амссан
- Бага наснаасаа маллаж ирсэн мал аж ахуйгаа авч явах, үр хүүхдүүддээ өвлүүлэн өгмөөр байна, гэтэл тийм боломж алга. Усны талаар маш их сэтгэл эмзэглэж байна.

5. М. Баярсайхан

- Ханан Даваанд өвөлжиж байсан
- Одоо ч Ханан Даваандаа
- Нүүгээгүй
- Бэлчээр тааруу, тоосжилт их, зам олон гарсан, бэлчээр шахагдсан
- Өвлийн бэлчээр 5-н айлтай хуваадаг, Эрдэнэжаргал, Намсрай, Гантогтох, Цагаандолгор мөн Эхэн Халивийн айлууд
- Зун намар оторын айлтай хуваадаг
- Зун намар нь онгоцны буудал буюу Таван Толгой, Эхэн Халивт зусч байсан
- Одоогоор өвөлжөөнийхөө хавьд
- Бэлчээр хомсдсон, оторын айлууд буудаг, зам олон болсон, бусад айлын бэлчээр хомсдсон, ойр орчмийн ус ховордсон
- Дугатын усыг уудаг байсан, дараа нь гүний ус засварлаж ашиглаж байна. Одоогоор хэмжилт хийж үзээгүй байна. Усандаа 5км явж хүрдэг
- 1996 оноос 300 малтай байсан, одоо 200 орчим. Бэлчээр хомс учир мал өсгөх боломжгүй
- Ус ховор, хадлан авах боломж муу, өвс тэжээл худалдан авах шаардлага их гарсан
- Нүд уушиг өвдөх гэх мэт малд өвчлөл их байгаа
- Ус ховор, бэлчээр хомс учир мал өсгөх боломжгүй байна. Усгүй болсноос малчид болон тухайн нутгийн иргэд амьдрах боломжгүй болж байна.

6. Б. Эрдэнэжаргал

- *Зараа гэдэг газар нутаглаж байсан*
- *Одоо Зараа гэдэг газраа байгаа. Тойн Цохионд зусч намарждаг байсан. ОТ нүүлгэн шилжүүлсэн айлд өвөлжөө гаргасан, зусах намаржих бэлчээргүй болсон. Өвөлжөөн дээрээ байнга суурьшиж байна*
- *Өмнөхтэй харьцуулахад бэлчээрийн хүрэлцээ муу. Манай өвөлжөөнд ойрхон 5н айл бий, Эрдэнэбаяр, Цагаан, Баярсайхан, Мэндбаяр, Долгор. ОТ-н нүүлгэн шилжүүлсэн айл нь Эрдэнэбаяр, Долгор хоёрых. Зун намаржаа байхгүй болсон, Гантогдох ОТ-оор нүүлгэн шилжүүлтэнд орсон айлд өвөлжөө гаргаад аргагүй болсон.*
- *Гар ус ашигладаг байсан боловч одоо боломжгүй боломжгүй болсон, ус хангахаа байсан учраас гүний ус гаргасан боловч ундарга муутай.*
- *Малын тоо бага зэрэг өссөн, бог 310, бод 115. Мал өсөх боломж бага. Бэлчээр хязгаарлагдмал, маллагаа сайн болсон.*
- *Малын ашиг шим багасаж байна.*
- *Замд ойрхон болохоор шороо ихтэй, малын эрүүл мэндэд муу (уушиг өвддөг). Малчид малаа маллаж амьдрахад ус бэлчээр бэрхшээлтэй болсон. ОТ Ханбогдын зам манайхаас 0,5км зайтай. Гүний хоолойн зам 0,1км явдаг, мал хүнд их нөлөөтэй. Малын бэлчээр нутгаас олон га газар үрэгдэж байна.*
- *Кариар өвөлжөөнд хэт ойрхон гаргаснаас болж тэр хавийн газар ургамал тоос болж тарга гүйцэд авахаа больсон юм шиг санагддаг.*
- *Энэ нөлөөлөл яг хэвээр, улам л илүү болж байгаа учраас малчин бид нартай гэрээгээ үргэлжлүүлж гомдол саналыг барагдуулж өгөх.*

7. Самдан Цэрэнхүү

- *Манайх 2000 онд Уст баг модонд өвөлжиж байсан*
- *Одоо манайх Ихэр Хондонд өвөлжиж байна.*
- *Манайх ОТ нүүлгэн шилжүүлэлтэнд ороод нүүсэн*
- *Өмнөх өвөлжөөнөөс харьцангуй муу байна. Олон айлын дунд бэлчээр талбай хааш хаашаа айлын мал шахна.*
- *Манайх 4н айлтай бэлчээр хуваадаг, Намсрай, Мөнгөншагай, Хандсүрэн, Гантогтох нарыхтай.*
- *Зун намартаа Халив дугат, Бор овоо, Бумбатад нутагладан байсан.*
- *Одоо зун намрын нутагладаг газар бууцаа тойроод нүүж байна.*
- *150 тоо толгой малтай байснаас одоо бол малыг тоо цөөрч 70н толгой малтай болсон.Бод мал байсан, бод маллах нөхцөл муутай учраас бод малаа дуусгасан.*
- *Ирээдүйд мал маллах нөхцөл муу, ус бэлчээр ховор болж байна.*

8. Д. Мөнхбаяр

- *2000 онд Бор хошуунд байсан*
- *Одоо Хороот*
- *ОТ-н шороо тоосноос холдож буусан*
- *Өмнөх өвөлжөө 3н хороотой байсан, мал их тухтай дээр үеийн бууц байсан*
- *Одоогийн өвөлжөө 1 модон хороотой, өвөлд их хүйтэн, мал хээл хаядаг*
- *Өмнөх өвөлжөөтэй харьцуулахад одоо ямар ч бэлчээргүй, зам малын бэлчээрийг хаасан*

- *Зам гарч мал бэлчээнэ. Зам дагуу явж буй малыг хайр найргүй дайрна. Манайх 3н ботготой ингээ дайруулж алуулсан*
- *Бусад өрхүүдтэй маш ойрхон учраас ер нь манайх ганцхан баруун талдаа бэлчээртэй, тэр нь зам эзлээд мал явах газаргүй болсон*
- *Өөр 3н айлтай бэлчээрээ хуваадаг. Манайх зүүн талдаа олон айлтай учраас бэлчээр байхгүй. Жаргалсайхан, Хандсүрэн, Цагаан нарыхтай хуваадаг*
- *Манай зуны бэлчээр Бор овоо, Будаа, Дугатад байсан*
- *Одоо манайд зуны бэлчээр өвөлжөөнийхөө ойролцоо л бууна даа. ОТ-н хашаанд бүх зуслангаа алдсан. Зуны бэлчээр зам гарах ОТ тоос шороо ихтэй байдаг*
- *Ашиглаж байсан гар ус ашигладаг. Одоо ус ундрахгүй болсон. Ус мал хангахгүй болсон. Гүний ус шавхагдсан*
- *Бог хэвээр 300, бод 210 бага зэрэг өссөн*
- *Бэлчээр багатай учраас мал өсгөх боломжгүй*
- *Бэлчээр ургамал ус багассан учраас малын ашиг шим ноолуур нь унаж гарц нь муудсан. ОТ тоосжилт их учраас хүнсэнд авсан малын уушги усжилттай, яршиж идээлсэн байх юм. Гэдэс дотор нь наалдац үүссэн байдаг. Өмнө нь зүгээр л байдаг байсан.*
- *Ирээдүйд мал аж ахуйг үргэлжлүүлэн явахад бидэнд сайн бэлчээр, ус хэрэгтэй. Бороо оролт хэвэндээ боловч өвс ургамал муу ургаж байна, хөрс ихээр бохирдсон.*

9. Ц. Хандсүрэн

- *Манайх 2000 онд Хайрцагт аман усанд өвөлждөг байсан*
- *Одоо энэ өвөлжөөндөө байна*
- *Манайх нүүгээгүй, айлууд нүүж ирсэн. Айлууд бэлчээр ус ойртож ус ургамал хомсдож бүх л байдлаараа тохиромж муутай болоод байна*
- *Манайх одоо Жаргалсайхных, мөн зүүн талдаа Цагаан гуайхтай бэлчээр их ойрхон тул зунжаанд зайтай гарах боломжгүй болсон*
- *Манайх урьд нь бууцандаа ойрхон хүний эрүүл мэндэд маш сайн устай байсан*
- *Энэ ус маань 2005-2006 оны үед ширгэж огт усгүй болсон. Тэгээд бэлчээрээр явж халивын усыг уудаг байсан ч удалгүй ус ховордож мал хангахаа больсон. Манайх зунжаандаа Халив, Бор овоог хүрч оторлодог байсан. Ухаа овоо гэх мэт.*
- *Одоо таван талдаа айлтай идэш бэлчээр маш хязгаарлагдаж малаа өсгөж амьдрахад маш хүнд болж байна.*
- *Манайх Мөнхбаатар, Намсрайжав, Самдан, Цагаан, Жаргалсайхан зэрэг айлуудтай бэлчээр хувааж байна. Зунжаа намаржаа бэлчээр болох Халив, Бор овоо гээд нутагнь ОТ-н хашаанд орсон. Мөн өрх гэр тусгаар гарсан хүүхдүүдийн өвөлжөө ус нь ОТ-н хашаанд хашигдсан тул малаа нэг ус өвөлжөөнд маллаж байна*
- *Энэ нь бидэнд малаа өсгөх маллахад бэрхшээл их, бүх талын хохирол нөлөөлөлд өртөж байна. Түүнээс гадна замын болон ОТ бүх үйл ажиллагаанаас нөлөөлөл маш их тусч байна. Тоосжилтоос болж хүн малын өвчлөлт элбэг болсон гэх зэрэг.*
- *Ирээдүйд МАА-г үргэлжлүүлэхэд үр хүүхэд болон бидэнд ашиг тустай боловч энэ бүх нөлөөллөөс хамаараад хойшдоо яаж ахуй амьжиргаагаа хөгжүүлж авч явахаа мэдэхгүй болоод байна. Бэлчээр ус гээд ч зогсохгүй аав ээжийн өлгий болсон газар нутгаа харсаар байгаад цөлжүүлмээргүй байна. Мөн энэ бүхнээс хамаараад амьдралын баталгаа болсон МАА-гаа үр хүүхдүүддээ өвлүүлж үлдээж чадахгүй болоод байна: Үр хүүхдээ зардал мөнгөний асуудлаас болоод сургууль боловсролд явуулж чадахгүй байгаа дээр нэмээд ОТ нөлөөлөл маш их дарамт болж байна. Харин бидний хүсч байгаа*

зүйл нь нутаг усаа нөхөж сэргээх, хохиролгүй болгох. Ирээдүй болсон үр хүүхдүүдээ мэргэжилтэй ажлын байртай болгож өгөхийг хүсч байна. ОТ байгаа цагт үйл ажиллагаагаа явуулж байгаа мөч болгонд манай нутагт болон бидний үр хүүхэд, амьдрал ахуйд нөлөөлөл байнгын хэвээр байна. Хүүхдүүдийг минь ажил мэргэжилтэй болгож өгөхийг маш их хүсч байна.

10. Пүрэвийн Цагаан

- 2000 онд Дугатад байсан
- Эргэн усанд өвөлжөөтэй
- ОТ-н лицензүүд газар орсноор нүүлгэн шилжүүлсэн
- Тохиромж муутай, нөмөр нөлөөгүй газар, худаг ус гарц муутай
- Бэлчээрийн хувьд хавчиг муу
- Хүнд байсан
- Эргэн тойрон айлтай
- ОТ, Бор овоо, Бумбат гэсэн газруудаар намаржиж зусдаг байсан
- Одоо зун намрын бэлчээр байхгүй
- Зуны бэлчээргүй муу байсан
- Дугатад гар худаг ашигладаг байсан
- Эргэн усд гар худаг хангамж муутай, мал ханадаггүй байсан
- Бог малын тоо толгой 180, бод мал тэмээ 5 байсан
- Одоогоор малгүй. Бэлчээр идээшлэг муу, уултай газраас тал газар бууснаас мал тогтохгүй, идээшлэхгүй, усанд ханахгүй байсан. Үрэгдэж хорогдсон, байгалийн хүнд нөхцөлд мал тэсвэрлэх нөмөр нөөлөггүй байсан.
- Өөр өрхийн мал маллаж байсан
- Одоо мал маллахгүй байгаа. Ашиг шимээ өгөхгүй, үрэгдсэн, ажиллагаа нэмэгдсэн, малаа байнга дагах, мал өдөртөө 2-3 удаа усаа эргэдэг байсан
- Одоогоор малгүй учир боломжгүй
- Тариан талбай болгон ашиглах, ус худаг сэргээн засах, хүлэмж байгуулах төлөвлөгөөтэй байна.

11. Дамдингийн Гантогтох

- 2000 онд Хөх үзүүрийн бууцанд байсан
- 2004 онд Тойн цохио гэдэг газар багтсанаар нүүлгэн шилжүүлсэн
- Одоо байгаа бууц газар олон айлын дунд тохиромж муутай
- Бэлчээр дунд зэрэг, ачаалал их
- Бэлчээр хувиарлалт муу
- Зун намрын бэлчээр Дугатад байсан
- Бууцаа тойроод айлтай, нэг талдаа бэлчээртэй
- Зуны бэлчээр байхгүй
- Дугатад гар худаг ашиглаж байсан, Тойн цохиод гүний худаг ашиглаж байна
- Одоогоор ямаа, тэмээ, адуу маллаж байна. Малын тоо толгой нэмэгдсэн
- Ажиллагаа нэмэгдсэн, тэжээл өвс худалдан авах гэх мэт зардал нэмэгдсэн
- Мал ашиг шимээ өгч байгаа, худаг мотороор ажилладаг тул бензин худалдан авах, мал арчилгаанд зардал өндөр гардаг
- Малын эрүүл мэнд, өсөлт, үржүүлгэнд их анхаардаг
- Одоохондоо бууц хашаа хороогоо засах, дулаалах төлөвлөгөөтэй байна.

12. Цэвэгдоржийн Түвшинтөгс

- 2000 онд Гашуун сухайтад байсан
- Одоо Гашуун сухайтад өвөлжиж байна
- Одоогийн бэлчээр ус муудсан тул Тэсгэл бууцыг худалдан авсан
- Тэсгэтийн бууц ус муутай, бэлчуур хавчигдмал, 5н айл тал талаас идээшүүлдэг. Хандсүрэн, Цагаан, Жаргалсайхан, Тогоо
- Тэсгэтийн усыг өмнө нь ашиглаж байсан, одоо ус нь муудсан уух боломжгүй
- Бог мал 570, Бод 35 байсан одоо Бог 440, бод 23 болсон
- Аав эгч 2н хамт давхар малладаг
- ОТ сайжруулсан зам тавих гэж бэлчээр ус муудсан

13. Лувсандагвын Мөнхбаатар

- Би 1989 онд төрсөн. 10н жилийн боловсролтой, МАА-д гарч ээжтэйгээ мал малладаг. Би Устын бууцыг өөрийн нэр дээр болгож авсан. Эхнэр 1 хүүхэдтэй. ОТ-д ажилд орох гээд чаддаггүй, намайг Устын бууцыг өөрийн нэр дээр авснаас хойш ОТ Гашуун сухайтын хооронд зам тавигдсан, шороо тоос олон техник ажиллаж дуу чимээ ихтэй, газар их эвдэж бэлчээр ихээр сүйтгэсэн. Мөн манай бууцаас 800 метрт элсний карьер гарч 600 га газрын элсийг 20-30 метр гүнтэй элсийг авч олон техник ажиллуулж, хүн ам малын амгалан тайван байдлыг алдагдуулж, газар бэлчжжр том том техникээр сүйрүүлсэн. Энэ бүгдэд надад ямар ч нөхөн олговор олгоогүй. Ажлын байр ч олдоогүй, иймд би учирлаж байна.

14. Долгорсүрэн (Намсрайн ээж)

2005 онд Хөх Хадны бууцанд өвөлжсөн. Энэ өвөлжөө Намсрайн нэр дээр байсан хэдий ч хэд хэдэн өрх энд амьдарч байсан байна. 2005 онд Намсрайнх нүүсэн (нүүлгэн шилжүүлэлтээр). ОТ өвөлжөөний гэрчилгээ эзэмшигч гээд ганцхан Намсрайг нөхөн олговорт оруулсан. Тэгээд ээж Долгорсүрэнг нь тооцоогүй. Тэрээр хамтран эзэмшигч гэж бүртгэгдсэн, гэхдээ гэрчилгээ өөрийнх нь нэр дээр биш байжээ.

Одоо 2015 онд тэрээр туслах малчин хөлсөлж, урьд хаваржаа нь байсан Байшинтад (Будаа голд) өвөлжөөтэй болж, өвөлжөөний гэрчилгээ авсан. Одоо бага хүү нь ашиглаж байгаа, тэмээний бэлчээрээр. Долгорсүрэн, түүний хүүгийн малыг хөлсний малчин маллаж байгаа ба Хөх Хад, Байшинтийн аль өвстөйд нь бэлчээдэг. Заримдаа Байшинт ачаалал ихтэй болохд малаа Намсрайн байгаа газар руу аваачдаг байна.

Өмнөх ба одоогийн бэлчээрийг харьцуулбал одоогийн бэлчээрийн төрөл/чанар гайгүй, харин мал ихтэй. Өмнө нь Хөх Хаданд хоёр л өрх байсан (Намсрай, Долгорсүрэн). Одоо Байшинтийн хавийг Одгариг, Түвшинтөгс, Намсрай, Хүрэлээгийнхэн ашигладаг.

Урьд зуны бэлчээрийг олон айл хуваадаг элбэг байсан. Үүнд одоо УЛТ-д орсон Бор овоо, Халив Дугатын бүсийн хашаан дотор болон гадна байгаа газрууд ордог байжээ.

Долгорсүрэн гуайн ярьснаар Халив Дугатад наад зах нь 10 айл зуны бэлчээрт гардаг байсан байна. Байнга ирдэг нь Бадамсамбу, Жаргалсайхан, Долгорсүрэн, Ц. Цагаан, Банди, Идэр-Боргил, Намсрай, Одгариг, Түвшинтөгс, Хүрэлээ.; мөн эдгээр өрхүүдийн хүүхдүүд; зуны бэлчээр тааруухан үед хааяа ирдэг өрхүүд. Хааяа ирдэг нь 20-иод хонодог (байгаад байдаг залхуу нэгнээс бусад нь).

Одоо ийм байдал үгүй болсон, малчид өвөлжөөндөө удаан байдаг болжээ. Хавар болтол өвөлжөөндөө. Урьд өмнө бол өвөлжөөнд 3 сар орчим байдаг байсан бол одоо удаан байдаг нүүвэл ойр

хавьдаа л нүүх болжээ. Учир нь зуны бэлчээрээ алдсан, нүүгээд явахаар бусад өрхүүдийн уламжлалт өвөлжөө, хаваржаа руу орчих гээд байдаг.

Манай зуны бэлчээр УЛТ-н урд талд өвөлжөөнийхөө ойр орчим, тэмээ Цанхи, Будаа руу явдаг, бог мал ихэнхдээ өвөлжөөнийхөө ойр хавиар эргэлддэг.

Зуны бэлчээрийн чанарын тухайд даац, чанар аль аль нь дордсон. Хойд талын бэлчээр илүү сайн тохиромжтой, тэжээллэг өвс ургамал сайтай байсан. Халив Дугат маш сайхан, гарц ихтэй, тэжээллэг байв. Бүр урагшаагаа говь цөл голдуу. Байшинт Халив Дугатын голын доод талд байдаг.

Долгорсүрэн гуай мөн хорхой шавьж ихэссэн, шинэ үзэгдээгүй шавьж хорхойн нүүдэл (дэлэнчирхүү?), өөр төрлийн царцаа үзэгдэх болсон гэж ярьж байв. Магадгүй энэ нь их ил ус байгаатай холбоотой байж ч болох юм, сайн мэдэхгүй байна гэж тэрээр ярьж байна (уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар байж болох уу?); анх 2005 оноос ийм шавьж хорхой харагдаж эхэлсэн гэж тэр хэллээ.

Тэрээр 200-300 малтай байсан, одоо 50 орчим. Хэд хэдэн шалтгаан бий: а) малаа хүүхдүүддээ хувааж өгсөн, б) бэлчээр ус хангалтгүй тул даацанд нь тааруулах болсон, в) мал төллөх хэмжээ сайнгүй.

Сүү, ноосны гарц багассан – урьд 1 ямаанаас 1 кг орчим ноолуур самналаг байсан одоо 700-800 грамм. Тэмээний ноосны гарц урьдын хэвээрээ.

15. М. Цээсүрэн (Батцэнгэлийн ээж), 86 настай

Цээсүрэн гуайн өвөлжөө Дугатын Хүрэн Дэлд байсан, Дугатын худгийг ашигладаг байсан байна.

2004 онд багийн дарга нүү, нүүхгүй бол хүчээр нүүлгэнэ гэсэн байна. ОТ-гоос нэг эмэгтэй өдөр болгон ирж нүүхийг шаардаж байсан. Түүнд шинэ өвөлжөө, худаг барьж өгнө гэж амласан тул шинэ газарт нүүж очсон, тэндхийн худаг нь 2-3 жил бодоод ширгэсэн.

Оюут Толгойтын хавь ойр жигтэйхэн үзэсгэлэнтэй байлаа, одоо бэлчээр жилээс жилд багасч байна. Малын чанар тааруу болж байна. Малынх нь тоо цөөрч, чанар муудсан тул тэрээр мал маллахаа больж, 2007/8 онд сумын төв рүү оржээ. Сумын төвийн амьдрал огт өөр. Мал маллаж байхдаа жаргалтай байжээ, сүүгээ уугаад, сумын төвд суурьшаад бие тааруу болсон. Хүүхдүүдийнхээ амьжиргаа, нутаг нь юу болох бол гэж санаа зовсоор сууна.

Хэрэг дээрээ тэдний өвөлжөөнд 3 айл байсан – өөрийнх нь (Цээсүрэн), хүү Бат-эрдэнэ, Мэндбаяр нарынх. 2004 онд бүгдээрээ нүүж, нисэх бүүдлын хавьцаа “Буйлсан Хөөвөрт” буусан. Түүнийг гэртээ ганцаараа байхад нүүлгэн шилжүүлэх цаасанд/гэрээнд гарын үсэг зуруулжээ. Үүгээр 3 өрхийг биш ганцыг нь нөлөөлөлд өртсөн гэж тооцсон.

Шинэ газар нь замд ойрхон, олон машин тэрэг бэлчээр түйвээн, гэрийн хажуугаар гардаг байсан байна. Өрөмдлөгийн компанийн кемп хажууд ойрхон байсан, мал амьтан, мөн нэг хүү ухсан нүхэнд ойчиж эндсэн.

Бат-Эрдэнэ 100 бог, 20 бодтой “Илгэн” рүү нүүжээ. Гэтэл мал идээших бэлчээр ус байхгүй тул Дугат руу буцаж ирээд хамаг малаа алдсан байна.

Мэндбаяр 100 бог, 5-6 тэмээтэй эцэг эхийн хамт нүүсэн, тэднийх малгүй болсон хойно ажилд орсон.

Одоо Цээсүрэн гуай 20 орчим малтай. Өмнө нь 300-400 бог, 10 тэмээтэй байсан, заримыг нь бас зуднаар алджээ.

Усны нөөцийн өөрчлөлтийн тухайд тэрээр хэлэхдээ:

Хөрсний ус маш элбэг байлаа. 1990-ээд онд мал угаах газар олддоггүй байсан, малын эмч олон ч газар ухсан, дандаа л ус гараад байсан гэв.

2010 он гэхэд худаг, задгайн ус байхгүй болсон, эхлээд худгийн түвшин нь буурч байгаад дараа нь бүх булаг шанд хатсан аж.

16. Билэгсайхан

Билэгсайханы өвөлжөө Ундай голд хар Толгойн Шандад байсан, зун, намартаа Халив Дугатад нутагладаг байжээ. 1996 оноос хойш ингэж л амьдарч байв. Дөнгөж гэрлэсэн, өвөлжөөний гэрчилгээ байхгүй, дөнгөж олгож эхэлж байсан үе. Зөндөө олон цооног өрөмдөөд байхыг хараад энэ нутагт мал маллахад тохиромжгүй болох нь дээ гэж бодож байжээ. Бор Овоо усны гол эх үүсвэр байв.

2000 онд Билэгсайхных Гавилууд багийн хойд хэсэг рүү нүүж, 2001 он хүртэл тэнд байжээ. Дараа нь сумын төвөөс 30 км зайтай Гурван Шавагтай руу нүүж очоод 7 жил нутагласан (2001 – 2006). Айл саахалттай зөрчилдөөнтэйн улмаас 2006 онд 2 км ойрхон нүүж, тэндээ 2013 он хүртэл байжээ. Шавагтайд 6 өрх нэг худгаас уудаг байсан. 2007 онд Шавагтайд өвөлжөөний гэрчилгээ авсан, тэр газраа өөрөө Үзүүрийн Шанд гэж нэрлэсэн байна. 2015 онд сумын төв рүү нүүсэн.

2000 оны үед Дугатын бэлчээр сайн байсан, гэхдээ маш их өрөмдлөг явагдаж байжээ. Мал аж ахуй эрхлэх газар хайн холдон нүүж байсан байна.

Билэгсайхан Ундайд өвөлжөө барих үе нь социализмын үеийн бүртгэл болон шинээр гэрчилгээ олголтын хооронд таарчээ. Залуу, дөнгөж гэрлэсэн байж. Ундай гол дахь өвөлжөөндөө гэрчилгээ аваагүй тул түүнийг нөхөн олговорт хамруулаагүй байна. 2016 онд 100-аад малтай байжээ (өөр үн маллаж байсан уу?).

17. П. Онон, нөхөр Г. Мэндбаяр

Цанхид өвөлжөөтэй байсан, 1993-2002 он хүртэл. Тэр үед бэлчээр зөндөө, дөрвөн өрх бууцаа хуваадаг байсан. Малаа баруун тийш бэлчээнэ. 2003 онд Их Гялаан руу нүүж, өөрийн өвөлжөөтэй болохын тулд Ц. Нэргүйн бууцыг засч янзалж авчээ. Зун, намар Халив Дугатын бэлчээрт гардаг байсан.

2004 онд Дугатад нутаглахыг хүссэн боловч зөвшөөрөхгүй болсон байлаа. Одоо том хүү нь эрийн цээнд хүрсэн, өвөлжөөтэй болж чадаагүй л байна. Тэд уламжлалт нутаг орон, малаа хүүхдүүддээ өвлүүлдэг ёс заншлыг дагах чадахгүй, малаа өсгөх аргагүй болжээ. ОТ хүүхдүүдийг нь ажилд авах байх гэж горьдож байсан ч бүтээгүй. Хоёр том хүүхэд нь ажилгүй.

Халив Дугатын нутаг өвч ургамал сайтай, хавар, зун, намрын бэлчээр байсан. Социализмын үед хонь угаах, ялгах гэх мэт мал аж ахуйн олон ажил явагддаг байжээ.

Өнөөдөр малчид маш их зөрчилдөөнтэй, тэр бүү хэл хамаатан садан дотроо муудалцах болж, дарамт ихэссэн. Өөр газарт очиход хүмүүс “Та нар газар нутгаа ОТ-д зарсан” гэдэг. “Социализмын үед өвөлжөө барихад сайшааж урамшуулдаг байлаа, одоо загнуулах болж.” Зан заншил, соёл, хүмүүсийн сэтгэл санааны тайван байдалд ноцтой нөлөөлөл учруулж байна гэж Онон үзэж байна.

2011 онд уг өрхийг нөлөөлөлд өртсөн гэж үзээд нэг жилийн гэрээгээр хог түүлгэх ажилд авчээ, гэтэл нөхөр нь өвдсөн байна (гэрээ сунгагдана). “Бид үнэхээр амьжиргаагаа тогтвортой залгуулах ямар нэгэн юм хийх хэрэгтэй байна” гэж Онон хэлэв.

18. Нэргүй

Нэргүй гуай хоёр охинтой, нэг нь малчин, нөгөө нь ажилгүй. Бэлчээр, ус ховор цагт малын тоо толгойг хязгаарлахаас өөр аргагүй, тиймээс тогтвортой амьжиргаагаар байхыг тулд бидэнд нөхөн олговор хэрэгтэй” гэж тэр хэллээ.

19. Л. Мандбаяр

Хүрэн Дэлийн худагт 4 айл цугтаа байсан. Бэлчээр, ус малд хангалттай сайн байв. 2004 онд өвөлжөөний гэрчилгээ ээжийнх нь нэр дээр олгогдсон тул 4 өрхийг нэг өрх гэж үзжээ. Тэрээр нүүхээс өөр аргагүй болж, олон малаа алдсан байна. Улаанбаатар орж, харуул зрэг янз бүрийн ажил хийж байж байсан. Түүнд юу ч үлдээгүй гэтэл түүнийг нөлөөлөлд өртсөн гэж үздэггүй. Одоо ч Улаанбаатарт гэр бүлийнхэнтэйгээ байгаа. Газар, амьжиргаагаа ОТ-д алдсан тул өөрийг нь нөлөөлөлд өртсөн гэж тооцохыг хүсдэг. ОТ байгаагүй бол тэр өөрөө мөн ах дүү нар нь цөмөөрөө малчин байх байсан.

20. Б. Эрдэнэбаяр

Эрдэнэбаярын өвөлжөө “Модот Цанхийн” овоонд байсан (Хүрэн хошууны бууц), одоо УЛТ-н зүүн хойд буланд, хашаанаас 400-500 метр зайтай. Эрдэнэбаяр ярьсан нь:

1993 оноос хойш өөрөө хашаа хороо барьж, гар худаг гаргасан. Тэр үед бэлчээр элбэг, малчид малаа өсгөх боломжтой. 1999 он хүртэл өвөлжөөндөө өвөлждөг байгаад 1999 онд хур бороо бага байсан тул, 1999/2000 оны өвөл зүүн тийшээ нүүж, тэндээ 2 жил өвөлжсөн. 2001/2 онд эргэж Хүрэн хошууны бууцандаа буусан. 2003 оны үед Бор хошуунаас 4 км орчимд байдаг эгчийнхтэйгээ цуг байхаар нүүсэн (хүүхдүүд бага, хоёр өрх цуг байвал хэн нэг нь малдаа явахад хүүхдүүдээ эзгүй орхихгүй). 2004 онд нүүлгэн шилжүүлэх тухай цуу тарж эхэлсэн. Хоёр хүүхэд сургуульд орчихсон, эхнэр нь хамтдаа сумын төвд байв. Нүүлгэн шилжүүлэлтийн тухай мэдээ ч үгүй. Нүүлгэн шилжүүлэлтийн хөтөлбөр эхлээд түүнээс хэн ч юу ч асуугаагүй. Компани, орон нутгийн захиргаа айлуудаар орохдоо сумын туслалцаатай нүүлгэн шилжүүлэлтийг хүлээн зөвшөөрөхгүй бол хүчээр нүүлгээд, юу ч өгөхгүй орхино гэж сүрдүүлж байжээ. Мөн гэрээ маш нууц, бусдад үзүүлж харуулж болохгүй гэдэг байжээ. Ямар ч байлаа Эрдэнэбаяртай нэг ч хүн уулзаагүй байна.

Мал нь эгчийнд нь, эхнэр хүүхдүүд сумын төвд, тэр өөрөө ирэн очин байжээ. Өөрийнх нь өвөлжөө хаягдсан юм шиг харагдсан байж болох юм. Тэр ОТ хүмүүстэй уулзаж, нөхцөл байдлыг нь харж үзэхийг хүсэхэд судалгаанд хамрагдаагүй үлдсэн тул нүүлгэн шилжүүлэх ёстой өрх гэж тооцогдохгүй гэсэн байна. Өвөлжөөгөө ашиглах боломжгүй болсон байтлаа гэрээ ч үгүй, нөхөн олговор ч үгүй хоцорчээ. ОТ үйл ажиллагаагаа эхлүүлэхээс өмнө тэнд өвөлжөө нь байсныг эндхийн хүн болгон мэднэ гэж тэр онцлон хэлж байв. Эрдэнэбаяр ОТ-г хаа нэгтээ шинээр өвөлжөө барихад туслалцаа үзүүлээч гэж хүсэхэд сумын засаг даргаас албан бичиг авчир гэснийг нь ёсоор болгосноор Зараагийн Бурхантад өвөлжөө барьж өгчээ. Энэ нь ердөө модон саравч (хагас саран хэлбэртэй), “зуны сууц” байсан бөгөөд түүнд нөхөн олговор, нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ аль аль нь байхгүй хэвээр байв.

Эрдэнэбаярын бэлчээр тэр чигээрээ алдагдсан. 30 хүрээгүй, залуухан, нүүдлийн мал аж ахуйн уламжлалыг үргэлжлүүлэн, биеэ даасан малчны гараагаа дөнгөж эхэлсэн байлаа. Бэлчээр ус байсан бол малаа өсгөх бүрэн боломжтой (200-300 малтай байсан). Өнөөдөр (2016 оны 3 сар) 40-50 богтой, 4 тэмээ, 17 адуутай л байна. Богоо бодвол олон тооны морь, тэмээтэйн учир нь нөгөө “зуны сууцны” ойр орчмын газар нь 40 метрийн зайтай өнгөрч буй Гүний хоолойн шугам, эрчим хүчний шугамын нөлөөлөлд орсон. 500 метрт ОТ-н хангамжийн зам (ОТ-Манлай-УБ). Зам худагтай нь тун ойрхон, ачааны тэрэгнүүд дээгүүр нь гараад тагийг нь эвдчихдэг. Баруун талд 4-5 км-т нисэх буудал. Мал зам гарах болох тул мал маллах арга бараг байхгүй.

2011 онд арай гэж түүнийг Гүний хоолойн дэд бүтцийн нөлөөлөлд өртсөн гэж тооцжээ. Тэрээр машин дээгүүр нь гараад эвдэрсэн худгийг засах, усны шинэ эх үүсвэртэй болоход туслалцаа үзүүлэх хүсэлтийг ОТ-д тавьсан байна.

Т. Пүрэв

2004 он хүртэл бүх насаараа Хөх Шандын бууцанд нутаглаж байсан түүнийг хүргэн Гантогтохын хамт 2004 онд Тойн Цохио руу нүүлгэн шилжүүлсэн. 7 жилийн өмнө Пүрэв гуай сумын төвд орж иржээ. Одоо (ОТ-д ажиллаж байгаа) Гантогтох түүний малыг малладаг.

Хавсралт 5 – Бүлгийн хэлэлцүүлэг 2016 оны 3 сарын 30/31

Хэлэлцүүлгийг 2000-2015 оны хооронд болон үүнээс хойш Халив Дугатын бүсийн бэлчээр, усны нөөцийн нөхцөл байдал, хүртээмжид гарсан өөрчлөлтүүдийн талаарх малчдын төсөөлөл, мэдээллийг дараалсан 5 жил тутмын нөхцөл байдлыг тодорхойлон авах замаар явуулав.

Бүлэг эхлээд Халив Дугатын бүсийн бэлчээр, усны бүх нөөцийг зураглан, нутгийн нэрээр тэмдэглэсэн. Тэгээд хугацааны туршид бэлчээр, усны нөөцийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдийн талаар ярилцан, нөхцөл байдалд оноо (0-5) өгөн үнэлсэн ба хамгийн сайн нөхцөлтэй байх үе нь 5 оноотой. Доорх хүснэгтэд хэлэлцүүлэгт оролцогсад өөрийн үгээр илэрхийлсэн үнэлгээ, дүгнэлтийг үзүүлээ.

Усны эх үүсвэр, Бэлчээрийн ачаалалд гарсан өөрчлөлтүүдийн тухайд малчдын бодол							
Эх үүсвэр	<2000	2000- /5	2005/10	2010/15	>2015	Өөрчлөлтийн шалтгаан	Бууруулах арга хэмжээ
Худгууд						Ил уурхай, далд уурхайн шууд нөлөөлөл. Худаг, цооногын тоо нэмэгдсэн.	1996 онд хайгуул эхэлсэн, 20 жилд ийм олон усны эх үүсвэр байхгүй болсон; уурхай бүрэн хүчин чадлаараа 60 жил ажиллана гэвэл тэд бидний амьжиргааг тэтгэх усаар хангах ёстой. Ирээдүйд үлдсэн хэдэн задгайг хамгаалах, цөөрөм, уст цэгүүдийг аль болох олноор байгуулах . Хөрсний чийгийг барих/хадгалахын тулд олон наст ургамал тарих.
Дугат	4	4	2	1	1	Хайгуулын өрөмдлөг, гүн өрмийн худгууд, худгийн усаар дээж угаасан	
Хөх Шанд	4	3	0	0	0	Хайгуулын өрөмдлөг, зам, карьер, бутлуур, өрөмдлөгийн цооногууд	
Шанд (Тухар эргийн)	4	3	0	0	0	Хайгуулын өрөмдлөг, зам, карьер, бутлуур, өрөмдлөгийн цооногууд	
Кольцот (Халивын)	4	3	?			Халивын эхэн дэх карьер, Хайгуулын өрөмдлөг, зам, карьер, бутлуур, өрөмдлөгийн цооногууд	
Хуурай (1998 онд ширгэсэн)	0	0	0	0	0	Халивын эхэн дэх карьер, Хайгуулын өрөмдлөг, зам, карьер, бутлуур, өрөмдлөгийн цооногууд	
Халив	4	3	2	?		Халивын эхэн дэх карьер, Хайгуулын өрөмдлөг, зам, карьер, бутлуур, өрөмдлөгийн цооногууд	
Бор Хошууны салаа	4	3	0	0	0	Хайрганы карьер, өрөмдлөг, зам	
Хүрэн Хошуу	4					Эрдэнэбаяраас лавлаж асуух	
Бор Хошуу	4	2	2	2	0	Элсний картер, өрөмдлөг, зам	

Бор Хошууны кольцот (80-аад оноос ашиглахаа больсон)	?					80-аад оноос хойш ашиглаагүй	
Оорцог	4	3	2	2	0	Халивын кольцотын усыг шавхсан	
Эргүүлэгт (Халивын)	4	3	2	2	0	өрөмдлөгт ашигласан	
Тэсгэт (1999 онд ширгэсэн)						өрөмдлөгт ашигласан	
Ухаа Цохио (1999 онд ширгэсэн)						өрөмдлөгт ашигласан	
Аман ус	4	3	0	0	0	Кольцот, Тэсгэтийн усыг ашигласан	
Улаан худаг	4	3	0	0	0	Кольцот, Тэсгэтийн усыг ашигласан	
Тойн Цохио	4	2	0	0	0	өрөмдлөгт ашигласан	
Тойн Цохио	4	2	0	0	0	өрөмдлөгт ашигласан	
Халив Дугатын бэлчээрийн бүсийн бэлчээрийн ачаалал						Тоос	Авсан бэлчээрийнхээ оронд тэд <u>ирээдүйн амьжиргааг баталгаатай байлгаж чадах хангалттай нөхөн олговор олгох.</u> <u>Өмнө учруулсан бүх хохирлыг нөхөн төлөх.</u> Хүүхдийн сургалтын зардлыг даах, төгссөний дараа ажлын байраар хангах, байнгын ажилтай олгох. Ирээдүйн төлөө зовж буй сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах
Дугат	4	2	0	0	0	УЛТ	
Хөх шанд	4	0	0	0	0	УЛТ	
Дугатын дугуй	4	0	0	0	0	УЛТ	
Халив	4	0	0	0	0	УЛТ	
Уст баг мод	4	3	1	1	1	Баруун талд хашаа, зүүн талд уул	

						хадаар хашигдсан, 5 айл хуваадаг, тоос	
Ухаа овоо	4	3	1	1	1	Баруун талд хашаа, 4 өрх хуваадаг, тоос	
Вандан Тогой	4	0	0	0	0	УЛТ	
Шунхат	4	0	0	0	0	УЛТ	
Оюут Толгой	4	0	0	0	0	УЛТ	
Ханан даваа	4	3	1	1	1	Баруун талд хашаа, хойноо нисэх буудалд шахагдсан, нөлөөлөлд өртсөн 2 өрх нүүж ирсэн, бас 2 айл дураараа буусан, нийтдээ 10 өрх, чулуутай, хадархаг, өвс ургамал ховор, чоно, шилүүс. Отрын бэлчээрийг Гүний хоолойн шугам, нисэх буудал эзэлсэн	
Монгол хар	4	3	1	1	1		
Хар овоо	4	3	1	1	1		
Тойн цохио	4	3	1	1	1	Нөлөөлөлд өртсөн 3 өрх нүүж ирсэн, нийтдээ 5 айлтай, жил бүр 3-4 айл отор хийн нүүж ирдэг, хадархаг	
Оорцог	4	3	1	1	1	5 айл хуваадгаас 3 нь нөлөөлөлд өртсөн өрх, отрын айлууд дамжин өнгөрдөг, 1 км-т зам, малд аюултай, осол гарч байсан	
Бор хошуу	4	3	2	1	1		
Будаа	4	3	2	1	1	Усгүй, зуны эхэнд л хэдхэн өдөр усыг нь уудаг	
Задгай/булгууд						Халив Дугатын голууд хаагдсан	Шинэ зам барихдаа хангалттай том хэмжээний нүхэн гарц гаргах, ус урсадаг газар болгонд барих
Дугатын задгай	4	0	0	0	0		
Хажуу хөөвөр	4	4	3	0	0		
Будаагийн задгай	4	4	3	0	0		
Оорцогийн булаг	4	4	3	0	0		Дэд бүтцийн улмаас
Бор хошууны	4	4	3	0	0		

булаг							
Хур бороо	4	4	4	4			
Малын ашиг шим	4	3	2	2	-	Бэлчээр дутмаг, зам, тоос зэргээс мал тарга хүч авч чаддаггүй. Ноос бохирдолтой (тоос), ноос сүүний гарц багассан	
Малын эрүүл мэнд	4	3	2	2	-	Тоос, бохир ус, мал их айж цочдог, малчид мал эмнэлгийн зардлыг дийлдэггүй, оторт гарч чадахгүй болсон тул мал эрдсийн дутагдалд орсон,	ОТ мал эмнэлгийн зардлыг даах.
Ургамалжилт (гарц)	4	3	2	2	-	Бэлчээрийн даац хэтэрсэн, бохирдсон, хөрсний чийг алдагдсан, олон наст ургамлын гарц багассан, нэг наст ургамал, хогийн ургамал ихэссэн, дэд бүтэц	

Хавсралт 6 – 2016 оны 3 сарын 28-наас 4 сарын 1, 6 сарын 7-8-ны өдрүүдэд хийсэн хээрийн судалгааны фото баримт



Халив-Дугатын бүс дэх өөрчлөлтийн шуудуу, Хаягдал Хадгалах Байгууламжийн хойд талд Эдгээр овгор шороо нь үерийн ус уурхайн талбай руу орохоос сэргийлж хийгдсэн шуудуу. Барихдаа үерийн усыг буцаагаад голын урсгалын доод руу оруулах суваг шиг цементэн гадаргуу хийж өгөөгүй, (Сабине авсан зураг, 2016 оны 3 сар, хээрийн судалгааны үеэр).



Будаа гол, УЛТ-н хашааны шугам огтлолцсон хэсэг болон түүнээс доохно. (Сабине авсан зураг, 2016 оны 3 сар. Намсрайн хэлснээр, 2015 оны зун үерийн ус голдуу Хуурай голоос, зарим нь Хаягдлын Байгууламжийн хойноос Халив Дугатын өөрчлөлтийн шуудуугаар орж ирсэн байна.



Гурван Модны Халив гол дээрх элсний карьер (2016 оны 3 сар, Сабине)



Уст Баг Мод/Гурван Модны Халив дахь элсний карьер. Цаашдаа эндээс олон жил элс авна, далд уурхайн барилгын цемент гаргахад хэрэгтэй (Цэрэннадмидын хэлснээр).



ХХБ-ийн ойролцоох шүүрэлтийн цөөрөм, 2016 оны 3 сар (Сабине авсан зураг)



ХХБ дахь ил ус, 2016 оны 3 сар. Цагаан хунгийн сүрэг. (Сабине авсан зураг)



Бүлгийн хэлэлцүүлэг, Халив Дугатын бэлчээр, усны нөөцийн зураг гаргаж байгаа нь,

2016 оны 3 сарын 30/31



Бүлгийн хэлэлцүүлэг - Халив Дугатын бэлчээр, усны нөөцийн зураг гаргаж, ус, 2000 – 2015 оны хооронд бэлчээрийн нөөцийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлтүүдийг үнэлж буй нь, 2016 оны 3 сарын 30/31.

Хавсралт 7 – 2016 оны 6 сарын 7,8-нд Ханбогд суманд ажилласан тухай

ХШБ-ийн гишүүн Сабине Шмидт 2016 оны 6 сарын 7-8-нд Ханбогдод очиж, 3, 4-р саруудад хийсэн уулзалтуудын дагуу малчдын өвөлжөө, улирлын нүүдэл, малын тоо зэрэгт гарсан өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл цуглуулахаар ажилласан болно.

6 сарын 7-8-ны өдрүүдэд дараах ажлуудыг хийлээ, үүнд: ГТЗ-ийн Удирдах Нэгж, ГТЗ-ийн гишүүд, ОТ-н бэлчээр, усны асуудал хариуцсан мэргэжилтнүүд, ГТЗ-ийн Дарга, Ханбогд сумын мал аж ахуйн тасгийн дарга нартай уулзав. Эхэн Халив хавиар нутагладаг малчид 7-ны өдрийн хуралд суусан бөгөөд тэдгээр малчид Халив-Дугатын бэлчээрийг зун, намар ашигладаг байсан, тиймээс нөлөөлөлд өртсөн гээд ХШБ үүнийг анхааралдаа авахын хүссэн. Эхэн Халиваар нутагладаг малчдаас хэдэн хүн 1-р шатны үед хийсэн уулзалтанд оролцож байсан.

Эхэн Халивт нутагтай малчин Улам-Ундрах ХШБ-т хандан Эхэн Халивын бүсийг ХШБ-ийн судалгаанд хамруулах хүсэлт тавьсан ба ОТ-гоос усаар хангаж байгаа нь (хааш хаашаа 20 км) (ХШБ-ийн 1-р шатны тайлангийн дагуу) эдгээр уст цэгүүдийн орчмын бэлчээр талхлагдахад хүргэж байгаад санаа зовж буйгаа илэрхийлсэн. ХШБ 2016 оны 6 сарын 7,8-нд Ханбогдод очихоос өмнө хүсэлтийг нь авч, түүнд хариу өгсөн болно.

Ингээд ХШБ-ийн гишүүн Сабине Шмидт эдгээр өрхүүдтэй тусад нь уулзаж, *өмнөх шатанд хийсэн шиг байгалийн нөөцийг* (бэлчээр, ус) ашиглаж байсан байдлын зураглал гаргаж, нөөцийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт, малчдын *ашигладаг* байгалийн нөөцийн хүртээмж, чанарт учирсан нөлөөлөлд үнэлгээ хийхээр тохирсон. Уг уулзалтыг 6 сарын 8-нд Эхэн Халивт хийлээ. Оролцогсод өөрсдийн өрхүүдийн тухайд болон өвөлжөө, улирлын чанартай нүүдэл, бэлчээрийн нөхцөл байдал, бэлчээрийн тохиромжтой байдал, малын ашиг шим, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүд, тэдгээрийн шалтгааны талаар мэдээлэл өгсөн.

6 сарын 7-нд ГТЗ-ийн төлөөлөгчид, ОТ-н орон нутаг/бэлчээр/усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй уулзах үеэр 11 тодорхой бэлчээрийн газрууд болон Халив Дугатын ойр хавьд мал бөөгнөрөх явдалд гарсан өөрчлөлтөнд үнэлгээ хийх судалгааг хамтран боловсруулж, мөн сумын архиваас мэдээлэл түүн нэгтгэхэд туслах хүнийг орон нутгаас сонгон, гэрээгээр ажиллуулахаар тохирсон.

ГТЗ-ийн дарга тэдгээр бэлчээр нутагт 2000 – 2015 онуудад өвөлжөөтэй байсан өрхүүдийн талаар мэдээлэл өгсөн бөгөөд үүнийг Сумын даргын орлогч, мал аж ахуйн тасгийн дарга нар хянаж/нэмсэн. Сумын архивын мэдээллийг 8 сард өгсөн бөгөөд мэдээллийг бүрдүүлэн/баталгаажуулах ажил үргэлжилж байна.

Хавсралт 8 – Эхэн Халив дахь өрхүүдийн мэдээлэл, Нөлөөллүүд, Бэлчээр, Усны нөөцөд гарсан өөрчлөлтүүдийн талаарх малчдын бодол

Эхэн Халивын малчид 2016 оны 6 сарын 7-ны уулзалтанд оролцож, Халив-Дугатын зун, намрын бэлчээрийг тэд ашигладаг/байсан тиймээс тэд өөрсдийгөө нөлөөлөлд өртсөн гэж үздэгээ ХШБ-ийн сонорт хүргэхийг хүссэн. ХШБ-ийн 1-р шатны уулзалтуудад Эхэн Халиваас хэд хэдэн малчид оролцож байсан болно.

ХШБ-ийн гишүүн судлаач Сабине Шмидт эдгээр өрхүүдтэй тусдаа уулзан, байгалийн нөөцийн (бэлчээр, ус) зураглал гаргаж, нөөцийн нөхцөл байдлын өөрчлөлт, малчдын нөөцийн чанар, хүртээмжид бий болсон өөрчлөлтийг үнэлэхээр тохирсны дагуу уг уулзалтыг 6 сарын 8-ны өдөр Эхэн Халивт хийв.

Оролцогсад өөрсдийн өрхийн тухай, өвөлжөө бууцны байршил, улирлын нүүдэл, бэлчээрийн нөхцөл, бэлчээрийн тохиромжтой байдал, малын ашиг шим, амьжиргаанд гарсан өөрчлөлтүүдийн талаарх мэдээллийг өглөө.

Малчдын ажиглалт - Халивын голын малчдын мал болон өөрсдийнх нь ундааны усанд гарсан өөрчлөлт.

д/д	Хариуцдаг эзэн	Усны нэр & төрөл	2000	2000 -2005	2005-2010	2010-2015	2016	Өөрчлөлтийн шалтгаан
1		Цанхийн хөв	Өнждөг байсан	Өнждөг байсан	Өжихөө басан	Хатсан	Устай болсон ч уддаггүй	Одоо усгүй
2		Эх нь Бортолгойн хөв	Устай байсан	Зундаа устай байдаг байв				Одоо усгүй ус хийсэнч ангасан газар 10 хоногийн дотор ширгээж авдаг
		Дунд бортолгойн хөв	Өнжмөл устай	Сайн байсан	Өнждөг байв	Зусдаг байв	Ус тогтсонч удахаа байсан	Энэ хөв одоо усгүй
		Адаг бортолгойн хөв	Гайгүй устай байсан	Устай байсан	Устай байсан	Хамгийн амархан дуусдаг	Усгүй	Усгүй
		Олон худгийн Хүрэнгийн ус	3 айл уудаг байсан	Мүү болсон	Бага устай болсноос айл нь нүүсэн	Мүү байгаа байхаа	Амны устай	Амны ус төдий
		Харганын хөв	Өнжмөл устай	Сайн байсан	Өнждөг байв	Зусдаг байв	Ус тогтсонч удахаа байсан	Энэ хөв одоо усгүй
3	Д.Туяа, Ч. Дэмбэрэл	Элгэн ЭУХ	Мал цөөн байсан	Мүүдсан	Бүүр шавхаж эхэлсэн	Засвалласан авч хэвэндээ байгаа	Хэвээр	Одоо бол ус муутай малаа хоногоор

			учир гайгүй					ээлжилж усалсан ч ханадаггүй
4		Тогоогийн шанд ЭУХ		Энэ үед гайгүй байсан	муудсан	Амны усны төдий	Одоо амны	Одоо ёроолд нь чийгтэй шороотой
5	М. Пүрэвдорж	Амны усны худаг ЭУХ				Гаднаа мань ус гаргасан болоод л байсан	Багассан	Одоо усгүй болсон
6	М. Пүрэвдорж	Эхэн халив ЭУХ	Гайгүй сайн устай байв	Мүүдаж эхэлсэн	Маш их шавхдаг болсон	ОТ ус хийж усалж байв	засварласан	Усгүй хуурай
7	Ш. Ганбат	Эхэн халивын Кольцот богино яндант байсан одоо ЭУХ	Эхэн халив ууж байсан тэр үед кольцот сайн байсан	Дунд зэрэг	Усны ундрага багасч ирсэн	Ундрага улам багассанаас шөнөдөө түвшиндээ ирэхгүй болсон	Шавхдаг болсон Хүлээж байж малаа усалсан	Ус маш муутай
8	Ц. Төмөртоогоо	Түймэртийн ус Сухайн ЭУХ	Сайн байсан 1000 мал уудаг байсан	Олон мал уудаг байлаа	Муудсан	Шавхдаг болсон ус нь эрс байгассан	Бага зэрэг дээрдсэн ч тэр байдал удаагүй	Одоо шавхаад л ундраагаад 400 бог уудаг
	М. Баярсайхан	Ахбаярын гаргасан худаг		Энэ үед дарагдсан	Усгүй	Усгүй	Усгүй	Усгүй
9	А. Наранцэцэг	ОТ Шинээр гарсан гүн өрмийн худаг				2015 онд гарсан ба 2016 оноос 2 айл ашиглаж эхэлсэн	Усны гаралт нарийссан	Одоо 300 бог мал хангахаа байсан
10	А. Улам- Ундрах	Дунд халив Богино яндант худаг	Элбэг устай	Амнаасаа 40 см- ийн доор хүрч ирдэг	Ус нь мүүдаж эхэлсэн	Усгүй болж дахин ОТ гаргасан	Ус хэвэндээ Малаа өнжөөж	Одоо 300 мал ханахгүй болсон. 2014

		байсныг ЭУХ болгосон		шавхагддаггүй худаг байсан. Мөн хажуугийн сайранд хулан татаалаа 40 см-ийн доороос татаал татаж ундаалдаг байсан		боловч 54 см уснаас хэтрээгүй тул ОТ ус хийж өгч байсан	усалж байсан	онд гүнзгийрүүлж 16 м ухан гаргасан ч 54 см устай болж улам багассан, 2015 онд ОТ-оор худаг руугаа ус хийлгэж ууж байсан боловч ус нь малын эрүүл мэндэд таарамжгүй байсан
11	Улам- Ундрах	Дунд халивын дээд талд ОТ 350 м-т кольцот малтсан ус				2012 онд гаргасан	Усны түвшин дээшлээгүй ундрага хомс	Одоо амны ус авах төдий устай Энэ нь хоногт 100 л гэсэн үг
12	А. Наранцэцэг	Адаг халив	Устай байсан	2 айлын 800 бог 60 гаруй тэмээ уудаг байсан.	муудсан	Усгүй болсон	Шавагт болон гүн эрэгт малаа усалж байв	Одоо зөвхөн амны усаа л авдаг болсон
13	Ц. Нэргүй Ц. Элбэгсайхан Г. Мэндбаяр Ц. Цагаан	Шавагийн 3 худаг ЭУХ- 2ш Богино яндант байсныг ЭУХ болгосон 1 ш	Устай	Гүн худаг нь их устай ч эдгээр 3 айлын мал нөгөө 2 дээр нь уугаад ханадаг байсан	Шавхагдаж эхэлсэн	Ханахаа байсан хажуугийн цооногийг уудаг болсон	Шавхуур Нэг худаг нь хуурайшиж нурсан	Одоо гурвуулангий нь уугаад ч ханадаггүй шавхагддаггүй байсан гүн худаг ч мөн шавхагддаг болсон.
14	У. Цацралт	Ханангийн худаг		Шинээр гаргасан	Анхны жилүүдэд айл уугаагүй	Шавхуур	2 онгоц дүүргээд шавхагддаг ундраагаад дахин усалдаг	Энэ байдал хэвээрээ

ЭХЭН ХАЛИВ ДАХЬ МАЛЧИН ӨРХҮҮД

1. Доржийн Туяа

- 2000 оноос өмнө Элгэний өвөлжөөнд байсан
- 1992 оноос хойш өнөөг хүртэл манайх энд өвөлжиж байна
- Олон жил нутагласан, тохиромжтой.
- ОТ 2005 онд бий болсноос хойш бэлчээр муудаж, усны ундарга удаан болсон.
- Бэлчээрээ 3-4 өрхтэй хуваадаг
- Нэг бэлчээртээ жилийн турш байдаг, зун намар ч ялгаагүй
- Бороо хурын байдлаас зуны бэлчээрээ сонгодог
- Усны хэрэглээ малын тоо толгойноос шалтгаална, одоо 2 өрхийн мал хоёр талаасаа уудаг. Бод малын тоо илүү олон болохоор ус улам ховор. Өмнө уудаг байсан усаа л ууж байгаа. Урьд бог, бодын тоо аль аль их байлаа. Худгаа шавхдаг болсноос хойш мал усаар ханахгүйгээс ноосны гарц багассан. Боро хур ихтэй бол малын ноос эрүүл байдаг.
- Цаашдаа малаа малламаар байвч бэлчээр, усны хүртээмж муу болохоор мал өсгөх боломж хомс. Малд бэлчээр, ус хүрэлцээтэй байвал малаас хараат амьжиргаатай малчин бид малаа өсгөмөөр л байна.

2. Мядагийн Пүрэвдорж

Эхэн Халивын өвөлжөө 1988 онд баригдсан, тэрнээс хойш 28 жил энд нутаглаж байна. Одоо ч энэ өвөлжөөндөө байгаа.

Манай ус амны ус төдий. Худаг 3 жилийн өмнө ширгэсэн. Ус ховор, ОТ 3 жил усаар зөөж өгсөн.

Бэлчээрээ 4 айлтай хуваадаг. Одоо 2 хүүгийнхтэйгээ 3 айлын мал маллаж байна. Усгүйгээс болоод 40 тэмээ, 20 адуугаа зарсан. Одоо зөвхөн 350 богтой.

Малын ашиг шим сайн, малын эрүүл мэнд хэвийн.

2 хүүгээ малчин болоосой гэж боддог, даанч усны хүрэлцээ хангалтгүй байна. Сайхан бэлчээр устай газар руу нүүж, 1000-т малчин болно. Ам бүл 7, 5 хүүхэдтэй, бүгд гэрлээд тусдаа амьдарч байгаа.

ОРЛОГО:

2000 онд:

Ямаа – 10; 7кг ноолуур х 20,000 = 140,000 төг

Тэмээ – 35; 100кг ноос х 1000 = 100,000 төг

5 ботготой ингэ; 5 л сүү өдөрт – сард 150 литр = 150,000 төг

150,000 х 12 сар = 1,800,000 төг

Адуу - 25

2005 онд:

Ямаа – 200 х 750гр ноолуур=150 кг ноолуур х 40,000=6,000,000 төг

Тэмээ – 50. 250 кг ноос х 3000=750,000 төг

Адуу – 35

Ээжийн 10 ботготой ингэ, 10 литр сүү өдөрт

10 л х 2000 х 30 = 600,000 х 12 = 7,200,000 төг

НИЙТ: 2,040,000 төг

2010 онд:

Ямаа – 400 х 740 гр ноолуур = 300 кг х 40,000 = 12,000,000 төг

Тэмээ – 50 х 3000 х 250 кг = 750,000 төг

Адуу – 40

Сүү – 10 ингэ сард 600,000 х 12 = 7,200,000 төг

НИЙТ: 19,950,000

НИЙТ: 13,950,000 tugrug

2015:

Ямаа – 300, ноолуур 210кг х 49.000=10,290,000 төг

Хонь – 80

Тэмээ – 30 х 5кг=150кг ноос х 3.000=450.000 төг

Адуу – 20

ОТ-н зам арчилгааны ажилчин, сарын цалин 900.000 х

12сар=9.800.000 төг

НИЙТ: 20.540.000

3. Жадамбын Мятаг

- 2000 онд Эхэн Халивт байсан
- Одоо Хажуу Улааны өвөлжөөнд
- Малын тоо толгой өссөн тул шинэ бууц барьсан.
- Өвлийн бэлчээрийн нөхцөл байдал хэвээрээ
- Өмнөх бэлчээртэй харьцуулахад одооны хүрэлцээ муу, даац хэтэрсэн
- Баруун талд Пүрэвдорж, хойно Баатарчулуун, зүүн талд Төмөртоогоогийнхтой бэлчээр хуваадаг.
- Зуны бэлчээр өвөлжөөний өмнө талд, нисэх буудлаас 500 метр зайтай.
- Эхэн Халивын кольцот худгаас уудаг байсан. Усны түвшин буурсан.
- 25 бод, 200 богтой байсан, бэлчээргүйгээс болоод бод малаа худалдсан, бог малаа ч их хэмжээгээр өсгөх боломжгүй. Тоосны улмаас малын эрүүл мэнд муудсан, идэш гаргахад малын уушиг харласан байдаг.
- Цаашдаа мал маллахад хэцүү, бэлчээр, ус муугаас малы тоог өсгөх аргагүй.

4. Шаравын Ганбат

- 2000 онд Эхэн Халивт байсан
- Одоо Замын Улааны өвөлжөөнд
- Малын тоо толгой нэмэгдсэн тул нүүх болсон
- Өвөлжөөний нөхцөл байдал боломжийн
- Өмнөхтэй харьцуулахад бэлчээр багатай
- Өмнөх бэлчээрээс ачаалал ихтэй
- Баруун талд Пүрэвдорж, хойно Батарчулуун, зүүнтээ Төмөртоогоогийнхтой хуваадаг.
- Зуны бэлчээр өвөлжөөнөөс өмнө зүгт, нисэх буудлаас 500 метр
- Эхэн Халивын кольцот худгаас уудаг байсан, одоо ч хэвээрээ. Усны түвшин багассан.
- 20 бод, 300 гаруй богтой байсан, бэлчээргүй болсон тул бод малаа худалдсан. Бог малын тоог өсгөх боломжгүй. Тоосны улмаас малын эрүүл мэнд муудсан. Мал гаргахад уушиг нь харласан байдаг.
- Цаашдаа мал маллах хэцүү, бэлчээр ус муу. Малын тоог нэмэгдүүлэх бодолгүй.

ОРЛОГО:

2000

Мах – 20 мал - 1,000,000
Сүү & айраг - 400,000
Хөдөлмөрийн хөлс (гагнуур) - 1,500,000
Ноос, ноолуур - 1,000,000

2005

Мах - 900,000
Сүү & айраг - 300,000
Ноос, ноолуур - 1,500,000

2010

Мах - 1,500,000
Сүү айраг - 500,000
Ноос ноолуур - 2,500,000

2015

Мах - 1,500,000
Сүү, айраг - 500,000
Ноос ноолуур - 2,600,000
Ажлын хөлс - 8,400,000

ЗАРЛАГА:

2000

Хүнс - 1,000,000
Шатахуун – 1,800,000
Сургуулийн төлбөр – 900,000

2005

Хүнс - 1,500,000
Шатахуун – 2,000,000
Сургуулийн төлбөр – 800,000

2010

Хүнс – 1,500,000
Шатахуун – 1,500,000
Сургуулийн төлбөр – 1,000,000

2015

Хүнс – 2,000,000
Шатахуун– 1,300,000
Сургуулийн төлбөр – 1,000,000

5. Ч. Дэмбэрэл

- Олон Худгийн Хүрэнгийн өвөлжөөнд байсан
- Одоо Улаан Хошууны өвөлжөөнд, өмнөх өвөлжөөнөөс зүүн тийш, нисэх буудлын хойно
- Ус ховордсон тул нүүсэн
- Мэдээж тохиромжтой байсан
- Бэлчээр талхлагдаж байна
- Ачаал их, мал олон
- “Хушуу багтвал идэж, хаяа багтвал бууна”гэгчээр бүгдээрээ бэлчээрээ хувааж байна. Манайх Д. Туяа, Ц. Нэргүй, М. Пүрэвдорж, Б. Баатарчулууныхтай хуваадаг.
- Зун, намрын бэлчээр манай 2 өвөлжөөтэй ойрхон.
- Одоо өвөлжөөнийхөө ойр өмнөх бэлчээртэй байгаа
- Зуны бэлчээрийн нөхцөл хэцүү, даац хэтэрсэн.

- Усны тухайд бороо хур элбэг үед нуур, тогтоол уснаас малаа усалдаг, бага бол гар худаг, ОТ-н авчирсан усыг уудаг.
- Усны эх үүсвэр байхгүй, хаана ч байхгүй.
- Бог – 300 гаруй, бод – 100 гаруй, бог малын тоо хэвээр, бод бага зэрэг өссөн. Амьжиргаагаа сайжруулахын тулд малаа өсгөмөөр байна.
- Уламжлалт мал маллагаа алдагдсан, малчид малдаа их мөнгө зарцуулах болсон
- Малыг ашиг шим, эрүүл мэнд их муудсан. Урьд өмнө мал эрүүл байдаг байсан.
- Ирээдүй бүрхэг байна. Мал маллахад улам л хэцүү болж байна.

6. Баянмөнхийн Баатарчулуун, Гавилуудын малчин

- 2000 оноос өнөө хүртэл Хараатын өвөлжөөнд.
- Хараатын хуучин өвөлжөөндөө л байгаа, манайх нүүгээгүй
- Бэлчээр ховордсон, уул уурхайн нөлөөгөөр. Бэлчээр муудсан, өвс ногоо бага болсон, ачаалал их.
- Манайх 5 айлтай бэлчээр хуваадаг: Гүрдорж, Дэмбэрэл, Ганбат, Төмөртоогоо.
- Зуны бэлчээр өвөлжөөнөөс зүүн тийш 2.5 км-т
- Нисэх буудлын хавиар намарждаг байсан. Одоо усны эх үүсвэр маш муу. Нисэх буудлыг манай намаржааны бэлчээрт барьсан.
- 2000 онд манай худгаас 300 тэмээ төвөггүй уудаг байсан, одоо 100 тэмээнд хүрэхгүй. Өмнө нь усны эх үүсвэр сайн байлаа, одоо маш дордсон. ОТ хоолойгоор гүний ус авч эхэлснээс худаг, булгууд ширгэсэн. Гүний худагтай болмоор байна.
- Одоо 500 орчим малтай. 700 байсын. Адуу 60, тэмээ 50, хонь 250, ямаа 200.
- Уул уурхай, зам, нүх, тоосноос болоод мал маллахад хэцүү болж байна.
- Бэлчээр, ус дутмаг, бутлуурын тоос зэргээс болоод малын ашиг шим өөрчлөгдсөн. Бэлчээр, ус муу, мөн тоос зэргээс малын эрүүл мэнд муудаж байна. ОТ, нисэх буудал, тоос мал төдийгүй хүний эрүүл мэндэд аюултай учруулж мэднэ.
- Ирээдүйд эрчимжсэн мал аж ахуй эрхлэн, мах, сүүний чанарыг сайжруулах хүсэлтэй. Малыг эрүүлжүүлэх вакцинжуулалт хэрэгтэй байна.

7. А. Улам-Ундрах

- 2000 онд Хөлийн бууцанд байсан.
- Одоо шар Хоолойд өвөлжөөтэй
- Манайх малаа зөвхөн баруун, өмнө зүг рүү бэлчээдэг. Хойд болон зүүн талд олон айлтай. Баруун талдаа нисэх буудлаар боогдсон болохоор хаваржаа, өвөлжөөнийхөө хооронд нутагладаг. Өвөлжөөний усны эх үүсвэр хомсдсон, 300 мал ч усалж хүрдэггүй. 300 livestock. Өнгөрсөн жил ОТ манай худагт ус хийж өгч байсан. Тэр ус нь малд тохиромжгүй. Манай өвөлжөөний бэлчээр хавчигдсаны дээр усгүй болохоор тун бэрх. Манай мал өвөлжөө, хаваржааны бэлчээрийн хооронд бэлчдэг, хаварт мал идэх юмгүй болохоор 50-100 мал алддаг. Мал маллахад элам л хэцүү болоод байна. Ачаалал их, бэлчээрээ бусадтай хуваадаг. Халив голын бүх айлууд манай өвөлжөөний газарт ирдэг, мөн Баян, Жавхлантын малчид малаа манай хаваржааны бэлчээрт авчирч хавар, намарт юу ч үгүй болтол нь идүүлдэг, тэгээд эндхийн манайх шиг өрхүүдэд маш их хохирол учруулаад явдаг. Бас Оюутын гол, Дугатын мал манай өвлийн бэлчээрт ирдэг.

- Зуны бэлчээр Хананд. Тэнд гүний худагтай ч малд ханадаггүй. Малаа аваачихаас өмнө 2 онгоц дүүргэдэг. Ундарга нь өвөлжөөнийхөөс арай хурдан юм шиг санагддаг. 10-15 минут болоод шахахад ус хэвийн гарна. С багадаа нь мотороо унтраахгүй бол эвдэрнэ.
- Бог – 350, бод - 20, үүнд манай 4 хүүхдийн мал орсон байгаа.
- Баруун талд нисэх буудал, урд зүгт замүүд байгаа тул тойрч явна, замын дагуух өндөр хашлагыг давна, замын тоосноос болоод юм харагдагүй.
- Сүүлийн үедблчээр, ус муугаас мал маллахад хэцүү болж байна. Малын тоо толгойг буурлъя гэхээр амьжиргаанд хүрэхгүй. Яахаа үнэндээ мэдэхгүй байна.
- Тоостой өвс идсэний улмаас малын уушиг нөжирсөн, уйланхайтай байх болсон. Өглөө их тоостой үед нүд загатнаж, хамар битүүрдэг. Өглөө 6 цагийн үед нэл тоос, 200-300 метрт байгаа юм харагдахгүй.
- Миний бодлоор мал аж ахуйг авч явах 1-2 зам байна. Уул уурхай малчид болон аж ахуйг дэмжих. Засгийн хүчтэй бодлого үгүйлэгдэж байна. Бие биенээ ойлгох хэрэгтэй байна.

Эхэн Халивын Бэлчээр ашиглагчид, бэлчээрийн нөхцөл байдал – Эхэн Халивын малчдын өгсөн мэдээлэл (2016 оны 6 сарын 8)

Халивын голын районы бэлчээрийн нөхцөл байдал.

д/д	Бэлчээрийн хэсгийн нэр	2000 он	2000-2005он	2005-2010	2010-2015	Шалтгаан
1	Элгэний энгэр, Хараат уулаас нааш	Д. Туяа Элгэн Ч. Дэмбэрэл Улаанхошуу Б. Баатарчүлүүн Хараат 4	Д. Туяа Элгэн Ч. Дэмбэрэл Улаанхошуу Б. Баатарчүлүүн Хараат 3	Д. Туяа Элгэн Ч. Дэмбэрэл Улаанхошуу Б. Баатарчүлүүн Хараат Д. Борбанди Модоншанд	Д. Туяа Элгэн Ч. Дэмбэрэл Улаанхошуу Б. Баатарчүлүүн Хараат	2009 онд малын идэш мүүдаж мал хорогдсон
2	Хонгил, Халивын голын эх, Замын-Улааны цавууд	Б. Хашчүлүүн Замын- Улаан Ш. Ганбат Хажуу-Улаан Ж. Мядаг Хонгил М. Пүрэвдорж Эхэн халив 4	Б. Хашчүлүүн Замын- Улаан Ш. Ганбат Хажуу-Улаан Ж. Мядаг Хонгил М. Пүрэвдорж Эхэн халив 3	Б. Хашчүлүүн Замын-Улаан Ш. Ганбат Хажуу- Улаан Ж. Мядаг Хонгил М. Пүрэвдорж Эхэн халив	Б. Хашчүлүүн Замын-Улаан Ш. Ганбат Хажуу- Улаан Ж. Мядаг Хонгил М. Пүрэвдорж Эхэн халив	2009 онд малын идэш мүүдаж мал хорогдсон М. Пүрэвдоржийнх 2013-14 онд Баян- Овоо суманд алсын отор хийсэн
3	Халивын уулс	Ц. Цэцэгмаа Дэл Б. Дамдин Түймэрт М. Амьтан Хөл Ц. Нэргүй Улаан овоо	А. Наранцэцэг Модонхонд Б. Дамдин Түймэрт Ц. Мөнхтөр Дэл Ц. Нэргүй Улаан овоо	Ц. Мөнхтөр Дэл А. Наранцэцэг Модонхонд Ц. Нэргүй Улаан овоо Ц. Элбэгсайхан Улаановоо Гялаан Мэндбаяр	Ц. Мөнхтөр Дэл А. Наранцэцэг Модонхонд Ө. Нандинцэцэг Мянгатхонд Ц. Нэргүй Улаан овоо Ц. Элбэгсайхан Улаановоо	2009 онд малын идэш мүүдаж мал хорогдсон 2014 онд Мөнхтөр, Наранцэцэг,Нэргүй, Элбэгсайхан, Мэндбаяр, Нандинцэцэг, Төмөртоогоо

		Ц. Элбэгсайхан Улаановоо Гялаан Мэндбаяр 4	Ц. Элбэгсайхан Улаановоо Гялаан Мэндбаяр Ц. Төмөртоогоо Түймэрт 3	Ц. Төмөртоогоо Түймэрт	Гялаан Мэндбаяр Ц. Төмөртоогоо Түймэрт Ц. Сайхандэлгэр Түймэрт	нарынх болсноос малын ус идэшгүй Цогтцэций сумруу алсын отор хийж нэлээд хохирол амссан
4	Таван толгойн тал	Б. Дамдин Түймэрт М. Амьтан Хөл Ц. Цэцэгмаа Дэл Д. Банди Эхэн халив М. Бямбаа Ихрийн улаан М. Пүрэвдорж Эхэн халив 4	А. Наранцэцэг Модонхонд Б. Дамдин Түймэрт М. Пүрэвдорж Эхэн халив Ц. Мөнхтөр Дэл Ц. Цагаан Хөл 3	А.Улам-Ундрах Шархоолой Ц. Мөнхтөр Дэл А. Наранцэцэг Модонхонд Ц. Цагаан Хөл 0	А.Улам-Ундрах Шархоолой Ц. Мөнхтөр Дэл А. Наранцэцэг Модонхонд Ц. Цагаан Хөл Х. Хаян Ц. Баттогтох 0	2009 онд малын идэш мүүдаж мал хорогдсон А. Улам- Ундрах, Цацралт, Түвшинтөгс нарынх 2013-2014 онд малын идэш мүүдаж ус ханахгүй болсноос Баян- Овоо суманд алсын оторт нүүж тэнд өвс сайн байсанч 68 малаа үхүүлж 54 малаа алдаж нутагтаа буцаж ирсэн
				Шалтгаан нь Asia gold компани ирж буун маш олон ерөмдлөг хийн усыг улам багасгав Оюут нисэх онгоцны буудлыг барьж үлэмж бэлчээрийг авч мөн таслан хуваав. Буудлын зүүн талд технологийн алдаанаас үүдэлтэй маш том халцгай болсон бэлчээрийг үлдээв. Мөн Бумбатын хөх үзүүр, Тавантолгойн буруун урд талын карьерууд болон түүний замд биологийн нөхөн сэргээлт хийгээгүй орхисноос бэлчээр сүйтгэгдэв 6709А талбайг хашсанаас хойш тэнд жилийн 4 улиралд идшилж байсан бод мал гарч ирэн байнгын байж бага	Шалтгаан нь Ханбумбат онгоцны буудал баригдаж маш их тоосжилтыг үүсгэж бэлчээрийг таслан хувааж мөн хомсдуулав Тавантолгойн зүүн талбайн 2 толгойг авсан карьераа нөхөн сэргээгээгүйгээс маш том талбайд шар шороо хийсэн хоцров “А” кемп бэлчээрт ирж байрлав Одоо нөхөн сэргээх нь битгий хэл нутги йн хог нь хөглөрч хэвтэнэ Жавхлант баг, Ундайн голын ус бэлчээргүй болсон малчид гарч ирэн танк тавиулж зунждаг, намарждаг болов. Үүнээс үүдэлтэйгээр жил бүрийн хавар төлтэйгээ нийлээд	

				малынхаа идэшийг иддэг болсон	100 орчим мал хорогддог болов. Гүний хоолой баригдаж тоосжилт ихсэж хэцүү байдалд байсан ба мөн л нэлээд зурвас бэлчээр үгүй болсон	
5	Шивээгийн хөндий	Ж. Мядаг Хонгил Ц. Баттогтох Хөхүзүүр 4	Ж. Мядаг Хонгил Ц. Баттогтох Хөх үзүүр	Ж. Мядаг Хонгил Ц. Баттогтох Хөх үзүүр	Ө. Баттогтох Гог	2009 онд малын идэш муудаж мал хорогдсон
6	Ханангийн хяр, Ханангийн хөндий	М. Баярсайхан Ханандаваа 4		А. Улам- Ундрах Ханан салхит	У. Цацралт Ханансалхит	2009 онд малын идэш муудаж мал хорогдсон Цацралтынх 2013-14 онд алсын нүүдэл хийсэн
7	Халивын гол дагуу	4			Ж. Энхсайхан С. Бум- Эрдэнэ Ч. Мандал	2009 онд малын идэш муудаж мал хорогдсон
8	Дугат, Бумбатын хөх- Үзүүрийн районы бэлчээр	3- 4 Шалтгаан нь Энд байнгын гүний өрөм ажиллаж зам аар машин хөлхөж байсан	3	2 Энэ үеэс бүүр хоёр талаараа сайжруулсан замтай болсон	0 У. Түвшинтөгс Бумбатын хөх үзүүр Гүүргүй засмал зам тавигдсанаас болж мал очиж уух боломж хомсдоноос гадна Дугатын булаг таслан хуваагдсан нь хамгийн ноцтой асуудал болон үлдэв. Дугат үндсэндээ ширгэв Худгийнх нь усны түвшин ч доошлов.	2009 онд малын идэш муудаж мал хорогдсон 2009 онд малын идэш муудаж мал хорогдсон

Бэлчээр, Ус, Малчдад учирсан нөлөөлөл – малчдын ажиглалт, 2016 оны 6 сарын 8-нд А. Улам-Ундрахын өгсөн мэдээлэл

Уг хүснэгтэнд А. Улам-Ундрах биед учруулсан хохирлуудыг мөн дурьдсан¹

2016 оны 06 дугаар сарын байдлаар.

д/д	Ямар нөлөөлөл	Хэнд юунд нөлөөлж байгаа	Яаж нөлөөлж байгаа	Ямар хугацаагаар	Нэмэлт тайлбар
1	Уурхайн 6709А лицензет талбай	Хүн малд	Одоогийн хашаа татан байрлаж олборлолт хийж байгаа 6709А цаашид хашигдах 6708А,6710А лицензет талбайнууд нь эргэн тойрондоо Дундан, Удаан толгой, Бумат, Дугат, Хар хад, Хөх хад, Бор-Овоо гээд эргэн тойрондоо арав гаруй булаг шандтай 3000 орчим бод мал жилийн 4 улиралд бэлчээрлэн байдаг малын бэлчээрийн маш их түшиц газар байсан нь хашигдсан учраас тэнд идшилж байсан Гавилууд, Жавхлант, Харзаг, Могойт багуудын бод малууд одоо Таван толгойн тал, Оорцог, Ханан, Шивээгийн хөндийнүүд, Унтаахай, Замын хөөвөр цаашлаад Сүмтын хөндийд бага малынхаа бэлчээрийг эзлэн бэлчээрлэж байгаагаас бэлчээрийн хүрц хавар муудсанаас бог мал улмаар өлгөдөж үхэх байдал сүүлийн жилүүдэд үлэмж	Байнга	

¹ Хүний эрх, сэтгэл санааны тайван байдалд учирсан нөлөөллүүдийг агуулж байгаа болно. Үүнд: “гэрээт компани Бамбай Секьюрити хүний эрхийг ноцтой зөрчдөг”, ГТЗ-ийн дүрэмд гишүүд нь бүх гишүүдээс зөвшөөрөл авахгүйгээр олон нийтэд мэдээлэл хийж болохгүй гэсэн нь асуудалтай гэх мэт.

			нэмэгдлээ. Жишээлбэл: Зөвхөн манайх гэхэд л энэ хавар 30 гаруй төл, мөн төдий чинээ том малын хорогдолтой явж байна. Энэ бол нэг малчин айлд эдийн засгийн хувьд үлэмж их хохирол юм.		
2	Нүүлгэн шилжүүлэгдсэн малчин өрхүүдийн нөлөөлөл	малд	Оюутолгойн лицензийн талбайгаасаа нүүлгэн шилжүүлсэн малчин айл өрхүүдийг тухайн үед ямарч ул суурьтай бодлогогүйгээр дуртай газраа буулган хороо бууц байр байшин барьж, худаг гаргаж өгсөн нь тэдгээрийг ирэхээс өмнө нутаглаж байсан малчдынхаа бэлчээр усыг шахан идшилж байгаа нь тэдэнд зовлон болоод байна. Одоо малчид бэлчээр усаа булаацалдах хоорондоо муудалцах, маргалдах нь ихсэж байгаа нь цаашид иргэд хоорондын мөргөлдөөнд ч хүргэж болзошгүй байна.	байнга	
3	Гүний хоолойн болон Галбын говийн хөрсний усыг газрын гүн рүү гоожуулж байгаа цооногууд		Гүний хоолой, Галбын говьд усны- Оюутолгойн эргэн тойронд 30 орчим км-ийн радиуст хийсэн хайгуулын болон хяналтын маш олон өрөмдлөгүүдээс ус доош алдагдан одоогийн Оюутолгой ХХК уурхайн усан хангамжаа авч байгаа газрын гүн рүү нийлэн гоожиж байгаа тул малчдын ундны болон мал сүргээ усалдаг хөрсний ус илт байхгүй болголоо. Усны асуудал бол малчин хүн битгий хэл хүн төрөлхтний хамгийн эн тэргүүний хэрэглээ тул үүнийг ямарч нөхөх олговор нөхөж үл чадах. Гэвч нөхөн олговрыг усан дээр олгох л ёстой. Олгох ч байлгүй гэж найддаг.	Байнга Цаашид ч нөлөөлсөн хэвээр байх болно. Байгалийн жам ёсны эко системийг алдагдуулсан тул	
4	Барилгажилтын шатанд ашиглаж байсан карьерууд түүнд хүрсэн зам харгуйнууд.		Оюутолгой ХХК нь барилгажилтын шатандаа ашигласан элс хайрга шороо чулууны карьерууд түүнд хүрсэн буцсан зам харгуйнуудаа нөхөн сэргээгээгүй, том уул уурхай бий болохын хэрээр түүнд ачаа тээвэр хүргэх, дэд бүтэцүүд бий болж түүн рүү гарсан асар олон зам харгуйгаас үүдэлтэйгээр ойролцоогоор 25- 30 000 га бэлчээр алдагдчихаад байна.Энэ нь одоогийн Гавилууд багийн хэмжээний газар нутаг юм. Цаашид туслан гүйцэтгэгч компаниуд уг төслийн эргэн тойронд ирж бууцгааснаар энэ байдал зогсолтгүй үргэлжлэх нь	Нөхөн биологийн талаар сэргээгдэж дуустал	1. Карьерууд- материал авах объект хоёрынхоо хооронд түр зам тавьж үйл ажиллагаа явуулаагүйгээс маш өрөгн уудам газрыг эвдсэн өргөн замууд бий болсон нь одоо болтол

			<p>ойлгомжтой болоод байна.</p> <p>Хамгийн том, бэлчээрийн хамгийн их түшиц газруудыг эзлэн оршдог технологийн алдаатай ашиглагдаад одоо болтол нөхөн сэргээгдээгүй карьеруудаас дурдахад</p> <ul style="list-style-type: none"> - Таван толгойн зүүн 2 толгойг ашиглаад орхисон карьер - Таван толгойн баруун урд толгойг ашиглаад биологийн нөхөн сэргээлт хийгээгүй орхисон карьер - Бумбатын Хөх- Үзүүрийн карьер - Устын голын карьер - Таван толгойн баруун урд үзүүрийн карьерт очих буцах түр зам тавиагүйгээс маш их зурвас газрыг гэмтээсэнд одоо болтол юу ч ургаагүй л байна. - Оюут нисэх буудлын зам - Оюут нисэх буудал барих үзд үүсгэсэн зүүн талын өтгөн тэсгэтэй хөндийг юу ч үгүй сүйтгэсэн газар - Улаанбаатараас Оюутолгой ордог маш өргөн болсон авто зам 		<p>нөхөн сэргээгдэж чадахгүй байна</p> <p>2. Оюутолгой- Гашуун сүхайтын хооронд байгуулсан баяжмал зөөдөг засмал зам нь бэлчээрийг таслан хуваадаг</p> <p>3. Манлай сумаас болон Ханбогд- Оюутолгой хоорондын, Оюутолгой- Дэл хоорондын сайжруулсан замууд нь өргөн газрыг эзлэн оршиж байгаа ба мал дайрагдах аюул их байгаа болно.</p> <p>4. Гүний хоолойн 70 км сайжруулсан зам</p>
5	Зэрлэг махчин амьтадын хүн малд дасалт, гэрсэлт амьдралын хэвшлийн гэрийн тэжээмэл амьтадын амьдралын хэвшил рүү аажмаар шилжиж буй өөрчлөлтийн нөлөөлөл		<p>Оюутолгойд олон хүн ажилладагийн хэрээр хоолны үлдэгдэл хаягдал төдий чинээ их гарч түүнээ хогийн цэгт нүхэнд хийснээр тэрхүү хогийг иддэг химлайн хажир, хожгор тас, хон хэрээ гэх мэт сэг зэмээр хооллодог араатан жигүүртнүүдийн амьдралын хэвшил нь өөрчлөгдөж улам гэрсэж хүн малаас айх үргэхээ больж төл малын хэлийг сугалах, нүдийг нь ухах, амьдаар нь улаан суга руу нь хошуугаараа шааж элэг зүрх уушгийг нь сугалан идэх, гол махыг нь бөгсөөр нь амьдаар нь ухаж идэх зэрэг үйлдлүүдээс болж зарим малчин өрх бойжуулсан төлийнхөө 50 хувийг шувуунд алдсан айл ч байна. Цаашид үнэг, хөх чоно ч ийм байдалд хүрэхэд ойрхон болжээ.</p>	Байнга	
6	Авто зам харгуйн		Одоогийн байдлаар хэмжилт хийгээд хэвийн байна	Байнга,	

	болон үйлдвэрийн цагаан тоос		гээд байгаа замын тоос, үйлдвэрийн цагаан тоос хүн малд үхлийн харанга дэлдээд байна. Өглөө оройд маш их тоос босч тогтуун үед өдөржин шөнөжин хургаж хонож байна. Үүнд аюултай цахиурын болон хар тугалаганы давхар ислүүд, угаарын хий, нүүрс хүчлийн хий, азаотын дан болон давхар ислүүд гээд хорт бодисууд тархаж байгаа нь цөмийн зэвсгээс өөрцгүй. Тогтоолгох бололцоо байхгүй ч би өөрөө бронхиалный астомтой болоод жил гаруй болж байна. Хүнсэнд хэрэглэж байгаа малын уушиг маш их өвчилсөн байгаа нь байдал ямар байгааг гэрчлээд байна.	цаашид ч	
7	Хүний эрхийн ноцтой зөрчлүүд		Эрүүгийн шинжтэй хүний эрхийн ноцтой зөрчил гэмт хэрэг гаргасан Туслан гүйцэтгэгч компанийг нь шаардаад шаардаад арга хэмжээ авч өгөхгүй болохоор нь цөхрөхдөө Оюутолгой ХХК-нд хандсан ч ямарч арга хэмжээ авч өгөөгүй. Уул нь эрүүгийн шинжтэй хүний эрхийг ноцтой зөрчсөн Бамбай Секрjурити сервис компани өнөөдөр энд ажиллаж байх хуулийн ч ёс суртахууны ч эрх байхгүй. Мөн саяхан Оюутолгой ХХК-ийн оролцоотой хийгддэг гурван талт зөвлөлийн хуралд би үг хэлэх эрхгүйгээр оролцлоо. Тэнд үг хэлэх эрхгүйгээр оролцсон болно. Энэ нь Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтыг ноцтойгоор зөрчиж байгаа юм. Тухайн улсынхаа Үндсэн хуулийг зөрчинө гэдэг бол үйл ажиллагаа явуулж байгаа улс орноо үл хүндэтгэж байна гэсэн үг. Мөн гурван талт зөвлөлийнхөн бусдынхаа зөвшөөрөлгүйгээр үг хэлэх хэвлэн нийтлэх эрхгүй байгаа нь тэнд ер нь ямар байгууллага ажиллаад байна гэж анхаарал хандуулахад хүрээд байна. Үүнд онцгой анхаарал хандуулахыг хүсч байна.	Ер нь л байнга гарах төлөв илрээд л байдаг	
8	Компанийн зарим удирдлагуудаас малчдад үзүүлж		Компанийн зарим удирдлагуудаас малчдад үзүүлж буй сэтгэлийн дарамт <ul style="list-style-type: none"> - Малчдыг битгий давруулаад бай - Малчид худагтаа чулуу чихдэг 	Тодорхой хугацаанд, тодорхой албан	

	буй сэтгэлийн дарамт		<p>- ОТ өвс тэжээл өгөөд хувийн бизнесийг хаагаад байна гэсэн худал цуурхалыг ОТ- д тараадаг гм гм</p> <p>Отроор нүүж явахад тухайн газарт мал маллаж байгаа малчид биднийг “ Оюутолгойд хамаг бэлчээрээ өгчихөөд та нар хаачиж яваа юм бэ Тэр Оюутолгойнхоо хажууд л байж байхгүй, яасан гэж энд бидний бэлчээрийг шахаж нүүж явцгаагаа юм бэ” гэдэг</p>	тушаалтнууд дээр гарч байна	
9	Хар зарчмуудын нөлөөлөл		Сүүлийн үед илт орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хуйвалдах явдал харагдаад байгаа тул орон нутгийн төр захиргаа- малчдын хооронд ч ангал үүсэхээр болоод байна.	Яг одоо бий болчихоод байгаа асуудал	<p>1.Төр ард түмний зайг холдуулдаг</p> <p>2. Төрийг дотор нь хагаралдуулна</p> <p>3. Өөрт үйлчилж чадах ашигтай талаа барьж авдаг нь ёс зүйгүй бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны зарчим байдаг.</p>
10	“Оюут” нисэх онгоцны хуучин буудлын нөлөөлөл		Энэ нь ихээхэн бэлчээрийг эзлэн оршдог ба мөн л бэлчээрийг таслан хуваадаг	Биологийн нөхөн сэргээлт хийгдэж дуустал	
11	“Ханбумбат” нисэх онгоцны буудал		Энэхүү буудал нь өмнө нь ашиглаж байсан “Оюут” нисэх буудлаасаа илүү их том бэлчээрийг эзлэн оршдог ба мөн л бэлчээрийг таслан хуваадаг. Энэ хоёр онгоцны буудлыг бүлгээр нь авч үзвэл Таван толгойн талыг үндсэнд нь таслан хуваадаг	Байнга цаашид ч	
12	Гүний хоолой ба замынх нь нөлөөлөл		70 км халцгай зурвас газар	Байнга цаашид ч	
13	Усны lagoon		Бага биш бэлчээрийг эзлэн хашаалан оршдог	Байнга цаашид ч байсаар байх болно.	
14	авто замын аюулгүй байдлын		Хурдтай яваа автомашинууд мал маш ихээр дайрч алж байна	Одоогоор бодитойгоор	

	нөлөөлөл			оршиж байгаа боловч бүх талын хүчин чармайлтаар багасгах буюу арилгаж болох нөлөөлөл	
15	Автозамын дуу чимээ, машинуудын хөдөлгөөний нөлөөлөл		<p>Замын ойролцоо бэлчээрлэж буй мал машинуудын дуу чимээнээс үргэх цочих улмаар цааш үргэж алдагдах явдал байна</p> <p>Замыг маш их гүнзгийлэн ухаж засдагаас үүдэлтэйгээр мотоцикльтой хөндлөн гарах ямарч боломжгүй болгосон байдаг тул маш их тойрох хэрэг гардаг. Хамгийн дээд тал нь 80- 90 см өндөр байгаа нь малчдад зовлон болоод зогсохгүй амь нас аюулгүй байдалд ч онцгой муу нөлөөтэй, мотоцикльтой хүмүүс гадлах гэж яваад унах гэмтэх цаашид машинд дайрагдах аюултай байна.</p>	Байнга	
16	Автомашинуудын хурц гэрлийн нөлөөлөл		Автомашинуудын хурц гэрлийн нөлөөгөөр мал хаашаа ч явж чадахгүй зогсож байгаад дайруулах явдал байна	Байнга	

Хавсралт 5 ХШБ-ийн 1-р шатны тайлан, өрхүүдийн нэрс – засварласан бүрэн

ХШБ-ийн 1-р шатны ажлын үеэр Зорилтот Бүлэгтэй хийсэн уулзалт, ярилцлага хийхэд дурьдагдсан Бор Овоо үгүй болсны улмаас зуны бэлчээрээ алдсан өрхүүд

Ундай голын дагуух бэлчээр тухайлбал Бор Овоо болон одоогийн Уурхайн Лицензит бүсийн эргэн тойронд зөвхөн Жавхлант багийн бүх малчид төдийгүй Ханбогд сумын бусад баг болон зэргэлдээх сумын малчид хааяа ашигладаг зуны бэлчээр нутаг байжээ.

Нутгийн малчид болон сум, багийн өмнөх захиргааны төлөөллүүд Бор Овоон задгай үгүй болсноор зуны бэлчээрээ алдсан 59 өрхийг нэрлэн жагсаасан. (Нөлөөлөл нийт орон нутгийн хэмжээний гэж үзэж байгаа тул уг жагсаалтыг нөлөөлөлд өртсөн бүх өрхүүдийн бүрэн жагсаалт гэж танилцуулж байгаа биш болно.)

Ундай голын дагуу өвөлжөөтэй, зуны бэлчээрээ алдсан өрхийн тоо (2013 оны 12 сард зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогсдын жагсааснаар) – нийтдээ 22

Ц. Баттогтох, О. Энхбаяр, С. Гочоосүрэн, “Батбаатар” (=Ю. Болчулуун), Д. Энхчулуун, Ч. Цогт, Ц. Биндэрьяа, Ө. Баттогтох, Д. Намсрай, Ө. Чулуу (нас барсан, эхнэрийн нэр Ц. Банди), Б. Шинэбаяр, Р. Цэнд-Аюуш, Т. Нямсүрэн, Н. Ширнэн, И. Должинсүрэн, Ю. Надмид, Х. Содномдорж, Х. Жаргалсайхан (нас барсан, эхнэрийн нэр Ц. Долгоржав), Д. Адъяа, А. Анхбаяр, Ц. Алтангэрэл (нас барсан, эхнэр М. Насан-Өлзий)

Зун ба хаврын бэлчээрээ алдсан өрхүүд (Ундай голоор нутагладаггүй, өөр газраас ирдэг) (2013 оны 12 сард зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогсдын жагсааснаар) – нийтдээ 28

Д. Борхүү, Х. Сүрэнхүү, Р. Дэмбэрэлноров (нас барсан, эхнэр Ц. Бадарчулуун), Ц. Бадамсүрэн, Ө. Сэр-Од, Ц. Идэрборгил, Б. Энх-Эрдэнэ, Ч. Дэмбэрэл, Ч. Нансалмаа, Д. Лувсандагва, Д. Болдбаяр (нас барсан, эхнэрийн нэр Ч. Намдагмаа), Ц. Бямба, Ц. Жаргалсайхан, Х. Отгонжав, Х. Гантулга, М. Хоньхүү, П. Үржин, Б. Эрдэнэбаяр, Д. Мөнхбаяр, Ц. Хандсүрэн, Ц. Нэргүй, Г. Мэндбаяр, Ц. Мөнхтөр, С. Жаргалсайхан, Х. Чулуунбаатар, П. Цэвэгдорж, Х. Ганболд, Л. Батцэнгэл

Бор Овоо, Ундай гол хавийн бэлчээрийг сүүлийн 10 жилд хамтдаа ашигласан өрхүүд (2014 оны 10 сард Намсрайн нэрлэснээр) (өмнө нь илүү олон айл өрх байсан). (дээр нэр нь дурьдагдсан хүмүүсийн нэрсийг хаалтанд хийв) – дээрх дээр нэмэгдэх нь нийтдээ 9.

Б. Бадамсамбуу (одоо ирэхээ больсон), (Х. Сүрэнхүү), Б. Одхүү, Б. Бадамсүрэн, (Ц. Идэр-Боргил), (Ө. Сэр-Од), А. Анхбаяр, Д. Адъяа, (Д. Мөнхбаяр), Ц. Цагаан, (Л. Батцэнгэл), (Ө. Баттогтох), (Р. Цэнд-Аюуш), (И. Должинсүрэн), Д. Намсрай (1962 оноос хойш), Е. Сүрэнхорлоо, (Х. Отгонжав), (Д. Борхүү), (Б. Шинэбаяр), (О. Энхбаяр), (Ц. Биндэрьяа), Ц. Баатарчулуун, (нас барсан хүмүүс: Д. Болдбаяр, Р. Дэмбэрэлноров, Ц. Алтангэрэл).